

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.40.49; 49.020

Иргэний нисэх. Ерөнхий Нэр томьёо, тодорхойлолт	MNS 6409:2024
Civil aviation. General terms and definitions	MNS 6409:2015-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн С/08 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол Улсын Иргэний нисэхийн салбарт хэрэглэгддэг Чикагогийн конвенцын Аппех-ын нэр томьёо болон ICAO Doc 8400-ийн товчлолыг нэгдсэн нэг утгаар ойлгох, тодорхойлоход оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандартыг иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байгаа төрийн өмчит болон хувийн хэвшлийн бүх байгууллага, энэ чиглэлээр сургалт, судалгаа, сурталчилгаа хийх газрууд Чикагогийн конвенцын Хавсралтуудтай холбоотой баримт бичгийг орчуулж, хэрэглэхэд ашиглана.

3 Норматив эшлэл

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас эрхлэн гаргадаг, Чикагогийн конвенцын Хавсралтуудын нэр томьёо, ICAO-гийн DOC 8400 "ICAO Abbreviations and Codes" болон Иргэний нисэхийн дүрмийн нэр томьёоны тайлбар

4 Бүтэц

- Тодорхойлолт - 1011
- Товчлол - 1130

1-р хүснэгт - Товчлол

Товчлол	Англи	Монгол
A	Amber	Хуван шар, улбар шар
A/A	Air-to-air	Агаар - агаар
A/G	Air-to-ground	Агаар - газар
AAA	(or AAB, AAC. . . etc., in sequence) Amended meteorological message (message type designator)	(AAB, AAC гэх мэт дараалалтай) Өөрчлөгдсөн цаг уурын мэдээ (мэдээний төрөл тодорхойлогч)
AAC	Aeronautical administrative communications	Нисэхийн захиргаа, удирдлагын холбоо
AAD	Assigned altitude deviation	Оноосон өндрийн-түвшний хазайлт
AAIM	Aircraft autonomous integrity monitoring	Агаарын хөлгийн бие даасан тохирлын мониторинг
AAL	Above aerodrome level	Аэродромын түвшнээс дээш
AAR	Air to air refuelling	Агаарт түлшээр сумлах
ABI	Advance boundary information	Бүсэд нэвтрэхээс өмнө урьдчилан авах мэдээлэл
ABM	Abeam	Траверз (тэгш өнцөг)
ABN	Aerodrome beacon	Аэродромын гэрэлт дохио
ABT	About	Ойролцоогоор, орчим, тухай
ABV	Above	Дээр, дээш
AC	Altostratus	Өндрийн бөөн үүл
ACARS†	(to be pronounced "AY-CARS") Aircraft communication addressing and reporting system	("ЭЙ-КАРС" гэж дуудна) Агаарын хөлгийн холбооны хаяглах ба мэдээлэх систем
ACAS†	(to be pronounced "AY-CAS") Airborne collision avoidance system	("ЭЙ-КАС" гэж дуудна) Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем
ACC‡	Area control centre or area control	Бүсийн удирдлагын төв, эсхүл бүсийн удирдлага
ACCID	Notification of an aircraft accident	Агаарын хөлгийн ослын мэдээ
ACFT	Aircraft	Агаарын хөлөг
ACK	Acknowledge	Мэдээ хүлээн авч ойлгосноо баталгаажуулах
ACL	Altimeter check location	Алтиметр шалгах байрлал
ACN	Aircraft classification number	Агаарын хөлгийн ангиллын дугаар
ACP	Acceptance (message type designator)	Зөвшөөрөл (мэдээний төрөл тодорхойлогч)
ACPT	Accept or accepted	Зөвшөөрөх эсхүл зөвшөөрсөн
ACT	Active or activated or activity	Ажиллагаатай эсхүл ажиллагаа
AD	Aerodrome	Аэродром
ADA	Advisory area	Зөвлөмжийн үйлчилгээтэй бүс
ADC	Aerodrome chart	Аэродромын зураг
ADDN	Addition or additional	Нэмэлт, эсхүл нэмэгдэл
ADF‡	Automatic direction-finding equipment	Автоматаар төхөөрөмж

Товчлол	Англи	Монгол
ADIZ†	(to be pronounced "AY-DIZ") Air defence identification zone	("ЭЙ-ДИЗ" гэж дуудна) Агаарын довтолгооноос хамгаалах тодорхой бүс
ADJ	Adjacent	Хажуу, зэргэлдээ
ADO	Aerodrome office (specify service)	Аэродромын алба (үйлчилгээг тодорхой заах)
ADR	Advisory route	Зөвлөмжийн үйлчилгээтэй агаарын зам
ADS*	Address (when this abbreviation is used to request a repetition, the question mark (IMI) precedes the abbreviation, e.g. IMI ADS) (to be used in AFS as a procedure signal)	Хаяг (дахин давтахыг хүсэж энэ товчлолыг хэрэглэсэн бол (IMI) асуултын тэмдгийг өмнө нь заана, ж-нь IMI ADS) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
ADS-B‡	Automatic dependent surveillance - broadcast	Автомат хамааралтай ажиглалт - радио нэвтрүүлэг
ADS-C‡	Automatic dependent surveillance - contract	Автомат хамааралтай ажиглалт - гэрээ
ADSU	Automatic dependent surveillance unit	Автомат хамааралтай ажиглалтын нэгж
ADVS	Advisory service	Зөвлөмжийн үйлчилгээ
ADZ	Advise	Зөвлөмж, зөвлөх
AES	Aircraft earth station	Агаарын хөлгийн хиймэл дагуулын станц
AFIL	Flight plan filed in the air	Агаарт бөглөсөн нислэгийн төлөвлөгөө
AFIS	Aerodrome flight information service	Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ
AFM	Yes or affirm or affirmative or that is correct	Тийм, эсхүл зөв, эсхүл зөвшөөрсөн, эсхүл тухайн зүйл зөв
AFS	Aeronautical fixed service	Нисэхийн суурин холбооны үйлчилгээ
AFT . . .	After (followed by time or place)	...-ны дараа (цаг, эсхүл газрын нэрийг ард нь заана)
AFTN‡	Aeronautical fixed telecommunication network	Нисэхийн суурин цахилгаан холбооны сүлжээ
AGA	Aerodromes, air routes and ground aids	Аэродром, агаарын зам болон газрын туслах төхөөрөмж
AGL	Above ground level	Газрын түвшнээс дээш
AGN	Again	Дахин, дахиад
AIC	Aeronautical information circular	Нисэхийн мэдээллийн цуврал
AIDC	Air traffic services interfacility data communications	НХҮ-ний байгууламж хоорондын өгөгдлийн холбоо
AIM	Aeronautical information management	Нисэхийн мэдээллийн удирдлага
AIP	Aeronautical information publication	Нисэхийн мэдээллийн эмхэтгэл
AIRAC	Aeronautical information regulation and control	Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт
AIREP†	Air-report	Агаарын хөлгийн мэдээ

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
AIRMET†	Information concerning en-route weather phenomena which may affect the safety of low-level aircraft operations	Бага түвшинд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй нислэгийн замын цаг агаарын аюултай үзэгдэлтэй холбоотой мэдээлэл
AIS	Aeronautical information services	Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (НМҮ)
ALA	Alighting area	Газардах бүс (усан дээр)
ALERFA†	Alert phase	Түгшүүрийн үе
ALR	Alerting (<i>message type designator</i>)	Анхааруулах мэдээ (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
ALRS	Alerting service	Аюулын дохио мэдээлэх үйлчилгээ
ALS	Approach lighting system	Ойртолтын гэрлэн систем
ALT	Altitude	Өндрийн-түвшин
ALTN	Alternate or alternating (<i>light alternates in colour</i>)	Хувьсах, эсхүл сэлгэх (<i>өнгөөр хувьсах гэрэл</i>)
ALTN	Alternate (<i>aerodrome</i>)	Бэлтгэл (аэродром)
AMA	Area minimum altitude	Бүсийн минимум өндрийн-түвшин
AMD	Amend or amended (<i>used to indicate amended meteorological message; message type designator</i>)	Өөрчлөлт, эсхүл өөрчлөгдсөн (<i>өөрчлөгдсөн цаг уурын мэдээг харуулахад ашигладаг; мэдээний төрөл тодорхойлогч</i>)
AMDT	Amendment (<i>AIP Amendment</i>)	Өөрчлөлт (AIP-ын Өөрчлөлт)
AMS	Aeronautical mobile service	Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ
AMSL	Above mean sea level	Далайн дундаж түвшнээс дээш
AMSS	Aeronautical mobile satellite service	Нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээ
ANC. . .	Aeronautical chart - 1:500 000 (<i>followed by name/title</i>)	Нислэгийн зураг - 1:500 000 (<i>нэр/гарчгийг ард нь заана</i>)
ANCS . . .	Aeronautical navigation chart - small scale (<i>followed by name/title and scale</i>)	Нислэгийн навигацийн зураг - бага масштабтай (<i>нэр/гарчиг болон масштабыг ард нь заана</i>)
ANS	Answer	Хариулт
AO	Aircraft operator	Агаарын тээвэрлэгч
AOC. . .	Aerodrome obstacle chart (<i>followed by type and name/title</i>)	Аэродромын саадын зураг (<i>төрөл болон нэр/гарчгийг ард нь заана</i>)
AP	Airport	Нисэх буудал (НБ)
APAPI†	(<i>to be pronounced "AY-PAPI"</i>) Abbreviated precision approach path indicator	("ЭЙ-ПАПИ" гэж дуудна) Товчилсон нарийвчлалтай ойртолтын зам заагч
APCH	Approach	Ойртолт
APDC. . .	Aircraft parking/docking chart (<i>followed by name/title</i>)	Агаарын хөлгийг зогсоолд тавих / хоолойд холбогдохоор зогсох зураг (<i>нэр/гарчгийг ард нь заана</i>)
APIS	Advance Passenger Information System	Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем
APN	Apron	Апрон
APP	Approach control office or approach control or approach control service	Ойртолтын удирдлагын байр, эсхүл ойртолтын удирдлага, эсхүл ойртолтын удирдлагын үйлчилгээ
APR	April	4-р сар

Товчлол	Англи	Монгол
APRX	Approximate or approximately	Ойролцоо, эсхүл ойролцоогоор
APSG	After passing	Нисэн өнгөрсний дараа
APU	Auxiliary power unit	Туслах хүчний төхөөрөмж
APV	Approach procedure with vertical guidance	Босоо чиглүүлэгчтэй ойртолтын журам
ARC	Area chart	Бүсийн зураг
ARNG	Arrange	Зохион байгуулах, зохицуулах, эрэмбэлэх
ARO	Air traffic services reporting office	НХУ-ний мэдээлэх төв
ARP	Aerodrome reference point	Аэродромын хяналтын цэг
ARP	Air-report (message type designator)	Агаарын хөлгийн мэдээ (мэдээний төрөл тодорхойлогч)
ARQ	Automatic error correction	Автоматаар алдаа засах
ARR	Arrival (message type designator)	Нисэн ирэх (мэдээний төрөл тодорхойлогч)
ARR	Arrive or arrival	Нисэн ирэх
ARS	Special air-report (message type designator)	Агаарын хөлгийн тусгай мэдээ (мэдээний төрөл тодорхойлогч)
ARST	Arresting (specify (part of) aircraft arresting equipment)	Зогсоох төхөөрөмж (агаарын хөлгийг зогсоох төхөөрөмжийг (төрлийг) тодорхойлох)
AS	Altostratus	Өндрийн давхраат бөөн үүл
ASAP	As soon as possible	Аль болох түргэн
ASC	Ascend to or ascending to	... хүртэл өндөр авах
ASDA	Accelerate-stop distance available	Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай
ASE	Altimetry system error	Алтиметрийн системийн алдаа
ASPH	Asphalt	Асфальт
AT . . .	At (followed by time at which weather change is forecast to occur)	...-д (урьдчилсан мэдээгээр цаг агаар өөрчлөгдөх цагийг ард нь заана)
ATA [‡]	Actual time of arrival	Нисэн ирсэн бодит цаг
ATC [‡]	Air traffic control (in general)	Нислэгийн хөдөлгөөний удирдлага (ерөнхий) (НХУ)
ATCSMAC. . .	Air traffic control surveillance minimum altitude chart (followed by name/title)	НХУ-ын ажиглалтын минимум өндрийн-түвшний зураг (нэр/гарчгийг ард нь заана)
ATD [‡]	Actual time of departure	Нисэн гарсан бодит цаг
ATFM	Air traffic flow management	Нислэгийн урсгал зохицуулалт
ATIS [†]	(to be pronounced "AY-TIS") Automatic terminal information service	("ЭЙ-ТИС" гэж дуудна) Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ
ATM	Air traffic management	Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт
ATN	Aeronautical telecommunication network	Нисэхийн цахилгаан холбооны сүлжээ
ATO	Approved training organization	Зөвшөөрөгдсөн сургалтын байгууллага
ATP . . .	At (followed by time or place)	...-д (цаг, эсхүл газрын нэрийг ард нь заана)

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
ATS	Air traffic services	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (НХҮ)
ATTN	Attention	Анхаар
AT-VASIS [†]	<i>(to be pronounced "AY-TEE-VASIS")</i> Abbreviated T visual approach slope indicator system	<i>("ЭЙ-ТИЙ-ВАСИС" гэж дуудна)</i> Товчилсон Т - ил харааны ойртолтын налуу заагч систем
ATZ	Aerodrome traffic zone	Аэродромын хөдөлгөөний бүс
AUG	August	8-р сар
AUTH	Authorized or authorization	Эрх бүхий, эрх
AUTO	Automatic	Автомат
AUW	All up weight	Бүх жин
AUX	Auxiliary	Туслах, нэмэлт
AVBL	Available or availability	Бэлэн байгаа, эсхүл бэлэн байдал
AVG	Average	Дундаж
AVGAS [†]	Aviation gasoline	Нисэх онгоцны бензин
AWOS	Automated weather observation system	Автоматжуулсан цаг агаарын ажиглалтын систем
AWTA	Advise at what time able	Хэдэн цагт боломжтойг зөвлөх
AWY	Airway	Агаарын зам
AZM	Azimuth	Азимут
B	Blue	Хөх
BA	Braking action	Тоормослох үйлдэл
BARO-VNAV [†]	<i>(to be pronounced "BAA-RO-VEE-NAV")</i> Barometric vertical navigation	<i>("БАА-РО-БИЙ-НАВ" гэж дуудна)</i> Барометрийн босоо тэнхлэгийн навигаци
BASE [†]	Cloud base	Үүлний суурь
BCFG	Fog patches	Хэсэг бусаг манан
BCN	Beacon <i>(aeronautical ground light)</i>	Гэрэлт дохио <i>(нисэхийн газрын гэрэл)</i>
BCST	Broadcast	Радио нэвтрүүлэг
BDRY	Boundary	Хил, бүс
BECMG	Becoming	Аажим өөрчлөлт, өөрчлөгдөх
BFR	Before	Өмнө, урьд
BKN	Broken	Эвдэрсэн, хэмхэрсэн, 3-4 октант үүлний хэмжээ
BL . . .	Blowing <i>(followed by DU = dust, SA = sand or SN = snow)</i>	Газраар шуурах <i>(DU = шороо, SA = элс, SN = цасыг ард нь заана)</i>
BLDG	Building	Барилга, байгууламж
BLO	Below clouds	Үүлнээс доош
BLW	Below	. . . аас доогуур, доош
BOMB	Bombing	Бөмбөгдөх
BR	Mist	Будан
BRF	Short <i>(used to indicate the type of approach desired or required)</i>	Богино дөт <i>(хүсэж байгаа, эсхүл шаардлагатай ойртолтын төрлийг харуулахад ашигладаг)</i>

Товчлол	Англи	Монгол
BRG	Bearing	Чиглэл
BRKG	Braking	Тоормослох, удаашруулах, зогсоох
BS	Commercial broadcasting station	Арилжааны радио нэвтрүүлгийн станц
BTL	Between layers	Давхарга хооронд
BTN	Between	Дунд, завсарт, хооронд
BUFR	Binary universal form for the representation of meteorological data	Цаг уурын өгөгдлийг илэрхийлэх Binary universal form
. . . C	Centre (<i>preceded by runway designation number to identify a parallel runway</i>)	Төв (<i>Зэрэгцээ ХБЗ-ыг ялгаж таних зорилгоор ХБЗ-ын чиглэлийн дугаарыг урд нь заана</i>)
C	Degrees Celsius (<i>Centigrade</i>)	Цельсийн хэм
CA	Course to an altitude	Өндрийн-түвшинд хүрэх курс
CAA	Civil aviation authority	Иргэний нисэхийн эрх бүхий байгууллага
CAR	Civil aviation rules	Иргэний нисэхийн дүрэм
CAT	Category	Категори (CAT)
CAT	Clear air turbulence	Тэнгэр цэлмэг үеийн сэгсрэлт
CAVOK†	(<i>to be pronounced "KAV-OH-KAY"</i>) Visibility, cloud and present weather better than prescribed values or conditions	("КАВ-ОО-КЕЙ" гэж дуудна) хараа, үүл болон бодит цаг агаар нь заасан үзүүлэлт, эсхүл нөхцөлөөс илүү сайн байх
CB‡	(<i>to be pronounced "CEE BEE"</i>) Cumulonimbus	("СИЙ-БИЙ" гэж дуудна) Борооны бөөн үүл
CC	Cirrocumulus	Сэмжин бөөн үүл
CCA	(<i>or CCB, CCC. . . etc., in sequence</i>) Corrected meteorological message (<i>message type designator</i>)	(CCB, CCC гэх мэт дараалалтай) Засварласан цаг уурын мэдээ (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
CCO	Continuous climb operations	Үргэлжлүүлэн өндөр авах үйл ажиллагаа
CD	Candela	Кандел
CDN	Coordination (<i>message type designator</i>)	Зохицуулалт, зохицуулалтын мэдээ (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
CDO	Continuous descent operations	Үргэлжлүүлэн өндөр алдах үйл ажиллагаа
CDR	Conditional route	Нөхцөлт нислэгийн зам
CF	Change frequency to . . .	Давтамжийг ... руу солино уу
CF	Course to a fix	Тухайн цэгт хүрэх курс
CFM*	Confirm or I confirm (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Ойлгосноо баталгаажуулах, эсхүл Би баталж байна (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
CGL	Circling guidance light(s)	Дагуулан эргэлдэгч гэрлүүд(үүд)
CH	Channel	Суваг
CH#	This is a channel-continuity-check of transmission to permit comparison of your record of channel-sequence numbers of	Энэ нь тухайн сувгаар хүлээн авсан мэдээний сувгийн дарааллын дугаарын бүртгэлийн харьцуулалтыг хийхэд шаардлагатай дамжуулалтын сувгийн нэвтрүүлэх чадварын

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
	messages received on the channel (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	шалгалт юм (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
CHEM	Chemical	Химийн
CHG	Modification (<i>message type designator</i>)	Өөрчлөлт (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
CI	Cirrus	Сэмжин үүл
CIDIN†	Common ICAO data interchange network	ICAO-гийн өгөгдөл солилцооны нийтлэг сүлжээ
CIV	Civil	Иргэний
CK	Check	Шалгах
CL	Centre line	Гол шугам
CLA	Clear type of ice formation	Мөстөлтийн цэвэр хэлбэр
CLBR	Calibration	Тохируулга
CLD	Cloud	Үүл
CLG	Calling	Дуудах
CLIMB-OUT	Climb-out area	Өндөр авалтын бүс
CLR	Clear(s) or cleared to . . . or clearance	Зөвшөөрөх, эсхүл ... ийг зөвшөөрсөн, эсхүл зөвшөөрөл
CLRD	Runway(s) cleared (<i>used in METAR/SPECI</i>)	ХБЗ(ууд) зөвшөөрөгдсөн (<i>METAR/SPECI-д хэрэглэдэг</i>)
CLSD	Close or closed or closing	Хаах, эсхүл хаасан, эсхүл хааж байна
CM	Centimetre	Сантиметр (см)
CMB	Climb to or climbing to	... хүртэл өндөр авах, эсхүл өндөр авч байна
CMPL	Completion or completed or complete	Гүйцэтгэсэн эсхүл гүйцэд бүрэн
CNL	Cancel or cancelled	Хүчингүй болгох, эсхүл хүчингүй болсон
CNL	Flight plan cancellation (<i>message type designator</i>)	Нислэгийн төлөвлөгөө цуцлах (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
CNS	Communications, navigation and surveillance	Холбоо, навигаци болон ажиглалт
COM	Communications	Холбоо
CONC	Concrete	Цемент, бетон
COND	Condition	Нөхцөл
CONS	Continuous	Үргэлжилсэн
CONST	Construction or constructed	Барилга, эсхүл барих, үүсгэх
CONT	Continue(s) or continued	Үргэлжлэх, эсхүл үргэлжилсэн
COOR	Coordinate or coordination	Зохицуулах, эсхүл зохицуулалт
COORD	Coordinates	Солбицлууд
COP	Change-over point	Солих цэг
COR	Correct or correction or corrected (<i>used to indicate corrected meteorological message; message type designator</i>)	Зөв, эсхүл засвар, эсхүл засварласан (<i>засварласан цаг уурын мэдээг харуулахад ашигладаг; мэдээний төрөл тодорхойлогч</i>)
CORSIA	Carbon Offsetting and Reduction Scheme for International Aviation	Олон улсын нисэхэд карбон бууруулах ба багасгах схем
COT	At the coast	Далайн эрэг дээр

Товчлол	Англи	Монгол
COV	Cover or covered or covering	Хамрах, хамарсан эсхүл хамарч байгаа
CPDLC [‡]	Controller-pilot data link communications	Нислэгийн хөдөлгөөний удирдагч - нисгэгч хоорондын холбооны data-link холбоо
CPL	Current flight plan (message type designator)	Бодит нислэгийн төлөвлөгөө (мэдээний төрөл тодорхойлогч)
CRC	Cyclic redundancy check	Циклийн үлдэгдлээр шалгах
CRM	Collision risk model	Мөргөлдөх эрсдэлийн загвар
CRP	Compulsory reporting point	Заавал мэдээлэх цэг
CRZ	Cruise	Аяллын ...
CS	Call sign	Дуудлага
CS	Cirrostratus	Сэмжин давхраат үүл
CTA	Control area	Удирдлагын бүс
CTAM	Climb to and maintain	Өндөр аваад хадгалах
CTC	Contact	Холбоо барих
CTL	Control	Удирдлага
CTN	Caution	Сэрэмжлүүлэг
CTR	Control zone	Удирдлагын зоон
CU	Cumulus	Бөөн үүл
CUF	Cumuliform	Бөөн хэлбэрийн үүл
CUST	Customs	Гааль
CVR	Cockpit voice recorder	Бүхээгийн дуу чимээ бичигч
CW	Continuous wave	Үргэлжилсэн долгион
CWY	Clearway	Саадаас чөлөөтэй талбай
D	Downward (tendency in RVR during previous 10 minutes)	Доошоо (ХБЗ-ын ил харааны зайн (RVR) өмнөх 10 минутын хандлага)
D . . .	Danger area (followed by identification)	Аюултай бүс (тэмдэглэгээг ард нь заана)
DA	Decision altitude	Шийдвэр гаргах өндрийн-түвшин
D-ATIS [†]	(to be pronounced "DEE-ATIS") Data link automatic terminal information service	("ДИЙ-АТИС" гэж дуудна) Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээний data-link
DCD	Double channel duplex	Хос сувагтай дуплексийн холбоо
DCKG	Docking	Хоолойд холбох
DCP	Datum crossing point	Өгөгдөхүүний огтлолцлын цэг
DCPC	Direct controller-pilot communications	Нислэгийн хөдөлгөөний удирдагч - нисгэгчийн шууд холбоо
DCS	Double channel simplex	Хос сувагтай симплексийн холбоо
DCT	Direct (in relation to flight plan clearances and type of approach)	Шууд (нислэгийн төлөвлөгөөний зөвшөөрөл болон ойртолтын төрөлтэй холбоотой)
DDM	Difference in depth of modulation	Модуляцийн гүний зөрүү

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
DE*	From (used to precede the call sign of the calling station) (to be used in AFS as a procedure signal)	...-аас (дуудаж байгаа станцын дуудлагын өмнө хэрэглэдэг) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
DEC	December	12-р сар
DEG	Degrees	Градус
DEP	Depart or departure	Нисэн гарах эсхүл нисэн гаралт
DEP	Departure (message type designator)	Нисэн гарах (мэдээний төрөл тодорхойлогч)
DEPO	Deposition	Байрлал
DER	Departure end of the runway	ХБЗ-ын төгсгөлөөр нисэн гарах
DES	Descend to or descending to	...хүртэл өндөр алдах эсхүл өндөр алдаж байна
DEST	Destination	Хүрэх газар
DETRESFA†	Distress phase	Аюулын үе
DEV	Deviation or deviating	Хазайлт, эсхүл хазайсан
DF	Direction-finding	Чиглэл-ологч
DFDR	Digital flight data recorder	Тоон нислэгийн өгөгдөл бичигч
DFTI	Distance from touchdown indicator	Газардах цэгийн заагч хүртэлх зай
DH	Decision height	Шийдвэр гаргах өндөр
DIF	Diffuse	Манан сарниулах
DIST	Distance	Зай (урт)
DIV	Divert or diverting	Чиглэлээсээ хазайх, холдох
DLA	Delay or delayed	Хойшлох, саатал, эсхүл хойшилсон, саатсан
DLA	Delay (message type designator)	Хойшлогдсон, саатсан (мэдээний төрөл тодорхойлогч)
DLIC	Data link initiation capability	Data-link-ийн эхлүүлэх чадамж
DLY	Daily	Өдөр бүр
DME‡	Distance measuring equipment	Зай хэмжих төхөөрөмж
DNG	Danger or dangerous	Аюул, эсхүл аюултай
DOF	Date of flight	Нислэгийн огноо
DOM	Domestic	Орон нутгийн
DP	Dew point temperature	Шүүдэр буух температур
DPT	Depth	Гүн
DR	Dead reckoning	Байгаа өгөгдлөөр тооцоолох навигацийн аргачлал
DR . . .	Low drifting (followed by DU = dust, SA = sand or SN = snow)	хунгарлах (DU = шороо, SA=элс, эсхүл SN=цасыг ард нь заана)
DRG	During	... хугацаанд
DS	Duststorm	Шороон шуурга
DSB	Double sideband	Хоёр хажуугийн зурвас
DTAM	Descend to and maintain	... хүртэл өндөр алдах ба хадгалах
DTG	Date-time group	Огноо - цагийн бичилт
DTHR	Displaced runway threshold	ХБЗ-ын шилжүүлсэн босго

Товчлол	Англи	Монгол
DTRT	Deteriorate or deteriorating	Муудах, эсхүл муудаж байгаа
DTW	Dual tandem wheels	Хос зэрэгцээ дугуй
DU	Dust	Шороо
DUC	Dense upper cloud	Дээд давхаргын нягт үүлс
DUPE#	This is a duplicate message (to be used in AFS as a procedure signal)	Энэ нь давтагдсан мэдээ болно (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
DUR	Duration	Үргэлжлэх хугацаа
D-VOLMET	Data link VOLMET	VOLMET data-link
DVOR	Doppler VOR	Допплерын бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч
DW	Dual wheels	Зэрэгцээ дугуй, хос дугуйтай
DZ	Drizzle	Шиврээ бороо
E	East or eastern longitude	Зүүн, зүүн уртраг
EAT	Expected approach time	Ойртолтын баримжаат цаг
EB	Eastbound	Зүүн зүг
EDA	Elevation differential area	Өндөрлөгийн ялгаатай бүс
EDTO	Extended diversion time operations	Даялах хугацаа сунгасан нислэгийн үйл ажиллагаа
EEE#	Error (to be used in AFS as a procedure signal)	Алдаа (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
EET	Estimated elapsed time	Тооцоот өнгөрөлтийн цаг
EFB	Electronic flight bag	EFB (Нислэгийн цахим цүнх)
EFC	Expect further clearance	Цаашдын зөвшөөрөл хүлээ
EFIS [†]	(to be pronounced "EE-FIS") Electronic flight instrument system	("ИИ-ФИС" гэж дуудна) Электроник нислэгийн хэрэглэлийн систем
EGNOS [†]	(to be pronounced "EGG-NOS") European geostationary navigation overlay service	("ИГ-НОС" гэж дуудна) Европын геостационарын навигацийн бүрхэлттэй үйлчилгээ
EHF	Extremely high frequency [30 000 to 300 000 MHz]	Хэтэрхий өндөр давтамж (30 000-300 000 МГц)
ELBA [†]	Emergency location beacon - aircraft	Агаарын хөлгийн ослын байрлал дохиологч
ELEV	Elevation	Өндөрлөг
ELR	Extra long range	Маш холын зай
ELT	Emergency locator transmitter	Ослын байрлал дамжуулагч
EM	Emission	Ялгаруулах
EMBD	Embedded in a layer (to indicate cumulonimbus embedded in layers of other clouds)	Давхаргад нэвтэрсэн (бусад үүлний давхаргуудад нэвтэрсэн бөөн үүлийг заана)
EMERG	Emergency	Онцгой нөхцөл, осол

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
END	Stop-end (<i>related to RVR</i>)	Зогсох төгсгөл (ХБЗ-ын ил харааны зайтай холбоотой)
ENE	East-north-east	Зүүн-зүүн хойд
ENG	Engine	Хөдөлгүүр
ENR	En-route	Нислэгийн замын
ENRC. . .	En-route chart (<i>followed by name/title</i>)	Нислэгийн замын зураг (<i>нэр/гарчгийг ард нь заана</i>)
EOBT	Estimated off-block time	Нислэг эхлэх тооцоот цаг
EQN	Equatorial latitudes northern hemisphere	Экваторын өргөргийн хойд хагас бөмбөрцөг
EQPT	Equipment	Төхөөрөмж
EQS	Equatorial latitudes southern hemisphere	Экваторын өргөргийн урд хагас бөмбөрцөг
ESE	East-south-east	Зүүн - өмнөд - зүүн
EST	Estimate <i>or</i> estimated <i>or</i> estimation (<i>message type designator</i>)	Тооцоолох эсхүл тооцоолсон эсхүл тооцоо (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
ETA*‡	Estimated time of arrival <i>or</i> estimating arrival	Тооцоот нисэн ирэх, эсхүл тооцоолж байгаа нисэн ирэх цаг
ETD‡	Estimated time of departure <i>or</i> estimating departure	Тооцоот нисэн гарах, эсхүл тооцоолж байгаа нисэн гарах цаг
ETO	Estimated time over significant point	Тодорхой цэгийг нисэн өнгөрөх тооцоот цаг
EUR RODEX	European regional OPMET data exchange	Европын бүсийн OPMET-ийн өгөгдөл солилцоо
EV	Every	Бүр, болгон, тутам
EVS	Enhanced vision system	Сайжруулсан дүрслэлийн систем
EXC	Except	-аас гадна
EXER	Exercises <i>or</i> exercising <i>or</i> to exercise	Сургуулилалт эсхүл сургуулилт хийж байгаа эсхүл сургуулилалт хийх
EXP	Expect <i>or</i> expected <i>or</i> expecting	Баримжаат, эсхүл баримжаалсан, баримжаалж байгаа
EXTD	Extend <i>or</i> extending <i>or</i> extended	Сунгах, уртасгах эсхүл сунгаж, уртасгаж байна эсхүл сунгасан, уртатгасан
F	Fixed	Байнгын, суурин
FA	Course from a fix to an altitude	Цэгээс тухайн өндрийн-түвшинд хүрэх курс
FAC	Facilities	Байгууламж
FAF	Final approach fix	Ойртолтын төгсгөлийн сегментийн цэг
FAL	Facilitation of international air transport	Олон улсын агаарын тээврийг хялбаршуулах
FAP	Final approach point	Ойртолтын төгсгөлийн сегментийн цэг
FAS	Final approach segment	Ойртолтын төгсгөлийн сегмент
FATO	Final approach and take-off area	Ойртолтын төгсгөлийн болон хөөрөлтийн талбай
FAX	Facsimile transmission	Факсаар дамжуулах
FBL	Light (<i>used to indicate the intensity of weather phenomena, interference or static reports, e.g. FBL RA = light rain</i>)	Сул, зөөлөн (<i>цаг агаарын аюултай үзэгдлийн хүч, хоорондын нөлөө, эсхүл статик мэдээг харуулахад ашигладаг, ж-нь: FBL RA = зөөлөн бороо</i>)

Товчлол	Англи	Монгол
FC	Funnel cloud (<i>tornado or waterspout</i>)	Юүлүүр хэлбэрийн үүл (торнадо, эсхүл усан шамарга)
FCST	Forecast	Урьдчилсан мэдээ
FCT	Friction coefficient	Үрэлтийн коэффициент
FDPS	Flight data processing system	Нислэгийн өгөгдөл боловсруулах систем
FEB	February	2-р саа
FEW	Few	Цөөн
FG	Fog	Манан
FIC	Flight information centre	Нислэгийн мэдээллийн төв
FIR [‡]	Flight information region	Нислэгийн мэдээллийн бүс
FIS	Flight information service	Нислэгийн мэдээллийн үйлчилгээ
FISA	Automated flight information service	Автоматжуулсан нислэгийн мэдээллийн үйлчилгээ
FL	Flight level	Нислэгийн түвшин
FLD	Field	Талбай, салбар
FLG	Flashing	Анивчих, гялс хийх
FLR	Flares	Хурц гэрэл, гялбаа
FLT	Flight	Нислэг, аялал
FLTCK	Flight check	Шалгах нислэг
FLUC	Fluctuating or fluctuation or fluctuated	Савлах, эсхүл савлагаа, эсхүл савласан
FLW	Follow(s) or following	Дараах, дагах, эсхүл дагаж байгаа
FLY	Fly or flying	Нисэх, эсхүл нисэж байгаа
FM	Course from a fix to manual termination (<i>used in navigation database coding</i>)	Тухайн цэгээс гар удирдлагаар зогсоох хүртэлх курс (<i>навигацийн өгөгдлийн санг кодлоход хэрэглэдэг</i>)
FM	From	-аас
FM . . .	From (<i>followed by time at which weather change is forecast to begin</i>)	-аас (<i>урьдчилсан мэдээгээр цаг агаарын өөрчлөлт эхлэх цагийг ард нь заана</i>)
FMC	Flight management computer	Нислэгийн удирдлагын компьютер
FMS [‡]	Flight management system	Нислэгийн удирдлагын систем
FMU	Flow management unit	Урсгал зохицуулалтын нэгж
FNA	Final approach	Ойртолтын төгсгөл
FPAP	Flight path alignment point	Нислэгийн зам шилжих цэг
FPL	Flight plan	Нислэгийн төлөвлөгөө
FPM	Feet per minute	Фут/минут
FPR	Flight plan route	Нислэгийн төлөвлөгөөний дагуух зам
FR	Fuel remaining	Үлдэгдэл түлш
FREQ	Frequency	Давтамж

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
FRI	Friday	Баасан гариг
FRNG	Firing	Буудах, буудлага
FRONT†	Front (<i>relating to weather</i>)	Фронт (<i>цаг агаартай холбоотой</i>)
FROST†	Frost (<i>used in aerodrome warnings</i>)	Цан хяруу (аэродромын анхааруулгад хэрэглэдэг)
FRQ	Frequent	Тогтмол, байнгын
FSL	Full stop landing	Бүрэн зогсолттой буулт
FSS	Flight service station	Нислэгийн үйлчилгээний төв
FST	First	Эхний, анхны, нэгдүгээр
FT	Feet (<i>dimensional unit</i>)	Фут (<i>хэмжих нэгж</i>)
FTE	Flight technical error	Нислэг техникийн алдаа
FTP	Fictitious threshold point	Зохиомол босгын цэг
FTT	Flight technical tolerance	Нислэг техникийн зөвшөөрөгдөх хэмжээ
FU	Smoke	Утаа
FZ	Freezing	Хүйтэн
FZDZ	Freezing drizzle	Хүйтэн шиврээ бороо
FZFG	Freezing fog	Хүйтэн манан
FZRA	Freezing rain	Хүйтэн бороо
G	Green	Ногоон
G . . .	Variations from the mean wind speed (gusts) (<i>followed by figures in METAR/SPECI and TAF</i>)	Салхины дундаж хурдны зөрүү (<i>өрөвхийлөлт</i>) (<i>METAR/SPECI ба TAF-д тоон утгыг ард нь заана</i>)
G/A	Ground-to-air	Газар - агаар
G/A/G	Ground-to-air and air-to-ground	Газар - агаар болон агаар - газар
GA	General aviation	Ерөнхий зориулалтын нисэх
GA	Go ahead, resume sending (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Та үргэлжлүүлнэ үү, явуулж эхэлж болно (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
GAGAN†	GPS and geostationary earth orbit augmented navigation	GPS болон геостационарын дэлхийн тойрог замын өндөр нарийвчлалтай навигаци
GAIN	Airspeed or head-wind gain	Хурд, эсхүл угтах салхи нэмэгдэх
GAMET	Area forecast for low-level flights	Нам түвшний нислэгт зориулсан бүсийн цаг агаарын урьдчилсан мэдээ
GARP	GBAS azimuth reference point	GBAS азимутын хяналтын цэг
GBAS†	(<i>to be pronounced "GEE-BAS"</i>) Ground-based augmentation system	(<i>"ЖЕЕ-БАСС"</i> гэж дуудна) Газарт суурилуулсан нарийвчлалыг өсгөх систем
GCA‡	Ground controlled approach system or ground controlled approach	Газрын хяналттай ойртолтын систем, эсхүл газрын хяналттай ойртолт
GEN	General	Ерөнхий
GEO	Geographic or true	Газар зүйн, эсхүл жинхэнэ
GES	Ground earth station	Хиймэл дагуулын газрын станц
GLD	Glider	Глайдер

Товчлол	Англи	Монгол
GLONASS [†]	(<i>to be pronounced "GLO-NAS"</i>) Global navigation satellite system	("ГЛО-НААС" гэж дуудна) Глобал навигацийн хиймэл дагуулын систем (ОХУ)
GLS [‡]	GBAS landing system	GBAS буулт үйлдэх систем
GMC . . .	Ground movement chart (<i>followed by name/title</i>)	Газрын хөдөлгөөний зураг (<i>нэр/гарчгийг ард нь заана</i>)
GND	Ground	Газар
GNDCK	Ground check	Газрын шалгалт
GNSS [‡]	Global navigation satellite system	Глобал навигацийн хиймэл дагуулын систем
GOV	Government	Засгийн газар
GP	Glide path	Глиссад
GPA	Glide path angle	Глиссадын өнцөг
GPIP	Glide path intercept point	Глиссадтай огтлолцох цэг
GPS [‡]	Global positioning system	Глобал байршил тогтоох систем
GPU	Ground power unit	Газрын цахилгаан тэжээл
GPWS [‡]	Ground proximity warning system	Газарт ойртсоныг анхааруулах систем
GR	Hail	Мөндөр
GRAS [†]	(<i>to be pronounced "GRASS"</i>) Ground-based regional augmentation system	("ГРАСС" гэж дуудна) Газар суурилуулсан бүсийн нарийвчлалыг өсгөх систем
GRASS	Grass landing area	Буултын зүлгэн талбай
GRIB	Processed meteorological data in the form of grid point values expressed in binary form (<i>in meteorological code</i>)	Binary form-аар илэрхийлдэг торны огтлолцлын цэгийн утга хэлбэртэй боловсруулсан цаг уурын өгөгдөл (цаг уурын кодоор)
GRVL	Gravel	Хайрга, шороо
GS	Ground speed	Газрын хурд
GS	Small hail and/or snow pellets	Жижиг мөндөр ба/эсхүл цасан туйлаадас
GUND	Geoid undulation	Геоидийн долгион
H	High pressure area <i>or</i> the centre of high pressure	Өндөр даралтын бүс эсхүл өндөр даралтын төв
H . . .	Significant wave height (<i>followed by figures in METAR/SPECI</i>)	Нөлөөлөх давлагааны өндөр (METAR/SPECI-д тоон утгыг ард нь заана)
H24	Continuous day and night service	24 цагийн үйлчилгээ
HA	Holding/racetrack to an altitude	Өндрийн-түвшинд хүрэх хүлээх/тойрог нислэгийн зам
HAPI	Helicopter approach path indicator	Нисдэг тэрэгний ойртолтын зам заагч
HBN	Hazard beacon	Аюулын гэрэлт дохио
HCH	Heliport crossing height	Хэлипортыг огтлох өндөр
HDF	High frequency direction-finding station	Өндөр давтамжийн чиглэл-ологч станц
HDG	Heading	Чиглэл (агаарын хөлгийн чиглэл)

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
HEL	Helicopter	Нисдэг тэрэг
HF	Holding/racetrack to a fix	Тухайн цэгт хүрэх хүлээх/тойрог нислэгийн зам
HF [‡]	High frequency [3 000 to 30 000 kHz]	Өндөр давтамж (3 000-30 000 кГц)
HGT	Height or height above	Өндөр, эсхүл ... дээших өндөр
HJ	Sunrise to sunset	Нар мандахаас нар жаргах хүртэл
HLDG	Holding	Хүлээх нислэг
HLP	Heliport	Хэлипорт
HLS	Helicopter landing site	Нисдэг тэрэг буух талбай
HM	Holding/racetrack to a manual termination	Гар удирдлагаар зогсоох хүлээх/тойрог нислэгийн зам
HN	Sunset to sunrise	Нар жаргахаас нар мандах хүртэл
HNH	High latitudes northern hemisphere	Хойд хагас бөмбөрцгийн хойд өргөрөг
HO	Service available to meet operational requirements	Үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн үзүүлэх үйлчилгээ
HOL	Holiday	Амралтын өдөр
HOSP	Hospital aircraft	Эмнэлгийн агаарын хөлөг
HPA	Hectopascal	Гектопаскаль
HR	Hours	Цаг
HRP	Heliport reference point	Хэлипортын хяналтын цэг
HS	Service available during hours of scheduled operations	Хуваарьт ажлын цагаар үзүүлэх үйлчилгээ
HSH	High latitudes southern hemisphere	Урд хагас бөмбөрцгийн урд өргөрөг
HUD	Head-up display	Head-up дэлгэц
HUM	Humanitarian	Хүмүүнлэгийн
HURCN	Hurricane	Далайн хар салхи
HVDF	High and very high frequency direction-finding stations (at the same location)	Өндөр болон хэт өндөр давтамжийн чиглэл-ологч станц (ижил байрлалд байгаа)
HVY	Heavy	Хүнд
HVY	Heavy (used to indicate the intensity of weather phenomena, e.g. HVY RA = heavy rain)	Ширүүн (цаг агаарын аюултай үзэгдлийн хүчийг харуулахад ашигладаг, ж-нь: HVY RA = ширүүн бороо гэх мэт)
HX	No specific working hours	Тогтоосон ажлын цаггүй
HYR	Higher	Илүү өндөрт
HZ	Haze	Униар
HZ	Hertz (cycle per second)	Герц (цикл / секунд)
IAC . . .	Instrument approach chart (followed by name/title)	Хэрэглэлийн ойртолтын зураг (нэр/гарчгийг ард нь заана)
IAF	Initial approach fix	Ойртолтын эхлэлийн цэг
IAO	In and out of clouds	Үүлэнд орох, гарах
IAP	Instrument approach procedure	Хэрэглэлийн ойртолтын журам
iAPI	Interactive API	Интерактив зорчигчийн урьдчилсан мэдээлэл

Товчлол	Англи	Монгол
IAR	Intersection of air routes	Агаарын замын огтлолцол
IAS	Indicated airspeed	Хэрэглэлийн хурд
IBN	Identification beacon	Ялгах гэрэлт дохио
ICAO	International Civil Aviation Organization	Олон улсын иргэний нисэхийн байгууллага
ICE	Icing	Мөстөлт
ID	Identifier or identify	Таних тэмдэг эсхүл таних
IDENT [†]	Identification	Дуудлага, таних тэмдэг
IF	Intermediate approach fix	Ойртолтын дундын цэг
IFF	Identification friend/foe	Өөрийн тал/дайсныг ялгах таних тэмдэг
IFR [‡]	Instrument flight rules	Хэрэглэлийн нислэгийн дүрэм
IGA	International general aviation	Олон улсын ерөнхий зориулалтын нисэх
ILS [‡]	Instrument landing system	Хэрэглэлээр буулт үйлдэх систем
IM	Inner marker	Ойрын маркер
IMC [‡]	Instrument meteorological conditions	Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл
IMG	Immigration	Цагаачлал
IMI*	Interrogation sign (question mark) (to be used in AFS as a procedure signal)	Асуултын тэмдэг (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
IMPR	Improve or improving	Сайжрах, эсхүл сайжирч байгаа
IMT	Immediate or immediately	Яаралтай
INA	Initial approach	Ойртолтын эхлэл
INBD	Inbound	Орох, ирэх
INC	In cloud	Үүлэн дотор
INCERFA [†]	Uncertainty phase	Тодорхой бус үе
INCORP	Incorporated	Хэрэгжүүлсэн
INFO [†]	Information	Мэдээлэл
INOP	Inoperative	Ажиллагаагүй
INP	If not possible	Хэрвээ боломжгүй бол
INPR	In progress	Гүйцэтгэж байгаа
INS	Inertial navigation system	Инерцийн навигацийн систем
INSTL	Install or installed or installation	Суурилуулах эсхүл суурилуулсан эсхүл суурилуулалт
INSTR	Instrument	Хэрэглэл
INT	Intersection	Огтлолцол, уулзвар
INTL	International	Олон улсын
INTRG	Interrogator	Интегратор
INTRP	Interrupt or interruption or interrupted	Тасалдуулах, эсхүл тасалдал, эсхүл тасалдсан
INTSF	Intensify or intensifying	Ихэсгэх, эсхүл ихэсгэж байгаа

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
INTST	Intensity	Эрчим, тодорц
IR	Ice on runway	ХБЗ дээрх мөс
IRS	Inertial reference system	Инерцийн хяналтын систем
ISA	International standard atmosphere	Олон улсын стандарт атмосфер
ISB	Independent sideband	Үл хамаарах хажуугийн зурвас
ISOL	Isolated	Тусгаарлагдсан
JAN	January	1-р сар
JTST	Jet stream	Олгойдох урсгал
JUL	July	7-р сар
JUN	June	6-р сар
KG	Kilograms	Килограмм (кг)
KHZ	Kilohertz	Килогерц (кГц)
KIAS	Knots indicated airspeed	Кнотоор илэрхийлдэг хурд
KM	Kilometres	Километр (км)
KMH	Kilometres per hour	Километр/цаг (км/ц)
KPA	Kilopascal	Килопаскаль (кПа)
KT	Knots	Кнот (далайн милээр илэрхийлдэг хурд)
KW	Kilowatts	Киловатт (кВт)
...L	Left (<i>preceded by runway designation number to identify a parallel runway</i>)	Зүүн (<i>Зэрэгцээ ХБЗ-ыг ялгаж таних зорилгоор ХБЗ-ын чиглэлийн дугаарыг урд нь заана</i>)
L	Litre	Литр
L	Locator	Байрлал заагч
L	Low pressure area or the centre of low pressure	Бага даралтын бүсийн төв
LAM	Logical acknowledgement (<i>message type designator</i>)	Мэдээ хүлээж авсныг батлах (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
LAN	Inland	Дотор
LAT	Latitude	Өргөрөг
LCA	Local or locally or location or located	Орон нутгийн, эсхүл орон нутгийн хэмжээнд, эсхүл байрлал, эсхүл байрласан
LDA	Landing distance available	Буултын боломжит зай
LDAN	Landing distance available, helicopter	Нисдэг тэрэгний буултын боломжит зай
LDG	Landing	Буулт
LDI	Landing direction indicator	Буултын чиглэл заагч
LEN	Length	Урт
LF	Low frequency [30 to 300 kHz]	Нам давтамж (30-300 кГц)
LGT	Light or lighting	Гэрэл, эсхүл гэрэлтүүлэг
LGTD	Lighted	Гэрэлтэй
LIH	Light intensity high	Өндөр тодорцтой гэрэл
LIL	Light intensity low	Бага тодорцтой гэрэл

Товчлол	Англи	Монгол
LIM	Light intensity medium	Дунд тодорцтой гэрэл
LINE	Line (<i>used in SIGMET</i>)	Бүс, зурвас (SIGMET-д хэрэглэдэг)
LM	Locator, middle	Дундын байрлал заагч /локатор/
LMT	Local mean time	Орон нутгийн дундаж цаг
LNAV†	(<i>to be pronounced "EL-NAV"</i>) Lateral navigation	("ЭЛ-НАВ" гэж дуудна) Хэвтээ тэнхлэгийн навигаци
LNG	Long (<i>used to indicate the type of approach desired or required</i>)	Холын (хүсэж байгаа, эсхүл шаардсан ойртолтын төрлийг харуулахад ашигладаг)
LO	Locator, outer	Холын байрлал заагч /локатор/
LOC	Localizer	Локалайзер
LONG	Longitude	Уртраг
LORAN†	LORAN (<i>long range air navigation system</i>)	Лоран (<i>Холын зайн агаарын навигацийн систем</i>)
LOSS	Airspeed or head-wind loss	Хурд, эсхүл угтах салхи багасах
LPV	Localizer performance with vertical guidance	Босоо чиглүүлэгчтэй локалайзерын үзүүлэлт
LR	Last message received by me was . . . (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Миний хүлээн авсан сүүлийн мэдээ бол . . . (AFS-д <i>процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
LRG	Long range	Холын зай
LS	Last message sent by me was . . . or Last message was . . . (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Миний явуулсан сүүлийн мэдээ бол . . . (AFS-д <i>процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
LTA	Lower control area	Доод агаарын зайн удирдлагын бүс
LTD	Limited	Хязгаарласан
LTP	Landing threshold point	Буултын босгын цэг
LV	Light and variable (<i>relating to wind</i>)	Зөөлөн бөгөөд тогтмол биш (<i>салхитай холбоотой</i>)
LVE	Leave or leaving	Орхин явах эсхүл орхин явж байгаа
LVL	Level	Түвшин
LVP	Low-visibility procedures	Хараа бага үед ашиглах журам
LYR	Layer or layered	Давхарга, эсхүл давхаргатай
. . . M	Metres (<i>preceded by figures</i>)	Метр (<i>тоон утгыг урд нь заана</i>)
M . . .	Mach number (<i>followed by figures</i>)	Mach-тоо (<i>тоон утгыг ард нь заана</i>)
M . . .	Minimum value of runway visual range (<i>followed by figures in METAR/SPECI</i>)	ХБЗ-ын ил харааны зайн минимум утга (<i>MET/SPEC-д тоон утгыг ард нь заана</i>)
MAA	Maximum authorized altitude	Зөвшөөрөгдсөн максимум өндрийн-түвшин
MAG	Magnetic	Соронзон
MAHF	Missed approach holding fix	Ойртолтоос 2-т гарах хүлээх цэг
MAINT	Maintenance	Техник үйлчилгээ

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
MAP	Aeronautical maps and charts	Нислэгийн газрын зураг ба зургууд
MAPT	Missed approach point	Ойртолтоос 2-т гарах цэг
MAR	At sea	Далайд
MAR	March	3-р сар
MATF	Missed approach turning fix	Ойртолтоос 2-т гарах эргэлтийн цэг
MATZ	Military aerodrome traffic zone	Цэргийн аэродромын хөдөлгөөний бүс
MAX	Maximum	Максимум
MAY	May	5-р сар
MB ST	Microburst	Микротэсрэлт
MCA	Minimum crossing altitude	Огтлолцох минимум өндрийн-түвшин
MCTR	Military control zone	Цэргийн удирдлагын бүс
MCW	Modulated continuous wave	Модуляцлагдсан үргэлжилсэн долгион
MDA	Minimum descent altitude	Өндөр алдах минимум өндрийн-түвшин
MDF	Medium frequency direction-finding station	Дунд давтамжийн чиглэл-ологч станц
MDH	Minimum descent height	Өндөр алдах минимум өндөр
MEA	Minimum en-route altitude	Нислэгийн замын минимум өндрийн-түвшин
MEDEVAC	Medical evacuation flight	Эмнэлгийн тусламжийн нислэг
MEHT	Minimum eye height over threshold <i>(for visual approach slope indicator systems)</i>	Босго давах нүдээр баримжаалсан минимум өндөр <i>(Ил харааны ойртолтын налуу заагч системийн хувьд)</i>
MET REPORT	Local routine meteorological report <i>(in abbreviated plain language)</i>	Орон нутгийн цаг уурын бодит мэдээ <i>(товчилсон энгийн үгээр)</i>
MET†	Meteorological or meteorology	Цаг уурын, эсхүл цаг уур
METAR†	Aerodrome routine meteorological report <i>(in meteorological code)</i>	Аэродромын цаг уурын бодит мэдээ <i>(цаг уурын кодоор)</i>
MF	Medium frequency [300 to 3 000 kHz]	Дунд давтамж (300-3 000 кГц)
MHA	Minimum holding altitude	Хүлээлтийн минимум өндрийн-түвшин
MHDF	Medium and high frequency direction-finding stations <i>(at the same location)</i>	Дунд болон өндөр давтамжийн чиглэл-ологч станц <i>(ижил байрлалд байгаа)</i>
MHVDF	Medium, high and very high frequency direction-finding stations <i>(at the same location)</i>	Дунд, өндөр болон хэт өндөр давтамжийн чиглэл-ологч станц <i>(ижил байрлалд байгаа)</i>
MHZ	Megahertz	Мегагерц (МГц)
MID	Mid-point <i>(related to RVR)</i>	Дундын-цэг (ХБЗ-ын ил харааны зайтай холбоотой)
MIFG	Shallow fog	Нимгэн манан
MIL	Military	Цэргийн
MIN*	Minutes	Минут
MIS	Missing . . . <i>(transmission identification) (to be used in AFS as a procedure signal)</i>	Алдагдаж байна . . . <i>(дамжуулалтын таних тэмдэг) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)</i>
MKR	Marker radio beacon	Маркерийн радио дохиологч
MLS‡	Microwave landing system	Хэт богино долгионы буултын систем

Товчлол	Англи	Монгол
MM	Middle marker	Дундын маркер
MNH	Middle latitudes northern hemisphere	Хойд хагас бөмбөрцгийн дунд өргөрөг
MNM	Minimum	Минимум
MNPS	Minimum navigation performance specifications	Навигацийн минимум үзүүлэлтийн тодорхойлолт
MNT	Monitor or monitoring or monitored	Хянах, эсхүл хянаж байгаа, эсхүл хяналттай
MNTN	Maintain	Хадгалах
MOA	Military operating area	Цэргийн үйл ажиллагааны бүс
MOC	Minimum obstacle clearance (required)	Саадыг давах минимум зай (шаардлагатай)
MOCA	Minimum obstacle clearance altitude	Саадыг давах минимум өндрийн-түвшин
MOD	Moderate (used to indicate the intensity of weather phenomena, interference or static reports, e.g. MODRA = moderate rain)	Зөөлөн, эсхүл тогтвортой (цаг агаарын аюултай үзэгдлийн хүч хоорондын нөлөө, эсхүл статик мэдээг харуулахад ашигладаг, ж-нь: MOD RA = Зөөлөн бороо)
MON	Above mountains	Уулсын дээгүүр
MON	Monday	Даваа гариг
MOPS [†]	Minimum operational performance standards	Үйл ажиллагааны үзүүлэлтийн минимум стандарт
MOV	Move or moving or movement	Хөдлөх эсхүл хөдөлгөөнт эсхүл хөдөлгөөн
MPS	Metres per second	Метр/секунд
MRA	Minimum reception altitude	Дохио хүлээж авах минимум өндрийн-түвшин
MRG	Medium range	Дундын зай
MRP	ATS/MET reporting point	ATS/MET мэдээлэх цэг
MS	Minus	Хасах
MSA	Minimum sector altitude	Секторын минимум өндрийн-түвшин
MSAS [†]	(to be pronounced "EM-SAS") Multifunctional transport satellite (MTSAT) satellite-based augmentation system	("ЭЭМ-САС" гэж дуудна) Олон үйлдэлт тээврийн хиймэл дагуулд (MSAT) суурилсан нарийвчлалыг өсгөх систем
MSAW	Minimum safe altitude warning	Минимум аюулгүй өндрийн-түвшнийг анхааруулах
MSG	Message	Мэдээ
MSH	Middle latitudes southern hemisphere	Урд хагас бөмбөрцгийн дунд өргөрөг
MSL	Mean sea level	Далайн дундаж түвшин
MSR#	Message . . . (transmission identification) has been misrouted (to be used in AFS as a procedure signal)	Мэдээ ... (дамжуулалтын таних тэмдэг) буруу чиглэлд дамжуулсан (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
MSSR	Monopulse secondary surveillance radar	Моноимпульсийн ажиглалтын хоёрдогч радар
MT	Mountain	Уул
MTOM	Maximum take-off mass	Максимум хөөрөлтийн масс
MTU	Metric units	Метрийн хэмжих нэгж

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
MTW	Mountain waves	Уулын долгион
MVDF	Medium and very high frequency direction-finding stations <i>(at the same location)</i>	Дунд болон хэт өндөр давтамжийн чиглэл-ологч станц <i>(ижил байрлалд байгаа)</i>
MWO	Meteorological watch office	Цаг уурын ажиглалтын алба
MX	Mixed type of ice formation <i>(white and clear)</i>	Мөстөлтийн холимог төрөл <i>(цагаан ба тунгалаг)</i>
N	No distinct tendency <i>(in RVR during previous 10 minutes)</i>	Тодорхой хандлагагүй <i>(өмнөх 10 минутын ХБЗ-ын ил харааны зай)</i>
N	North or northern latitude	Хойд, эсхүл хойд өргөрөг
NADP	Noise abatement departure procedure	Дуу намсган нисэн гарах журам
NASC†	National AIS system centre	Үндэсний НМҮ-ний системийн төв
NAT	North Atlantic	Хойд Атлантын
NAV	Navigation	Навигаци
NAVAID	Navigation aid	Навигацийн туслах хэрэгсэл
NB	Northbound	Хойд зүг
NBFR	Not before	...-аас өмнө биш
NC	No change	Өөрчлөлтгүй
NCD	No cloud detected <i>(used in automated METAR/SPECI)</i>	Мэдэгдэх үүлгүй <i>(автомат METAR/SPECI-д хэрэглэдэг)</i>
NDB‡	Non-directional radio beacon	Чиглүүлэгчгүй радио дохиологч
NDV	No directional variations available <i>(used in automated METAR/SPECI)</i>	Чиглүүлэгчийг өөрчлөх боломжгүй <i>(автомат METAR/SPECI-д хэрэглэдэг)</i>
NE	North-east	Зүүн хойд
NEB	North-eastbound	Зүүн хойд зүг
NEG	No or negative or permission not granted or that is not correct	Үгүй, эсхүл зөвшөөрөхгүй, эсхүл зөвшөөрөл олгоогүй, эсхүл буруу
NGT	Night	Шөнө
NIL*†	None or I have nothing to send to you	Байхгүй, эсхүл Надад танд өгөх мэдээ байхгүй
NM	Nautical miles	Далайн миль
NML	Normal	Хэвийн
NN	No name, unnamed	Нэргүй, нэрлэгдээгүй
NNE	North-north-east	Хойд - зүүн хойд
NNW	North-north-west	Хойд - баруун хойд
NO	No (negative) <i>(to be used in AFS as a procedure signal)</i>	Үгүй <i>(зөвшөөрөхгүй) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)</i>
NOF	International NOTAM office	Олон улсын NOTAM-ын төв
NONSTD	Non-standard	Стандарт бус
NOSIG†	No significant change <i>(used in trend-type landing forecasts)</i>	Нөлөөлөхүйц өөрчлөлт байхгүй <i>(буултын trend-type цаг уурын урьдчилсан мэдээнд хэрэглэдэг)</i>
NOTAMC	Cancelling NOTAM	Цуцалж байгаа NOTAM
NOTAMN	New NOTAM	Шинэ NOTAM

Товчлол	Англи	Монгол
NOTAMR	Replacing NOTAM	Сольж байгаа NOTAM
NOV	November	11-р сар
NOZ‡	Normal operating zone	Хэвийн үйл ажиллагаатай бүс
NPA	Non-precision approach	Нарийвчлалтай бус ойртолт
NR	Number	Дугаар, эсхүл тоо
NRH	No reply heard	Ямар ч хариулт сонсоогүй
NS	Nimbostratus	Борооны давхраат үүл
NSC	Nil significant cloud	Онцлох үүлгүй
NSE	Navigation system error	Навигацийн системийн алдаа
NSW	Nil significant weather	Цаг агаарын онцгой үзэгдэлгүй
NTL	National	Үндэсний
NTZ‡	No transgression zone	Хязгаарлагдсан завсрын бүс
NW	North-west	Баруун хойд
NWB	North-westbound	Баруун хойд зүг
NXT	Next	Дараагийн
O/R	On request	Хүсэлтээр/ захиалгаар
OAC	Oceanic area control centre	Далайн бүсийн удирдлагын төв
OAS	Obstacle assessment surface	Саадын үнэлгээний гадаргуу
OBS	Observe or observed or observation	Ажиглах, эсхүл ажиглалттай, эсхүл ажиглалт
OBSC	Obscure or obscured or obscuring	Бүдэг, эсхүл бүдгэрсэн, эсхүл бүдгэрч байгаа
OBST	Obstacle	Саад
OCA	Obstacle clearance altitude	Саадыг давах өндрийн-түвшин
OCA	Oceanic control area	Далайн удирдлагын бүс
OCC	Occulting (<i>light</i>)	Бүдгэрч анивчдаг (<i>гэрэл</i>)
OCH	Obstacle clearance height	Саадыг давах өндөр
OCNL	Occasional or occasionally	Хааяа, эсхүл заримдаа
OCS	Obstacle clearance surface	Саадыг давах гадаргуу
OCT	October	10-р сар
OFZ	Obstacle free zone	Саадаас чөлөөтэй зоон
OGN	Originate (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Үүсгэх (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
OHD	Overhead	Дээгүүр
OIS	Obstacle identification surface	Саадыг тодорхойлох гадаргуу
OK*	We agree or It is correct (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Бид зөвшөөрч байна, эсхүл Зөв байна (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
OLDI†	On-line data interchange	Сүлжээгээр өгөгдөл солилцох
OM	Outer marker	Холын маркер

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайлийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
OPA	Opaque, white type of ice formation	Зузаан, цагаан төрлийн мөстөлт
OPC	Control indicated is operational control	Харуулсан удирдлага нь үйл ажиллагааны удирдлага
OPMET†	Operational meteorological (<i>information</i>)	Цаг уурын үйл ажиллагааны (<i>мэдээ</i>)
OPN	Open or opening or opened	Нээлттэй эсхүл нээлт эсхүл нээсэн
OPR	Operator or operate or operative or operating or operational	Тээвэрлэгч, эсхүл ажиллах, эсхүл ажиллагаатай, эсхүл ажиллаж байгаа, эсхүл үйл ажиллагааны
OPS†	Operations	Үйл ажиллагаа
ORD	Order	Дэс дараалал
OSV	Ocean station vessel	Далайн хөлгөн станц
OTP	On top	Дээгүүр
OTS	Organized track system	Замыг зохион байгуулах тогтолцоо
OUBD	Outbound	Гарах
OVC	Overcast	Бүрхэг үүлтэй, битүү үүлтэй
P . . .	Maximum value of wind speed or runway visual range (<i>followed by figures in METAR/SPECI and TAF</i>)	<i>Салхины хурд, эсхүл ХБЗ-ын ил харааны зайн максимум утга (METAR/SPECI болон TAF-д тоон утгыг ард нь заана)</i>
P . . .	Prohibited area (<i>followed by identification</i>)	<i>Хориотой бүс (тэмдэглэгээг ард нь заана)</i>
PA	Precision approach	Нарийвчлалтай ойртолт
PALS	Precision approach lighting system (<i>specify category</i>)	Нарийвчлалтай ойртолтын гэрэлтүүлгийн систем (<i>ангиллыг зааж өгнө</i>)
PANS	Procedures for air navigation services	Агаарын навигацийн үйлчилгээний журам
PAPI†	Precision approach path indicator	Нарийвчлалтай ойртолтын зам заагч
PAR†	Precision approach radar	Нарийвчлалтай ойртолтын радар
PARL	Parallel	Параллел
PATC. . .	Precision approach terrain chart (<i>followed by name/title</i>)	Нарийвчлалтай ойртолтын газрын бартааны зураг (<i>нэр/гарчгийг ард нь заана</i>)
PAX	Passenger(s)	Зорчигч (ид)
PBC	Performance-based communication	Үзүүлэлтэд суурилсан холбоо
PBN	Performance-based navigation	Үзүүлэлтэд суурилсан навигаци
PBS	Performance-based surveillance	Үзүүлэлтэд суурилсан ажиглалт
PCD	Proceed or proceeding	Үргэлжлүүл эсхүл үргэлжлүүлэх
PCL	Pilot-controlled lighting	Удирдлагын гэрэлтүүлэг
PCN	Pavement classification number	Хучилтын ангиллын дугаар
PCT	Per cent	Хувь
PDC†	Pre-departure clearance	Нисэн гарахын өмнөх зөвшөөрөл
PDG	Procedure design gradient	Журам зохиолтын тооцоолсон налуу
PER	Performance	Үзүүлэлт
PERM	Permanent	Тогтмол
PIB	Pre-flight information bulletin	Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол

Товчлол	Англи	Монгол
PJE	Parachute jumping exercise	Шүхрээр буух сургуулилт
PL	Ice pellets	Мөсөн туйлаадас
PLA	Practice low approach	Нам өндрөөр ойртолт гүйцэтгэх
PLVL	Present level	Хадгалж байгаа түвшин
PN	Prior notice required	Урьдчилан мэдэгдэх шаардлагатай
PNR	Point of no return	Буцах боломжгүй болох цэг
PO	Dust/sand whirls (<i>dust devils</i>)	Шороо/элсэн хуй
POB	Persons on board	Агаарын хөлөгт байгаа хүмүүс
POSS	Possible	Боломжтой
PPI	Plan position indicator	Байршил заагч дэлгэц (радар)
PPR	Prior permission required	Урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай
PPSN	Present position	Одоогийн байршил
PRFG	Aerodrome partially covered by fog	Аэродром манангаар хэсэгчлэн бүрхэгдсэн
PRI	Primary	Анхдагч, үндсэн
PRKG	Parking	Зогсоох, зогсоол
PROB†	Probability	Магадлал
PROC	Procedure	Журам
PROP	Propeller	Сэнс
PROV	Provisional	Түр зуурын, нэмэлт
PRP	Point-in-space reference point	Огторгуйд тогтоосон хяналтын цэг
PS	Plus	Нэмэх
PSG	Passing	Өнгөрч байгаа
PSN	Position	Байршил (газар зүйн)
PSP	Pierced steel plank	Нүхэлсэн хэлбэртэй төмөр шугам
PSR‡	Primary surveillance radar	Ажиглалтын үндсэн радар
PSYS	Pressure system(s)	Даралтын систем (үүд)
PTN	Procedure turn	Стандарт-эргэлт
PTS	Polar track structure	Туйлын замын зохион байгуулалт
PWR	Power	Хүч
QDL	Do you intend to ask me for a series of bearings? or I intend to ask you for a series of bearings (<i>to be used in radiotelegraphy as a Q Code</i>)	Та надаас чиглэлийн серийг асуусан уу? эсхүл Би танаас чиглэлийн серийг асууж байна (<i>радиотелеграфт Q код болгон хэрэглэдэг</i>)
QDM‡	Magnetic heading (<i>zero wind</i>)	Соронзон чиглэл (<i>салхигүй үед</i>)
QDR	Magnetic bearing	Соронзон чиглэл
QFE‡	Atmospheric pressure at aerodrome elevation (<i>or at runway threshold</i>)	Аэродромын өндөрлөгийн (<i>эсхүл ХБЗ-ын босгын</i>) атмосферийн даралт

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайлийн үйлчилгээнд ашиглах дохио.

Товчлол	Англи	Монгол
QFU	Magnetic orientation of runway	ХБЗ-ын соронзон чиглэл
QGE	What is my distance to your station? or Your distance to my station is (<i>distance figures and units</i>) (<i>to be used in radiotelegraphy as a Q Code</i>)	Би танай станцаас хэр хол байна? эсхүл Та манай станцаас зайтай байна. (зайг илэрхийлсэн тоо ба нэгжийг өгнө) (радиотелеграфт Q код болгон хэрэглэдэг)
QJH	Shall I run my test tape/a test sentence? or Run your test tape/a test sentence (<i>to be used in AFS as a Q Code</i>)	Би тест хальсаа/тест өгүүлбэрээ явуулах уу? Эсхүл Тест хальсаа/тест өгүүлбэрээ явуулна уу (<i>AFS-ээр Q код болгон хэрэглэдэг</i>)
QNH‡	Altimeter sub-scale setting to obtain elevation when on the ground	Газарт байхдаа тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтаар тохируулах
QSP	Will you relay to . . . free of charge? or I will relay to . . . free of charge (<i>to be used in AFS as a Q Code</i>)	Та ... уруу үнэгүй дамжуулах уу? Эсхүл Би ... уруу үнэгүй дамжуулна (<i>AFS-ээр Q код болгон хэрэглэдэг</i>)
QTA	Shall I cancel telegram number . . . ? or Cancel telegram number . . . (<i>to be used in AFS as a Q Code</i>)	Би ... дугаартай телеграмаа хүчингүй болгож болох уу? эсхүл Миний ... дугаартай телеграмыг хүчингүй болгоно уу. (<i>AFS-ээр Q код болгон хэрэглэдэг</i>)
QTE	True bearing	Жинхэнэ чиглэл
QTF	Will you give me the position of my station according to the bearings taken by the D/F stations which you control? or The position of your station according to the bearings taken by the D/F stations that I control was . . . latitude . . . longitude (<i>or other indication of position</i>), class . . . at . . . hours (<i>to be used in radiotelegraphy as a Q Code</i>)	Та өөрийн удирдаж байгаа чиглэл тогтоогч станцаас авсан чиглэлээрээ манай станцын байршлыг надад өгнө үү? эсхүл Миний ашиглаж байгаа чиглэл тогтоогч станцын чиглэлийн заалтаар танай станцын байршил нь ... өргөрөг .. уртрагт (<i>эсхүл өөр байршил тогтоох хэмжээсээр</i>) ... цагийн байдлаар ... ангилалд байна (<i>Q кодоор радиотелеграфт хэрэглэдэг</i>)
QUAD	Quadrant	Тойргийн дөрөвний нэг
QUJ	Will you indicate the TRUE track to reach you? or The TRUE track to reach me is . . . degrees at . . . hours (<i>to be used in radiotelegraphy as a Q Code</i>)	Таны байрлалд хүрэх ЖИНХЭНЭ замыг зааж өгнө үү? эсхүл Миний байрлалд хүрэх ЖИНХЭНЭ зам ... цагт ... градусст байна (радиотелеграфт Q код болгон хэрэглэдэг)
. . . R	Right (<i>preceded by runway designation number to identify a parallel runway</i>)	Баруун (<i>Зэрэгцээ ХБЗ-ыг ялгаж таних зорилгоор ХБЗ-ын чиглэлийн дугаарыг урд нь заана</i>)
R	Rate of turn	Эргэлтийн хурд
R	Red	Улаан
R . . .	Radial from VOR (<i>followed by three figures</i>)	VOR-ын радиал (3 оронтой тоон утыг ард нь заана)
R . . .	Restricted area (<i>followed by identification</i>)	Хязгаарлалттай бүс (<i>тэмдэглэгээг ард нь заана</i>)
R . . .	Runway (<i>followed by figures in METAR/SPECI</i>)	Хөөрч буух зурвас (<i>METAR/SPECI-д тоон утыг ард нь заана</i>)
R*	Received (<i>acknowledgement of receipt</i>) (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Хүлээн авлаа (<i>хүлээн авснаа мэдэгдэх</i>) (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
RA	Rain	Бороо
RA	Resolution advisory	Шийдвэр гаргах зөвлөмж
RAC	Rules of the air and air traffic services	Нислэгийн дүрмүүд болон НХҮ

Товчлол	Англи	Монгол
RAG	Ragged	Урагдсан
RAG	Runway arresting gear	ХБЗ-ын зогсоох хэрэгсэл
RAI	Runway alignment indicator	ХБЗ голын тэгш заагч
RAIM†	Receiver autonomous integrity monitoring	Хүлээн авагчийн бие даасан тохирлын мониторинг
RASC†	Regional AIS system centre	Бүсийн НМҮ-ний тогтолцоо
RASS	Remote altimeter setting source	Алтиметрийг тохируулах зөөврийн эх үүсвэр
RB	Rescue boat	Аврагч завь
RCA	Reach cruising altitude	Аяллын өндрийн-түвшинд хүрэх
RCC	Rescue co-ordination centre	Авран туслах зохицуулалтын төв
RCF	Radiocommunication failure (<i>message type designator</i>)	Радио холбооны саатал, гэмтэл (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
RCH	Reach or reaching	Хүрэх эсхүл хүрч байна
RCL	Runway centre line	ХБЗ-ын гол шугам
RCLL	Runway centre line light(s)	ХБЗ-ын гол шугамын гэрэл
RCLR	Recleared	Дахин зөвшөөрөл өгсөн
RCP‡	Required communication performance	Холбооны шаардлагатай үзүүлэлт
RDH	Reference datum height	Хяналтын цэгийн өндөр
RDL	Radial	Радиал
RDO	Radio	Радио
RDOACT	Radioactive	Радио идэвхт
RE	Recent (<i>used to qualify weather phenomena, e.g. RERA = recent rain</i>)	Саяхан болж өнгөрсөн (<i>цаг агаарын аюултай үзэгдлийг тодорхойлоход ашигладаг, ж-нь RERA=саяхны бороо</i>)
REC	Receive or receiver	Хүлээн авах, эсхүл хүлээн авагч
REDL	Runway edge light(s)	ХБЗ-ын захын гэрэл
REF	Reference to . . . or refer to-аас авсан эшлэл, эсхүл ...-аас эш татах
REG	Registration	Бүртгэл
RENL	Runway end light(s)	ХБЗ-ын төгсгөлийн гэрэл
REP	Report or reporting or reporting point	Илтгэх, эсхүл илтгэж байгаа, эсхүл илтгэх цэг
REQ	Request or requested	Хүсэлт, эсхүл хүссэн
TERTE	Re-route	Нислэгийн зам өөрчлөх
RESA	Runway end safety area	ХБЗ-ын төгсгөлийн аюулгүйн талбай
RF	Constant radius arc to a fix	Тухайн цэгийн нумын тогтмол радиус
RFFS	Rescue and fire fighting services	Аврах болон гал унтраах үйлчилгээ
RG	Range (<i>lights</i>)	Шугам (<i>гэрлүүд</i>)
RHC	Right-hand circuit	Баруун гарын хайрцаг

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
RIF	Reclearance in flight	Нислэгийн үед дахин зөвшөөрөл авах
RIME [†]	Rime (<i>used in aerodrome warnings</i>)	Цан (<i>аэродромын анхааруулгад хэрэглэдэг</i>)
RL	Report leaving	Орхиж байгаагаа илтгэх (өндрөө)
RLA	Relay to	... -руу дамжуулах
RLCE	Request level change en-route	Нислэгийн замын түвшин өөрчлөх хүсэлт
RLLS	Runway lead-in lighting system	ХБЗ-ын хөтлөх гэрлэн систем
RLNA	Requested level not available	Хүссэн түвшнийг зөвшөөрөх боломжгүй
RMK	Remark	Тайлбар
RNAV [†]	(<i>to be pronounced "AR-NAV"</i>) Area navigation	("АР-НАВ" гэж дуудна) Бүсийн навигаци
RNG	Radio range	Радио долгионы бүрхэлт
RNP [‡]	Required navigation performance	Навигацийн шаардлагатай үзүүлэлт
ROBEX [†]	Regional OPMET bulletin exchange (<i>scheme</i>)	Бүсийн OPMET бюллетен солилцоо
ROC	Rate of climb	Өндөр авах хурд
ROD	Rate of descent	Өндөр алдах хурд
RON	Receiving only	Зөвхөн хүлээн авах
RPDS	Reference path data selector	Хяналтын цэгийн өгөгдөл сонгогч
RPI [‡]	Radar position indicator	Радарын байршил заагч
RPL	Repetitive flight plan	Давтагдах нислэгийн төлөвлөгөө
RPLC	Replace or replaced	Солих, эсхүл сольсон
RPS	Radar position symbol	Радарын байршлын тэмдэгт
RPT [*]	Repeat or I repeat (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Давтах эсхүл би давтаж байна (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
RQ [*]	Request (<i>to be used in AFS as a procedure signal</i>)	Хүсэлт (<i>AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг</i>)
RQMNTS	Requirements	Шаардлага
RQP	Request flight plan (<i>message type designator</i>)	Нислэгийн төлөвлөгөө хүсэх (мэдээний төрөл тодорхойлогч)
RQS	Request supplementary flight plan (<i>message type designator</i>)	Нэмэлт нислэгийн төлөвлөгөө хүсэх (мэдээний төрөл тодорхойлогч)
RR	Report reaching	Хүрч байгаа цэгээ илтгэх
RRA	(<i>or RRB, RRC. . . etc., in sequence</i>) Delayed meteorological message (<i>message type designator</i>)	(<i>RRB, RRC гэх мэт дараалалтай</i>) Хойшлогдсон цаг уурын мэдээ (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
RSC	Rescue sub-centre	Авран туслах дэд төв
RSCD	Runway surface condition	ХБЗ-ын гадаргуугийн нөхцөл
RSP	Responder beacon	Хариулагч радио дохиологч
RSP [‡]	Required surveillance performance	Ажиглалтын шаардлагатай үзүүлэлт
RSR	En-route surveillance radar	Нислэгийн замын ажиглалтын радар
RSS	Root sum square	Квадратын нийлбэрийн квадрат язгуур

Товчлол	Англи	Монгол
RTD	Delayed (<i>used to indicate delayed meteorological message; message type designator</i>)	Хойшлогдсон (<i>хойшлогдсон цаг уурын мэдээг харуулахад ашигладаг; мэдээний төрөл тодорхойлогч</i>)
RTE	Route	Нислэгийн зам
RTF	Radiotelephone	Радиотелефон
RTG	Radiotelegraph	Радиотелеграф
RTHL	Runway threshold light(s)	ХБЗ-ын босгын гэрэл
RTN	Return or returned or returning	Буцах, эсхүл буцсан, эсхүл буцаж байгаа
RTODAH	Rejected take-off distance available, helicopter	Татгалзсан хөөрөлтийн боломжит зай (нисдэг тэрэг)
RTS	Return to service	Ашиглалтад шилжүүлэх
RTT	Radioteletypewriter	Радиотелетайп төхөөрөмж
RTZL	Runway touchdown zone light(s)	ХБЗ-ын газардах зооны гэрэл
RUT	Standard regional route transmitting frequencies	Бүсийн нислэгийн замын мэдээлэл дамжуулах стандарт давтамж
RV	Rescue vessel	Авран туслах усан онгоц
RVA	Radar vectoring area	Радараар чиглүүлэх бүс
RVR [‡]	Runway visual range	ХБЗ-ын ил харааны зай
RVSM [‡]	Reduced vertical separation minimum [300 m (1 000 ft) between FL 290 and FL 410]	FL290-ээс FL410-ын хооронд (300 м-ээр (1000фут)) багасгасан босоо зайчлалын минимум
RWY	Runway	Хөөрч буух зурвас (ХБЗ)
S	South or southern latitude	Өмнө, эсхүл өмнөд өргөрөг
S . . .	State of the sea (<i>followed by figures in METAR/SPECI</i>)	Далайн чанад дахь улс орон (<i>METAR/SPECI-д тоон утгыг ард нь заана</i>)
SA	Sand	Элс
SALS	Simple approach lighting system	Энгийн ойртолтын гэрэлтүүлгийн систем
SAN	Sanitary	Эрүүл ахуй
SAR	Search and rescue	Эрэн хайх, авран туслах (ЭХАТ)
SARICC	Search and rescue co-ordination centre	ЭХАТ мэдээлэл зохицуулалтын төв
SARPS	Standards and Recommended Practices [ICAO]	Стандарт болон зөвлөмж (ICAO)
SAT	Saturday	Бямба гариг
SATCOM [†]	Satellite communication (<i>used only when referring generally to both voice and data satellite communication or only data satellite communication</i>)	Хиймэл дагуулын холбоо (<i>хиймэл дагуулын дуут болон өгөгдлийн холбоог хоёуланг нь, эсхүл зөвхөн хиймэл дагуулын өгөгдлийн холбоог голчлон ашиглаж байх үед зөвхөн хэрэглэдэг</i>)
SATVOICE [†]	Satellite voice communication	Хиймэл дагуулын дуут харилцаа холбоо
SB	Southbound	Өмнө зүг

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
SBAS [†]	(to be pronounced "ESS-BAS") Satellite-based augmentation system	("ЭСС-БАС" гэж дуудна) Хиймэл дагуулд суурилсан нарийвчлалыг өсгөх систем
SC	Stratocumulus	Давхраат бөөн үүл
SCT	Scattered	Сарнисан үүл
SD	Standard deviation	Стандарт хазайлт
SDBY	Stand by	Нөөц байдалд байгаа, бэлэн байдалд байгаа
SDF	Step down fix	Шаталсан өндөр алдалтын цэг
SE	South-east	Зүүн өмнөд
SEA	Sea (used in connection with sea-surface temperature and state of the sea)	Далай (далайн гадаргуугийн температур болон далайн нөхцөлтэй холбоотой хэрэглэдэг)
SEB	South-eastbound	Зүүн - өмнөд зүг
SEC	Seconds	Секунд (сек)
SECN	Section	Хэсэг, Section
SECT	Sector	Салбар, хэсэг, сектор
SELCAL [†]	Selective calling system	Сонгож дуудах систем
SEP	September	9-р сар
SER	Service or servicing or served	Үйлчилгээ, эсхүл үйлчлэх, эсхүл үйлчилсэн
SEV	Severe (used to qualify icing and turbulence reports)	Хүчтэй (ж-нь мөстөлт, сэгсрэлтийг мэдээлэхэд хэрэглэдэг)
SFC	Surface	Гадаргуу
SG	Snow grains	Цасан үрэл
SGL	Signal	Дохио, дохиолол
SH . . .	Shower (followed by RA = rain, SN = snow, PL = ice pellets, GR = hail, GS = small hail and/or snow pellets or combinations thereof, e.g. SHRASN = showers of rain and snow)	Хур тунадас (RA = бороо, SN = цас, PL = Мөсөн туйлаадас, GR = мөндөр, GS = Жижиг мөндөр ба/эсхүл цасан туйлаадас, эсхүл тэдгээрийн хосолмолыг ард нь заана, Ж-нь: SHRASN = бороо болон цастай хур тунадас)
SHF	Super high frequency [3 000 to 30 000 MHz]	Супер өндөр давтамж (3 000-30 000 МГц)
SI	International system of units	Олон улсын нэгжийн систем
SID [†]	Standard instrument departure	Стандарт хэрэглэлээр нисэн гарах
SIF	Selective identification feature	Сонгон таних чадвар
SIG	Significant	Онцгой, ач холбогдолтой, нөлөөлөхүйц
SIGMET [†]	Information concerning en-route weather and other phenomena in the atmosphere that may affect the safety of aircraft operations	Агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болох нислэгийн замын цаг агаар болон атмосферийн аюултай үзэгдэлтэй холбоотой мэдээ
SIMUL	Simultaneous or simultaneously	Нэгэн зэрэг
SIWL	Single isolated wheel load	Тусгайлан авсан нэг дугуйны ачаалал
SKED	Schedule or scheduled	Хуваарь, эсхүл хуваарьт
SLP	Speed limiting point	Хурд хязгаарлах цэг
SLW	Slow	Удаан

Товчлол	Англи	Монгол
SMC	Surface movement control	Гадаргуугийн хөдөлгөөний удирдлага
SMR	Surface movement radar	Гадаргуугийн хөдөлгөөний радар
SN	Snow	Цас (газар дээр)
SNOCLO	Aerodrome closed due to snow (<i>used in METAR/SPECI</i>)	Аэродром цаснаас шалтгаалан хаагдсан (<i>METAR/SPECI-д хэрэглэдэг</i>)
SOC	Start of climb	Өндөр авч эхлэх
SPECI [†]	Aerodrome special meteorological report (<i>in meteorological code</i>)	Аэродромын цаг уурын тусгай мэдээ (<i>цаг уурын кодоор</i>)
SPECIAL [†]	Local special meteorological report (<i>in abbreviated plain language</i>)	Орон нутгийн цаг уурын тусгай мэдээ (<i>товчилсон энгийн үгээр</i>)
SPI	Special position indicator	Тусгай байршил заагч
SPL	Supplementary flight plan (<i>message type designator</i>)	Нэмэлт нислэгийн төлөвлөгөө (<i>мэдээний төрөл тодорхойлогч</i>)
SPOC	SAR point of contact	ЭХАТ мэдээлэл хүлээн авах цэг
SPOT [†]	Spot wind	Тогтворгүй салхи
SQ	Squall	Нөөлөг салхи
SQL	Squall line	Нөөлөг салхины бүс
SR	Sunrise	Нар мандах
SRA	Surveillance radar approach	Ойртолтын ажиглалтын радар
SRE	Surveillance radar element of precision approach radar system	Нарийвчлалтай ойртолтын радар системийн ажиглалтын радарын элемент
SRG	Short range	Богино зай
SRR	Search and rescue region	Эрэн хайх, авран туслах бүс
SRY	Secondary	Хоёрдогч, туслах
SS	Sandstorm	Элсэн шуурга
SS	Sunset	Нар жаргах
SSB	Single sideband	Нэг хажуугийн зурвас
SSE	South-south-east	Өмнөд-зүүн өмнөд
SSR [‡]	Secondary surveillance radar	Ажиглалтын хоёрдогч радар
SST	Supersonic transport	Дуунаас хэт хурдан тээвэрлэгч /тээвэр/
SSW	South-south-west	Өмнөд-баруун өмнөд
ST	Stratus	Давхраат үүл
STA	Straight-in approach	Чиг шулуун ойртолт
STAR [†]	Standard instrument arrival	Стандарт хэрэглэлээр нисэн ирэх
STD	Standard	Стандарт
STF	Stratiform	Давхраат хэлбэрийн үүл
STN	Station	Станц
STNR	Stationary	Хөдөлгөөнгүй

[†] Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

[‡] Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайлийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
STOL	Short take-off and landing	Богино зайд хөөрөлт ба буулт үйлдэх
STS	Status	Төлөв, төлөв байдал, статус
STWL	Stopway light(s)	Зогсоох зурвасын гэрэл
SUBJ	Subject to	...-наас хамааралтай
SUN	Sunday	Ням гариг
SUP	Supplement (<i>AIP Supplement</i>)	Нэмэлт (AIP-ын нэмэлт)
SUPPS	Regional supplementary procedures	Бүсийн нэмэлт журам
SVC	Service (<i>message type only</i>)	Үйлчилгээ (зөвхөн мэдээний төрөл)
SVCBL	Serviceable	Ажиллагаатай
SW	South-west	Баруун өмнөд
SWB	South-westbound	Баруун - өмнө зүг
SWX	Space weather	Сансрын цаг агаар
SWXC	Space weather centre	Сансрын цаг агаарын төв
SWY	Stopway	Зогсоох зурвас
...T	True (<i>preceded by a bearing to indicate reference to True North</i>)	Жинхэнэ (<i>Жинхэнэ Хойд зүгтэй харьцуулан харуулсан чиглэлийн утгыг урд нь заана</i>)
T	Temperature	Хэм
TA	Traffic advisory	Хөдөлгөөний талаарх зөвлөмж
TA	Transition altitude	Шилжих өндрийн-түвшин
TA/H	Turn at an altitude/height	Тухайн өндрийн-түвшинд / өндөрт эргэлт хийх
TAA	Terminal arrival altitude	Аэродромд нисэн ирэх өндрийн-түвшин
TACAN [†]	UHF tactical air navigation aid	УНF тактикийн агаарын навигацийн туслах хэрэгсэл
TAF [†]	Aerodrome forecast (<i>in meteorological code</i>)	Аэродромын урьдчилсан мэдээ (<i>цаг уурын кодоор</i>)
TAIL [†]	Tail-wind	Арын салхи
TAR	Terminal area surveillance radar	Аэродромын бүсийн ажиглалтын радар
TAS	True airspeed	Жинхэнэ агаарын хурд
TAX	Taxiing or taxi	Явгалалт, эсхүл явгалах
TC	Tropical cyclone	Тропик циклон
TCAC	Tropical cyclone advisory centre	Тропик циклоноос сэрэмжлүүлэх төв
TCAS RA [†]	(<i>to be pronounced "TEE-CAS-AR-AY"</i>) Traffic alert and collision avoidance system resolution advisory	(<i>"ТИЙ-КАС-АР-ЭЙ"</i> гэж дуудна) Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс зайлсхийх системийн шийдвэр гаргах зөвлөмж
TCH	Threshold crossing height	Босго давах өндөр
TCU	Towering cumulus	Цамхаг хэлбэрийн бөөн үүл
TDO	Tornado	Торнадо
TDZ	Touchdown zone	Газардах бүс
TECR	Technical reason	Техникийн шалтгаан
TEL	Telephone	Телефон холбоо
TEMPO [†]	Temporary or temporarily	Түр зуурын, эсхүл түр

Товчлол	Англи	Монгол
TF	Track to fix	Тухайн цэгт хүрэх замын мөр
TFC	Traffic	Хөдөлгөөн
TGL	Touch-and-go landing	Газардаад 2-т гарах буулт
TGS	Taxiing guidance system	Явгалалт чиглүүлэх систем
THR	Threshold	Босго
THRU	Through	Дундуур, нэвт, дуустал
THU	Thursday	Пүрэв гариг
TIBA†	Traffic information broadcast by aircraft	Агаарын хөлгөөс радио нэвтрүүлгээр дамжуулсан нислэгийн хөдөлгөөний мэдээлэл
TIL†	Until	... хүртэл
TIP. . .	Until past (<i>followed by place</i>)	...-ыг өнгөрөх хүртэл (<i>газрын нэрийг ард нь заана</i>)
TKOF	Take-off	Хөөрөлт
TL . . .	Till (<i>followed by time by which weather change is forecast to end</i>)	... хүртэл (<i>урьдчилсан мэдээгээр цаг агаарын өөрчлөлт дуусах цагийг ард нь заана</i>)
TLOF	Touchdown and lift-off area	Газардах болон хөөрөх талбай
TMA‡	Terminal control area	Ойртолтын удирдлагын бүс
TN . . .	Minimum temperature (<i>followed by figures in TAF</i>)	Минимум хэм (TAF-д <i>тоон утгыг ард нь заана</i>)
TNA	Turn altitude	Эргэлтийн өндрийн-түвшин
TNH	Turn height	Эргэлтийн өндөр
TO . . .	To (<i>followed by place</i>)	... уруу (<i>газрын нэрийг ард нь заана</i>)
TOC	Top of climb	Өндөр авах хязгаар
TODA	Take-off distance available	Хөөрөлтийн боломжит зай
TODAH	Take-off distance available, helicopter	Хөөрөлтийн боломжит зай, Нисдэг тэрэг
TOP†	Cloud top	Үүлний дээд хил
TORA	Take-off run available	Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай
TOX	Toxic	Хортой
TP	Turning point	Эргэх цэг
TR	Track	Замын мөр
TRA	Temporary reserved airspace	Түр нөөцөлсөн агаарын зай
TRANS	Transmits or transmitter	Дамжуулах, эсхүл дамжуулагч
TREND†	Trend forecast	Урьдчилсан мэдээний хандлага
TRG	Training	Сургалт
TRL	Transition level	Шилжих түвшин
TROP	Tropopause	Тропопауз
TS	Thunderstorm (<i>in aerodrome reports and forecasts, TS used alone means thunder</i>)	Аянга цахилгаан (<i>аэродромын мэдээ болон цаг уурын урьдчилсан мэдээнд TS-г дангаар нь</i>)

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
	<i>heard but no precipitation at the aerodrome)</i>	<i>хэрэглэвэл тэнгэр дуугарч боловч аэродром дээр хур тунадасгүй болохыг илэрхийлнэ)</i>
TS...	Thunderstorm (followed by RA = rain, SN = snow, PL = ice pellets, GR = hail, GS = small hail and/or snow pellets or combinations thereof, e.g. TSRASN = thunderstorm with rain and snow)	Аянга цахилгаан (RA = бороо, SN = цас, PL = мөсөн мөндөр, GR = мөндөр, GS = Жижиг мөндөр ба/эсхүл цасан туйлаадас, эсхүл эдгээрийн хосолмолыг ард нь заана. Ж-нь: TSRASN= бороо болон цастай аянга цахилгаан)
TSUNAMI†	Tsunami (used in aerodrome warnings)	Цунами (аэродромын анхааруулгад хэрэглэдэг)
TT	Teletypewriter	Телетайп төхөөрөмж
TUE	Tuesday	Мягмар гариг
TURB	Turbulence	Сэгсрэлт, хуйлрал
T-VASIS†	(to be pronounced "TEE-VASIS") T visual approach slope indicator system	("ТИЙ-ВАСИС" гэж дуудна) Т - ил харааны ойртолтын налуу заагч систем
TVOR	Terminal VOR	Аэродромын VOR
TWR	Aerodrome control tower or aerodrome control	Аэродромын удирдлагын цамхаг, эсхүл аэродромын удирдлага
TWY	Taxiway	Явгалах зам
TX...	Maximum temperature (followed by figures in TAF)	Максимум хэм (TAF-д тоон утгыг ард нь заана)
TXL	Taxilane	Явгалах шугам
TXT*	Text (when the abbreviation is used to request a repetition, the question mark (IMI) precedes the abbreviation, e.g. IMI TXT) (to be used in AFS as a procedure signal)	Текст (дахин давтамдахыг хүсэж энэхүү товчлолыг хэрэглэхдээ товчлолын өмнө асуултын тэмдгийг (IMI) оруулна, ж-нь: IMI TXT) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
TYP	Type of aircraft	Агаарын хөлгийн төрөл
TYPH	Typhoon	Далайн шуурга, Тайфун
U	Upward (tendency in RVR during previous 10 minutes)	Дээшээ (ХБЗ-ын ил харааны зайн өмнөх 10 минутын хандлага)
U/S	Unserviceable	Ажиллагаагүй
UA	Unmanned aircraft	Хүнгүй агаарын хөлөг
UAB	Until advised by -ийг хэлэх хүртэл
UAC	Upper area control centre	Дээд агаарын зайн бүсийн удирдлагын төв
UAR	Upper air route	Дээд агаарын зам
UAS	Unmanned aircraft system	Хүнгүй агаарын хөлгийн систем
UDF	Ultra high frequency direction-finding station	Ультра өндөр давтамжийн чиглэл-ологч станц
UFN	Until further notice	Дараагийн мэдээ хүртэл
UHDT	Unable higher due traffic	Хөдөлгөөнөөс шалтгаалан өндөр, түвшин өгөх боломжгүй
UHF‡	Ultra high frequency [300 to 3 000 MHz]	Ультра өндөр давтамж (300-3 000 МГц)
UIC	Upper information centre	Дээд агаарын зайн мэдээллийн төв
UIR‡	Upper flight information region	Дээд агаарын зайн нислэгийн мэдээллийн бүс

Товчлол	Англи	Монгол
ULM	Ultra light motorized aircraft	Хөдөлгүүртэй хэт хөнгөн агаарын хөлөг
ULR	Ultra long range	Хэт холын зай
UNA	Unable	Боломжгүй
UNAP	Unable to approve	Зөвшөөрөх боломжгүй
UNL	Unlimited	Хязгааргүй
UNREL	Unreliable	Найдваргүй
UP	Unidentified precipitation (used in automated METAR/SPECI)	Танигдаагүй тунадас (автомат METAR/SPECI-д хэрэглэдэг)
UTA	Upper control area	Дээд агаарын зайн удирдлагын бүс
UTC [‡]	Coordinated Universal Time	Олон улсын цаг /UTC/
...V...	Variations from the mean wind direction (preceded and followed by figures in METAR/SPECI, e.g. 350V070)	Зонхилох салхины чиглэлийн зөрүү (METAR/SPECI-д тоон утгыг өмнө болон ард нь заана. Ж-нь: 350V070)
VA	Heading to an altitude	Өндрийн-түвшинд хүрэх чиглэл
VA	Volcanic ash	Галт уулын үнс
VAAC	Volcanic ash advisory centre	Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв
VAC ...	Visual approach chart (followed by name/title)	Ил харааны ойртолтын зураг (нэр/гарчгийг ард нь заана)
VAL	In valleys	Хөндийд
VAN	Runway control van	ХБЗ-ын хяналтын тээврийн хэрэгсэл
VAR	Magnetic variation	Соронзон хазайлт
VAR	Visual-aural radio range	Харааны - сонсголын радио алслалт
VASIS	Visual approach slope indicator systems	Ил харааны ойртолтын налуу заагч систем
VC ...	Vicinity of the aerodrome (followed by FG = fog, FC = funnel cloud, SH = shower, PO = dust/sand whirls, BLDU = blowing dust, BLSA = blowing sand, BLSN = blowing snow, DS = duststorm, SS = sandstorm, TS = thunderstorm or VA = volcanic ash, e.g. VCFG = vicinity fog)	Аэродромын орчим (ард нь FG = манан, FC = борооны үүл, SH = Хур тунадас, PO = Шороо/элсэн хуй, BLDU = шороогоор шуурах, BLSA = элсээр шуурах, BLSN = цасаар шуурах, DS = шороон шуурга, SS = элсэн шуурга, TS = аянга цахилгаан, эсхүл VA = галт уулын үнс гэх мэтээр ард нь заана, Ж-нь: VCFG = Аэродромын орчим манантай)
VCY	Vicinity	Ойр орчим, ойролцоо
VDF	Very high frequency direction-finding station	Хэт өндөр давтамжийн чиглэл-ологч станц
VER	Vertical	Босоо
VFR [‡]	Visual flight rules	Ил харааны нислэгийн дүрэм
VHF [‡]	Very high frequency [30 to 300 MHz]	Хэт өндөр давтамж (30-300 МГц)
VI	Heading to an intercept	Огтлолцолд хүрэх чиглэл
VIP [‡]	Very important person	Маш чухал хүн
VIS	Visibility	Хараа

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

MNS 6409:2024

Товчлол	Англи	Монгол
VLF	Very low frequency [3 to 30 kHz]	Хэт бага давтамж (3-30 кГц)
VLR	Very long range	Алс холын зай
VM	Heading to a manual termination	Гар удирдлагаар зогсоох хүртэлх чиглэл
VMC‡	Visual meteorological conditions	Ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөл
VNAV†	<i>(to be pronounced “VEE-NAV”)</i> Vertical navigation	<i>(“ВИ-НАВ” гэж дуудна)</i> Босоо тэнхлэгийн навигаци
VOL. . .	Volume <i>(followed by I, II. . .)</i>	Volume <i>(I, II ... гэж ард нь заана)</i>
VOLMET†	Meteorological information for aircraft in flight	Нислэгт байгаа агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээлэл
VOR‡	VHF omnidirectional radio range	Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч
VORTAC†	VOR and TACAN combination	VOR болон TACAN системийн комбинац
VOT	VOR airborne equipment test facility	VOR-ыг агаарт шалгах төхөөрөмж
VPA	Vertical path angle	Босоо замын өнцөг
VPT	Visual manoeuvre with prescribed track	Тогтоосон замаар ил хараагаар маневр хийх
VRB	Variable	Тогтворгүй (салхи)
VSA	By visual reference to the ground	Газрын ил харааны баримжаа
VSP	Vertical speed	Босоо хурд
VTF	Vector to final	Вектороор төгсгөл хийх
VTOL	Vertical take-off and landing	Босоо хөөрөлт ба буулт
VV . . .	Vertical visibility <i>(followed by figures in METAR/SPECI and TAF)</i>	Босоо хараа <i>(METAR/SPECI болон TAF-д тоон утгыг ард нь заана)</i>
W	West or western longitude	Баруун, эсхүл баруун уртраг
W	White	Цагаан
W . . .	Sea-surface temperature <i>(followed by figures in METAR/SPECI)</i>	<i>Далайн гадаргуугийн хэм (METAR/SPECI-д тоон утгыг ард нь заана)</i>
WAAS†	Wide area augmentation system	Өргөн хүрээтэй нарийвчлалыг өсгөх систем
WAC. . .	World Aeronautical Chart - ICAO 1: 1 000 000 <i>(followed by name/title)</i>	Дэлхийн Нислэгийн Зураг - ICAO 1:1 000 000 <i>(нэр/гарчгийг ард нь заана)</i>
WAFC	World area forecast centre	Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв
WB	Westbound	Баруун зүг
WBAR	Wing bar lights	Жигүүрийн гэрэл
WDI	Wind direction indicator	Салхины чиглэл заагч
WDSPR	Widespread	Өргөн тархсан
WED	Wednesday	Лхагва гариг
WEF	With effect from or effective from	...-нд хүчинтэй, эсхүл ...-аас хүчинтэй болно
WGS84	World Geodetic System 1984	Дэлхийн Геодезийн солбицлын систем-1984
WI	Within	...-ын дотор
WID	Width or wide	Өргөн, эсхүл уужуу
WIE	With immediate effect or effective immediately	Энэ мөчөөс яаралтай үйлчилж эхэлнэ

Товчлол	Англи	Монгол
WILCO†	Will comply	...-ыг дагана, биелүүлнэ
WIND	Wind	Салхи
WIP	Work in progress	Ажил хийгдэж байна
WKN	Weaken or weakening	Буурах/сулрах, эсхүл буурч/суларч байна
WNW	West-north-west	Баруун-баруун хойд
WO	Without	... байхгүйгээр
WPT	Way-point	Замын цэг
WRNG	Warning	Анхааруулга / түгшүүр
WS	Wind shear	Салхины огтлол
WSPD	Wind speed	Салхины хурд
WSW	West-south-west	Баруун - баруун өмнөд
WT	Weight	Жин
WTSPT	Waterspout	Усан шамарга
WWW	Worldwide web	Дэлхийг бүрхсэн сүлжээ
WX	Weather	Цаг агаар
WXR	Weather radar	Цаг агаарын радар
X	Cross	Хөндлөн
XBAR	Crossbar (of approach lighting system)	Гэрлэн хэвтээ чиглэл (ойртолтын гэрлийн систем)
XNG	Crossing	Огтлох, эсхүл хөндлөн гарах
XS	Atmospherics	Атмосферийн
Y	Yellow	Шар
Y CZ	Yellow caution zone (runway lighting)	Сэрэмжлүүлэх шар бүс (ХБЗ-ын гэрэлтүүлэг)
YES*	Yes (affirmative) (to be used in AFS as a procedure signal)	Тийм (зөвшөөрсөн) (AFS-д процедурын дохио болгон хэрэглэдэг)
YR	Your	Таны, чиний
Z	Coordinated Universal Time (in meteorological messages)	Олон улсын цаг (цаг уурын мэдээнд)

† Радио утас ашиглах үед товчлол, нэр томъёо нь ярианы үг хэлбэрээр дамждаг.

‡ Радио утас ашиглах үед товчилсон үг, нэр томъёо нь авианы бус хэлбэрээр бие даасан үсгүүдийг ашиглан дамжуулагдана.

* Дохио нь далайн хөдөлгөөнт үйлчилгээний станцуудтай холбогдоход ашиглах боломжтой.

Зөвхөн телетайпийн үйлчилгээнд ашиглах дохио.

2-р хүснэгт - Нэр томъёоны тодорхойлолт

НЭР ТОМЪЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Accelerate-stop distance available (ASDA)	Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай (ASDA)	The length of the take-off run available plus the length of stopway, if provided.	Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) урт дээр нэмж зогсоох зурвасын урт, хэрэв байгаа бол (AN 6/I; AN 14/I)
Acceptable level of safety	Аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшин	A minimum level of acceptable performance used to determine a safety rating of the operation.	Аюулгүй байдлын зэрэглэлийг тодорхойлоход ашигладаг, хүлээн зөвшөөрөгдөхүйц гүйцэтгэлийн минимум түвшин (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 11; AN 14; AN 19)
Accepting unit	Удирдлага хүлээн авч байгаа нэгж	ATC unit next to take control of an aircraft.	Агаарын хөлгийн удирдлагыг хүлээн авах дараагийн НХУ-ын нэгж (AN 11)
Accident	Осол	<p>An occurrence associated with the operation of an aircraft which, in the case of a manned aircraft, takes place between the time any person boards the aircraft with the intention of flight until such time as all such persons have disembarked, or in the case of an unmanned aircraft, takes place between the time the aircraft is ready to move with the purpose of flight until such time as it comes to rest at the end of the flight and the primary propulsion system is shut down, in which:</p> <p>a) a person is fatally or seriously injured as a result of:</p> <ul style="list-style-type: none"> - being in the aircraft, or - direct contact with any part of the aircraft, including parts which have become detached from the aircraft, or - direct exposure to jet blast, <p>except when the injuries are from natural causes, self-inflicted or inflicted by other persons, or when the injuries are to stowaways hiding outside the areas normally available to the passengers and crew; or</p> <p>b) the aircraft sustains damage or structural failure which:</p>	<p>Хүнтэй агаарын хөлгийн хувьд аливаа этгээд нислэгт оролцох зорилготойгоор агаарын хөлөгт орсноос эхлэн тухайн этгээд түүнийг орхин гарах хүртэлх цаг хугацаа, эсхүл хүнгүй агаарын хөлгийн хувьд нислэг үйлдэхээр хөдлөхөд бэлэн болсноос эхлэн тухайн нислэг дуусаж, үндсэн татах хүчний системийг унтраах хүртэлх цаг хугацааны хооронд агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан дараах хэрэг явдал:</p> <p>a) аливаа этгээд дараах тохиолдолд амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн:</p> <ul style="list-style-type: none"> - агаарын хөлөгт байх үедээ; эсхүл - агаарын хөлгөөс салсан эд ангийг оролцуулан агаарын хөлгийн эд ангийн шууд нөлөөллөөс; эсхүл - тийрэлтэт хийн урсгалын шууд нөлөөллөөс; <p>үүнд ердийн шалтгаанаас үүдэлтэй гэмтэл, өөрийгөө гэмтээсэн, эсхүл бусад этгээд гэмтээсэн, эсхүл хөлгийн баг болон зорчигчид зориулсан бүхээгийн хэсгийн гадна нуугдан зорчиж байх үед авсан гэмтэл хамаарахгүй; эсхүл</p> <p>b) агаарын хөлөг дараах гэмтэл, эсхүл бүтцийн эвдрэлд өртөх:</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>- adversely affects the structural strength, performance or flight characteristics of the aircraft, and</p> <p>- would normally require major repair or replacement of the affected component, except for engine failure or damage, when the damage is limited to a single engine (including its cowlings or accessories), to propellers, wing tips, antennas, probes, vanes, tires, brakes, wheels, fairings, panels, landing gear doors, windcreens, the aircraft skin (such as small dents or puncture holes), or for minor damages to main rotor blades, tail rotor blades, landing gear, and those resulting from hail or bird strike (including holes in the radome); or</p> <p>c) the aircraft is missing or is completely inaccessible.</p>	<p>- тухайн агаарын хөлгийн бүтцийн бөх бат чанар, техникийн, эсхүл нислэгийн үзүүлэлтэд аюултай нөлөөлөх;</p> <p>- ихэвчлэн гэмтсэн бүрдэл хэсгийг солих, эсхүл том засвар хийхийг шаарддаг,</p> <p>үүнд хөдөлгүүрийн татгалзал, эсхүл тухайн гэмтэл нь С-хаалт, эсхүл туслах эд ангийг багтаасан ганц хөдөлгүүр, сэнс, далавчны үзүүр, антен, хүлээн авагч (probes), хаалт (vanes), дугуйн хаймар, тоормос, дугуй, бүрээс, нээлхий, газардах ангийн хаалга, салхины шил болон агаарын хөлгийн гадаргуугийн жижиг хонхойлт, эсхүл цооролтоор хязгаарлагдсан гэмтэл, эсхүл үндсэн роторын алга, сүүлний роторын алга, газардах анги болон мөндөр, эсхүл шувуутай мөргөлдсөнөөс үүссэн radome-ийн нүхийг багтаасан бусад жижиг гэмтэл хамаарахгүй; эсхүл</p> <p>c) агаарын хөлөг сураггүй алга болох, эсхүл хүрэх боломжгүй болох. (AN 11; AN 13; AN 19)</p>
Accident investigation authority	Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах байгууллага	The authority designated by a State as responsible for aircraft accident and incident investigations within the context of Annex 13.	Аппех 13-ын дагуу агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах зорилгоор Хэлэлцэн тохиролцогч Улсын томилсон эрх бүхий байгууллага (AN 13)
Accompanying person	Дагалдагч этгээд	<p>An adult who is travelling with a minor. This person will not necessarily be the parent or legal guardian of the minor.</p> <p><i>Note.- It is to be noted that this definition might need to be applied in light of any obligation resulting from the application of national regulations on border checks.</i></p>	<p>Насанд хүрээгүй этгээдтэй аялж байгаа насанд хүрсэн этгээд. Уг этгээд нь тухайн насанд хүрээгүй этгээдийн эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч байх шаардлагагүй. (AN 9)</p> <p><i>Тэмдэглэл: Энэхүү тодорхойлолтыг хилийн хяналтын тухай үндэсний хууль, тогтоомжийг хэрэглэхээс үүссэн аливаа үүрэг хариуцлагыг харгалзан хэрэглэнэ.</i></p>
Accredited medical conclusion	Итгэмжлэгдсэн эмчийн дүгнэлт	The conclusion reached by one or more medical experts acceptable to the Licensing Authority for the purposes of the case concerned, in consultation with flight operations or other experts as necessary.	Шаардлагатай гэж үзвэл нислэгийн үйл ажиллагааны, эсхүл бусад мэргэжлийн шинжээчтэй зөвлөлдөн тухайн асуудалтай холбоотойгоор гэрчилгээжүүлэх эрх бүхий

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			байгууллагын хүлээн зөвшөөрөхүйц нэг, эсхүл хэд хэдэн эксперт-эмчийн гаргасан дүгнэлт (AN 1)
Accredited representative	Итгэмжлэгдсэн төлөөлөгч	A person designated by a State, on the basis of his or her qualifications, for the purpose of participating in an investigation conducted by another State. The accredited representative would normally be from the State's accident investigation authority.	Мэргэжлийн дадлага туршлагыг үндэслэн бусад Улсын шинжлэн шалгах ажиллагаанд оролцуулахаар тухайн Улсын томилсон этгээд. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ихэвчлэн тухайн Улсын ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага томилдог (AN 13)
Acrobatic flight	Аэробатик нислэг	Manoeuvres intentionally performed by an aircraft involving an abrupt change in its attitude, an abnormal attitude, or an abnormal variation in speed.	Орон зайд байрлалаа огцом өөрчлөх, хэвийн бус байдал, эсхүл хурдны хэт огцом өөрчлөлт зэргийг багтаасан, агаарын хөлгөөр зориуд гүйцэтгэж байгаа нислэгийн маневр (AN 2)
Acts of unlawful interference	Хууль бус нөлөөллийн үйлдэл	These are acts or attempted acts such as to jeopardize the safety of civil aviation and air transport, i.e.: <ul style="list-style-type: none"> - unlawful seizure of aircraft in flight, - destruction of an aircraft in service, - hostage-taking on board an aircraft or on aerodromes, - forcible intrusion on board an aircraft, at an airport or on the premises of an aeronautical facility, - introduction on board an aircraft or at an airport of a weapon or hazardous device or material intended for criminal purposes, - use of an aircraft in service for the purpose of causing death, serious bodily injury, or serious damage to property or the environment, - communication of false information as to jeopardize the safety of an aircraft in flight or on the ground, of passengers, crew, ground personnel or the general public, at an airport or on the premises of a civil aviation facility. 	Иргэний нисэхийн аюулгүй байдалд аюул учруулах, дараах үйлдлийг багтаасан үйлдэл, эсхүл завдсан үйлдэл: <ul style="list-style-type: none"> - агаарын хөлгийг нислэгийн үед хууль бусаар булаах; - үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлгийг устгах; - агаарын хөлгийн бүхээгт, эсхүл аэродром дээр хүн барьцаалах; - агаарын хөлгийн бүхээг, нисэх буудал, эсхүл нисэхийн байгууламжийн байранд хүч хэрэглэн нэвтрэх; - агаарын хөлгийн бүхээг эсхүл нисэх буудалд гэмт хэргийн зорилгоор зэвсэг, эсхүл аюултай хэрэгсэл, материалыг нэвтрүүлэх; - үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлгийг үхэл, биеийн хүнд гэмтэл, эсхүл эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зорилгоор ашиглах; - нислэгт, эсхүл нисэх буудал, эсхүл нисэхийн байгууламжийн байрлалд газарт байгаа агаарын хөлгийн зорчигч, нисэх баг, газрын ажилтан, эсхүл олон нийтийн аюулгүй байдал

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			аюул учруулах худал мэдээлэл дамжуулах; (AN 17)
Adapted competency model	Нийцүүлсэн ур чадварын загвар	A group of competencies with their associated description and performance criteria adapted from an ICAO competency framework that an organization uses to develop competency-based training and assessment for a given role.	Тухайн чиг үүрэгт зориулсан ур чадварт суурилсан сургалт болон үнэлгээ боловсруулах зорилгоор тухайн байгууллага ICAO-гийн ур чадварын тодорхойлолтод нийцүүлэн ашигладаг тодорхойлолт болон үзүүлэлтийн шалгууртай холбоотой ур чадварын бүлэг (AN 1)
Administrative partnership	Хамтран зохицуулагч	Delegation of administering tasks in this Volume from one State to another State(s).	Annex 16, Volume IV-ийн зохицуулах ажлыг нэг Улсаас нөгөө Улсад шилжүүлэх (AN 16/IV)
Admission	Нэвтрэх зөвшөөрөл	The permission granted to a person to enter a State by the public authorities of that State i.a.w its national laws.	Тухайн Улсын төрийн эрх бүхий байгууллагаас үндэсний хуулийн дагуу этгээдэд тухайн Улсад нэвтрэхийг зөвшөөрсөн эрх (AN 9)
ADS-C agreement	ADS-C гэрээ	A reporting plan which establishes the conditions of ADS-C data reporting (i.e. data required by the ATS unit and frequency of ADS-C reports which have to be agreed to prior to using ADS-C in the provision of ATS). <i>Note.- The terms of the agreement will be exchanged between the ground system and the aircraft by means of a contract, or a series of contracts.</i>	ADS-C өгөгдлийг мэдээлэх (data reporting) нөхцөлийг тогтоодог мэдээллийн төлөвлөгөө (ж-нь, НХҮ-ний нэгж болон НХҮ-ний хангалтад ADS-C хэрэглэхээс өмнө тохиролцдог ADS-C мэдээллийн давтамжаар шаарддаг өгөгдөл) <i>Тэмдэглэл: Гэрээний нөхцөлийг газрын систем болон агаарын хөлөг хооронд гэрээ, эсхүл цуврал гэрээ хэлбэрээр солилцдог. (AN 2)</i>
Advance Passenger Information System (APIS)	Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем (APIS)	An electronic communications system whereby required data elements are collected and transmitted to border control agencies prior to flight departure or arrival and made available on the primary line at the airport of entry.	Шаардлагатай өгөгдлийн хэсгийг нисэх буудалд нэвтрэх үндсэн хэсэгт ашиглахад бэлэн байхаар нисэн гарах, эсхүл нисэн ирэх нислэгийн өмнө хилийн хяналтын байгууллагад цуглуулж, дамжуулдаг электрон холбооны систем (AN 9)
Advanced aircraft	Сайжруулсан агаарын хөлөг	An aircraft with equipment in addition to that required for a basic aircraft for a given take-off, approach or landing operation.	Үндсэн агаарын хөлгийн хөөрөлт, ойртолт, эсхүл буултын үйл ажиллагаанд шаардлагатай төхөөрөмжөөс гадна нэмэлт төхөөрөмжөөр тоногдосон агаарын хөлөг (AN 6/II)
Adviser	Зөвлөх	A person appointed by a State, on the basis of his or her qualifications, for the purpose of assisting its accredited representative in an investigation.	Өөрийн мэргэжилд үндэслэн шинжлэн шалгах ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн Улсын томилсон этгээд (AN 13)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Advisory airspace	Зөвлөмжийн үйлчилгээтэй агаарын зай	An airspace of defined dimensions, or designated route, within which air traffic advisory service is available.	Нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээтэй, тогтоосон хэмжээтэй агаарын зай, эсхүл зориулалтын агаарын зам (AN 2; AN 11; PANS-ATM)
Advisory route	Зөвлөмжийн үйлчилгээтэй агаарын зам	A designated route along which air traffic advisory service is available.	Нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээ авах боломжтой байхаар тогтоосон агаарын зам (AN 2; AN 11; PANS-ATM)
Aerial work	Агаараас гүйцэтгэх ажил	An aircraft operation in which an aircraft is used for specialized services such as agriculture, construction, photography, surveying, observation and patrol, SAR, aerial advertisement, etc.	Хөдөө аж ахуй, барилга, зураг авалт, хайгуул, ажиглалт болон эргүүл, ЭХАТ, зар сурталчилгаа зэрэг тусгай үйлчилгээнд ашигладаг агаарын хөлгийн үйл ажиллагаа (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 17)
Aerodrome	Аэродром	A defined area on land or water (including any buildings, installations and equipment) intended to be used either wholly or in part for the arrival, departure and surface movement of aircraft.	Агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуугийн хөдөлгөөнд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулсан, эсхүл зохион бүтээсэн, газар, эсхүл усан дээр тогтоосон, түүний барилга, байгууламж болон төхөөрөмжийг багтаасан талбай (AN 2; AN 3; AN 4; AN 6/I; AN 6/II; AN 11; AN 14/I; PANS-ATM)
Aerodrome beacon	Аэродромын гэрэлт дохио	Aeronautical beacon used to indicate the location of an aerodrome from the air.	Агаараас аэродромын байрлалыг харуулах зорилгоор ашигладаг нисэхийн гэрэлт дохио (AN 14/I)
Aerodrome certificate	Аэродромын гэрчилгээ	A certificate issued by the appropriate authority under applicable regulations for the operation of an aerodrome.	Аэродромын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор зохих дүрмийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ (AN 14/I)
Aerodrome climatological summary	Аэродромын уур амьсгалын тодорхойлолт	Concise summary of specified meteorological elements at an aerodrome, based on statistical data.	Статистик өгөгдөлд үндэслэн гаргасан аэродромын цаг уурын тодорхойлогдсон элементүүдийн товч хураангуй (AN 3)
Aerodrome climatological table	Аэродромын уур амьсгалын хүснэгт	Table providing statistical data on the observed occurrence of one or more meteorological elements at an aerodrome.	Аэродромын нэг, эсхүл хэд хэдэн цаг уурын элементийн ажиглагдсан үзэгдлийн статистик өгөгдлийг багтаасан хүснэгт (AN 3)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aerodrome control radio station	Аэродромын удирдлагын радио станц	A station providing radiocommunication between an aerodrome control tower and aircraft or mobile aeronautical stations.	Аэродромын удирдлагын цамхаг болон агаарын хөлөг, эсхүл нисэхийн хөдөлгөөнт холбооны станцуудын хооронд радио-холбоогоор хангадаг станц (AN 10/II)
Aerodrome control service	Аэродромын удирдлагын үйлчилгээ	ATC service for aerodrome traffic.	Аэродромын хөдөлгөөнийг удирдлагаар хангадаг НХУ-ын үйлчилгээ (AN 1; AN 11; AN 2; PANS-ATM)
Aerodrome control tower	Аэродромын удирдлагын цамхаг	A unit established to provide ATC service to aerodrome traffic.	Аэродромын хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)
Aerodrome elevation	Аэродромын өндөрлөг	The elevation of the highest point of the landing area.	Буултын талбайн хамгийн өндөр цэгийн өндөрлөг (AN 3; AN 4; AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Aerodrome identification sign	Аэродромын таних тэмдэг	A sign placed on an aerodrome to aid in identifying the aerodrome from the air.	Агаараас аэродромыг танихад туслах зорилгоор аэродром дээр байрлуулсан тэмдэглэгээ (AN 14/I)
Aerodrome mapping data (AMD)	Аэродромын зураглалын өгөгдөл (AMD)	Data collected for the purpose of compiling aerodrome mapping information for aeronautical uses. <i>Note.- Aerodrome mapping data are collected for purposes that include the improvement of the user's situational awareness, surface navigation operations, training, charting and planning.</i>	Нисэхийн хэрэгцээнд ашиглахаар аэродромын зураглалын мэдээллийг нэгтгэх зорилготой цуглуулсан өгөгдөл <i>Тэмдэглэл:</i> Аэродромын зураглалын өгөгдлийг хэрэглэгчийн нөхцөл байдлыг таних чадвар, гадаргуу дээрх хөдөлгөөний үйл ажиллагаа, сургалт, нислэгийн зураг болон төлөвлөлтийг сайжруулах зорилгоор цуглуулна. (AN 14/I; AN 15)
Aerodrome mapping database (AMDB)	Аэродромын зураглалын өгөгдлийн сан (AMDB)	A collection of aerodrome mapping data organized and arranged as a structured data set.	Тодорхой бүтэцтэй өгөгдлийн багц хэлбэрээр зохион байгуулсан болон системчилсэн аэродромын зураглалын өгөгдлийн цуглуулга (AN 14/I; AN 15)
Aerodrome meteorological office	Аэродромын цаг уурын алба	An office designated to provide meteorological service for aerodromes serving international air navigation.	Олон улсын нислэгт үйлчилдэг аэродромд цаг уурын үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон нэгж (AN 3)
Aerodrome operating minima	Аэродромын үйл ажиллагааны минимал	The limits of usability of an aerodrome for:	Аэродромын ашиглалт нь дараах хязгаарлалттай байж болно:

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		a) take-off, expressed in terms of runway visual range and/or visibility and, if necessary, cloud conditions; b) landing in 2D instrument approach operations, expressed in terms of visibility and/or runway visual range, minimum descent altitude/height (MDA/H) and, if necessary, cloud conditions; and c) landing in 3D instrument approach operations, expressed in terms of visibility and/or runway visual range and decision altitude/height (DA/H) as appropriate to the type and/or category of the operation.	a) хөөрөлтийн - ХБЗ-ын ил харааны зай ба/эсхүл хараа, хэрэв шаардлагатай бол үүлний нөхцөлөөр илэрхийлдэг; b) 2D хэрэглэлийн ойртолтоор үйлдэх буултын - хараа ба/эсхүл ХБЗ-ын ил харааны зай, өндөр алдах минимум өндрийн-түвшин/өндөр (MDA/H), хэрэв шаардлагатай бол үүлний нөхцөлөөр илэрхийлдэг; c) 3D хэрэглэлийн ойртолтоор үйлдэх буултын - хараа ба/эсхүл ХБЗ-ын ил харааны зай болон тухайн үйл ажиллагааны төрөл ба/эсхүл категорид хамааралтайгаар шийдвэр гаргах минимум өндрийн-түвшин/өндөрөөр (DA/H) илэрхийлдэг; (AN 4; AN 6/I; AN 6/II)
Aerodrome pair	Аэродромын хос	A group of two aerodromes composed of a departing aerodrome and an arrival aerodrome.	Нисэн гарах аэродром болон нисэн хүрэх аэродромоос бүрдсэн хоёр аэродромын бүлэг (AN 16/IV)
Aerodrome reference point	Аэродромын хяналтын цэг	The designated geographical location of an aerodrome.	Аэродромын газар зүйн байршлыг тодорхойлдог цэг (AN 4; AN 14/I)
Aerodrome traffic	Аэродромын хөдөлгөөн	All traffic on the manoeuvring area of an aerodrome and all aircraft flying in the vicinity of an aerodrome. <i>Note.- An aircraft is in the vicinity of an aerodrome when it is in, entering or leaving an aerodrome traffic circuit.</i>	Аэродромын маневрын талбай дээрх бүх хөдөлгөөн болон аэродромын ойролцоо нисэж байгаа бүх агаарын хөлгийн хөдөлгөөн. <u>Тэмдэглэл:</u> Агаарын хөлөг аэродромын нислэгийн хөдөлгөөний хайрцагт байх, орох эсхүл гарах үеийг аэродромын ойролцоо гэж үзнэ. (AN 2; AN 11; PANS-ATM)
Aerodrome traffic density	Аэродромын хөдөлгөөний нягтрал	a) <i>Light.</i> Where the number of movements in the mean busy hour is not greater than 15 per runway or typically less than 20 total aerodrome movements. b) <i>Medium.</i> Where the number of movements in the mean busy hour is of the order of 16 to 25 per runway or typically between 20 to 35 total aerodrome movements.	a) <i>Бага</i> - Хамгийн их ачаалалтай цагийн дундаж хөдөлгөөний тоо нэг ХБЗ-д 15-аас ихгүй, эсхүл 20-оос бага аэродромын хөдөлгөөн. b) <i>Дунд</i> - Хамгийн их ачаалалтай цагийн дундаж хөдөлгөөний тоо нэг ХБЗ-д 16-25, эсхүл 20-35 аэродромын хөдөлгөөн. c) <i>Их</i> - Хамгийн их ачаалалтай цагийн дундаж хөдөлгөөний тоо нэг ХБЗ-д 26 ба түүнээс их, эсхүл 35-аас их аэродромын хөдөлгөөн.

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>c) <i>Heavy</i>. Where the number of movements in the mean busy hour is of the order of 26 or more per runway or typically more than 35 total aerodrome movements.</p> <p><i>Note 1.- The number of movements in the mean busy hour is the arithmetic mean over the year of the number of movements in the daily busiest hour.</i></p> <p><i>Note 2.- Either a take-off or a landing constitutes a movement.</i></p>	<p><i>Тэмдэглэл 1: Хамгийн их ачаалалтай цагийн дундаж хөдөлгөөний тоо гэж жилийн хөдөлгөөний хамгийн их ачаалалтай байсан цагийн дундаж үзүүлэлт.</i></p> <p><i>Тэмдэглэл 2: Аэродромын хөдөлгөөн гэж хөөрөлт болон буултыг хэлнэ. (AN 14/I)</i></p>
Aerodrome traffic zone	Аэродромын хөдөлгөөний зоон	An airspace of defined dimensions established around an aerodrome for the protection of aerodrome traffic.	Аэродромын хөдөлгөөнийг хамгаалах зорилгоор аэродромыг тойруулан тогтоосон хэмжээтэй агаарын зай (AN 2)
Aeronautical administrative communications (AAC)	Нисэхийн захиргаа, удирдлагын холбоо (AAC)	Communications necessary for the exchange of aeronautical administrative messages.	Нисэхийн захиргаа, удирдлагын мэдээлэл солилцоход шаардлагатай холбоо (AN 10/III)
Aeronautical beacon	Нисэхийн гэрэлт дохио	An aeronautical ground light visible at all azimuths, either continuously or intermittently, to designate a particular point on the surface of the earth.	Газрын гадаргуу дээрх тодорхой нэг цэгийн байршлыг илтгэн, зүг бүрд харагдахуйцаар тогтмол, эсхүл тодорхой хэмнэлтэйгээр анивчих гэрлэн дохио (AN 14/I)
Aeronautical broadcasting service	Нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ	A broadcasting service intended for the transmission of information relating to air navigation.	Нислэгтэй холбоотой мэдээлэл дамжуулах зорилготой радио нэвтрүүлгийн үйлчилгээ (AN 10/II)
Aeronautical chart	Нислэгийн зураг	A representation of a portion of the Earth, its culture and relief, specifically designated to meet the requirements of air navigation.	Нислэг үйлдэх шаардлагыг хангах зорилгоор тусгайлан бүтээсэн Дэлхийн гадаргуугийн хэсэг, түүний соёл иргэншил болон өндрийн огтлолын (relief) дүрслэл (AN 4)
Aeronautical data	Нисэхийн өгөгдөл	A representation of aeronautical facts, concepts or instructions in a formalized manner suitable for communication, interpretation or processing.	Харилцах, тайлбарлан таниулах, эсхүл боловсруулахад тохиромжтой байх хэлбэрээр албажуулсан нисэхийн бодит үзүүлэлт, зарчим, эсхүл зааварчилгааны дүрслэл (AN 15)
Aeronautical fixed circuit	Нисэхийн суурин холбооны хэлхээ	A circuit forming part of the aeronautical fixed service (AFS).	AFS-ийн хэсгийг бүрдүүлдэг хэлхээ (AN 10/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aeronautical fixed service (AFS)	Нисэхийн суурин холбооны үйлчилгээ (AFS)	A telecommunication service between specified fixed points provided primarily for the safety of air navigation and for the regular, efficient and economical operation of air services.	Нислэгийн аюулгүй байдал болон агаарын навигацийн үйлчилгээг тогтмол, үр ашигтай, эдийн засгийн хэмнэлттэй байлгах тэргүүн зорилгоор хангадаг тусгайлан тогтоосон тогтмол цэг хоорондын цахилгааны холбооны үйлчилгээ (AN 3; AN 10/II; AN 11; PANS-ATM)
Aeronautical fixed station	Нисэхийн суурин холбооны станц	A station in the aeronautical fixed service.	Нисэхийн суурин холбооны үйлчилгээний станц (AN 10/II; PANS-ATM)
Aeronautical fixed telecommunication network (AFTN)	AFTN (Нисэхийн суурин цахилгаан холбооны сүлжээ)	A worldwide system of aeronautical fixed circuits provided, as part of the aeronautical fixed service, for the exchange of messages and/or digital data between aeronautical fixed stations having the same or compatible communications characteristics.	Ижил, эсхүл тэнцүү холбооны үзүүлэлт бүхий нисэхийн суурин холбооны станцуудын хооронд мэдээ ба/эсхүл тоон өгөгдөл солилцоход зориулсан AFS-ийн хэсэг болох нисэхийн суурин холбооны хэлхээний дэлхийн систем (AN 3; AN 10/II)
Aeronautical ground light	Нисэхийн газрын гэрэл	Any light specially provided as an aid to air navigation, other than a light displayed on an aircraft.	Агаарын хөлөгт суурилуулсан гэрлээс бусад, нислэг үйлдэхэд туслах зорилгоор тусгайлан байрлуулсан аливаа гэрэл (AN 14/I; PANS-ATM)
Aeronautical information	Нисэхийн мэдээлэл	Information resulting from the assembly, analysis and formatting of aeronautical data.	Нисэхийн өгөгдлийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, тогтсон загварт оруулсны үр дүнд бий болсон мэдээлэл (AN 15)
Aeronautical Information Circular (AIC)	Нисэхийн мэдээллийн цуврал (AIC)	A notice containing information that does not qualify for the origination of a NOTAM or for inclusion in the AIP, but which relates to flight safety, air navigation, technical, administrative or legislative matters.	NOTAM-аар мэдээлэх, эсхүл AIP-д оруулах шаардлагагүй боловч нислэгийн аюулгүй байдлын, агаарын навигацийн, техникийн, захиргааны, эсхүл хууль эрх зүйн холбогдолтой мэдээллийг агуулсан мэдэгдэл (AN 15)
Aeronautical information management (AIM)	Нисэхийн мэдээллийн удирдлага (AIM)	The dynamic, integrated management of aeronautical information through the provision and exchange of quality-assured digital aeronautical data in collaboration with all parties.	Оролцогч талууд хамтран чанарын шаардлага хангасан нисэхийн тоон өгөгдлийг түгээх ба солилцох нисэхийн мэдээллийн динамик, нэгдсэн зохицуулалт (AN 15)
Aeronautical information product	Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн	Aeronautical data and aeronautical information provided either as digital data sets or as a standardized presentation in paper or electronic media. Aeronautical information products include:	Цаасан, эсхүл цахим стандартчилсан танилцуулга, эсхүл тоон өгөгдлийн багц, эсхүл аль алиныг нь хангадаг нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээлэл. Үүнд дараах мэдээлэл багтана:

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<ul style="list-style-type: none"> - AIP, including Amendments and Supplements; - AIC; - aeronautical charts; - NOTAM; and - digital data sets. <p><i>Note.- Aeronautical information products are intended primarily to satisfy international requirements for the exchange of aeronautical information.</i></p>	<ul style="list-style-type: none"> - AIP (өөрчлөлт болон нэмэлтийг багтаасан); - AIC; - нислэгийн зураг; - NOTAM; болон - тоон өгөгдлийн багц; (AN15, PANS-AIM) <p><i>Тэмдэглэл: Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн нь нисэхийн мэдээллийг солилцох олон улсын шаардлагыг хангахад голчлон зориулагдана.</i></p>
Aeronautical Information Publication (AIP)	Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)	A publication issued by or with the authority of a State and containing aeronautical information of a lasting character essential to air navigation.	Тухайн Улс, эсхүл түүний зөвшөөрлөөр эрхлэн гаргадаг, нислэг үйлдэхэд зайлшгүй шаардлагатай, байнгын шинж чанартай нисэхийн мэдээллийг агуулсан хэвлэл (AN 2; AN 11; AN 15; PANS-ATM)
Aeronautical information service (AIS)	Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (HMY)	A service established within the defined area of coverage responsible for the provision of aeronautical data and aeronautical information necessary for the safety, regularity and efficiency of air navigation.	Тухайн бүсэд агаарын навигацийг аюулгүй, тогтмол, үр ашигтай гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай нисэхийн мэдээлэл болон нисэхийн өгөгдлөөр хангах үүрэгтэй үйлчилгээ (AN 15)
Aeronautical meteorological station	Нисэхийн цаг уурын өртөө	A station designated to make observations and meteorological reports for use in international air navigation.	Олон улсын агаарын навигацид зориулан цаг уурын ажиглалт хийх болон мэдээ дамжуулахаар томилогдсон өртөө (AN 3)
Aeronautical mobile (route) service (RR S1.33)	Нисэхийн хөдөлгөөнт (замын) холбооны үйлчилгээ (RR S1.33)	An aeronautical mobile service reserved for communications relating to safety and regularity of flight, primarily along national or international civil air routes.	Үндэсний, эсхүл олон улсын иргэний нисэхийн агаарын замын нислэгийн аюулгүй байдал, тогтмолжилтыг хангах үндсэн зорилготой холбооны зориулалтаар нөөцөлсөн нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ (AN 10/II)
Aeronautical mobile service (RR S1.32)	Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ (RR S1.32)	A mobile service between aeronautical stations and aircraft stations, or between aircraft stations, in which survival craft stations may participate; emergency position-indicating radiobeacon stations may also participate in this service on designated distress and emergency frequencies.	Нисэхийн холбооны станц болон агаарын хөлгийн станцын хооронд, эсхүл агаарын хөлгийн станцуудын хоорондох хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, үүнд агаарын хөлгийн аврах станц багтаж болно. Энэ үйлчилгээнд аюулын болон ослын оноосон давтамжаар ослын байршил заадаг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			радио дохиологч станц багтаж болно. (AN 3; AN 10/II; AN 11; PANS-ATM)
Aeronautical mobile-satellite (route) service (RR S1.36)	Нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт (замын) холбооны үйлчилгээ (RR S1.36)	An aeronautical mobile-satellite service reserved for communications relating to safety and regularity of flights, primarily along national or international civil air routes.	Үндэсний, эсхүл олон улсын иргэний нисэхийн агаарын замын нислэгийн аюулгүй байдал, тогтмолжилтыг хангах үндсэн зорилготой холбооны зориулалтаар нөөцөлсөн нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээ (AN 10/II)
Aeronautical mobile-satellite service (RR S1.35)	Нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээ (RR S1.35)	A mobile-satellite service in which mobile earth stations are located on board aircraft; survival craft stations and emergency position-indicating radiobeacon stations may also participate in this service.	Агаарын хөлөгт суурилуулсан хиймэл дагуулын хөдөлгөөнт станц ашигладаг хиймэл дагуулын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ. Энэ үйлчилгээнд агаарын хөлгийн аврах станц болон ослын байршил заадаг радио дохиологч станц багтаж болно. (AN 10/II)
Aeronautical operational control (AOC)	Нисэхийн үйл ажиллагааны удирдлагын холбоо (AOC)	Communication required for the exercise of authority over the initiation, continuation, diversion or termination of flight for safety, regularity and efficiency reasons.	Аюулгүй, тогтмол болон үр ашигтай байх зорилгоор нислэгийг эхлүүлэх, үргэлжлүүлэх, даялах, эсхүл цуцлах эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай холбоо (AN 10/III)
Aeronautical radio navigation service (RR S1.46)	Нисэхийн радио навигацийн үйлчилгээ	A radio navigation service intended for the benefit and for the safe operation of aircraft.	Агаарын хөлгийн үр ашигтай, аюулгүй үйл ажиллагаанд зориулсан радио навигацийн үйлчилгээ (AN 10/II)
Aeronautical station (RR S1.81)	Нисэхийн холбооны станц (RR S1.81)	A land station in the aeronautical mobile service. In certain instances, an aeronautical station may be located, for example, on board ship or on a platform at sea.	Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний газрын станц. Зарим тохиолдолд, жишээ нь нисэхийн холбооны станц нь усан онгоц, эсхүл далайн платформ дээр байрлаж болно. (AN 2; AN 10/II; PANS-ATM)
Aeronautical telecommunication agency	Нисэхийн цахилгаан холбооны байгууллага	An agency responsible for operating a station or stations in the aeronautical telecommunication service.	Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний станц, эсхүл станцуудын үйл ажиллагааг хариуцсан байгууллага (AN 10/II)
Aeronautical telecommunication log	Нисэхийн цахилгаан холбооны бүртгэл	A record of the activities of an aeronautical telecommunication station.	Нисэхийн цахилгаан холбооны станцын ажиллагааны бүртгэл (AN 10/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aeronautical telecommunication network (ATN)	Нисэхийн цахилгаан холбооны сүлжээ (ATN)	A global internetwork architecture that allows ground, air-ground and avionic data subnetworks to exchange digital data for the safety of air navigation and for the regular, efficient and economic operation of ATS.	НХУ-ний үйл ажиллагаа нь тогтмол, үр ашигтай ба эдийн засгийн хэмнэлттэй байх болон нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор газар, агаар-газар болон цахилгаан-өгөгдлийн дэд сүлжээнд тоон өгөгдлийг солилцох боломж олгодог дэлхийн интернэт сүлжээний бүтэц (AN 10/III)
Aeronautical telecommunication service	Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээ	A telecommunication service provided for any aeronautical purpose.	Нисэхийн зориулалтаар хангадаг цахилгаан холбооны үйлчилгээ (AN 10/II; PANS-ATM)
Aeronautical telecommunication station	Нисэхийн цахилгаан холбооны станц	A station in the aeronautical telecommunication service.	Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний станц (AN 3; AN 10/II; AN 11; PANS-ATM)
Aeroplane	Нисэх онгоц	A power-driven heavier-than-air aircraft, deriving its lift in flight chiefly from aerodynamic reactions on surfaces which remain fixed under given conditions of flight.	Нислэгийн тухайн нөхцөлд хөдөлгөөнгүй байрласан гадаргуу агаартай харьцсан аэродинамикийн хүчний нөлөөллөөр нислэгт ихэнх өргөх хүчээ үүсгэдэг, хөдөлгүүртэй, агаараас хүнд агаарын хөлөг (AN 1; AN 2; AN 6/I; AN 6/II; AN 7; AN 8; AN 16/I; AN 19)
Aeroplane owner	Нисэх онгоцны өмчлөгч	Person(s), organization(s) or enterprise(s) identified via Item 4 (Name of owner) and Item 5 (Address of owner) on the certificate of registration of an aeroplane.	Тухайн нисэх онгоцны бүртгэлийн гэрчилгээний Заалт 4 (Өмчлөгчийн нэр) болон Заалт 5-аар (Өмчлөгчийн хаяг) тодорхойлдог хүн, байгууллага, эсхүл компани (AN 16/IV)
Aeroplane reference field length	Нисэх онгоцны хяналтын талбайн урт	The minimum field length required for take-off at maximum certificated take-off mass, sea level, standard atmospheric conditions, still air and zero runway slope, as shown in the appropriate aeroplane flight manual prescribed by the certificating authority or equivalent data from the aeroplane manufacturer. Field length means balanced field length for aeroplanes, if applicable, or take-off distance in other cases. <i>Note.- Attachment A, Section 2, provides information on the concept of balanced field length and the Airworthiness Manual (Doc 9760) contains detailed guidance on matters related to take-off distance.</i>	Гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын баталсан нисэх онгоцны нислэгийн зааварт, эсхүл тухайн нисэх онгоц үйлдвэрлэгчийн дүйцэх өгөгдөлд заасан, MCTOW-тэй, далайн түвшинд, ISA-д, тогтуун агаарт, тэг налуутай ХБЗ дээр хөөрөлт үйлдэхэд шаардлагатай минимум талбайн урт. Талбайн урт гэж хэрэв хамааралтай бол тухайн нисэх онгоцонд тогтоосон талбайн урт (balanced field length), эсхүл бусад тохиолдолд хөөрөлтийн зай (take-off distance) (AN 14/I) <i>Тэмдэглэл: Annex 14, Vol.I, Attachment A, Section 2 нь тогтоосон талбайн уртыг тодорхойлох зарчмын мэдээллийг хангадаг ба Airworthiness Manual (Doc 9760)</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			нь хөөрөлтийн зайтай холбоотой дэлгэрэнгүй аргачлалыг агуулдаг.
After burning	Турбины арын шаталт (форсаж)	A mode of engine operation wherein a combustion system fed (in whole or part) by vitiated air is used.	Турбины дараа түлштэй агаараар шатаах системийг дэмжих (бүрэн, эсхүл хэсэгчлэн) хөдөлгүүрийн үйл ажиллагааны горим (AN 16/II)
AFTN circuit	AFTN хэлхээ	A circuit forming part of the aeronautical fixed telecommunication network (AFTN).	Нисэхийн суурин цахилгаан холбооны сүлжээ (AFTN)-г бүрдүүлдэг хэлхээ (AN 10/II)
AFTN communication centre	AFTN холбооны төв	An AFTN station whose primary function is the relay or retransmission of AFTN traffic from (or to) a number of other AFTN stations connected to it.	Түүнтэй холбоо тогтоосон бусад AFTN станцаас AFTN-ний урсгалыг хүлээн авах, эсхүл дахин дамжуулах үндсэн үүрэгтэй AFTN станц (AN 10/II)
AFTN destination station	AFTN хүлээн авах станц	An AFTN station to which messages and/or digital data are addressed for processing for delivery to the addressee.	Хүлээн авагчид хүргэх зорилгоор боловсруулалт хийлгэхээр тухайн мэдээ ба/эсхүл тоон өгөгдлийг хаягласан AFTN станц (AN 10/II)
AFTN origin station	AFTN илгээх станц	An AFTN station where messages and/or digital data are accepted for transmission over the AFTN.	Мэдээ ба/эсхүл тоон өгөгдлийг AFTN-ээр дамжуулахыг зөвшөөрсөн AFTN станц (AN 10/II)
AFTN station	AFTN станц	A station forming part of the aeronautical fixed telecommunication network (AFTN) and operating as such under the authority or control of a State.	Тухайн Улсын удирдлага, эсхүл хяналтын доор үйл ажиллагаа гүйцэтгэдэг, AFTN-ний хэсгийг бүрдүүлдэг станц (AN 10/II)
Agreement summary	Гэрээний тойм	When an aircraft is operating under an Article 83 bis agreement between the State of Registry and another State, the agreement summary is a document transmitted with the Article 83 bis Agreement registered with the ICAO Council that identifies succinctly and clearly which functions and duties are transferred by the State of Registry to that other State. <i>Note.- The other State in the above definition refers to the State of the principal location of a general aviation operator.</i>	Агаарын хөлөг Бүртгэгч улс болон өөр Улсын хооронд Зүйл 83 bis гэрээний дагуу үйл ажиллагаа хийж байгаа бол, гэрээний тойм гэж Бүртгэгч Улсаас нөгөө Улсад ямар ажил, үүргийг шилжүүлсэн болохыг товч бөгөөд тодорхой заасан ICAO Консулд бүртгэгдсэн Зүйл 83 bis гэрээтэй хамт дамжуулсан баримт бичгийг ойлгоно. <i>Тэмдэглэл: Дээрх тайлбарт орсон өөр Улс гэж ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан ёсоор байрладаг Улсыг ойлгоно. (AN 4; AN 6/II)</i>
AIP Amendment	AIP-ын өөрчлөлт	Permanent changes to the information contained in the AIP.	AIP-ын мэдээлэлд орсон байнгын шинж чанартай өөрчлөлт (AN 15)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
AIP Supplement	AIP-ын нэмэлт	Temporary changes to the information contained in the AIP which are provided by means of special pages.	AIP-ын мэдээлэлд орсон, тусгай хуудсаар хэвлэн нийтэлсэн түр өөрчлөлт (AN 15)
Air defence identification zone	Агаараас эсэргүүцэн хамгаалах системийн таньж тогтоох бүс	Special designated airspace of defined dimensions within which aircraft are required to comply with special identification and/or reporting procedures additional to those related to the provision of ATS.	НХУ-ний хангалттай холбоотой журмаас гадна тухайн бүсэд агаарын хөлөг тусгай таньж тогтоох ба/эсхүл илтгэх журмыг дагаж мөрдөх шаардлагатай байхаар оноосон хэмжээтэй тусгайлан тогтоосон агаарын зай (AN 4; AN 15)
Air operator certificate	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ	A certificate authorizing an operator to carry out specified commercial air transport operations.	Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгодог гэрчилгээ (AN 6/I; AN 6/III)
Air traffic	Нислэгийн хөдөлгөөн	All aircraft in flight or operating on the manoeuvring area of an aerodrome.	Нисэж байгаа, эсхүл аэродромын маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бүх агаарын хөлөг (AN 2; AN 11; PANS-ATM)
Air traffic advisory service	Нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээ	A service provided within advisory airspace to ensure separation, in so far as practical, between aircraft which are operating on IFR flight plans.	IFR нислэгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг хоорондын зайчлалыг аль болох боломжит хэлбэрээр бататгах зорилготой зөвлөх үйлчилгээтэй агаарын зайд үзүүлдэг үйлчилгээ (AN 2; AN 11; PANS-ATM)
Air traffic controller schedule	Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн хуваарь	A plan for allocating air traffic controller duty periods and non-duty periods over a period of time, otherwise referred to as a roster.	Тодорхой цаг хугацаанд нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэгт хугацаа болон үүргээс чөлөөтэй байх хугацааг заасан төлөвлөгөө; өөрөөр ээлжийн хуваарь гэж нэрлэдэг. (AN 11)
Air traffic flow management	Нислэгийн урсгал зохицуулалт	A service established with the objective of contributing to a safe, orderly and expeditious flow of air traffic by ensuring that ATC capacity is utilized to the maximum extent possible and that the traffic volume is compatible with the capacities declared by the appropriate ATS authority.	НХУ-ын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадвар нь боломжит дээд түвшинд ашиглагдаж байгаа ба хөдөлгөөний урсгал нь НХУ-ний эрх бүхий байгууллагаас зарласан багтаамжид нийцэж байгаа болохыг бататгах замаар нислэгийн хөдөлгөөний урсгалын аюулгүй, дэс дараалалтай, түргэн шуурхай байдлыг хангах зорилгоор үзүүлдэг үйлчилгээ (AN 11; PANS-ATM)
Air traffic management (ATM)	Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт (ATM)	The dynamic, integrated management of air traffic and airspace (including ATS, airspace management and air traffic flow management) -	Бүх оролцогч талуудтай хамтран, агаар ба газарт суурилсан ажиллагааг оролцуулсан байгууламж болон нэгдсэн үйлчилгээний хангалтаар

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		safely, economically and efficiently - through the provision of facilities and seamless services in collaboration with all parties and involving airborne and ground-based functions.	дамжуулан нислэгийн хөдөлгөөн болон агаарын зайн аюулгүй, эдийн засгийн үр ашигтай ба үр дүнтэй, динамик, нэгдсэн зохицуулалт (AN 15)
Air traffic service	НХУ (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ)	A generic term meaning variously, flight information service, alerting service, air traffic advisory service, ATC service (area control service, approach control service or aerodrome control service).	Нислэгийн мэдээллийн, анхааруулах, нислэгийн хөдөлгөөний зөвлөх, НХУ-ын (бүсийн, ойртолтын, аэродромын удирдлагын) үйлчилгээ зэрэг олон утгатай ерөнхий ойлголт (AN 2; AN 4; AN 10/III; AN 11; PANS-ATM)
Air transit route	Агаараар явгалах зам	A defined route for the air transiting of helicopters.	Нисдэг тэрэг агаараар шилжих хөдөлгөөн хийхэд зориулан тогтоосон зам (AN 4; AN 14/II)
AIRAC (Aeronautical information regulation and control)	AIRAC (Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт)	An acronym (aeronautical information regulation and control) signifying a system aimed at advance notification, based on common effective dates, of circumstances that necessitate significant changes in operating practices.	Нийтлэг хүчинтэй хугацаанд суурилсан, үйл ажиллагааны практикт зарчмын өөрчлөлт оруулахыг шаарддаг нөхцөл байдлын талаар урьдчилсан мэдээллээр хангах зорилготой тогтолцоог илэрхийлдэг товчлол (AN 15)
Airborne collision avoidance system (ACAS)	Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем	An aircraft system based on secondary surveillance radar (SSR) transponder signals which operates independently of ground-based equipment to provide advice to the pilot on potential conflicting aircraft that are equipped with SSR transponders.	Ажиглалтын хоёрдогч радар (SSR) транспондерын мэдээлэлд үндэслэн, SSR транспондероор тоногдсон агаарын хөлөгтэй ойртож байгаа мэдээллийг нисгэгчид өгөх зориулалттай, газарт суурилуулсан төхөөрөмжөөс хамааралгүй ажилладаг бүхээгийн систем (AN 2; AN 10/IV; AN 11; PANS-ATM; PANS-OPS/I)
Aircraft	Агаарын хөлөг	Any machine that can derive support in the atmosphere from the reactions of the air other than the reactions of the air against the earth's surface.	Агаар газрын гадаргуутай харилцан үйлчилснээс өөр, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд хөөрөн нисэх чадвартай төхөөрөмж (AN 1; AN 2; AN 3; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 7; AN 8; AN 11; AN 13; AN 16/I; AN 19; PANS-ATM)
Aircraft - category	Агаарын хөлгийн категори	Classification of aircraft according to specified basic characteristics, e.g. aeroplane, helicopter, glider, free balloon.	Нисэх онгоц, бөмбөлөг, глайдер, ханг-глайдер, нисдэг тэрэг, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн ангилал (AN 1)
Aircraft - type of	Агаарын хөлгийн маяг	All aircraft of the same basic design including all modifications thereto except those modifications	Агаарын хөлгийн жолоодлого, эсхүл нислэгийн үзүүлэлтэд том өөрчлөлт оруулдаг модификацаас

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		which result in a change in handling or flight characteristics.	бусад түүнд хийсэн бүх модификацийг багтаасан ижил үндсэн загвартай бүх агаарын хөлөг (AN 1)
Aircraft address	Агаарын хөлгийн хаяг	A unique combination of twenty-four bits available for assignment to an aircraft for the purpose of airground communications, navigation and surveillance.	Агаар-газрын холбоо, навигаци, ажиглалтыг хангах үүднээс агаарын хөлөгт оноож өгсөн дахин давтагдахгүй 24 битийн хэмжээтэй хаяг (AN 10/III; PANS-ATM)
Aircraft avionics	Агаарын хөлгийн хэрэглэл, цахилгааны төхөөрөмж	A term designating any electronic device - including its electrical part - for use in an aircraft, including radio, automatic flight control and instrument systems.	Агаарын хөлөгт ашигладаг радио-холбоо, автомат нислэгийн удирдлага, хэрэглэлийн системийг багтаасан, түүний аливаа цахилгаан эд анги, хэрэгслийг нэрлэх нэр томьёо (AN 1)
Aircraft certificated for single-pilot operation	Ганц нисгэгчтэй үйл ажиллагаанд гэрчилгээжсэн агаарын хөлөг	A type of aircraft which the State of Registry has determined, during the certification process, can be operated safely with a minimum crew of one pilot.	Гэрчилгээжүүлэлтийн явцад Бүртгэгч Улс, минимум багийн гишүүн нэг нисгэгчтэй аюулгүй нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж чадахыг тогтоосон агаарын хөлгийн маяг (AN 1)
Aircraft classification rating (ACR)	Агаарын хөлгийн ангиллын зэрэглэл	A number expressing the relative effect of an aircraft on a pavement for a specified standard subgrade category.	Заасан стандартын ул хөрсний ангиллын хувьд тухайн агаарын хөлөг хучилтад нөлөөлөх чадварыг илэрхийлдэг тоон утга (AN 14/I)
Aircraft earth station (AES)	Агаарын хөлгийн хиймэл дагуулын станц (AES)	A mobile earth station in the aeronautical mobile-satellite service located on board an aircraft.	Агаарын хөлөгт суурилуулсан нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашигладаг хөдөлгөөнт станц (GES-ыг мөн үз) (AN 10/III)
Aircraft equipment	Агаарын хөлгийн төхөөрөмж	Articles, including first-aid and survival equipment and commissary supplies, but not spare parts or stores, for use on board an aircraft during flight.	Анхны тусламжийн болон аврах төхөөрөмж, зорчигч үйлчилгээний хангамжийг багтаасан нислэгийн үед агаарын хөлгийн үйлчилгээнд хэрэглэх эд зүйл, гэхдээ үүнд сэлбэг эд анги, эсхүл түүний нөөц орохгүй (AN 9)
Aircraft observation	Агаарын хөлгөөс ажиглалт хийх	The evaluation of one or more meteorological elements made from an aircraft in flight.	Нислэгт байгаа агаарын хөлгөөс хийсэн нэг, эсхүл хэд хэдэн цаг уурын элементийн үнэлгээ (AN 3; PANS-ATM)
Aircraft operating agency	Агаарын хөлгийн үйл ажиллагааны байгууллага	A person, organization or enterprise engaged in, or offering to engage in, an aircraft operation.	Агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл эрхлэхийг зорьж байгаа хүн, байгууллага, аж ахуйн нэгж (AN 10/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aircraft operating manual	Агаарын хөлгийн үйл ажиллагааны заавар	A manual, acceptable to the State of the Operator, containing normal, abnormal and emergency procedures, checklists, limitations, performance information, details of the aircraft systems and other material relevant to the operation of the aircraft.	Хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн үйл ажиллагаа, агаарын хөлгийн шалгах хуудас, хязгаарлалт, үзүүлэлтийн мэдээлэл, түүний системийн дэлгэрэнгүй мэдээлэл болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг багтаасан, Үйл ажиллагаа эрхлэгчийг харьяалах Улс хүлээн зөвшөөрсөн заавар (AN 6/I; AN 6/III)
Aircraft operator	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	A person, organization or enterprise engaged in or offering to engage in an aircraft operation.	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл эрхлэхийг зорьж байгаа иргэн, хуулийн этгээд (AN 3; AN 6/I; AN 6/III; AN 9; AN 12; AN 13; AN 18)
Aircraft operators' documents	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн баримт бичиг	Air waybills/consignment notes, passenger tickets and boarding passes, bank and agent settlement plan documents, excess baggage tickets, miscellaneous charges orders (M.C.O.), damage and irregularity reports, baggage and cargo labels, timetables, and weight and balance documents, for use by aircraft operators.	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зориулсан ачааны дагалдах бичиг, зорчигчийн тийз, суугчийн тасалбар, агент / төлөөлөгчийн болон банк хоорондын төлбөр тооцооны баримт, илүү тээшний төлбөрийн болон төрөл бүрийн хураамжийн төлбөрийн баримт (M.C.O), гэмтсэн болон зөрчилтэй тээшний акт, тээш, ачааны шошго, цагийн хуваарь, жин ба төвлөрөлтийн баримт бичиг (AN 9)
Aircraft required to be operated with a co-pilot	Хамтран нисгэгч шаардлагатай агаарын хөлөг	A type of aircraft that is required to be operated with a co-pilot, as specified in the flight manual or by the air operator certificate.	Нислэгийн зааварт, эсхүл агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд нь хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа гүйцэтгэх шаардлагатай гэж заасан агаарын хөлгийн маяг (AN 1)
Aircraft security check	Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын үзлэг	An inspection of the interior of an aircraft to which passengers may have had access and an inspection of the hold for the purposes of discovering suspicious objects, weapons, explosives or other dangerous devices, articles and substances.	Сэжигтэй биет, зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл болон бодисыг илрүүлэх зорилготой, зорчигч орох боломжтой агаарын хөлгийн дотор хэсгийн үзлэг шалгалт болон хадгалах хэсгийн үзлэг шалгалт (AN 17)
Aircraft security search	Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын шалгалт	A thorough inspection of the interior and exterior of the aircraft for the purpose of discovering suspicious objects, weapons, explosives or other dangerous devices, articles or substances.	Сэжигтэй биет, зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг илрүүлэх зорилготой, агаарын хөлгийн дотор болон гадна хэсгийн үзлэг шалгалт (AN 17)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aircraft stand	Агаарын хөлгийн зогсоол	A designated area on an apron intended to be used for parking an aircraft.	Агаарын хөлгийг байрлуулахад зориулан апро дээр тогтоосон бүс (AN 4; AN 14/I)
Aircraft station (RR S1.83)	Агаарын хөлгийн станц	A mobile station in the aeronautical mobile service, other than a survival craft station, located on board an aircraft.	Агаарын хөлгийн аврах станцаас бусад, агаарын хөлөгт суурилуулсан нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний хөдөлгөөнт станц (AN 10/II)
Aircraft to be intercepted (intercepted aircraft)	Албадан саатуулах агаарын хөлөг	<p>Aircraft suspected by military, customs, police authorities or ATS organization for following violation:</p> <p>a) suspect that an aircraft is engaged in illegal flight and/or transportation of illicit goods or persons, inconsistent with the aims of the Chicago Convention and contrary to the laws of said State.</p> <p>b) enters the sovereign airspace of a State through different positions or routes from those stated in the overflight permission; or</p> <p>c) are unable to secure positive identification of an aircraft observed in or entering the sovereign airspace of the State by means other than visual inspection, i.e. by co-ordination with ATS units and/or by surveillance system;</p> <p>d) enters the sovereign airspace of a State without proper permission and fails to comply with instructions to land or to leave the airspace;</p> <p>e) observe that an aircraft without proper authorization is about to enter, or has entered, an area in its territory in which civil flights are restricted or prohibited;</p> <p>f) observe that an aircraft within its airspace deviates from a designated ATS route, or a flight plan route outside the ATS route network, without a known or apparent valid reason for the deviation; or</p> <p>g) constitutes a hazard to other aircraft.</p>	<p>Батлан хамгаалах, гааль, цагдаагийн эрх бүхий байгууллага, эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага дараах зөрчилд сэжиглэгдэж байгаа агаарын хөлөг:</p> <p>a) Конвенцын зорилгод нийцэхгүй, тухайн Улсын хууль зөрчин хууль бус бараа, эсхүл этгээдийг тээвэрлэх хууль бус нислэг ба/эсхүл тээвэрлэлт хийсэн гэж сэжиглэгдэж байгаа; эсхүл</p> <p>b) зөвшөөрөлд зааснаас өөр цэгээр Монгол Улсын агаарын зайд нэвтэрсэн, эсхүл өөр агаарын замаар нислэг үйлдсэн; эсхүл</p> <p>c) нислэгийн хөдөлгөөний ажиглалтын ба/эсхүл бусад оптик төхөөрөмж ашиглан бүрэн танигдаж тогтоогдоогүй байдалтай Монгол Улсын агаарын зайд нэвтэрсэн, эсхүл нэвтрэхийг завдсан; эсхүл</p> <p>d) зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын агаарын зайд нэвтэрч, агаарын зайг орхин гарах, эсхүл буух шаардлагыг биелүүлээгүй; эсхүл</p> <p>e) нислэг үйлдэхийг хориглосон цэргийн үйл ажиллагааны хориотой, эсхүл хязгаарлалттай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, эсхүл нэвтрэхийг завдсан; эсхүл</p> <p>f) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон агаарын замаас гарсан, эсхүл нислэгийн төлөвлөгөөнд заасан замаас хазайсан; эсхүл</p> <p>g) бусад агаарын хөлөгт аюул учруулсан. (AN 2)</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Aircraft tracking	Агаарын хөлгийн замын хяналт	A process, established by the operator, that maintains and updates, at standardized intervals, a ground-based record of the four dimensional position of individual aircraft in flight.	Нислэгт байгаа агаарын хөлгийн дөрвөн хэмжээст байршлын газарт суурилсан бүртгэлийг стандартчилсан үечлэлтэйгээр шинэчлэн тогтоодог үйл ажиллагаа эрхлэгчийн тогтоосон процесс (AN 6/I)
Air-ground communication	Агаар - газар хоёр талын холбоо	Two-way communication between aircraft and stations or locations on the surface of the earth.	Агаарын хөлөг болон газрын гадаргууд байрлах станц, эсхүл байрлал хооронд барих хоёр талын холбоо (AN 10/II; AN 11; PANS-ATM)
Air-ground control radio station	Агаар - газрын удирдлагын радио станц	An aeronautical telecommunication station having primary responsibility for handling communications pertaining to the operation and control of aircraft in a given area.	Тогтоосон бүсэд байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаа болон удирдлагад хамаарах холбооны үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэгтэй нисэхийн цахилгаан холбооны станц (AN 2; AN 10/II; PANS-ATM)
Airline	Агаарын тээвэрлэгч	As provided in Article 96 of the Convention, any air transport enterprise offering or operating a scheduled international air service.	Конвенцын Зүйл 96-д заасны дагуу хуваарьт олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлдэг, эсхүл түүнийг санал болгож байгаа агаарын тээврийн байгууллага (AN 9)
Airmanship	Нислэгийн ур чадвар	The consistent use of good judgement and well-developed knowledge, skills and attitudes to accomplish flight objectives.	Нислэгийн үүрэг гүйцэтгэхдээ зөв шийдвэр гаргах чадвар, өндөр мэдлэг боловсрол, чадвар болон зөв ёс суртахуун хандлагаа байнга ашиглах төлөв байдал (AN 1)
AIRMET information	AIRMET мэдээ	Information issued by a meteorological watch office concerning the occurrence or expected occurrence of specified en-route weather phenomena which may affect the safety of low-level aircraft operations and which was not already included in the forecast issued for low-level flights in the flight information region concerned or sub-area thereof.	Нислэгийн нам өндрийн-түвшинд агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй ба тухайн FIR, эсхүл дэд бүсийн нислэгийн нам өндрийн-түвшинд урьдчилсан мэдээнд багтаагүй нислэгийн замд ажиглагдсан, эсхүл үүсэж болно гэж таамагласан цаг уурын аюултай үзэгдлийн талаар цаг уурын ажиглалтын төвөөс гаргадаг мэдээ (AN 3; AN 11; PANS-ATM)
Air-report	Агаарын хөлгийн мэдээ	A report from an aircraft in flight prepared in conformity with requirements for position, and operational and/or meteorological reporting. <i>Note.- Details of the AIREP form are given in the PANS-ATM (Doc 4444).</i>	Нислэгт байгаа агаарын хөлгөөс байршил, үйл ажиллагаа ба/эсхүл цаг уурын мэдээний шаардлагад нийцүүлэн бэлдэж дамжуулдаг мэдээ (AN 3; AN 10/II; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			<i>Тэмдэглэл: PANS-ATM (Doc 4444)-т AIREP маягтын дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн.</i>
Airship	Дирижабль	A power-driven lighter-than-air aircraft.	Хөдөлгүүртэй, агаараас хөнгөн агаарын хөлөг (AN 1; AN 7)
Airside	Хамгаалалттай бүс	The movement area of an airport, adjacent terrain and buildings or portions thereof, access to which is controlled.	Нисэх буудлын хөдөлгөөний талбай, түүний зэргэлдээх хяналттай нэвтэрдэг бүс болон байгууламж, эсхүл түүний хэсэг (AN 17)
Air-taxiing	Агаараар явгалах	Movement of a helicopter/VTOL above the surface of an aerodrome, normally in ground effect and at a ground speed normally less than 37 km/h (20 kt). <i>Note.- The actual height may vary, and some helicopters may require air-taxiing above 8 m (25 ft) AGL to reduce ground effect turbulence or provide clearance for cargo slingloads.</i>	Аэродромын гадаргуугаас дээш, босоо хөөрөлт буулт үйлдэх (VTOL) нисдэг тэрэгний, 37 км/цагаас дээшгүй хурдтайгаар, газрын нөлөөний үйлчлэлээр агаараар шилжих хөдөлгөөн <i>Тэмдэглэл: Бодит өндөр өөр өөр байж болно. Газрын нөлөөний хуйлралыг багасгах, эсхүл татлагат ачааны саадыг давах өндрийг хангах зорилгоор зарим нисдэг тэрэгт агаараар явгалахын тулд газрын гадаргуугаас дээш 8 м-ээс (25 ft) илүү өндөр шаардлагатай байж болно. (AN 2; AN 11; PANS-ATM)</i>
Air-to-ground communication	Агаар - газар нэг талын холбоо	One-way communication from aircraft to stations or locations on the surface of the earth.	Агаарын хөлгөөс газрын гадаргуу дээрх станц, эсхүл байрлал руу барих нэг талын холбоо (AN 10/II; PANS-ATM)
Airway	Агаарын зам	A control area or portion thereof established in the form of a corridor.	Хонгил хэлбэрээр тогтоосон НХУ-тай бүс, эсхүл түүний хэсэг (AN 1; AN 2; AN 4; AN 11; PANS-ATM)
Airworthy	Нислэгт тэнцэх	The status of an aircraft, engine, propeller or part when it conforms to its approved design and is in a condition for safe operation.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл түүний эд анги нь батлагдсан загварын стандартад нийцэж байгаа ба үйл ажиллагааны аюулгүй нөхцөлд байгаа төлөв байдал (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 8)
ALERFA	ALERFA	The code word used to designate an alert phase.	Түгшүүрийн үеийг илэрхийлэхэд зориулан ашигладаг түлхүүр үг (AN 11)
Alert phase (ALERFA)	Түгшүүрийн үе (ALERFA)	A situation wherein apprehension exists as to the safety of an aircraft and its occupants.	Агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд санаа зовох шалтгаан үүссэн нөхцөл (AN 11; AN 12; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Alerting post	Анхааруулах мэдээллийн нэгж	Any facility intended to serve as an intermediary between a person reporting an emergency and a rescue coordination centre or rescue subcentre.	Онцгой байдлын талаар мэдээлсэн этгээд болон авран туслах зохицуулалтын төв, дэд төвийн хооронд холбох үүрэгтэй нэгж (AN 12)
Alerting service	Аюулын дохио мэдээлэх үйлчилгээ	A service provided to notify appropriate organizations regarding aircraft in need of SAR aid, and assist such organizations as required.	ЭХАТ тусламж шаардлагатай агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх, шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (AN 1; AN 2; AN 11; PANS-ATM)
Alternate aerodrome	Бэлтгэл аэродром	<p>An aerodrome to which an aircraft may proceed when it becomes either impossible or inadvisable to proceed to or to land at the aerodrome of intended landing where the necessary services and facilities are available, where aircraft performance requirements can be met and which is operational at the expected time of use. Alternate aerodromes include the following:</p> <p><i>Take-off alternate.</i> An alternate aerodrome at which an aircraft would be able to land should this become necessary shortly after take-off and it is not possible to use the aerodrome of departure.</p> <p><i>En-route alternate.</i> An alternate aerodrome at which an aircraft would be able to land in the event that a diversion becomes necessary while en route.</p> <p><i>Destination alternate.</i> An alternate aerodrome at which an aircraft would be able to land should it become either impossible or inadvisable to land at the aerodrome of intended landing.</p> <p><i>Note.- The aerodrome from which a flight departs may also be an en-route or a destination alternate aerodrome for that flight.</i></p>	<p>Буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд буух, эсхүл түүнийг чиглэн нисэх боломжгүй, эсхүл эргэлзээтэй болсон үед агаарын хөлөг чиглэн нисэж болох, шаардлагатай үйлчилгээ болон байгууламжтай, агаарын хөлгийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж чадах ба тухайн цаг хугацаанд ажилтай байгаа аэродром. Дараах бэлтгэл аэродром байдаг:</p> <p><i>Хөөрөлтийн бэлтгэл аэродром (Take-off alternate)</i> - нисэн гарсан аэродромыг ашиглах боломжгүй тохиолдолд хөөрөлтийн дараа агаарын хөлөг буулт үйлдэх шаардлага гарсан үед буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром;</p> <p><i>Нислэгийн замын бэлтгэл аэродром (En-route alternate)</i> - нислэгийн замд даялах шаардлага гарсан тохиолдолд агаарын хөлөг буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром;</p> <p><i>Нисэн очих бэлтгэл аэродром (Destination alternate)</i> - буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд буулт үйлдэх боломжгүй, эсхүл эргэлзээтэй болсон үед агаарын хөлөг буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром. (AN 2, AN 3, AN 6/I, AN 6/II AN 11)</p> <p><u>Тэмдэглэл:</u> Тухайн нислэг нисэн гарсан аэродром нь тухайн нислэгт замын, эсхүл нисэн хүрэх бэлтгэл аэродром байж болно.</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Alternative means of communication	Холбооны нөөц хэрэгсэл	A means of communication provided with equal status, and in addition to the primary means.	Ижил статустай ба үндсэн хэрэгсэлд нэмэлт байдлаар хангадаг холбооны хэрэгсэл (AN 10/II; AN 10/V)
Altimetry system error (ASE)	Алтиметрийн системийн алдаа	The difference between the altitude indicated by the altimeter display, assuming a correct altimeter barometric setting, and the pressure altitude corresponding to the undisturbed ambient pressure.	Алтиметрийн даралтын тохируулгыг зөв гэж тооцон, алтиметрийн дэлгэцэд зааж байгаа өндрийн-түвшин болон тогтуун орчны даралтад хамаарах өндрийн-түвшний даралт хоорондын зөрүү (AN 6/I; AN 6/II)
Altitude	Өндрийн-түвшин	The vertical distance of a level, a point or an object considered as a point, measured from MSL.	MSL-ээс хэмжсэн, түвшний, цэгийн, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зай (AN 2; AN 3; AN 4; AN 10/I; AN 10/II; AN 11; PANS-ATM; PANS-OPS/II)
Ampere (A)	Ампер (A)	Constant electric current which, if maintained in two straight parallel conductors of infinite length, of negligible circular cross-section, and placed 1 metre apart in a vacuum, would produce between these conductors a force equal to 2×10^{-7} newton per metre of length.	Хязгааргүй урттай, маш бага хөндлөн огтлолтой, параллел хоёр шулуун дамжуулагчийг вакуум орчинд хооронд нь 1 м зайтай байрлуулсан байхад эдгээр дамжуулагчийн хооронд 1 м тутамд 2×10^{-7} N-той тэнцүү хүч үүсгэдэг тогтмол цахилгаан гүйдэл (AN 5)
Angular displacement sensitivity	Өнцгийн шилжилтийн мэдрэмж	The ratio of measured DDM to the corresponding angular displacement from the appropriate reference line.	Зохих хяналтын шугамаас хазайсан хамаарах өнцгийн шилжилтийг хэмжсэн DDM-д хуваасан харьцаа (AN 10/I)
Annex	Annex	Annex to the Convention.	Конвенцын Хавсралт
Anticipated operating conditions	Таамаглаж байгаа үйл ажиллагааны нөхцөл	Those conditions which are known from experience or which can be reasonably envisaged to occur during the operational life of the aircraft taking into account the operations for which the aircraft is made eligible, the conditions so considered being relative to the meteorological state of the atmosphere, to the configuration of terrain, to the functioning of the aircraft, to the efficiency of personnel and to all the factors affecting safety in flight. Anticipated operating conditions do not include: a) those extremes which can be effectively avoided by means of operating procedures; and	Туршлагаар мэдэж болох, эсхүл агаарын хөлөг тухайн үйл ажиллагааны зориулалтыг тооцон, агаарын хөлгийн ашиглалтын явцад үүсэж болохыг урьдчилан харж болох нөхцөл. Эдгээр нөхцөлийг атмосферийн цаг уурын төлөв, газрын бартааны бүтэц, агаарын хөлгийн ажиллагаа, ажилтны гүйцэтгэлийн үр дүн болон нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх бүх хүчин зүйлтэй холбоотойгоор авч үзнэ. Таамаглаж байгаа үйл ажиллагааны нөхцөлд дараах нөхцөл багтахгүй: а) үйл ажиллагааны журмыг ашиглан үр дүнтэй зайлсхийж болох аюултай нөхцөл;

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		b) those extremes which occur so infrequently that to require the Standards to be met in such extremes would give a higher level of airworthiness than experience has shown to be necessary and practical.	b) ийм аюултай нөхцөлд, илүү өндөр НТЧ-ын түвшин хангах стандартыг шаардах нь хэрэгцээгүй бөгөөд хэрэгжүүлэх шаардлагагүй болох нь туршлагаас харагддаг бөгөөд ховор тохиолддог аюултай нөхцөл. (AN 8)
Application	Хэрэглээ	Manipulation and processing of data in support of user requirements (ISO 19104*).	Хэрэглэгчийн шаардлагыг хангах зорилгоор өгөгдөлд өөрчлөлт болон боловсруулалт хийх (ISO 19104*) (AN 4; AN 15)
Approach and landing phase - helicopters	Ойртолт болон буултын үе шат - нисдэг тэрэг	That part of the flight from 300 m (1 000 ft) above the elevation of the FATO, if the flight is planned to exceed this height, or from the commencement of the descent in the other cases, to landing or to the balked landing point.	FATO-гийн өндөрлөгөөс дээш 300 м хүртэлх (хэрэв тухайн нислэгийг энэ өндрөөс дээш гүйцэтгэхээр төлөвлөсөн бол), бусад тохиолдолд өндөр алдалтын эхлэлээс буултын, эсхүл цуцлагдсан буултын (2-т гарах) цэг хүртэлх нислэгийн хэсэг (AN 6/III)
Approach control service	Ойртолтын удирдлагын үйлчилгээ	ATC service for arriving or departing controlled flights.	Нисэн гарах, эсхүл нисэн ирэх хяналттай нислэгт үзүүлэх НХУ-ын үйлчилгээ (AN 2; AN 11; PANS-ATM)
Approach control unit	Ойртолтын удирдлагын нэгж	A unit established to provide ATC service to controlled flights arriving at, or departing from, one or more aerodromes.	Нэг, эсхүл хэд хэдэн аэродромоос нисэн гарах, эсхүл нисэн ирэх хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх нэгж (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)
Approach phase	Ойртолтын үе шат	The operating phase defined by the time during which the engine is operated in the approach operating mode.	Хөдөлгүүр ойртолтын горимоор ажилласан хугацаагаар тодорхойлдог нислэгийн үе шат (AN 16/II)
Appropriate airworthiness requirements	Холбогдох НТЧ-ын шаардлага	The comprehensive and detailed airworthiness codes established, adopted or accepted by a Contracting State for the class of aircraft, engine or propeller under consideration.	Шаардлагатай агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний ангилалд зориулан Хэлэлцэн тохиролцогч Улсын хэрэгжүүлсэн, авч ашигласан, эсхүл хүлээн зөвшөөрсөн цогц болон дэлгэрэнгүй НТЧ-ын код (AN 1)
Appropriate ATS authority	НХУ-ний эрх бүхий байгууллага	The relevant authority designated by the State responsible for providing ATS in the airspace concerned.	Тухайн агаарын зайд НХУ үзүүлэх үүрэг бүхий Улсын томилсон эрх бүхий байгууллага (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Appropriate authority	Холбогдох эрх бүхий байгууллага	<p>a) <i>Regarding flight over the high seas:</i> The relevant authority of the State of Registry.</p> <p>b) <i>Regarding flight other than over the high seas:</i> The relevant authority of the State having sovereignty over the territory being overflown.</p>	<p>a) <i>Их далай дээгүүрх нислэгийн хувьд:</i> Бүртгэгч Улсын эрх бүхий байгууллага;</p> <p>b) <i>Их далай дээгүүрхээс бусад нислэгийн хувьд:</i> тухайн агаарын зайд онц бүрэн эрхтэй Улсын эрх бүхий байгууллага (AN 2; PANS-ATM)</p>
Approval	Зөвшөөрөл	<p>An authorization granted by an appropriate national authority for:</p> <p>a) the transport of dangerous goods forbidden on passenger and/or cargo aircraft where the Technical Instructions state that such goods may be carried with an approval; or</p> <p>b) other purposes as provided for in the Technical Instructions.</p> <p><i>Note.- In the absence of a specific reference in the Technical Instructions allowing the granting of an approval, an exemption may be sought.</i></p>	<p>Холбогдох үндэсний эрх бүхий байгууллагаас гаргасан дараах шийдвэр:</p> <p>a) Техникийн зааварчилгаанд тухайн барааг тээвэрлэхэд зөвшөөрөл шаардлагатай гэж заасан, зорчигчийн ба/эсхүл ачааны агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон аюултай барааг тээвэрлэхэд шаардлагатай; эсхүл</p> <p>b) Техникийн зааварчилгаанд заасан бусад зорилгоор шаардлагатай.</p> <p><i>Тэмдэглэл:</i> Хэрэв зөвшөөрөл олгох талаар Техникийн зааварчилгаанд тусгайлсан заалт байхгүй бол дүрмийн шаардлагаас чөлөөлөх замаар шийдвэрлэх боломжтой. (AN 18)</p>
Approved	Зөвшөөрөгдсөн	Accepted by a Contracting State as suitable for a particular purpose.	Тодорхой шаардлага хангасан болохыг Хэлэлцэн тохиролцогч Улс зөвшөөрсөн (AN 8)
Approved maintenance organization	Зөвшөөрөгдсөн техник үйлчилгээний байгууллага	An organization approved by a Contracting State, i.a.w the requirements of Annex 8, Part II, Chapter 6 - Maintenance Organization Approval, to perform maintenance of aircraft, engine, propeller or parts thereof and operating under supervision approved by that State.	Аннекс 8, Part II, Chapter 6 “Техник үйлчилгээний байгууллагын зөвшөөрөл”-ийн шаардлагын дагуу агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл түүний эд ангид техник үйлчилгээ хийх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч Улс зөвшөөрсөн ба тухайн Улсын хяналтын доор үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага (AN 1)
Approved training	Зөвшөөрөгдсөн сургалт	Training conducted under special curricula and supervision approved by a Contracting State.	Хэлэлцэн тохиролцогч Улсын зөвшөөрсөн тусгай хөтөлбөр болон хяналтын доор зохион байгуулсан сургалт (AN 1)
Approved training organization	Зөвшөөрөгдсөн сургалтын байгууллага	An organization approved by and operating under the supervision of a Contracting State i.a.w the requirements of Annex 1 to perform approved training.	Аннекс 1-ийн шаардлагын дагуу Хэлэлцэн тохиролцогч Улсын хяналтын доор зөвшөөрөгдсөн сургалт зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөгдсөн байгууллага (AN 1)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Apron	Апрон	A defined area, on a land aerodrome, intended to accommodate aircraft for purposes of loading or unloading passengers, mail or cargo, fuelling, parking or maintenance.	Зорчигч, ачаа, эсхүл шууданг ачих, эсхүл буулгах, түлшээр сумлах, зогсоолд тавих, эсхүл техник үйлчилгээ хийх зорилгоор агаарын хөлгийг байрлуулахаар газрын аэродром дээр тогтоосон талбай (AN 2; AN 4; AN 11; AN 14/I; PANS-ATM)
Apron management service	Апрон зохицуулалтын үйлчилгээ	A service provided to regulate the activities and the movement of aircraft and vehicles on an apron.	Апрон дээрх агаарын хөлөг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээ (AN 11; AN 14/I)
Area control centre	Бүсийн удирдлагын төв	A unit established to provide ATC service to controlled flights in control areas under its jurisdiction.	Өөрийн хариуцах удирдлагын бүсэд, хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)
Area control service	Бүсийн удирдлагын үйлчилгээ	ATC service for controlled flights in control areas.	Удирдлагын бүсэд, хяналттай нислэгт үзүүлэх НХУ-ын үйлчилгээ (AN 2; AN 11; PANS-ATM)
Area minimum altitude (AMA)	Бүсийн минимум өндрийн-түвшин	The minimum altitude to be used under IMC, that provides a minimum obstacle clearance within a specified area, normally formed by parallels and meridians.	Ихэвчлэн голдоч болон зэргэдээр тодорхойлдог, заасан бүс хүрээнд минимум саадыг давах зайг хангасан, IMC-д ашиглахад зориулсан минимум өндрийн-түвшин (AN 4)
Area navigation (RNAV)	Бүсийн навигаци (RNAV)	A method of navigation which permits aircraft operation on any desired flight path within the coverage of ground- or space-based navigation aids or within the limits of the capability of self-contained aids, or a combination of these.	Газарт, эсхүл сансарт суурилсан навигацийн туслах төхөөрөмжийн бүрхэлтийн хүрээнд, эсхүл өөртөө агуулсан туслах төхөөрөмжийн хүчин чадлын хязгаарлалтын хүрээнд, эсхүл тэдгээрийн комбинацын хүрээнд агаарын хөлгийн үйл ажиллагааг хүссэн нислэгийн замаар хийх боломжийг олгодог навигацийн аргачлал (AN 11; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Area navigation route	Бүсийн навигацийн зам	An ATS route established for the use of aircraft capable of employing area navigation.	Бүсийн навигацийг хийх чадвартай агаарын хөлгийг ашиглахад зориулан тогтоосон НХУ-тэй нислэгийн зам (AN 11)
Arresting system	Тогтоох систем	A system designed to decelerate an aeroplane overrunning the runway.	Нисэх онгоц ХБЗ-ыг даван гүйж гарахад тогтоох зорилгоор зохион бүтээсэн систем (AN 14/I)
Arrival routes	Нисэн ирэх зам	Routes identified in an instrument approach procedure by which aircraft may proceed from the en-route phase of flight to an initial approach fix.	Хэрэглэлийн ойртолтын журамд агаарын хөлөг нислэгийн замын үе шатнаас ойртолтын эхлэлийн цэг (IAF) хүртэл нисэхээр заасан зам (AN 4)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
ASHTAM	ASHTAM	A special series NOTAM notifying by means of a specific format change in activity of a volcano, a volcanic eruption and/or volcanic ash cloud that is of significance to aircraft operations.	Агаарын хөлгийн ажиллагаанд нөлөөлөхүйц, галт уул, галт уулын дэлбэрэлт ба/эсхүл галт уулын үнсэн үүлний идэвхжлийн өөрчлөлтийг тусгайлсан форматаар мэдээлдэг тусгай серийн NOTAM (AN 15)
Assemble	Нэгтгэх	A process of merging data from multiple sources into a database and establishing a baseline for subsequent processing. <i>Note.- The assemble phase includes checking the data and ensuring that detected errors and omissions are rectified.</i>	Эх сурвалжаас авсан өгөгдлийг нэгтгэж өгөгдлийн сан үүсгэн дараагийн шатны боловсруулалтад бэлтгэх үйл явц (AN 15) <i>Тэмдэглэл: Нэгтгэх үе шат нь өгөгдлийг шалгах болон илрүүлсэн алдаа болон зөрүүг залруулсныг бататгах үйлдлийг багтаасан.</i>
Associated aircraft systems	Туслах хөдөлгүүрээс хамааралтай агаарын хөлгийн систем	Those aircraft systems drawing electrical/pneumatic power from an auxiliary power unit during ground operations.	Газрын үйл ажиллагааны үед цахилгаан / даралтат агаарын эх үүсвэрийг туслах хөдөлгүүрээс авч ашигладаг агаарын хөлгийн систем (AN 16/1)
ATC clearance	НХУ-ын зөвшөөрөл	Authorization for an aircraft to proceed under conditions specified by an ATC unit. <i>Note 1.- For convenience, the term "ATC clearance" is frequently abbreviated to "clearance" when used in appropriate contexts.</i> <i>Note 2.- The abbreviated term "clearance" may be prefixed by the words "taxi", "take-off", "departure", "en route", "approach" or "landing" to indicate the particular portion of flight to which the ATC clearance relates.</i>	НХУ-ын нэгжийн тогтоосон нөхцөлийн дагуу тухайн агаарын хөлгийн дагаж мөрдөх зөвшөөрөл <i>Тэмдэглэл 1: Хялбарчлах зорилгоор "НХУ-ын зөвшөөрлийг" "зөвшөөрөл" гэж хураангуйлан хэрэглэдэг.</i> <i>Тэмдэглэл 2: Тухайн НХУ-ын зөвшөөрөл нь нислэгийн аль үе шатанд хамааралтайгаас шалтгаалан "taxi", "take-off", "departure", "en-route," "approach", "landing" зэрэг тодотголыг "зөвшөөрөл" гэсэн үгийн өмнө хэрэглэж болно. (AN 2; AN 11; PANS-ATM)</i>
ATC service	НХУ-ын үйлчилгээ	A service provided for the purpose of: a) preventing collisions: 1) between aircraft, and 2) on the manoeuvring area between aircraft and obstructions, and b) expediting and maintaining an orderly flow of air traffic.	Дараах зорилгоор үзүүлж байгаа үйлчилгээ: a) мөргөлдөхөөс сэргийлэх: 1) агаарын хөлгүүд хоорондоо; 2) агаарын хөлөг маневрын талбай дээрх саадтай; b) нислэгийн хөдөлгөөний урсгалыг аюулгүй, үр дүнтэй хурдасгах болон зохицуулах (AN 2; AN 11; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
ATC unit	НХУ-ын нэгж	A generic term meaning variously, area control centre, approach control unit or aerodrome control tower.	Бүсийн удирдлагын төв, ойртолтын удирдлагын төв, эсхүл аэродромын удирдлагын цамхаг зэрэг олон утгатай ерөнхий ойлголт (AN 2; AN 11; PANS-ATM)
ATS airspaces	НХУ-тэй агаарын зай	Airspaces of defined dimensions, alphabetically designated, within which specific types of flights may operate and for which ATS and rules of operation are specified. <i>Note.- ATS airspaces are classified as Class A to G as described in 2.6.</i>	НХУ болон үйл ажиллагаа нь дүрмийн зохицуулалттай, тодорхой төрлийн нислэг үйлдэж болдог, тогтоосон хэмжээтэй, үсгээр тэмдэглэгдсэн агаарын зай <i>Тэмдэглэл: НХУ-тэй агаарын зай нь А - G ангилалтай байна.</i> (AN 2; AN 11; PANS-ATM)
ATS direct speech circuit	НХУ-ний шууд ярианы сүлжээ	An aeronautical fixed service (AFS) telephone circuit, for direct exchange of information between ATS units.	НХУ-ний нэгж хооронд мэдээлэл шууд солилцох зорилготой AFS-ийн утсан холбооны сүлжээ (AN 10/II)
ATS reporting office	НХУ-ний мэдээлэх төв	A unit established for the purpose of receiving reports concerning ATS and flight plans submitted before departure. <i>Note.- An ATS reporting office may be established as a separate unit or combined with an existing unit, such as another ATS unit, or a unit of the AIS.</i>	Нисэн гарахаас өмнө хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөө болон НХУ-тэй холбоотой мэдээллийг хүлээн авах зорилгоор байгуулсан нэгж <i>Тэмдэглэл: НХУ-ний мэдээлэх төвийг тусдаа нэгж, эсхүл бусад НХУ-ний нэгж, эсхүл НМУ-ний нэгжтэй нэгдсэн байдлаар байгуулж болно.</i> (AN 2; AN 11; PANS-ATM)
ATS route	НХУ-тэй нислэгийн зам	A specified route designed for channelling the flow of traffic as necessary for the provision of ATS.	НХУ-гээр хангах шаардлагатай нислэгийн хөдөлгөөний урсгалыг хуваарилах зорилгоор тусгайлан тогтоосон зам (AN 2; AN 4; AN 11; PANS-ATM)
ATS surveillance service	НХУ ажиглалтын үйлчилгээ	A term used to indicate a service provided directly by means of an ATS surveillance system.	НХУ-ний ажиглалтын системийн шууд үзүүлдэг үйлчилгээг илэрхийлэхэд ашигладаг нэр томьёо (AN 1)
ATS surveillance system	НХУ-ний ажиглалтын систем	A generic term meaning variously, ADS-B, PSR, SSR or any comparable ground-based system that enables the identification of aircraft. <i>Note.- A comparable ground-based system is one that has been demonstrated, by comparative assessment or other methodology, to have a level of safety and performance equal to or better than monopulse SSR.</i>	Агаарын хөлгийг таньж тогтоох ADS-B, PSR, SSR, эсхүл газарт суурилсан бусад төстэй систем зэрэг олон утгатай ерөнхий ойлголт <i>Тэмдэглэл: Газарт суурилсан төстэй систем гэж харьцуулсан үнэлгээгээр, эсхүл бусад аргачлалаар аюулгүй байдлын түвшин болон үзүүлэлт нь monopulse</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			SSR-тай тэнцүү, эсхүл илүү гэж тогтоогдсон системийг ойлгоно. (AN 1; AN 4; AN 15)
ATS unit	НХУ-ний нэгж	A generic term meaning variously, ATC unit, flight information centre or ATS reporting office.	НХУ-ын нэгж, нислэгийн мэдээллийн төв, эсхүл НХУ-ний мэдээлэх төв зэрэг олон утгатай ерөнхий ойлголт (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)
Authorized agent	Эрх бүхий агент	A person who represents an aircraft operator and who is authorized by or on behalf of such operator to act on formalities connected with the entry and clearance of the operator's aircraft, crew, passengers, cargo, mail, baggage or stores and includes, where national law permits, a third party authorized to handle cargo on the aircraft.	Үндэсний хууль зөвшөөрдөг бол агаарын хөлөгт ачааны зохицуулалт хийхээр зөвшөөрөгдсөн гуравдагч этгээдийг багтаасан, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг төлөөлдөг ба үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлөг, нисэх баг, зорчигч, ачаа, шуудан, тээш, эсхүл бүхээгийн нөөцөд нэвтрэх болон зөвшөөрөл авахтай холбоотой албан үүрэг гүйцэтгэхээр тухайн үйл ажиллагаа эрхлэгч зөвшөөрсөн, эсхүл түүний нэрийн өмнөөс зөвшөөрөл авсан этгээд (AN 9)
Authorized Economic Operator (AEO)	Гаалийн харилцаанд оролцогч (AEO)	AEO is a party involved in the international movement of goods in whatever function that has been approved by or on behalf of a national Customs administration as complying with WCO or equivalent supply chain security standards. AEOs may include manufacturers, importers, exporters, brokers, carriers, consolidators, intermediaries, ports, airports, terminal operators, integrated operators, warehouses, distributors and freight forwarders. <i>Note.- The definition is aligned with that found in the World Customs Organization's "SAFE Framework of Standards to Secure and Facilitate Global Trade."</i>	AEO бол Олон улсын гаалийн байгууллагын шаардлага, эсхүл дүйцэх ханган нийлүүлэлтийн сүлжээний аюулгүйн хамгаалалтын стандартыг хангасан гэж үндэсний Гаалийн байгууллагаар, эсхүл түүнээс өмнөөс зөвшөөрөгдсөн олон улсын бараа эргэлтийн аливаа ажиллагаанд оролцогч тал. АЕО-д үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч, брокер, тээвэрлэгч, консолидатор, зуучлагч, боомт, нисэх буудал, терминалын үйл ажиллагаа эрхлэгч, нэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч, агуулах, дистрибьютор болон ачаа тээвэрлэгч багтаж болно. (AN 9) <i>Тэмдэглэл: Энэ тодорхойлолтыг Дэлхийн Гаалийн Байгууллагын "SAFE Framework of Standards to Secure and Facilitate Global Trade."-тэй нэгтгэсэн.</i>
Automated Border Control (ABC)	Автоматжуулсан хилийн хяналт (ABC)	An automated system which authenticates the electronic machine readable travel document or token, establishes that the passenger is the rightful holder of the document or token, queries border control records, then determines eligibility for border crossing according to pre-defined rules.	Цахим машинаар уншдаг аяллын баримт бичиг, эсхүл өгөгдөл зөөгчийг (token) таньж, тухайн зорчигч нь уг баримт бичиг, эсхүл өгөгдөл зөөгчийн хууль ёсны эзэмшигч болохыг тогтоон, хилийн хяналтын бүртгэлийн лавлагааг хийсний дараа урьдчилан тодорхойлсон журмын дагуу хил

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			нэвтрэх эрхтэй болохыг тогтоодог автоматжуулсан систем (AN 9)
Automatic dependent surveillance - broadcast (ADS-B)	ADS-B (радио нэвтрүүлэг)	A means by which aircraft, aerodrome vehicles and other objects can automatically transmit and/or receive data such as identification, position and additional data, as appropriate, in a broadcast mode via a data link.	Data-link-ээр радио нэвтрүүлгийн горимд агаарын хөлөг, аэродромын тээврийн хэрэгсэл болон бусад байгууламжийн дугаар, байршил болон нэмэлт өгөгдөл зэрэг холбогдох өгөгдлийг автоматаар дамжуулах ба/эсхүл хүлээн авах арга (AN 2; AN 10/II; AN 11; AN 15)
Automatic dependent surveillance - contract (ADS-C)	ADS-C (гэрээ)	A means by which the terms of an ADS-C agreement will be exchanged between the ground system and the aircraft, via a data link, specifying under what conditions ADS-C reports would be initiated, and what data would be contained in the reports. <i>Note.- The abbreviated term "ADS contract" is commonly used to refer to ADS event contract, ADS demand contract, ADS periodic contract or an emergency mode.</i>	Ямар нөхцөлийн дагуу ADS-C мэдээлэл эхлүүлэх болон аль өгөгдөл тухайн мэдээлэлд агуулагдсан байхыг заасан, data-link-ээр газрын систем болон агаарын хөлөг хооронд ADS-C гэрээний нөхцөлийг солилцох арга <i>Тэмдэглэл: "ADS-C" гэж ADS event contract, ADS demand contract, ADS periodic contract, эсхүл emergency mode-г илэрхийлдэг, нийтлэг хэрэглэдэг товчлол (AN 2; AN 3; AN 10/III; AN 11; AN 15)</i>
Automatic dependent surveillance-broadcast (ADS-B) IN	ADS-B IN	A function that receives surveillance data from ADS-B OUT data sources.	ADS-B OUT өгөгдлийн эх үүсвэрээс ажиглалтын өгөгдлийн хүлээж авдаг ажиллагаа (AN 10/IV)
Automatic dependent surveillance-broadcast (ADS-B) OUT	ADS-B OUT	A function on an aircraft or vehicle that periodically broadcasts its state vector (position and velocity) and other information derived from on-board systems in a format suitable for ADS-B IN capable receivers.	Өөрийн ерөнхий байдлын вектор (байрлал болон хурд) болон бүхээгийн системээс авсан бусад мэдээллийг ADS-B IN чадвартай хүлээн авагчид тохиромжтой форматаар, тодорхой давтамжтайгаар мэдээлдэг агаарын хөлөг, эсхүл тээврийн хэрэгслийн ажиллагаа (AN 10/IV)
Automatic relay installation	Автомат дахин дамжуулах төхөөрөмж	A teletypewriter installation where automatic equipment is used to transfer messages from incoming to outgoing circuits. <i>Note.- This term covers both fully automatic and semi-automatic installations.</i>	Оролтын мэдээллийг гаралтад автоматаар дамжуулдаг автомат төхөөрөмжтэй телетайп төхөөрөмж <i>Тэмдэглэл: Энэхүү ойлголтод бүтэн автомат болон хагас автомат төхөөрөмжийг хоёуланг нь хамруулна. (AN 10/II)</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Automatic telecommunication log	Цахилгаан холбооны автомат бүртгэл	A record of the activities of an aeronautical telecommunication station recorded by electrical or mechanical means.	Цахилгаан, эсхүл механик хэлбэрээр бичдэг, нисэхийн цахилгаан холбооны станцын үйл ажиллагааны бүртгэл (AN 10/II)
Automatic terminal information service (ATIS)	Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ (ATIS)	The automatic provision of current, routine information to arriving and departing aircraft throughout 24 hours or a specified portion thereof: <i>Data link-automatic terminal information service (D-ATIS)</i> . The provision of ATIS via data link. <i>Voice-automatic terminal information service (Voice-ATIS)</i> . The provision of ATIS by means of continuous and repetitive voice broadcasts.	Нисэн ирж байгаа болон нисэн гарч байгаа агаарын хөлөгт 24 цагаар, эсхүл тодорхой заасан цагт бодит, байнгын мэдээллийг автоматаар дамжуулах дараах хэрэгсэл: <i>D-ATIS</i> - ATIS-ийг Data-link-ээр өгөх аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ; <i>Voice-ATIS</i> - ATIS-ийг яриагаар тасралтгүй, давтдаг аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ. (AN 11; PANS-ATM)
Autonomous runway incursion warning system (ARIWS)	ХБЗ-аас нэвтэрч гарахыг анхааруулах автомат систем (ARIWS)	A system which provides autonomous detection of a potential incursion or of the occupancy of an active runway and a direct warning to a flight crew or a vehicle operator.	Ашиглаж байгаа ХБЗ-ыг нэвтэрч гарах боломжит тохиолдлыг, эсхүл ХБЗ завгүй байгааг автоматаар тодорхойлж, нисэх баг, эсхүл тээврийн хэрэгслийн операторт шууд анхааруулах дохио өгдөг систем (AN 14/I)
Auxiliary power unit (APU)	Туслах хөдөлгүүр (APU)	A self-contained power unit on an aircraft providing electrical/pneumatic power to aircraft systems during ground operations or in flight, separate from the propulsion engine(s).	Татах хүчний төхөөрөмжөөс тусдаа, нислэгт, эсхүл газрын үйл ажиллагааны үед агаарын хөлгийн системийг цахилгаан / даралтат агаарын эх үүсвэрээр хангадаг, агаарын хөлөгт өөртөө агуулсан хүчний төхөөрөмж (AN 16/I)
Aviation security	Нисэхийн аюулгүйн хамгаалалт	Safeguarding civil aviation against acts of unlawful interference. This objective is achieved by a combination of measures and human and material resources.	Иргэний нисэхийг хууль бус нөлөөллийн үйлдлээс хамгаалах зорилготой хүний нөөц, материаллаг эх үүсвэр болон арга хэмжээний нэгдэл (AN 17)
Back course sector	Курсийн эсрэг сектор	The course sector which is situated on the opposite side of the localizer from the runway.	ХБЗ-аас локалайзерын эсрэг тал руу чиглэсэн курсийн сектор (AN 10/I)
Background check	Суурь шалгалт	A check of a person's identity and previous experience, including criminal history and any other security related information relevant for assessing the person's suitability, i.a.w national legislation.	Үндэсний хууль, эрх зүйн дагуу гэмт хэргийн түүх болон тухайн этгээдийн тохиромжтой байдлыг үнэлэхэд холбогдох бусад аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийг багтаасан тухайн этгээдийг таньж тогтоох болон өмнөх түүхийг шалгах (AN 17)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Baggage	Тээш	Personal property of passengers or crew carried on an aircraft by agreement with the operator.	Агаарын хөлөгт үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу тээвэрлэдэг, зорчигч, эсхүл багийн гишүүдийн хувийн өмч хөрөнгө (AN 9)
Balked landing	Цуцлагдсан буулт	A landing manoeuvre that is unexpectedly discontinued at any point below the obstacle clearance altitude/height (OCA/H).	Саадыг давах өндрийн-түвшин / өндрөөс (OCA/H) дооших аливаа цэгээс гэнэтийн нөхцөлөөс шалтгаалан цуцалсан буултын маневр (AN 14/I)
Balloon	Бөмбөлөг	A non-power-driven lighter-than-air aircraft. <i>Note.- For the purposes of Annex 1, this definition applies to free balloons.</i>	Хөдөлгүүргүй, агаараас хөнгөн агаарын хөлөг <i>Тэмдэглэл: Annex 1-ийн хувьд, энэ тодорхойлолт нь чөлөөт бөмбөлөгт хамаарна.</i> (AN 1; AN 7)
Bare Earth	Эх дэлхий	Surface of the Earth including bodies of water and permanent ice and snow, and excluding vegetation and man-made objects.	Ургамал болон хүний гараар бүтээсэн байгууламжаас бусад, ус, мөнх цас, мөсөөр хучигдсан газрыг багтаасан дэлхийн гадаргуу (AN 4; AN 15)
Barrette	Шугаман гэрэл	Three or more aeronautical ground lights closely spaced in a transverse line so that from a distance they appear as a short bar of light.	Хөндлөн шугам дээр ойрхон зайтай байрлуулсан, тодорхой зайнаас богино гэрлэн судал мэт харагддаг гурав, эсхүл түүнээс олон нисэхийн газрын гэрэл (AN 14/I)
Base turn	Үндсэн-эргэлт	A turn executed by the aircraft during the initial approach between the end of the outbound track and the beginning of the intermediate or final approach track. The tracks are not reciprocal. <i>Note.- Base turns may be designated as being made either in level flight or while descending, according to the circumstances of each individual procedure.</i>	Агаарын хөлөг гарах замын (outbound track / downwind) төгсгөл болон ойртолтын дундын замын (3-р эргэлт), эсхүл ойртолтын төгсгөлийн замын эхлэл (4-р эргэлт) хооронд ойртолтын эхлэлд гүйцэтгэдэг эргэлт. Замуудын чиглэл нь эсрэг биш. <i>Тэмдэглэл: Тухайн журмын нөхцөлөөс шалтгаалан үндсэн-эргэлтийг чиг шулуун нислэгт, эсхүл өндөр алдаж байхдаа гүйцэтгэж болно.</i> (AN 11; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Basic aircraft	Үндсэн агаарын хөлөг	An aircraft which has the minimum equipment required to perform the intended take-off, approach or landing operation.	Төлөвлөсөн хөөрөлт, ойртолт эсхүл буултын үйл ажиллагаанд шаардлагатай минимум төхөөрөмжөөр тоногдсон агаарын хөлөг
Becquerel (Bq)	Беккерель (Бк)	The activity of a radionuclide having one spontaneous nuclear transition per second.	Секунд дахь нэг цөмийн шилжилтээр өөрөө үүссэн радио идэвхт үүсгүүрийн нуклидын идэвхжил (AN 5)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Behaviour detection	Зан төлөвийг тодорхойлох	Within an aviation security environment, the application of techniques involving the recognition of behavioural characteristics, including but not limited to physiological or gestural signs indicative of anomalous behaviour, to identify persons who may pose a threat to civil aviation.	Нисэхийн аюулгүйн хамгаалалтын хүрээнд иргэний нисэхэд аюул заналхийлэл учруулж болзошгүй этгээдийг таньж тогтоох зорилгоор физиологийн, эсхүл гар, биеийн хөдөлгөөний эрүүл бус төлөвийг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй зан төлөвийг тодорхойлоход ашигладаг арга техник (AN 17)
Bit error rate	Битийн алдааны хэмжээ	The number of bit errors in a sample divided by the total number of bits in the sample, generally averaged over many such samples.	Ихэвчлэн олон жишээний дунджаар тооцдог, жишээний нийт битийн тоонд хуваасан тухайн жишээнд байгаа битийн алдааны тоо (AN 10/III)
Blind transmission	Харанхуй дамжуулалт	A transmission from one station to another station in circumstances where two-way communication cannot be established but where it is believed that the called station is able to receive the transmission.	Хоёр талын радио-холбоог тогтоож чадаагүй нөхцөлд, дуудагдаж байгаа станц нь тухайн дамжуулалтыг хүлээн авах боломжтой гэдэгт итгэлтэй байх тохиолдолд нэг станцаас нөгөө станц руу хийж байгаа дамжуулалт (AN 10/II; PANS-ATM)
Border security	Хилийн халдашгүй дархан байдал	The enforcement, by a State, of its laws and/or regulations concerning the movement of goods and/or persons across its borders.	Бараа ба/эсхүл зорчигч Улсын хил дамжих хөдөлгөөнтэй холбоотойгоор тухайн Улс өөрийн хууль ба/эсхүл зохицуулалтыг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ (AN 9)
Briefing	Зааварчилгаа	Oral commentary on existing and/or expected meteorological conditions.	Бодит ба/эсхүл урьдчилан таамагласан цаг уурын нөхцөлийн талаарх аман тайлбар (AN 3)
Broadcast	Радио нэвтрүүлэг	A transmission of information relating to air navigation that is not addressed to a specific station or stations.	Нислэгийн үйл ажиллагаатай холбоотой, тусгайлсан станц, эсхүл станцуудад хаяглагдаагүй мэдээллийн дамжуулалт (AN 10/II; AN 10/III; PANS-ATM)
Bypass ratio	Контур хоорондын харьцаа	The ratio of the air mass flow through the bypass ducts of a gas turbine engine to the air mass flow through the combustion chambers calculated at maximum thrust when the engine is stationary in an international standard atmosphere at sea level.	Хөдөлгүүр далайн түвшинд, ISA-д, максимум татах хүчний горимоор жигд ажиллаж байх үед тооцсон, хийн турбинт хөдөлгүүрийн гадна контураар дайран гарах агаарын урсгалын жинг шатаах камераар дайран гарах агаарын урсгалын жинд харьцуулсан харьцаа (AN 16/I)
Cabin crew member	Бүхээгийн ажилтан	A crew member who performs, in the interest of safety of passengers, duties assigned by the	Зорчигчийн аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		operator or the pilot-in-command of the aircraft, but who shall not act as a flight crew member.	тухайн хөлгийн даргын оноосон үүрэг гүйцэтгэдэг нисэх багийн гишүүдээс бусад багийн гишүүн (AN 6/I; AN 6/III)
Calendar	Хуанли	Discrete temporal reference system that provides the basis for defining temporal position to a resolution of one day (ISO 19108*).	Цаг хугацааны нарийвчлалыг нэг өдрөөр тодорхойлдог хийсвэр он тооллын тогтолцоо (ISO 19108*) (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)
Candela	Кандел (кд)	The luminous intensity, in the perpendicular direction, of a surface of 1/600 000 square metre of black body at the temperature of freezing platinum under a pressure of 101 325 newtons per square metre.	101325 Н/м ² даралтад, платинумын хөлдөх температурт байгаа 1/600000 м ² талбайтай гэрэл үүсгэгч биетээс перпендикуляр чиглэлд цацрах гэрлийн тодорц (AN 5)
Canopy	Бүрхүүл	Bare Earth supplemented by vegetation height.	Ургамлын өндрийг оруулсан эх дэлхий (AN 4; AN 15)
Cargo	Ачаа	Any property carried on an aircraft other than mail, stores and accompanied or mishandled baggage.	Шуудан, нөөц сэлбэг болон тээшнээс бусад, агаарын хөлөгт тээвэрлэж байгаа өмч хөрөнгө (AN 9; AN 17)
Cargo aircraft	Ачааны агаарын хөлөг	Any aircraft, other than a passenger aircraft, which is carrying goods or property.	Зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгөөс бусад, бараа, эсхүл өмч хөрөнгө тээвэрлэж байгаа агаарын хөлөг (AN 18)
Carrier-to-multipath ratio (C/M)	Зөөгчийн шууд ба ойсон сигналын харьцаа	The ratio of the carrier power received directly, i.e. without reflection, to the multipath power, i.e. carrier power received via reflection.	Зөөгчийн шууд хүлээн авсан сигналын чадлыг ойсон сигналын чадалд харьцуулсан харьцаа (AN 10/III)
Carrier-to-noise density ratio (C/N ₀)	Зөөгчийн сигналын ба шуугианы нягтралын харьцаа	The ratio of the total carrier power to the average noise power in a 1 Hz bandwidth, usually expressed in dBHz.	Зөөгчийн сигналын нийт чадлыг ба 1 Гц-ийн зурвасын шуугианы дундаж чадалд харьцуулсан харьцаа (ихэвчлэн дБГц-ээр илэрхийлдэг) (AN 10/III)
Category A	Категори-А	With respect to helicopters, means a multi-engine helicopter designed with engine and system isolation features specified in Part IVB of Annex 8 and capable of operations using take-off and landing data scheduled under a critical engine failure concept which assures adequate designated surface area and adequate	Нисдэг тэрэгний хувьд Part IVB-д заасан хөдөлгүүр болон систем нь тусгаар байх чадвартай бөгөөд тохиромжтой гадаргуугийн талбай болон үзүүлэлтийн хүчин чадлаараа нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх, эсхүл татгалзсан хөөрөлтийг үйлдэх чадвартай байхыг бататгах эрсдэлтэй хөдөлгүүр татгалзах концепцын дагуу тогтоосон хөөрөлт, буултын өгөгдлийг ашиглан үйл ажиллагаа

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		performance capability for continued safe flight or safe rejected take-off.	гүйцэтгэх чадвартай байхаар зохион бүтээсэн олон хөдөлгүүрт нисдэг тэрэг (AN 8)
Category B	Категори-В	With respect to helicopters, means a single-engine or multi-engine helicopter which does not meet Category A standards. Category B helicopters have no guaranteed capability to continue safe flight in the event of an engine failure, and a forced landing is assumed.	Нисдэг тэрэгний хувьд, категори-А-ийн стандарт шаардлага хангаагүй нэг, эсхүл олон хөдөлгүүрт нисдэг тэрэг. Категори-В нисдэг тэрэг нь хөдөлгүүр татгалзсан тохиолдолд нислэгийг аюулгүй үргэлжлүүлж, аргагүйдсэн буулт үйлдэх баталгаажгаагүй чадвартай. (AN 8; SL 03/103)
Causes	Шалтгаан	Actions, omissions, events, conditions, or a combination thereof, which led to the accident or incident. The identification of causes does not imply the assignment of fault or the determination of administrative, civil or criminal liability.	Тухайн осол, эсхүл зөрчил гарахад хүргэсэн үйлдэл, эс үйлдэл, тохиолдол, нөхцөл, эсхүл тэдгээрийн комбинац. Шалтгааныг тодорхойлох нь гэм бурууг тогтоох эсхүл захиргааны, иргэний эсхүл эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн үг биш юм. (AN 13)
Ceiling	Үүлний суурийн өндөр	The height above the ground or water of the base of the lowest layer of cloud below 6 000 metres (20 000 feet) covering more than half the sky.	Газар, эсхүл усан гадаргуугаас дээш, тэнгэрийн хагасаас илүүг бүрхсэн, 6000 м-ээс (20 000 ft) доош өндөртэй, үүлний хамгийн доод давхаргын суурь хүртэлх өндөр (AN 2; PANS-ATM)
Celsius temperature (t°C)	Цельсийн температур (t°C)	The Celsius temperature is equal to the difference $t^{\circ}\text{C} = T - T_0$ between two thermodynamic temperatures T and T_0 where T_0 equals 273.15 kelvin.	Термодинамикийн T болон 273.15 кельвинтэй тэнцүү T_0 температур хоорондын ялгавартай ($t^{\circ}\text{C} = T - T_0$) тэнцүү Цельсийн температур (AN 5)
Certification	Гэрчилгээжүүлэлт	A formal evaluation and confirmation by or on behalf of the appropriate authority for aviation security that a person possesses the necessary competencies to perform assigned functions to an acceptable level as defined by the appropriate authority.	Тухайн этгээд нь оноогдсон үүрэг, даалгавраа зохих эрх бүхий байгууллагын тогтоосон хүлээн зөвшөөрөхүйц түвшинд гүйцэтгэх шаардлагатай ур чадвар эзэмшсэн болоход, нисэхийн аюулгүй хамгаалалтын холбогдох эрх бүхий байгууллага, эсхүл түүний нэрийн өмнөөс хийдэг албан ёсны үнэлгээ болон баталгаа (AN 17)
Certified aerodrome	Гэрчилгээжсэн аэродром	An aerodrome whose operator has been granted an aerodrome certificate.	ИНД-139-ийн дагуу гэрчилгээ олгосон аэродром (AN 14/I)
Certify as airworthy (to)	Нислэгт тэнцэхийг гэрчилгээжүүлэх	To certify that an aircraft or parts thereof comply with current airworthiness requirements after	Агаарын хөлөг, эсхүл түүний эд ангид техник үйлчилгээг хийж дууссаны дараа тухайн агаарын хөлөг, эсхүл түүний эд анги нь тухайн цаг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		maintenance has been performed on the aircraft or parts thereof.	хугацаанд НТЧ-ын шаардлагыг хангаж байгаа болохыг гэрчилгээжүүлэх (AN 1)
Change-over point	Солих цэг	The point at which an aircraft navigating on an ATS route segment defined by reference to very high frequency omnidirectional radio ranges (VOR) is expected to transfer its primary navigational reference from the facility behind the aircraft to the next facility ahead of the aircraft.	VOR ашигладаг НХУ-тэй нислэгийн замын хэсэгт нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг ард үлдсэн байгууламжаас тухайн агаарын хөлгийн өмнөх дараагийн байгууламж руу үндсэн навигацийн хяналтын цэгээ шилжүүлэхээр төлөвлөсөн цэг
Channel rate	Сувгийн дамжуулах хурд	The rate at which bits are transmitted over the RF channel. These bits include those bits used for framing and error correction, as well as the information bits. For burst transmission, the channel rate refers to the instantaneous burst rate over the period of the burst.	Радио давтамжийн сувгаар битийг дамжуулах хурд. Энэхүү битүүдэд фрэймлэх, алдаа засах, мөн мэдээллийн битүүд багтана. Багц дамжуулалтын хувьд энэхүү хурд нь багцыг дамжуулах агшин зуурын хурд. (AN 10/III)
Channel rate accuracy	Сувгаар дамжуулах хурдны нарийвчлал	This is relative accuracy of the clock to which the transmitted channel bits are synchronized.	Сувгаар дамжуулсан битийг синхрончилсон цагийн харьцангуй нарийвчлал (AN 10/III)
Circuit mode	Хэлхээний горим	A configuration of the communications network which gives the appearance to the application of a dedicated transmission path.	Зориулсан дамжуулалтын замын хэрэглээний дүрслэлийг өгдөг холбооны сүлжээний бүтэц (AN 10/III)
Civil aviation inspector	Иргэний нисэхийн байцаагч	A civil aviation inspector is an individual, designated by a Contracting State, who is charged with the inspection of the safety, security or related aspects of air transport operations as directed by the appropriate authority. <i>Note.- Examples of civil aviation inspectors include inspectors responsible for airworthiness, flight operations and other safety-related aspects, and security-related aspects, of air transport operations.</i>	Холбогдох эрх бүхий байгууллагын даалгавраар нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, эсхүл агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хяналт шалгалт хийхээр Хэлэлцэн тохиролцогч Улсын томилсон этгээдийг. <u>Тэмдэглэл:</u> Иргэний нисэхийн байцаагч нь НТЧ, нислэгийн үйл ажиллагаа болон агаарын тээврийн үйл ажиллагааны аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой бусад асуудлыг хариуцна. (AN 9)
Clearance limit	Зөвшөөрлийн хязгаар	The point to which an aircraft is granted an ATC clearance.	Тухайн агаарын хөлөгт олгосон НХУ-ын зөвшөөрөл үйлчлэх төгсгөлийн цэг (AN 2; AN 11; PANS-ATM)
Clearance of goods	Барааны гаалийн бүрдүүлэлт	The accomplishment of the customs formalities necessary to allow goods to enter home use, to be	Барааг дотоодын хэрэглээнд зориулан нэвтрүүлэх, экспортлох болон гаалийн өөр горимд

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		exported or to be placed under another customs procedure.	шилжүүлэхэд шаардлагатай гаалийн бүрдүүлэлтийн ажиллагаа (AN 9)
Clearway	Саадаас чөлөөтэй талбай	A defined rectangular area on the ground or water under the control of the appropriate authority, selected or prepared as a suitable area over which an aeroplane may make a portion of its initial climb to a specified height.	Холбогдох эрх бүхий байгууллагын хяналтад байгаа, дээгүүр нь нисэх онгоц тогтоосон өндрөө авах хүртэл өндөр авалтын эхний үе шатыг (initial climb) гүйцэтгэхэд тохиромжтой байхаар сонгосон, эсхүл бэлтгэсэн, ХБЗ-ын нисэн гарах төгсгөлд байгаа хуурай газар, эсхүл усан дээр тогтоосон тэгш өнцөгт талбай (AN 4; AN 14/I)
Climb phase	Өндөр авалтын үе шат	The operating phase defined by the time during which the engine is operated in the climb operating mode.	Хөдөлгүүр өндөр авалтын горимоор ажилласан хугацаагаар тодорхойлдог нислэгийн үе шат (AN 16/II)
Cloud of operational significance	Үйл ажиллагаанд нөлөөлөхүйц үүл	A cloud with the height of cloud base below 1 500 m (5 000 ft) or below the highest minimum sector altitude, whichever is greater, or a cumulonimbus cloud or a towering cumulus cloud at any height.	Суурийн өндөр нь 1 500 м-ээс (5 000 ft) доор байгаа, эсхүл хамгийн их секторын минимум өндрийн-түвшнээс доор байгаа үүлний аль өндрийг, эсхүл борооны бөөн үүл, эсхүл цамхаг хэлбэрийн бөөн үүл (AN 3)
Cockpit crew zone	Нисэх багийн бүхээг	The part of the cabin that is exclusively designated for flight crew use.	Зөвхөн нисэх багийн гишүүд ашиглахад зориулагдсан бүхээгийн хэсэг (AN 16/III)
Collision avoidance logic	Мөргөлдөхөөс сэргийлэх логик схем	The sub-system or part of ACAS that analyses data relating to an intruder and own aircraft, decides whether or not advisories are appropriate and, if so, generates the advisories. It includes the following functions: range and altitude tracking, threat detection and RA generation. It excludes surveillance.	Ойртож байгаа болон өөрийн агаарын хөлгийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, тухайн зөвлөмж зөв эсэхийг шийддэг ба хэрэв зөв бол зөвлөмж өгдөг ACAS-ын дэд систем, эсхүл түүний хэсэг. Үүнд зай болон өндрийн-түвшин хянах, аюул заналхийллийг тодорхойлох болон шийдвэр гаргах зөвлөмж өгөх ажиллагаа багтана. Гэхдээ ажиглалт багтахгүй. (AN 10/IV)
COMAT	COMAT	Operator material carried on an operator's aircraft for the operator's own purposes.	Үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлөгт өөрийн үйл ажиллагаанд зорилгоор тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийн материал (AN 6/I)
Combined vision system (CVS)	Хосолсон дүрслэлийн систем (CVS)	A system to display images from a combination of an enhanced vision system (EVS) and a synthetic vision system (SVS).	Сайжруулсан дүрслэлийн систем (EVS) болон синтетик дүрслэлийн системийн (SVS) нийлүүлсэн дүрсийг харуулах систем (AN 6/I, AN 6/II; AN 6/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Command and control (C2) link	Дохио болон удирдлагын (C2) холболт	The data link between the remotely piloted aircraft and the remote pilot station for the purposes of managing the flight.	Тухайн нислэгийг удирдах зорилготой зайнаас удирддаг агаарын хөлөг болон зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байр хоорондын data-link (AN 1, AN 2)
Commencement of journey	Аялал эхлэх цэг	The point at which the person began a journey, without taking into account any airport at which the person stopped in direct transit, either on a through-flight or a connecting flight, if the person did not leave the direct transit area of the airport in question.	Шууд нислэгт, эсхүл холбосон нислэгт хэрэв тухайн этгээд нисэх буудлын транзит бүсээс гараагүй бол шууд дамжин нисэхээр зогссон аливаа нисэх буудлыг тооцохгүйгээр тухайн этгээд аяллаа эхэлсэн цэг (AN 9)
Commercial air transport operation	Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа	An aircraft operation involving the transport of passengers, cargo or mail for remuneration or hire.	Зорчигч, ачаа, эсхүл шууданг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх үйл ажиллагаа (AN 1; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 17)
Commissary supplies	Зорчигч үйлчилгээний хангамж	Items, either disposable or intended for multiple use, that are used by the aircraft operator for provision of services during flights, in particular for catering, and for the comfort of passengers.	Хоол хүнс болон зорчигчийн тав тухыг хангахад зориулан агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нислэгийн үеийн үйлчилгээнд ашигладаг, нэг, эсхүл олон удаа хэрэглэдэг эд зүйлс (AN 9)
Common mark	Нэгдсэн харьяаллын тэмдэг	A mark assigned by the International Civil Aviation Organization to the common mark registering authority registering aircraft of an international operating agency on other than a national basis. <i>Note.- All aircraft of an international operating agency which are registered on other than a national basis will bear the same common mark.</i>	Үндэсний харьяаллын тэмдгээс ялгаатай, олон улсын үйл ажиллагааны байгууллагын агаарын хөлгийг бүртгэдэг, нэгдсэн харьяаллын тэмдэг олгох эрх бүхий байгууллагад ICAO-гоос оноосон харьяаллын тэмдэг <i>Тэмдэглэл: Үндэсний харьяалалд бүртгэгдсэнээс бусад олон улсын үйл ажиллагааны байгууллагын агаарын хөлгүүд нь ижил нэгдсэн харьяаллын тэмдэгтэй байна.</i> (AN 7)
Common mark registering authority	Нэгдсэн харьяаллын тэмдэг олгох эрх бүхий байгууллага	The authority maintaining the non-national register or, where appropriate, the part thereof, in which aircraft of an international operating agency are registered.	Үндэсний харьяаллын бүртгэлгүй, эсхүл тусгай шаардлагын дагуу олон улсын үйл ажиллагааны байгууллагын агаарын хөлөг бүртгэдэг эрх бүхий байгууллага (AN 7)
Communication centre	Холбооны төв	An aeronautical fixed station which relays or retransmits telecommunication traffic from (or to) a number of other aeronautical fixed stations directly connected to it.	Түүнтэй шууд холбоо тогтоосон бусад нисэхийн суурин холбооны станцуудын хооронд цахилгаан холбооны мэдээг дамжуулах, эсхүл дахин

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			дамжуулах нисэхийн суурин холбооны станц (AN 10/II)
Competency	Ур чадвар	A dimension of human performance that is used to reliably predict successful performance on the job. A competency is manifested and observed through behaviours that mobilize the relevant knowledge, skills and attitudes to carry out activities or tasks under specified conditions.	Тухайн ажил үүргийн амжилттай гүйцэтгэлийг найдвартай урьдчилан тодорхойлоход ашигладаг хүний чадавхын хэмжээ. Ур чадвар нь тогтоосон нөхцөлийн дагуу үйл ажиллагаа, эсхүл ажлыг гүйцэтгэхэд холбогдох мэдлэг, чадвар болон хандлагаа ашиглаж байгаа зан төлөвөөр илэрхийлэгддэг ба таньж тогтоогддог. (AN 1)
Competency standard	Ур чадварын стандарт	A level of performance that is defined as acceptable when assessing whether or not competency has been achieved.	Ур чадвар хангасан эсэхэд үнэлгээ хийхэд хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж тодорхойлоход хэрэглэдэг гүйцэтгэлийн түвшин (AN 1)
Competency-based training and assessment	Ур чадварт суурилсан сургалт ба үнэлгээ	Training and assessment that are characterized by a performance orientation, emphasis on standards of performance and their measurement, and the development of training to the specified performance standards.	Гүйцэтгэл болон түүний үр дүнг хэмждэг стандартад суурилсан гүйцэтгэлийн хандлага болон тогтоосон гүйцэтгэлийн стандартын сургалт зохион байгуулалтаар илэрхийлэгддэг сургалт болон үнэлгээ (AN 1)
Conditions	Нөхцөл	Anything that may qualify a specific environment in which performance will be demonstrated.	Гүйцэтгэлээ үзүүлэхэд шаардлагатай тодорхой хүрээлэн буй орчныг тодорхойлох аливаа хүчин зүйл (AN 1)
Conference communications	Хурлын холбоо	Communication facilities whereby direct speech conversation may be conducted between three or more locations simultaneously.	Гурав, эсхүл түүнээс олон байрлалын хооронд нэгэн зэрэг шууд аман харилцан яриа хийж болдог холбооны төхөөрөмж (AN 11)
Confidence level	Итгэлцлийн түвшин	The probability that the true value of a parameter is within a certain interval around the estimate of its value. <i>Note.- The interval is usually referred to as the accuracy of the estimate.</i>	Параметрийн жинхэнэ утга нь түүний тооцоот утгын тодорхой интервал дотор байх магадлал <u>Тэмдэглэл:</u> Интервалыг ихэвчлэн тооцоот утгын нарийвчлал гэж нэрлэдэг. (AN 15)
Configuration (as applied to the aeroplane)	Конфигураци	A particular combination of the positions of the moveable elements, such as wing flaps and landing gear, etc., that affect the aerodynamic characteristics of the aeroplane.	Агаарын хөлгийн хувьд, тухайн нисэх онгоцны аэродинамик үзүүлэлтэд нөлөөлдөг далавчны флапс, эсхүл газардах анги зэрэг хөдөлгөөнт хэсгийн байрлалын тодорхой комбинац (AN 8)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Configuration deviation list	Конфигурацийн өөрчлөлтийн жагсаалт (CDL)	A list established by the organization responsible for the type design with the approval of the State of Design which identifies any external parts of an aircraft type which may be missing at the commencement of a flight, and which contains, where necessary, any information on associated operating limitations and performance correction.	Холбогдох үйл ажиллагааны хязгаарлалт болон нислэгийн үзүүлэлтийн залруулгын талаарх шаардлагатай мэдээллийг агуулсан бөгөөд нислэг эхлэх үед байхгүй байж болох тухайн агаарын хөлгийн маягийн гаднах эд ангийг тодорхойлдог, Зохион бүтээгч Улсын зөвшөөрөлтэй тухайн маягийн загварыг хариуцсан байгууллага боловсруулж гаргасан жагсаалт (AN 6/I; AN 6/III)
Congested area	Шигүү суурьшлын бүс	In relation to a city, town or settlement, any area which is substantially used for residential, commercial or recreational purposes.	Хот, сум, эсхүл суурингийн хувьд, орон сууц, үйлдвэрлэл, худалдаа, эсхүл амралт зугаалгын зорилгоор ашигладаг талбай (AN 6/III)
Congested hostile environment	Шигүү суурьшлын аюултай орчин	A hostile environment within a congested area.	Шигүү суурьшлын бүс дэх аюултай орчин (AN 6/III)
Consignment	Илгээх бараа	One or more packages of dangerous goods accepted by an operator from one shipper at one time and at one address, receipted for in one lot and moving to one consignee at one destination address.	Нэг илгээгчээс нэг цагт, нэг хаягаар, нэг авалтаар авсан ба нэг хүлээн авагчид нэг хаягаар хүргэхээр үйл ажиллагаа эрхлэгч хүлээн авсан нэг, эсхүл түүнээс олон аюултай барааны баглаа боодол (AN 18)
Consultation	Зөвлөгөөн	Discussion with a meteorologist or another qualified person of existing and/or expected meteorological conditions relating to flight operations; a discussion includes answers to questions.	Нислэгийн үйл ажиллагаатай холбоотой цаг уурын бодит ба/эсхүл урьдчилан таамагласан нөхцөлийн талаар цаг уурч, эсхүл бусад мэргэшсэн этгээдтэй хийдэг хэлэлцүүлэг. Хэлэлцүүлэг нь асуултын хариултыг багтаана. (AN 3)
Contact tracing	Хавьтлыг мөшгөх	Contact tracing is the practice of identifying, notifying, and monitoring individuals who may have had close contact with or who have been exposed to, and possibly infected by, a person having a confirmed or probable case of an infectious disease as a means of controlling the spread of infection. The confirmed or potentially infected person's identity is not discussed with contacts, even if asked.	Хавьтлыг мөшгөх гэж халдварт өвчний батлагдсан эсхүл боломжит тохиолдол бүхий этгээдтэй ойр хавьталд байсан эсхүл нөлөөлөлд автан халдвар авсан байж болзошгүй хүмүүсийг ялгаж таних, мэдэгдэх болон ажиглалт хийх халдварт өвчний тархалтыг хянах практик арга. Халдвар авсан нь батлагдсан эсхүл халдвар авсан байж болзошгүй этгээдийн хувийн мэдээллийг нууцална.(AN 9)
Contaminated runway	Тунадастай ХБЗ	A runway is contaminated when a significant portion of the runway surface area (whether in isolated areas or not) within the length and width	Ашиглах урт болон өргөний дотор ХБЗ-ын гадаргуун талбайн ихэнх хэсэг нь ХБЗ-ын гадаргуугийн нөхцөлийг тодорхойлогчийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		being used is covered by one or more of the substances listed in the runway surface condition descriptors. <i>Note.- Further information on runway surface condition descriptors can be found in the Annex 14, Volume I - Definitions.</i>	жагсаалтад ордог нэг, эсхүл түүнээс олон бодисоор хучигдсан бол ХБЗ-ыг тунадастай гэж үзнэ. <i>Тэмдэглэл: ХБЗ-ын гадаргуугийн нөхцөлийг тодорхойлогчийн тухай мэдээллийн Annex 14, Vol I, Definitions-ээс харж болно. (AN 6/I)</i>
Continuing airworthiness	НТЧ-ын хадгалалт	The set of processes by which an aircraft, engine, propeller or part complies with the applicable airworthiness requirements and remains in a condition for safe operation throughout its operating life.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, ротор, сэнс, эсхүл эд анги нь холбогдох НТЧ-ын шаардлагыг хангаж байгаа бөгөөд ашиглалтын хугацаанд аюулгүй үйл ажиллагааг хангах чадвартай болохыг бататгах цогц үйл ажиллагаа (AN 6/I; AN 6/II; AN 8; AN 6/III)
Continuing airworthiness records	НТЧ-ын хадгалалтын бүртгэл	Records which are related to the continuing airworthiness status of an aircraft, engine, propeller or associated part.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл холбогдох эд ангийн НТЧ-ын хадгалалтын төлөв байдалтай холбоотой бүртгэл (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Continuous descent final approach (CDFA)	Үргэлжлэн өндөр алдах ойртолтын төгсгөл (CDFA)	A technique, consistent with stabilized approach procedures, for flying the final approach segment (FAS) of an instrument non-precision approach (NPA) procedure as a continuous descent, without leveloff, from an altitude/height at or above the final approach fix altitude/height to a point approximately 15 m (50 ft) above the landing runway threshold or the point where the flare manoeuvre begins for the type of aircraft flown; for the FAS of an NPA procedure followed by a circling approach, the CDFA technique applies until circling approach minima (circling OCA/H) or visual flight manoeuvre altitude/height are reached.	Түвшин хадгалахгүйгээр, ойртолтын төгсгөлийн сегментийн цэгийн (FAF) өндрийн-түвшин/өндөрт, эсхүл түүнээс дээших өндрийн-түвшин/өдрөөс буулт үйлдэх ХБЗ-ын босгын дээрх ойролцоогоор 15 м (50 ft) өндөртэй цэг хүртэл, эсхүл нисэж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд тэгшлэх маневр эхлэх цэг хүртэл нарийвчлалтай бус хэрэглэлийн ойртолтын (NPA) журмын ойртолтын төгсгөлийн сегментэд (FAS) үргэлжлэн өндөр алдан нисэхэд ашигладаг тогтвортой ойртолтын журамд тохирсон арга техник; NPA журмын дараа тойргоор ойртолт үйлдэх FAS-ын хувьд CDFA арга техник нь тойргоор ойртолт үйлдэх минима (circling OCA/H) хүртэл, эсхүл ил харааны нислэгийн маневрын өндрийн-түвшин/өндөр хүртэл үйлчилнэ. (AN 6/I)
Contour line	Хаялбар	A line on a map or chart connecting points of equal elevation.	Газрын зураг, эсхүл зураг (схем) дээрх ижил өндөртэй цэгүүдийг холбосон шугам (AN 4; PANS-OPS/II)
Contributing factors	Нөлөөлөх хүчин зүйл	Actions, omissions, events, conditions, or a combination thereof, which, if eliminated, avoided or absent, would have reduced the probability of	Хэрэв арилгасан, тойрон гарсан, эсхүл байхгүй байсан бол тухайн осол, эсхүл зөрчил гарах магадлалыг бууруулж болох, эсхүл осол, зөрчлийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		the accident or incident occurring, or mitigated the severity of the consequences of the accident or incident. The identification of contributing factors does not imply the assignment of fault or the determination of administrative, civil or criminal liability.	үр дагаврын хүндрэлийг багасгаж болох үйлдэл, эс үйлдэл, тохиолдол, нөхцөл, эсхүл эдгээрийн комбинац. Нөлөөлөх хүчин зүйлийн тодорхойлолтыг гэм бурууг тогтоох, эсхүл захиргааны, иргэний, эсхүл эрүүгийн хариуцлага оногдуулахад ашиглахгүй. (AN 13)
Control area	Удирдлагын бүс	A controlled airspace extending upwards from a specified limit above the earth.	Газраас дээш тогтоосон хязгаараас дээш үргэлжлэх хяналттай агаарын зай (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)
Control zone	Удирдлагын зоон	A controlled airspace extending upwards from the surface of the earth to a specified upper limit.	Газрын гадаргуугаас дээш тогтоосон дээд хязгаар хүртэл үргэлжлэх хяналттай агаарын зай (AN 2; AN 11; PANS-ATM)
Controlled aerodrome	Хяналттай аэродром	An aerodrome at which ATC service is provided to aerodrome traffic. <i>Note.- The term "controlled aerodrome" indicates that ATC service is provided to aerodrome traffic but does not necessarily imply that a control zone exists.</i>	Аэродромын нислэгийн хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэг аэродром <i>Тэмдэглэл: "хяналттай аэродром" гэсэн ойлголт нь тухайн аэродромын нислэгийн хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэг, гэхдээ удирдлагын зоон байгаа гэж ойлгож болохгүй.</i> (AN 2; AN 11; PANS-ATM)
Controlled airspace	Хяналттай агаарын зай	An airspace of defined dimensions within which ATC service is provided i.a.w the airspace classification. <i>Note.- Controlled airspace is a generic term which covers ATS airspace Classes A, B, C, D and E as described in Annex 11, 2.6.</i>	Агаарын зайн ангиллын дагуу, IFR болон VFR нислэгт НХУ-ээр хангадаг тогтоосон хэмжээтэй агаарын зай <i>Тэмдэглэл: Хяналттай агаарын зай гэж ерөнхий ойлголт бөгөөд Annex 11, 2.6-д заасан НХУ-ний Ангилал А, В, С, D болон E агаарын зай багтана.</i> (AN 2; AN 11; PANS-ATM)
Controlled flight	Хяналттай нислэг	Any flight which is subject to an ATC clearance.	НХУ-ын зөвшөөрөл шаардлагатай нислэг (AN 2)
Controller-pilot data link communications	Нислэгийн хөдөлгөөний удирдагч - нисгэгч хоорондын data-link холбоо	A means of communication between controller and pilot, using data link for ATC communications.	НХУ-ын холбооны data-link ашиглан, нисгэгч болон нислэгийн хөдөлгөөний удирдагч хооронд холбоо барих аргачлал (AN 2; AN 10/II; AN 11; AN 15; PANS-ATM)
Conversion process	Нэрэлтийн үйл явц	A type of technology used to convert a feedstock into aviation fuel.	Түүхий эдийг нисэхийн түлш болгон өөрчлөхөд ашигладаг технологийн төрөл (AN 16/IV)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Co-pilot	Хамтран нисгэгч	A licensed pilot serving in any piloting capacity other than as pilot-in-command but excluding a pilot who is on board the aircraft for the sole purpose of receiving flight instruction.	Хөлгийн даргаас бусад, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд нислэгийн заавраар шаардсан нисгэгч; гэхдээ тухайн агаарын хөлгийн бүхээгт байгаа нисгэгчээс нислэгийн зааварчилгаа авч байгаа нисгэгч багтахгүй (AN 1)
Corporate aviation operation / Corporate aviation	Байгууллагын нисэхийн үйл ажиллагаа / Байгууллагын нисэх	The non-commercial operation or use of aircraft by a company for the carriage of passengers or goods as an aid to the conduct of company business, flown by a professional pilot(s) employed to fly the aircraft.	Агаарын хөлгийг өөрийн мэргэжлийн нисгэгчээр нисгэн компани бизнесээ дэмжих зорилгоор зорчигч, эсхүл барааг тээвэрлэх компанийн агаарын хөлгийн арилжааны бус үйл ажиллагаа, эсхүл хэрэглээ (AN 6/II, AN 17)
CORSIA eligible fuel	CORSIA хангасан түлш	A CORSIA sustainable aviation fuel or a CORSIA lower carbon aviation fuel, which an operator may use to reduce their offsetting requirements.	Шаардлагатай үзүүлэлтийг багасгах зорилгоор үйл ажиллагаа эрхлэгч хэрэглэдэг CORSIA тогтвортой нисэхийн түлш, эсхүл CORSIA бага карбонтой нисэхийн түлш (AN 16/IV)
CORSIA lower carbon aviation fuel	CORSIA бага карбонтой нисэхийн түлш	A fossil-based aviation fuel that meets the CORSIA Sustainability Criteria under this Volume.	Annex 16, Volume IV-ийн дагуу CORSIA тогтвортой байх шалгуурыг хангадаг шатамхай ашигт малтмалаас гаргадаг нисэхийн түлш (AN 16/IV)
CORSIA sustainable aviation fuel	CORSIA тогтвортой нисэхийн түлш	A renewable or waste-derived aviation fuel that meets the CORSIA Sustainability Criteria under this Volume.	Annex 16, Volume IV-ийн дагуу CORSIA тогтвортой байх шалгуурыг хангадаг дахин боловсруулсан, эсхүл хаягдлаас гаргаж авсан нисэхийн түлш (AN 16/IV)
Coulomb (C)	Кулон (C)	The quantity of electricity transported in 1 second by a current of 1 ampere.	1 секундэд 1 ампер гүйдэл дамжуулах цахилгааны гүйдлийн хэмжээ (AN 5)
Course line	Курсийн шугам	The locus of points nearest to the runway centre line in any horizontal plane at which the DDM is zero.	Модуляцийн гүний зөрүү (DDM) нь 0-тэй тэнцүү хэвтээ хавтгайн ХБЗ-ын гол шугамд хамгийн ойр байх геометрийн цэг (AN 10/I)
Course sector	Курсийн сектор	A sector in a horizontal plane containing the course line and limited by the loci of points nearest to the course line at which the DDM is 0.155.	Чиглэлийн шугамыг агуулсан ба модуляцийн гүний зөрүү (DDM) нь 0.155-тай тэнцүү чиглэлийн шугамтай хамгийн ойрын геометрийн цэгээр хязгаарлагдсан хэвтээ хавтгайн сектор (AN 10/I)
CPDLC message	CPDLC мэдээ	Information exchanged between an airborne system and its ground counterpart. A CPDLC message consists of a single message element or	Бүхээгийн систем болон газар дээрх түүний хамтрагчийн хооронд солилцох мэдээлэл. CPDLC мэдээ нь мэдээ санаачлагчийн нэг дамжуулалтад

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		a combination of message elements conveyed in a single transmission by the initiator.	дамжуулагдаж буй мэдээний нэг элемент эсхүл мэдээний элементүүдийн багцаас бүрдэнэ.
CPDLC message set	CPDLC мэдээний багц	A list of standard message elements and free text message elements.	Стандарт мэдээний элементүүд болон чөлөөт текст мэдээний элементүүдийн жагсаалт
Credit	Кредит	Recognition of alternative means or prior qualifications.	Өөр хэлбэрийг, эсхүл өмнөх мэргэшлийг хүлээн зөвшөөрөх (AN 1)
Crew member	Багийн гишүүн	A person assigned by an operator to duty on an aircraft during a flight duty period.	Нислэгийн хугацаанд агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэхээр агаарын тээвэрлэгчийн томилсон этгээд (AN 6/I; AN 6/III; AN 9; AN 18)
Critical engine	Эрсдэлтэй хөдөлгүүр	Any engine whose failure gives the most adverse effect on the aircraft characteristics relative to the case under consideration. <i>Note.- On some aircraft there may be more than one equally critical engine. In this case, the expression “the critical engine” means one of those critical engines.</i>	Тухайн хөдөлгүүрийн татгалзал нь агаарын хөлгийн үзүүлэлтэд ноцтойгоор нөлөөлдөг хөдөлгүүр <i>Тэмдэглэл: Зарим агаарын хөлөгт нэгээс илүү ижил тэнцүү эрсдэлтэй хөдөлгүүр байж болно. Энэ тохиолдолд “эрсдэлтэй хөдөлгүүр” гэж эдгээр эрсдэлтэй хөдөлгүүрийн аль нэгийг ойлгоно. (AN 8)</i>
Cross-country	Нутаг дамнасан нислэг	A flight between a point of departure and a point of arrival following a pre-planned route using standard navigation procedures.	Нисэн гарах болон нисэн ирэх цэгийн хооронд, урьдчилан төлөвлөсөн замыг даган, стандарт нислэгийн журмын дагуу гүйцэтгэх нислэг (AN 1)
Cruise climb	Аяллын нислэгийн өндөр авалт	An aeroplane cruising technique resulting in a net increase in altitude as the aeroplane mass decreases.	Нисэх онгоцны жингийн бууралт нь өндрийн-түвшний бодит өсөлтийг бий болгодог нисэх онгоцны аяллын нислэг үйлдэх аргачлал (AN 2; PANS-ATM)
Cruise relief pilot	Аяллын орлон нисгэгч	A flight crew member who is assigned to perform pilot tasks during cruise flight, to allow the pilot-in-command or a co-pilot to obtain planned rest.	Аяллын нислэгийн үед хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчид түр амрах боломж олгодог, нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон нисэх багийн гишүүн (AN 6/I)
Cruising level	Аяллын түвшин	A level maintained during a significant portion of a flight.	Нислэгийн дийлэнх хэсэгт хадгалдаг нислэгийн түвшин (AN 2; AN 3; AN 6/I; AN 11; PANS-ATM)
Culture	Соёл иргэншил	All man-made features constructed on the surface of the Earth, such as cities, railways and canals.	Дэлхийн гадаргуу дээр хүний гараар бүтээгдсэн хот суурин, төмөр зам, суваг шуудуу зэрэг байгууламж (AN 4; AN 15)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Current data authority	Хүчинтэй өгөгдлийн эрх бүхий нэгж	The designated ground system through which a CPDLC dialogue between a pilot and a controller currently responsible for the flight is permitted to take place.	Тухайн нислэгийг зөвшөөрсөн ба хариуцсан нислэгийн хөдөлгөөний удирдагч болон нисгэгч хоорондын CPDLC яриаг дамжуулахад зориулсан газрын систем (AN 10/II; PANS-ATM)
Current flight plan	Хүчинтэй нислэгийн төлөвлөгөө	The flight plan, including changes, if any, brought about by subsequent clearances.	НХУ-ын зөвшөөрөл шаардлагатай өөрчлөлтийг багтаасан нислэгийн төлөвлөгөө (AN 2; PANS-ATM)
Cyclic redundancy check (CRC)	Циклийн үлдэгдэл шалгах	A mathematical algorithm applied to the digital expression of data that provides a level of assurance against loss or alteration of data.	Тухайн өгөгдлийн алдагдал, эсхүл өөрчлөлтийн эсрэг хамгаалалтын тодорхой түвшнийг хангадаг өгөгдлийн тоон илэрхийлэлд хэрэглэдэг математик аргачлал (AN 4; AN 11; AN 14/I; AN 15)
D	D	The largest overall dimension of the helicopter when rotor(s) are turning measured from the most forward position of the main rotor tip path plane to the most rearward position of the tail rotor tip path plane or helicopter structure.	Хамгийн урд байрлалд байгаа үндсэн роторын үзүүрээс хамгийн арын байрлалд байгаа сүүлний роторын үзүүр, эсхүл нисдэг тэрэгний бүтэц хүртэлх ротор эргэлдэж байхад хэмжсэн нисдэг тэрэгний хамгийн урт нийт хэмжээ (AN 14/II)
Danger area	Аюултай бүс	An airspace of defined dimensions within which activities dangerous to the flight of aircraft may exist at specified times.	Тодорхой хугацаанд тухайн агаарын зайд явагдах ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй, тодорхой хэмжээтэй тогтоосон агаарын зай (AN 2; AN 4; AN 15)
Dangerous goods	Аюултай бараа	Articles or substances which are capable of posing a risk to health, safety, property or the environment and which are shown in the list of dangerous goods in the Technical Instructions or which are classified according to those Instructions. <i>Note.- Dangerous goods are classified in Annex 18, Chapter 3.</i>	Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох ICAO-гийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгаанд заасан, эсхүл ангилсан эд зүйл, эсхүл бодис <i>Тэмдэглэл: Аюултай барааг "Annex 18, Chapter 3"-аар ангилдаг. (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 18)</i>
Dangerous goods accident	Аюултай бараатай холбоотой осол	An occurrence associated with and related to the transport of dangerous goods by air which results in fatal or serious injury to a person or major property or environmental damage.	Агаараар аюултай бараа тээвэрлэх явцад аливаа этгээдийг үхэлд хүргэсэн, эсхүл хүнд гэмтээсэн, эсхүл эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулсан хэрэг явдал (AN 18)
Dangerous goods incident	Аюултай барааны зөрчил	An occurrence, other than a dangerous goods accident, associated with and related to the	Агаараар аюултай бараа тээвэрлэхтэй холбоотой аюултай барааны ослоос бусад агаарын хөлгийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		transport of dangerous goods by air, not necessarily occurring on board an aircraft, which results in injury to a person, property or environmental damage, fire, breakage, spillage, leakage of fluid or radiation or other evidence that the integrity of the packaging has not been maintained. Any occurrence relating to the transport of dangerous goods which seriously jeopardizes the aircraft or its occupants is also deemed to constitute a dangerous goods incident.	бүхээгт заавал гарсан байх албагүй, баглаа боодлын бүрэн бүтэн байдал хадгалагдаагүй улмаас хүнийг гэмтээх, эд хөрөнгө эсхүл хүрээлэн буй орчинд хохирол учруулах, гал гарах, эвдрэх, шингэн асгарах, гоожих, эсхүл радиацид өртөх зэрэг бусад нотолгоотой холбоотой хэрэг явдал. Мөн агаарын хөлөг эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүст ноцтойгоор аюул учруулсан аюултай барааг тээвэрлэхтэй холбоотой гарсан аливаа хэрэг явдлыг аюултай барааны зөрчилд тооцно. (AN 18)
Data accuracy	Өгөгдлийн нарийвчлал	A degree of conformance between the estimated or measured value and the true value.	Тооцоолсон, эсхүл хэмжсэн утга болон жинхэнэ утга хоорондын нийцлийн түвшин (AN 11; AN 14/I; AN 15)
Data completeness	Өгөгдлийн бүрдэл	The degree of confidence that all of the data needed to support the intended use is provided.	Төлөвлөсөн хэрэглээнд ашиглах шаардлагатай бүх өгөгдөл нь хангагдсан байх итгэлцлийн зэрэг (AN 15)
Data format	Өгөгдлийн формат	A structure of data elements, records and files arranged to meet standards, specifications or data quality requirements.	Стандарт, үзүүлэлт, эсхүл өгөгдлийн чанарын шаардлагыг хангах зорилгоор эрэмбэлсэн өгөгдлийн элемент, бүртгэл болон файлын бүтэц (AN 15)
Data integrity (assurance level)	Өгөгдлийн бүрэн байдал (бататгах түвшин)	A degree of assurance that an aeronautical data and its value has not been lost or altered since the origination or authorized amendment.	Нисэхийн өгөгдөл болон түүний утга нь тухайн өгөгдлийг үүсгэсэн, эсхүл зөвшөөрөгдсөн өөрчлөлт хийснээс хойш алдагдаагүй, эсхүл өөрчлөгдөөгүй болохыг бататгах зэрэг (AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)
Data link communications	Data-link холбоо	A form of communication intended for the exchange of messages via a data link.	Data-link-ээр дамжуулан мэдээлэл солилцоход зориулсан холбооны хэлбэр (AN 2; AN 11)
Data link flight information services (D-FIS)	Data-link нислэгийн мэдээллийн үйлчилгээ (D-FIS)	The provision of FIS via data link.	Data-link-ээр нислэгийн мэдээллийн үйлчилгээг хангах (AN 10/III)
Data link VOLMET (D-VOLMET)	VOLMET data-link (D-VOLMET)	Provision of current aerodrome routine meteorological reports (METAR) and aerodrome special meteorological reports (SPECI),	Аэродромын цаг уурын бодит мэдээ (METAR), аэродромын цаг уурын тусгай мэдээ (SPECI), Аэродромын урьдчилсан мэдээ (TAF), SIGMET

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		aerodrome forecasts (TAF), SIGMET, special air-reports not covered by a SIGMET and, where available, AIRMET via data link.	болон боломжтой тохиолдолд AIRMET мэдээллийг data-link-ээр хангах (AN 3; AN 15)
Data product	Өгөгдлийн бүтээгдэхүүн	Data set or data set series that conforms to a data product specification (ISO 19131*).	Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолтод нийцсэн өгөгдлийн багц, эсхүл өгөгдлийн багцын бүрдэл (AN 15)
Data product specification	Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт	Detailed description of a data set or data set series together with additional information that will enable it to be created, supplied to and used by another party (ISO 19131*). <i>Note.- A data product specification provides a description of the universe of discourse and a specification for mapping the universe of discourse to a data set. It may be used for production, sales, end-use or other purpose.</i>	Бүтээгдэхүүн бий болгох, бусад этгээдийг хангах болон бусад этгээд ашиглах боломжтой нэмэлт мэдээлэл бүхий өгөгдлийн багц, эсхүл өгөгдлийн багцын бүрдлийн дэлгэрэнгүй <i>Тэмдэглэл: Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт нь хэрэглээний тайлбар болон өгөгдлийн багцын хэрэглээний дүрслэлийн тодорхойлолтоор хангадаг. Энэ тодорхойлолтыг өгөгдөл бүрдүүлэх, борлуулах, хэрэглэх, эсхүл бусад зорилгоор ашиглана. (AN 4; AN 15)</i>
Data quality	Өгөгдлийн чанар	A degree or level of confidence that the data provided meet the requirements of the data user in terms of accuracy, resolution, integrity (or equivalent assurance level), traceability, timeliness, completeness and format.	Өгсөн өгөгдөл нь нарийвчлал, зөвшөөрөгдөх хэмжээ, бүрэн байдал (эсхүл дүйцэх бататгах түвшин), эргэн тогтоох боломж, цагийн хязгаар, бүрдэл болон форматын хувьд өгөгдөл хэрэглэгчийн шаардлага хангасан байдлын зэрэг, эсхүл түвшин (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)
Data resolution	Өгөгдлийн зөвшөөрөгдөх хэмжээ	A number of units or digits to which a measured or calculated value is expressed and used.	Хэмжсэн, эсхүл тооцоолсон утгыг илэрхийлсэн ба хэрэглэсэн нэгжийн тоо, эсхүл дугаар (AN 4; AN 15)
Data set	Өгөгдлийн багц	Identifiable collection of data (ISO 19101*).	Өгөгдлийн тодорхой цуглуулга (AN 15)
Data set series	Өгөгдлийн багцын бүрдэл	Collection of data sets sharing the same product specification (ISO 19115*).	Ижил бүтээгдэхүүний тодорхойлолттой өгөгдлийн багцын цуглуулга (AN 15)
Data timeliness	Өгөгдлийн цагийн хязгаар	The degree of confidence that the data is applicable to the period of its intended use.	Тухайн өгөгдөл нь хэрэглэхээр төлөвлөсөн хугацаанд хамааралтай байх итгэлцлийн зэрэг (AN 15)
Data traceability	Өгөгдлийг эргэн тогтоох боломж	The degree that a system or a data product can provide a record of the changes made to that product and thereby enable an audit trail to be followed from the end-user to the originator.	Тогтолцоо, эсхүл өгөгдлийн бүтээгдэхүүн нь тухайн бүтээгдэхүүнд хийсэн өөрчлөлтийн бүртгэлийг харуулж чаддаг байх ба аудит шалгалтаар эцсийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			хэрэглэгчээс эх үүсвэр хүртэл нь эргэн мөшгөн тогтоох боломж олгодог байх зэрэг (AN 15)
Date of manufacture	Үйлдвэрлэсэн огноо	The date of issue of the document attesting that the individual aircraft or engine as appropriate conforms to the requirements of the type or the date of an analogous document.	Агаарын хөлөг, эсхүл хөдөлгүүрийн аль хамааралтай нь тухайн маягийн шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулсан баримт бичгийг олгосон огноо, эсхүл ижил төстэй баримт бичгийг олгосон огноо (AN 16/II)
Datum	Өгөгдөхүүн	Any quantity or set of quantities that may serve as a reference or basis for the calculation of other quantities (ISO 19104*).	Бусад тоо хэмжээг тооцоолох үндэс, эсхүл тогтоосон өгөгдөл болоход ашиглаж болдог тоо хэмжээ, эсхүл тоо хэмжээний багц (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)
Day	Өдөр	The hours between- - the beginning of morning civil twilight, which is when the centre of the rising sun's disc is 6 degrees below the horizon which starts approximately 30 minutes before sunrise; and - the end of evening sunset civil twilight, which is when the centre of the setting sun's disc is 6 degrees below the horizon which ends approximately 30 minutes after sunset:	Үүрийн гэгээ эхлэхээс үдшийн бүрий дуусах хүртэлх хугацаа: - Үүрийн гэгээ нь ургаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар мандахаас 30 минутын өмнө эхэлнэ. - Үдшийн бүрий нь жаргаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар жаргаснаас хойш 30 минутын дараа дуусна. (AN 1; AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Decision altitude (DA) or Decision height (DH)	Шийдвэр гаргах өндрийн-түвшин (DA), эсхүл шийдвэр гаргах өндөр (DH)	A specified altitude or height in a 3D instrument approach operation at which a missed approach must be initiated if the required visual reference to continue the approach has not been established. <i>Note 1.- Decision altitude (DA) is referenced to MSL and decision height (DH) is referenced to the threshold elevation.</i> <i>Note 2.- The required visual reference means that section of the visual aids or of the approach area which should have been in view for sufficient time for the pilot to have made an assessment of the aircraft position and rate of change of position, in relation to the desired flight path. In Category III operations with a decision height the required visual reference is that specified for the particular procedure and operation.</i>	Хэрэв ойртолтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай тухайн ил харааны баримжаат цэгийг тогтоож чадаагүй бол, ойртолтоос 2-т гарах ёстой 3D хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаанд тогтоосон өндрийн-түвшин, эсхүл өндөр. <i>Тэмдэглэл 1: Шийдвэр гаргах өндрийн-түвшин (DA) гэж MSL-тэй харьцуулан тогтоосон ба шийдвэр гаргах өндөр (DH) гэж ХБЗ-ын босготой харьцуулан тогтоосон.</i> <i>Тэмдэглэл 2: Шаардлагатай ил харааны баримжаа гэж тухайн нислэгийн замын хувьд агаарын хөлгийн байрлал болон байрлалын өөрчлөлтийн хурданд үнэлгээ хийхэд нисээгчид хангалттай хугацааны турш харж болох ил харааны туслах хэрэгсэл, эсхүл ойртолтын талбайн хэсэг. Шийдвэр гаргах өндөртэй (DH) CAT III үйл ажиллагаанд шаардлагатай ил</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		Note 3.- For convenience where both expressions are used they may be written in the form "decision altitude/height" and abbreviated "DA/H".	харааны баримжаа гэж тухайн журам болон үйл ажиллагаанд заасныг ойлгоно. <u>Тэмдэглэл 3:</u> DA, DH хоёр ойлголтыг хамт ашиглах бол хялбарчлах зорилгоор "Шийдвэр гаргах өндрийн-түвшин / өндөр буюу DA/H" гэж товчилдог. (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Declarant	Мэдүүлэгч	Any person who makes a goods declaration or in whose name such a declaration is made.	Ачааны гаалийн мэдүүлэг гаргагч аливаа этгээд, эсхүл мэдүүлэгчийн өмнөөс ийм гаалийн мэдүүлэг гаргаж байгаа этгээд (AN 9)
Declared capacity	Зарласан багтаамж	A measure of the ability of the ATC system or any of its subsystems or operating positions to provide service to aircraft during normal activities. It is expressed as the number of aircraft entering a specified portion of airspace in a given period of time, taking due account of weather, ATC unit configuration, staff and equipment available, and any other factors that may affect the workload of the controller responsible for the airspace.	Хэвийн үйл ажиллагааны үед агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлж байгаа НХУ-ын систем, болон түүний дэд систем, эсхүл үйл ажиллагааны нэгжийн үйлчилгээний чадварыг хэмжих нэгж. Зарласан багтаамжийг тухайн агаарын зайг хариуцаж байгаа нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын ачаалалд нөлөөлж болох цаг агаар, НХУ-ын нэгжийн бүтэц, бэлэн байгаа боловсон хүчин болон төхөөрөмж болон бусад хүчин зүйлийг тооцон, тодорхой хугацаанд уг агаарын зайд нэвтрэн орж болох агаарын хөлгийн тоогоор илэрхийлдэг. (AN 11)
Declared distances	Зарласан зай	<p>a) <i>Take-off run available (TORA)</i>. The length of runway declared available and suitable for the ground run of an aeroplane taking off.</p> <p>b) <i>Take-off distance available (TODA)</i>. The length of the take-off run available plus the length of the clearway, if provided.</p> <p>c) <i>Accelerate-stop distance available (ASDA)</i>. The length of the take-off run available plus the length of the stopway, if provided.</p> <p>d) <i>Landing distance available (LDA)</i>. The length of runway which is declared available and suitable for the ground run of an aeroplane landing.</p>	<p>a) <i>Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай (TORA)</i> - Нисэх онгоцны хөөрөлтийн газрын гүйлтэд ашиглахад тохиромжтой ба боломжтой гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн мэдүүлсэн ХБЗ-ын уртыг,</p> <p>b) <i>Хөөрөлтийн боломжит зай (TODA)</i> - Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) урт дээр нэмж аливаа саадаас чөлөөтэй талбайн уртыг,</p> <p>c) <i>Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай (ASDA)</i> - Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн урт (TORA) дээр нэмж зогсоох зурвасын уртыг,</p> <p>d) <i>Буултын боломжит зай (LDA)</i> - Нисэх онгоцны газрын гүйлтэд ашиглахад бэлэн ба</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			тохиромжтой гэж тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс мэдэгдсэн ХБЗ-ын уртыг, (AN 14)
Declared distances - heliports	Хэлипортын зарласан зай	<p>a) <i>Take-off distance available (TODAH)</i>. The length of the FATO plus the length of helicopter clearway (if provided) declared available and suitable for helicopters to complete the take-off.</p> <p>b) <i>Rejected take-off distance available (RTODAH)</i>. The length of the FATO declared available and suitable for helicopters operated in performance class 1 to complete a rejected take-off.</p> <p>c) <i>Landing distance available (LDAH)</i>. The length of the FATO plus any additional area declared available and suitable for helicopters to complete the landing manoeuvre from a defined height.</p>	<p>a) <i>Хөөрөлтийн боломжит зай (TODAH)</i>: Ойртолтын төгсгөлийн болон хөөрөлтийн талбайн урт дээр нэмэх нь нисдэг тэрэг хөөрөлт үйлдэхэд боломжтой болон тохиромжтой гэж зарласан нисдэг тэрэгний саадаас чөлөөтэй талбай (clearway) (хэрэв өгөгдсөн бол)</p> <p>b) <i>Татгалзсан хөөрөлтийн боломжит зай (RTODAH)</i>. Хүчин чадлын ангилал-1 нисдэг тэрэг татгалзсан хөөрөлт үйлдэх боломжтой болон тохиромжтой гэж зарласан ойртолтын төгсгөлийн болон хөөрөлтийн талбайн урт</p> <p>c) <i>Буултын боломжит зай (LDAH)</i>. Ойртолтын төгсгөлийн болон хөөрөлтийн талбайн урт дээр нэмэх нь нисдэг тэрэг заасан өндрөөс буултын маневр гүйцэтгэхэд боломжтой болон тохиромжтой гэж зарласан аливаа нэмэлт талбай (AN 14/II)</p>
Defined point after take-off	Хөөрөлтийн дараах тодорхойлсон цэг	<p>The point, within the take-off and initial climb phase, before which the helicopter's ability to continue the flight safely, with one engine inoperative, is not assured and a forced landing may be required.</p> <p><i>Note.- Defined points apply to helicopters operating in performance Class 2 only.</i></p>	<p>Тухайн цэгт хүрэхээс өмнө нэг хөдөлгүүр ажиллагаагүй болсон үед нисдэг тэрэг нислэгээ аюулгүй үргэлжлүүлэх чадвар нь батлагдаагүй ба аргагүйдсэн буулт үйлдэх шаардлагатай болж болох хөөрөлтийн болон өндөр авалтын эхний үе шатны хоорондох цэг</p> <p><i>Тэмдэглэл: Зөвхөн хүчин чадлын Ангилал - 2 дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэргэнд хамаарах тогтоосон цэг (AN 6/III)</i></p>
Defined point before landing	Буултын өмнөх тодорхойлсон цэг	<p>The point, within the approach and landing phase, after which the helicopter's ability to continue the flight safely, with one engine inoperative, is not assured and a forced landing may be required.</p>	<p>Тухайн цэгийг өнгөрөхөд нэг хөдөлгүүр ажиллагаагүй болсон үед нисдэг тэрэг нислэгээ аюулгүй үргэлжлүүлэх чадвар нь батлагдаагүй ба аргагүйдсэн буулт үйлдэх шаардлагатай болж болох ойртолт болон буултын үе шатны хоорондох цэг (AN 6/III)</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Degree Celsius	Цельсийн хэм	The special name for the unit kelvin for use in stating values of Celsius temperature.	Цельсийн температурын хэмжээг илэрхийлэхэд ашигладаг кельвин нэгжийн тусгай нэр (AN 5)
De-icing / anti-icing facility	Мөстөлт арилгах / мөстөлт эсэргүүцэх байгууламж	A facility where frost, ice or snow is removed (de-icing) from the aeroplane to provide clean surfaces, and/or where clean surfaces of the aeroplane receive protection (anti-icing) against the formation of frost or ice and accumulation of snow or slush for a limited period of time. <i>Note.- Further guidance is given in the Manual of Aircraft Ground De-icing/Anti-icing Operations (Doc 9640).</i>	Гадаргууг цэвэр байлгах зорилгоор нисэх онгоцыг цан, мөс, эсхүл цаснаас цэвэрлэдэг (de-icing) ба/эсхүл нисэх онгоцны цэвэр гадаргууг тодорхой хязгаартай цаг хугацаанд цас, эсхүл шалбааг тогтох болон цан, эсхүл мөс үүсэхээс хамгаалдаг (anti-icing) байгууламж <i>Тэмдэглэл: Бусад гарын авлага Manual of Aircraft Ground De-icing/Anti-icing Operations (Doc 9640)-д байгаа. (AN 14/I)</i>
De-icing / anti-icing pad	Мөстөлт арилгах / мөстөлт эсэргүүцэх ажлын талбай	An area comprising an inner area for the parking of an aeroplane to receive de-icing/anti-icing treatment and an outer area for the manoeuvring of two or more mobile de-icing/anti-icing equipment.	Нисэх онгоцыг мөстөлт арилгах/мөстөлт эсэргүүцэх үйлчилгээ авахаар байрлуулах дотор талбай болон хоёр, эсхүл түүнээс олон мөстөлт арилгах/мөстөлт эсэргүүцэх хөдөлгөөнт төхөөрөмжийн маневрт зориулсан гадна талбайгаас бүрддэг талбай (AN 14/I)
Deleterious effects	Халдварын нөлөөлөл	Effects that are capable of posing a hazard to the health of passengers, personnel, live cargo or on the structure of the aircraft.	Зорчигчид, ажилтнууд, амьд ачааны эрүүл мэнд, эсхүл агаарын хөлгийн бүтцэд аюул учруулж болзошгүй нөлөөлөл (AN 9)
Dependent parallel approaches	Хамааралтай зэрэгцээ зурвасын ойртолт	Simultaneous approaches to parallel or near-parallel instrument runways where radar separation minima between aircraft on adjacent extended runway centre lines are prescribed.	Зэрэгцээ ХБЗ-ын гол шугамын дагуу агаарын хөлөг хооронд радарын зайчлалын минимал тогтоосон зэрэгцээ, эсхүл бараг зэрэгцээ хэрэглэлийн ХБЗ-нд нэгэн зэрэг үйлдэх ойртолт (AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Deportation order	Албадан гаргах шийдвэр	A written order, issued by the competent authorities of a State and served upon a deportee, directing the deportee to leave that State.	Эрх бүхий байгууллагаас тухайн Улсыг орхин гаргах талаар албадан гаргаж буй этгээдэд гардуулах бичгээр гаргасан шийдвэр (AN 9)
Deportee	Албадан гаргах этгээд	A person who had legally been admitted to a State by its authorities or who had entered a State illegally, and who at some later time is formally ordered by the competent authorities to leave that State.	Тухайн Улсад хуулийн дагуу ирсэн, эсхүл тухайн Улсад хууль бусаар нэвтэрсэн боловч хэсэг хугацааны дараа эрх бүхий байгууллагаас тус улсыг орхин гарахыг албан ёсоор шаардсан этгээд (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Derivative version	Сайжруулсан хувилбар	An aircraft gas turbine engine of the same generic family as an originally type-certificated engine and having features which retain the basic core engine and combustor design of the original model and for which other factors, as judged by the certificating authority, have not changed. <i>Note.- Attention is drawn to the difference between the definition of “derived version of an aeroplane” in Volume I of Annex 16 and the definition of “derivative version” in this Volume.</i>	Үндсэн маягаар гэрчилгээжсэн хөдөлгүүртэй ижил ерөнхий бүлэгт багтдаг ба суурь цөм хөдөлгүүр болон шатаах камерын маяг нь үндсэн загвараа хадгалсан хэв шинжтэй ба бусад хүчин зүйлийн хувьд өөрчлөлтгүй гэж гэрчилгээжүүлэгч байгууллага шийдвэрлэсэн агаарын хөлгийн хийн турбинт хөдөлгүүр <i>Тэмдэглэл: Annex 16 Volume I-ийн “өөрчлөгдсөн хувилбар” тодорхойлолт болон Volume II-ийн “сайжруулсан хувилбар” тодорхойлолт хоорондоо зөрүүтэй болохыг анхаарна уу. (AN 16/II)</i>
Derived version of a CO ₂ -certified aeroplane	CO ₂ гэрчилгээжсэн нисэх онгоцны өөрчлөгдсөн хувилбар	An aeroplane which incorporates a change in the type design that either increases its MTOM, or that increases its CO ₂ emissions evaluation metric value by more than: a) 1.35 per cent at a MTOM of 5 700 kg, decreasing linearly to; b) 0.75 per cent at a MTOM of 60 000 kg, decreasing linearly to; c) 0.70 per cent at a MTOM of 600 000 kg; and d) a constant 0.70 per cent at MTOM greater than 600 000 kg.	MTOM, эсхүл CO ₂ -хийн ялгаруулалтын хэмжилтийн хэмжээ, эсхүл аль аль нь дараахаас ихээр өөрчлөгдсөн, маягийн загварт нь өөрчлөлт орсон нисэх онгоц: a) MTOM 5 700 кг-д 1.35%-аас шугаман хамаарлаар буурдаг; b) MTOM 60 000 кг-д 0.75%-аас шугаман хамаарлаар буурдаг; c) MTOM 600 000 кг-д 0.70%; d) MTOM 600 000 кг-аас дээш бол тогтмол 0.70%; (AN 16/III)
Derived version of a helicopter	Нисдэг тэрэгний өөрчлөгдсөн хувилбар	A helicopter which, from the point of view of airworthiness, is similar to the noise certificated prototype but incorporates changes in type design which may affect its noise characteristics adversely.	НТЧ-ын хувьд, дуу чимээний гэрчилгээтэй үндсэн загвартай төстэй боловч дуу чимээний үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохоор маягийн загварт нь өөрчлөлт орсон нисдэг тэрэг (AN 16/I)
Derived version of a non-CO ₂ -certified aeroplane	CO ₂ - гэрчилгээжээгүй нисэх онгоцны өөрчлөгдсөн хувилбар	An individual aeroplane that conforms to an existing Type Certificate, but which is not certified to Annex 16, Volume III, and to which a change in the type design is made prior to the issuance of the aeroplane’s first certificate of airworthiness that increases its CO ₂ emissions evaluation metric value by more than 1.5 per cent or is considered to be a significant CO ₂ change.	Өөрийн маягийн гэрчилгээнд тохирч байгаа боловч Annex 16, Volume III -ийн дагуу гэрчилгээжээгүй бөгөөд CO ₂ хийн ялгаруулалтын хэмжилтийн хэмжээ нь 1.5 %-иас илүү нэмэгдсэн эсхүл CO ₂ -ын том өөрчлөлт гэж тооцогдсон маягийн загварын өөрчлөлтийг анхны НТЧ гэрчилгээг олгохоос өмнө хийсэн өөрчлөлттэй тухайн нисэх онгоц (AN 16/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Derived version of an aeroplane	Нисэх онгоцны өөрчлөгдсөн хувилбар	An aeroplane which, from the point of view of airworthiness, is similar to the noise certificated prototype but incorporates changes in type design which may affect its noise characteristics adversely.	НТЧ-ын хувьд, дуу чимээний гэрчилгээтэй үндсэн загвартай төстэй боловч дуу чимээний үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохоор маягийн загвар нь өөрчлөгдсөн нисэх онгоц (AN 16/I)
Design D	Маяг D	The D of the design helicopter.	Нисдэг тэрэгний маягийн D (AN 14/II)
Design landing mass	Тооцоот буултын масс	The maximum mass of the aircraft at which, for structural design purposes, it is assumed that it will be planned to land.	Агаарын хөлгийн бүтцийг зохион бүтээх бөх батын тооцоонд буулт үйлдэх үед байж болохоор тооцсон максимум масс (AN 8)
Design take-off mass	Тооцоот хөөрөлтийн масс	The maximum mass at which the aircraft, for structural design purposes, is assumed to be planned to be at the start of the take-off run.	Агаарын хөлгийн бүтцийг зохион бүтээх бөх батын тооцоонд хөөрөлтийн гүйлтийг эхлүүлэх үед байж болохоор тооцсон максимум масс (AN 8)
Design taxiing mass	Тооцоот явгалалтын масс	The maximum mass of the aircraft at which structural provision is made for load liable to occur during use of the aircraft on the ground prior to the start of take-off.	Агаарын хөлгийн бүтцийг зохион бүтээх бөх батын тооцоонд, хөөрөлт эхлүүлэхээс өмнө тухайн агаарын хөлгийг газар дээр ашиглаж байх үед дааж чадах ачааллыг тооцсон максимум масс (AN 8)
Designated postal operator	Томилогдсон шуудангийн үйл ажиллагаа эрхлэгч	Any governmental or non-governmental entity officially designated by a Universal Postal Union (UPU) member country to operate postal services and to fulfil the related obligations arising from the acts of the UPU Convention on its territory.	Өөрийн нутаг дэвсгэрт Дэлхийн шуудангийн холбооны (UPU) Конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх болон шуудангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор UPU-гийн гишүүн Улс албан ёсоор томилсон, засгийн газрын, эсхүл засгийн газрын бус байгууллага (AN 18)
Detect and avoid	Тодорхойлох ба зайлсхийх	The capability to see, sense or detect conflicting traffic or other hazards and take the appropriate action.	Зөрчилдөж байгаа нислэгийн хөдөлгөөн, эсхүл бусад аюулыг харах, мэдрэх, эсхүл тодорхойлж, шаардлагатай арга хэмжээ авах чадвар (AN 1, AN 2)
DETRESFA	DETRESFA	The code word used to designate a distress phase.	Аюулын үеийг илэрхийлэхэд зориулан ашигладаг түлхүүр үг (AN 11)
Difference in depth of modulation (DDM)	Модуляцийн гүний зөрүү (DDM)	The percentage modulation depth of the larger signal minus the percentage modulation depth of the smaller signal, divided by 100.	Хувиар илэрхийлсэн том дохионы модуляцийн гүнээс хувиар илэрхийлсэн жижиг дохионы модуляцийн гүнийг хасаж, 100-д хуваасан (AN 10/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Digital elevation model	Өндөрлөгийн тоон загвар	The representation of terrain surface by continuous elevation values at all intersections of a defined grid, referenced to common datum. <i>Note. - Digital Terrain Model (DTM) is sometimes referred to as DEM.</i>	Тодорхойлсон торны огтлол бүрийг үргэлжилсэн өндөрлөгийн утгаар дүрслэн, нийтлэг өгөгдсөн цэгээр илэрхийлдэг газрын бартааны гадаргуугийн дүрслэл <i>Тэмдэглэл: Саадын тоон загварыг (DTM) заримдаа Өндөрлөгийн тоон загвар (DEM) гэдэг. (AN 4; AN 15)</i>
Direct transit area	Шууд транзитын бүс	A special area established in an international airport, approved by the public authorities concerned and under their direct supervision or control, where passengers can stay during transit or transfer without applying for entry to the State.	Холбогдох төрийн эрх бүхий байгууллагын баталсан ба тэдний шууд хяналт, эсхүл удирдлагын доор дамжин өнгөрөх, эсхүл шилжин суух зорчигчид тухайн Улсад нэвтрэхгүйгээр байрлаж болох олон улсын нисэх буудалд тусгайлан тогтоосон бүс (AN 9)
Direct transit arrangements	Шууд транзитын зохицуулалт	Special arrangements approved by the public authorities concerned by which traffic which is pausing briefly in its passage through the Contracting State may remain under their direct control.	Тухайн Хэлэлцэн тохиролцогч Улсыг дайран өнгөрөхдөө түр зогсолт хийдэг аль нислэгийн хөдөлгөөн нь тэдний шууд хяналтад хэвээр байхыг тогтоох зорилгоор төрийн эрх бүхий байгууллагын баталсан тусгай зохицуулалт (AN 9; AN 15)
Discrete source damage	Биетээс үүссэн эвдрэл	Structural damage of the aeroplane that is likely to result from: impact with a bird, uncontained fan blade failure, uncontained engine failure, uncontained high-energy rotating machinery failure or similar causes.	Шувуутай мөргөлдөх, фэний алга, хөдөлгүүр, эсхүл өндөр хурдтай эргэх механизмын гэнэтийн эвдрэл, эсхүл ижил төрлийн бусад тохиолдлоос шалтгаалсан байж болох нисэх онгоцны бүтцийн эвдрэл (AN 8)
Disembarkation	Агаарын хөлгөөс буух	The leaving of an aircraft after a landing, except by crew or passengers continuing on the next stage of the same through-flight.	Тухайн нислэгийг үргэлжлүүлж байгаа нисэх багийн гишүүд, зорчигчоос бусад этгээдийг тухайн агаарын хөлгөөс буулгах үйл явц (AN 9)
Disinfection	Халдваргүйжүүлэлт	The procedure whereby health measures are taken to control or kill infectious agents on a human or animal body, in or on affected parts of aircraft, baggage, cargo, goods or containers, as required, by direct exposure to chemical or physical agents.	Химийн болон физикийн бодисын шууд үйлчлэлээр хүн, амьтан, эсхүл шаардлагатай бол агаарын хөлгийн холбогдох эд анги, тээш, ачаа, бараа, эсхүл чингэлэгт эрүүл мэндийг хянах, эсхүл халдвар тараах биетийг устгах зорилгоор авах арга хэмжээний журам (AN 9)
Disinsection	Шавж устгал	The procedure whereby health measures are taken to control or kill insects present in aircraft, baggage, cargo, containers, goods and mail.	Агаарын хөлөг болон чингэлэгт байгаа шавжтай тэмцэх, эсхүл устгах арга хэмжээ авдаг үйл ажиллагаа (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Displaced threshold	Шилжүүлсэн босго	A threshold not located at the extremity of a runway.	ХБЗ-ын ирмэгт байрлаагүй босго (AN 4; AN 14/I)
Displacement sensitivity (localizer)	Шилжилтийн мэдрэмж (локалайзер)	The ratio of measured DDM to the corresponding lateral displacement from the appropriate reference line.	Зохих хяналтын шугамаас хазайсан хамаарах хажуугийн шилжилтийг хэмжсэн DDM-д хуваасан харьцаа (AN 10/I)
Disruptive passenger	Сахилгагүй зорчигч	A passenger who fails to respect the rules of conduct at an airport or on board an aircraft or to follow the instructions of the airport staff or crew members and thereby disturbs the good order and discipline at an airport or on board the aircraft.	Нисэх буудалд, эсхүл агаарын хөлөгт мөрдөх дүрмийг зөрчсөн, эсхүл нисэх буудлын ажилтан, эсхүл багийн гишүүний зааварчилгааг мөрдөөгүйн улмаас нисэх буудалд, эсхүл агаарын хөлөгт тогтсон хэв журам болон сахилга батыг алдагдуулсан зорчигч (AN 17)
Distress phase (DETRESFA)	Аюулын үе (DETRESFA)	A situation wherein there is reasonable certainty that an aircraft and its occupants are threatened by grave and imminent danger or require immediate assistance.	Агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүст ноцтой, гарцаагүй аюул тулгарсан, эсхүл яаралтай тусламж шаардлагатай гэж үзэх бодит итгэл үнэмшил бий болсон нөхцөл (AN 11; AN 12; PANS-ATM)
Ditching	Усан дээрх буулт	The forced landing of an aircraft on water.	Агаарын хөлгийн усан дээрх аргагүйдсэн буулт (AN 12)
Doppler shift	Доплерийн шилжилт	The frequency shift observed at a receiver due to any relative motion between transmitter and receiver.	Дамжуулагч ба хүлээн авагчийн хоорондын хөдөлгөөнөөс шалтгаалан хүлээн авагч дээр ажиглагддаг давтамжийн шилжилт (AN 10/I; AN 10/III)
Double channel simplex	Хоёр сувагтай симплекс	Simplex using two frequency channels, one in each direction. <i>Note. - This method was sometimes referred to as cross-band.</i>	Чиглэл бүрд нэг байх, хоёр давтамжийн суваг ашигладаг симплекс <i>Тэмдэглэл: Энэ аргыг заримдаа cross-band гэдэг.</i> (AN 10/II; AN 10/V)
Downstream clearance	Нислэгийн чиглэлийн зөвшөөрөл	A clearance issued to an aircraft by an ATC unit that is not the current controlling authority of that aircraft.	Тухайн мөчид агаарын хөлгийг удирдаагүй НХҮ-ний нэгжээс агаарын хөлөгт олгосон зөвшөөрөл (AN 11)
Dry runway	Хуурай ХБЗ	A runway is considered dry if its surface is free of visible moisture and not contaminated within the area intended to be used.	Хэрэв гадаргуу нь харагдахуйц чийггүй ба ашиглахаар төлөвлөж байгаа талбай нь тунадасгүй бол ХБЗ-ыг хуурай гэж үзнэ (AN 6/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Dual instruction time	Хосолсон нислэгийн зааварчилгааны цаг	Flight time during which a person is receiving flight instruction from a properly authorized pilot on board the aircraft, or from a properly authorized remote pilot using the remote pilot station during a remotely piloted aircraft flight.	Агаарын хөлөгт байгаа зохих ёсоор эрх олгогдсон нисгэгчээс, эсхүл зайнаас удирддаг агаарын хөлгийн нислэгт зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байранд зохих ёсоор эрх олгогдсон зайнаас-удирдах-нисгэгчээс нислэгийн зааварчилгаа авч байгаа этгээдийн нислэгийн цаг (AN 1)
Duplex	Дуплекс	A method in which telecommunication between two stations can take place in both directions simultaneously.	Хоёр станцын хооронд хоёр чиглэлд харилцан зэрэг холбоо барих аргачлал (AN 10/II; AN10/V)
Duty	Үүрэг	(A)Any task that flight or cabin crew members are required by the operator to perform, including, for example, flight duty, administrative work, training, positioning and standby when it is likely to induce fatigue. (AN 6/I) (B)Any task that an air traffic controller is required by an ATS provider to perform. These tasks include those performed during time-in-position, administrative work and training. (AN 11)	(A)Үйл ажиллагаа эрхлэгч нь нисэх баг, эсхүл бүхээгийн ажилтнаас гүйцэтгэхийг шаарддаг, жишээ нь: нислэгийн үүрэгт ажил, захиргааны ажил, сургалт, шилжин байрлалт болон хүлээлгийг багтаасан алжаал, ядаргаа үүсгэж болох аливаа ажил үүрэг (AN 6/I) (B)НХҮ үзүүлэгч нь нислэгийн хөдөлгөөний удирдагчаас гүйцэтгэхийг шаарддаг аливаа ажил. Энэ ажилд үүрэгт ажлын хугацаанд гүйцэтгэдэг ажил, захиргааны ажил болон сургалт багтана. (AN 11)
Duty Period	Үүрэгт хугацаа	(A)A period which starts when a flight or cabin crew member is required by an operator to report for or to commence a duty and ends when that person is free from all duties. (B)A period which starts when an air traffic controller is required by an ATS provider to report for or to commence a duty and ends when that person is free from all duties.	(A)Үйл ажиллагаа эрхлэгч нь нисэх баг, эсхүл бүхээгийн ажилтнаас ажил үүргээ илтгэх, эсхүл эхлүүлэхийг шаардахад эхэлдэг ба тэд бүх ажил үүргээс чөлөөтэй болоход дуусдаг хугацаа (AN 6/I; AN 6/III) (B)НХҮ үзүүлэгч нь нислэгийн хөдөлгөөний удирдагчаас ажил үүргээ илтгэх, эсхүл эхлүүлэхийг шаардахад эхэлдэг ба тэд бүх ажил үүргээс чөлөөтэй болоход дуусдаг хугацаа (AN 11)
D-value	D утга	A limiting dimension, in terms of “D”, for a heliport, helideck or shipboard heliport, or for a defined are a within.	Хэлипорт, нисдэг тэрэгний тавцан, эсхүл хөлөг онгоцны хэлипорт, эсхүл тогтоосон талбайн хувьд “D” тодорхойлолтоор хязгаарлагддаг хэмжээ (AN 14/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Dynamic load-bearing surface	Хөдөлгөөнт ачаалал даах гадаргуу	A surface capable of supporting the loads generated by a helicopter in motion.	Нисдэг тэрэгний хөдөлгөөнөөс үүссэн ачаалал даах гадаргуугийн чадвар (AN 14/II)
EDTO critical fuel	EDTO нислэгийн эрсдэлтэй түлш	The fuel quantity necessary to fly to an en-route alternate aerodrome considering, at the most critical point on the route, the most limiting system failure. <i>Note.- Guidance on EDTO critical fuel scenarios is contained in the Extended Diversion Time Operations (EDTO) Manual (Doc 10085).</i>	Тухайн нислэгийн замын хамгийн эрсдэлтэй цэгт хамгийн бага цагийн хязгаарлалттай систем татгалзана гэж тооцон, нислэгийн замын бэлтгэл аэродром руу нисэхэд шаардлагатай түлшний хэмжээ <u>Тэмдэглэл:</u> EDTO нислэгийн эрсдэлтэй түлш тооцох аргачлал нь Extended Diversion Time Operations (EDTO) Manual (Doc 10085)-д багтсан. (AN 6/I)
EDTO significant system	EDTO нислэгт нөлөөлөх систем	An aeroplane system whose failure or degradation could adversely affect the safety particular to an EDTO flight, or whose continued functioning is specifically important to the safe flight and landing of an aeroplane during an EDTO diversion.	Татгалзал, эсхүл доголдол нь ялангуяа EDTO нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох, эсхүл байнгын ажиллагаа нь EDTO даялах нислэгийн нисэх онгоцны аюулгүй нислэг болон буултад онцгой чухал ач холбогдолтой нисэх онгоцны систем (AN 6/I)
Effective acceptance bandwidth	Үр ашигтай хүлээн авах зурвасын өргөн	The range of frequencies with respect to the assigned frequency for which reception is assured when all receiver tolerances have been taken into account.	Хүлээн авахаар оноосон давтамжийн хувьд бүх хүлээн авагчийн зөвшөөрөгдөх зөрүүг тооцсон давтамжийн цар хүрээ (AN 10/I)
Effective adjacent channel rejection	Зэргэлдээ сувгийг үр дүнтэй дарах	The rejection that is obtained at the appropriate adjacent channel frequency when all relevant receiver tolerances have been taken into account.	Бүх холбогдох хүлээн авагчийн зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээг тооцоолж, тухайн зэргэлдээ сувгийн давтамжийг дарах чадвар (AN 10/I)
Effective intensity	Идэвхтэй тодорц	The effective intensity of a flashing light is equal to the intensity of a fixed light of the same colour which will produce the same visual range under identical conditions of observation.	Ижил өнгийн тогтмол цацрагтай гэрлийн тодорцтой тэнцүү бөгөөд ажиглалтын ижил нөхцөлд ижил ил харааны зайг харуулдаг анивчих гэрлийн идэвхтэй тодорц (AN 14/I)
Electronic aeronautical chart display	Нислэгийн зургийн электрон дэлгэц	An electronic device by which flight crews are enabled to execute, in a convenient and timely manner, route planning, route monitoring and navigation by displaying required information.	Шаардлагатай мэдээллийг дэлгэцэд харуулан замын төлөвлөгөө, замын хяналт болон нислэг үйлдэх боломжийг тохиромжтой, цаг хэмнэх хэлбэрээр нисэх багт олгодог электрон төхөөрөмж (AN 4)
Electronic flight bag (EFB)	Нислэгийн цахим цүнх (EFB)	An electronic information system, comprised of equipment and applications for flight crew, which	Нислэгийн үйл ажиллагаа, эсхүл ажил үүрэгт туслах зорилготой, EFB-ийн функцийг хадгалах,

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		allows for the storing, updating, displaying and processing of EFB functions to support flight operations or duties.	шинэчлэх, дэлгэцээр харуулах болон тооцоолох боломж олгодог, нисэх багт зориулсан төхөөрөмж болон хэрэглээний программ хангамжаас бүрдсэн электрон мэдээллийн систем (AN 6/I, AN 6/II; AN 6/III)
Electronic Travel Systems (ETS)	Цахим аяллын систем (ETS)	The automated process for the lodgement, acceptance and verification of a passenger's authorization to travel to a State, in lieu of the standard counterfoil paper visa.	Стандарт цаасан визийн оронд зорчигчид тухайн Улс руу аялах эрх олгох, хүлээн зөвшөөрөх болон баталгаажуулах автоматжуулсан үйл явц (AN 9)
Elevated heliport	Өргөгдсөн хэлипорт	A heliport located on a raised structure on land.	Газар дээрх өргөгдсөн байгууламж дээр байрладаг хэлипорт (AN 6/III; AN 14/II)
Elevation	Өндөрлөг	The vertical distance of a point or a level, on or affixed to the surface of the earth, measured from MSL.	MSL-ээс хэмжсэн, газрын гадаргуу дээрх, эсхүл түүний дээр байрласан цэгийн, эсхүл өндрийн-түвшний босоо зай (AN 3; AN 4; AN 10/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Ellipsoid height (Geodetic height)	Эллипсоидын өндөр (геодезийн өндөр)	The height related to the reference ellipsoid, measured along the ellipsoidal outer normal through the point in question.	Эллипсоидийн гадна шулуун шугамыг тухайн зорьсон цэгтэй холбон хэмжсэн, эллипсоидтой хамааралтай өндөр (AN 4; AN 14/I; AN 15)
Elongated	Уртасгасан	When used with TLOF or FATO, elongated means an area which has a length more than twice its width.	TLOF, эсхүл FATO-той хамт хэрэглэж байхад уртасгасан гэдэг нь өргөнөөсөө хоёр дахин урт талбайг ойлгоно. (AN 14/II)
Embarkation	Агаарын хөлөгт суух	The boarding of an aircraft for the purpose of commencing a flight, except by such crew or passengers as have embarked on a previous stage of the same through-flight.	Өмнөх нислэгээр ирж, нислэгийг үргэлжлүүлж байгаа нисэх багийн гишүүд, зорчигчоос бусад этгээдийг нислэг үйлдэх зорилгоор тухайн агаарын хөлөгт нэмж суулгах үйл явц (AN 9)
Emergency locator transmitter	Ослын байрлал дамжуулагч (ELT)	A generic term describing equipment which broadcast distinctive signals on designated frequencies and, depending on application, may be automatically activated by impact or be manually activated. An ELT may be any of the following: <i>Automatic fixed ELT (ELT(AF)).</i> An automatically activated ELT which is permanently attached to an aircraft.	Оноосон радио давтамжаар өвөрмөц дохиог дамжуулдаг ба хэрэглээнээс хамааран доргилтоор автоматаар ажилладаг, эсхүл гараар ажиллуулж болох төхөөрөмжийг тайлбарласан ерөнхий нэр томьёо. ELT нь дараах төрөлтэй: <i>Суурин автомат ELT (Automatic fixed ELT(AF))</i> - агаарын хөлөгт байнгын хэлбэрээр бэхэлсэн, автоматаар ажилладаг ELT.

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p><i>Automatic portable ELT (ELT(AP)).</i> An automatically activated ELT which is rigidly attached to an aircraft but readily removable from the aircraft.</p> <p><i>Automatic deployable ELT (ELT(AD)).</i> An ELT which is rigidly attached to an aircraft and which is automatically <i>deployed</i> and activated by impact, and, in some cases, also by hydrostatic sensors. Manual deployment is also provided.</p> <p><i>Survival ELT (ELT(S)).</i> An ELT which is removable from an aircraft, stowed so as to facilitate its ready use in an <i>emergency</i>, and manually activated by survivors.</p>	<p><i>Зөөврийн автомат ELT (Automatic portable ELT(AP))</i>- Агаарын хөлөгт хөдөлгөөнгүй суурилуулсан боловч хурдан салган хэрэглэж болдог автоматаар ажилладаг ELT.</p> <p><i>Автоматаар задардаг ELT (Automatic deployable ELT (ELT(AD)))</i>- Агаарын хөлөгт хөдөлгөөнгүй суурилуулсан, доргилтоор болон зарим тохиолдолд гидростатик мэдрэгчээр автоматаар задарч ажиллагаанд ордог ELT. Мөн гараар задлах боломжтой.</p> <p><i>Аврах ELT (Survival ELT (ELT(S)))</i>- агаарын хөлөгт ослын үед авч хэрэглэхэд хялбар байхаар бэхэлсэн, агаарын хөлгөөс салган авч болдог, гараар ажиллуулдаг ELT. (AN 6/I; AN 6/II; AN 6/III)</p>
Emergency phase	Онцгой нөхцөлийн үе шат	A generic term meaning, as the case may be, uncertainty phase, alert phase or distress phase.	Тодорхой бус, анхааруулах, эсхүл аюултай үе шатыг илэрхийлдэг ерөнхий ойлголт (AN 11; AN 12; PANS-ATM)
eMRTD	Цахим-аяллын баримт бичиг	An MRTD (passport, visa or card) that has a contactless integrated circuit embedded in it and the capability of being used for biometric identification of the MRTD holder i.a.w the standards specified in the relevant Part of Doc 9303 - <i>Machine Readable Travel Documents</i> .	ICAO Doc 9303 "Machine Readable Travel Documents"-д заасан стандартын дагуу аяллын баримт бичиг эзэмшигчийг нь биометрийн өгөгдлөөр таньж тогтоох чадвартай бөгөөд мэдээллийг нь зайнаас уншиж болохоор өөрт нь суулгасан цахим-аяллын баримт бичиг (паспорт, виз, эсхүл карт) (AN 9)
End-to-end	Төгсгөлөөс-төгсгөлд	Pertaining or relating to an entire communication path, typically from (1) the interface between the information source and the communication system at the transmitting end to (2) the interface between the communication system and the information user or processor or application at the receiving end.	Дамжуулалтын төгсгөлд байгаа мэдээллийн эх үүсвэр болон холбооны систем хоорондын холболт (1)-ээс хүлээн авалтын төгсгөлд байгаа холбооны систем болон тухайн мэдээллийг хэрэглэгч, эсхүл процессор, эсхүл хэрэглээ хоорондын холболт (2) хүртэлх нийт холболтын замд хамаарах, эсхүл холбоотой (AN 10/III)
End-user	Төгсгөлийн хэрэглэгч	An ultimate source and/or consumer of information.	Мэдээллийн үндсэн эх үүсвэр ба/эсхүл тухайн мэдээллийн хэрэглэгч (AN 10/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Energy per symbol to noise density ratio	Тэмдэгтийн чадал болон шуугианы нягтралын харьцаа	The ratio of the average energy transmitted per channel symbol to the average noise power in a 1 Hz bandwidth, usually expressed in dB. For A-BPSK and A-QPSK, one channel symbol refers to one channel bit.	Нэг тэмдэгтийн сувгаар дамжуулсан дундаж чадал болон 1 Hz зурвасын дундаж шуугианы чадлын dB-ээр илэрхийлдэг харьцаа. A-BPSK болон A-QPSK-ийн хувьд, нэг сувгийн тэмдэгт нь сувгийн нэг битийг илэрхийлнэ. (AN 10/III)
Engine	Хөдөлгүүр	A unit used or intended to be used for aircraft propulsion. It consists of at least those components and equipment necessary for functioning and control, but excludes the propeller/rotors (if applicable).	Удирдлага болон үйл ажиллагаанд шаардлагатай эд анги, төхөөрөмжөөс бүрдсэн, агаарын хөлгийн татах хүч болгон ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан хөдөлгүүр (Хэрэв хамааралтай бол, үүнд сэнс багтахгүй) (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 8)
Enhanced vision system (EVS)	Сайжруулсан дүрслэлийн систем (EVS)	A system to display electronic real-time images of the external scene achieved through the use of image sensors. <i>Note.- EVS does not include night vision imaging systems (NVIS).</i>	Дүрс мэдрэгч ашиглан гадаа талбайн электрон дүрсийг шууд харуулдаг систем <i>Тэмдэглэл: EVS нь шөнийн харааны дүрслэлийн систем (NVIS)-ийг агуулахгүй.</i> (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
En-route phase	Нислэгийн замын үе шат	That part of the flight from the end of the take-off and initial climb phase to the commencement of the approach and landing phase. <i>Note.- Where adequate obstacle clearance cannot be guaranteed visually, flights must be planned to ensure that obstacles can be cleared by an appropriate margin. In the event of failure of the critical engine, operators may need to adopt alternative procedures.</i>	Хөөрөлт болон өндөр авалтын эхний үе шатны төгсгөлөөс ойртолт болон буултын үе шатыг эхлүүлэх хүртэлх нислэгийн хэсэг <i>Тэмдэглэл: Ил хараагаар хангалттай саадыг давах зайг тогтоож чадахгүй тохиолдолд, тухайн саадыг хангалттай нөөцтэйгөөр давж чадахыг бататган нислэгийг төлөвлөх ёстой. Эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч нөөц журмыг дагаж мөрдөх ёстой.</i> (AN 6/III)
Equivalent isotropically radiated power	Изотроп цацруулалтын эквивалент чадал	The product of the power supplied to the antenna and the antenna gain in a given direction relative to an isotropic antenna (<i>absolute or isotropic gain</i>).	Изотроп антентай холбоотойгоор, антены чадлын гаралт ба өгөгдсөн чиглэлийн антены өсгөлтийн коэффициент (абсолют, эсхүл изотроп өсгөлтийн коэффициент) (AN 10/I; AN 10/III)
Equivalent procedure	Дүйцэх журам	A test or analysis procedure which, while differing from the one specified in this volume of Annex 16, in the technical judgement of the certificating authority yields effectively the same CO ₂ emissions evaluation metric value as the specified procedure.	Annex 16, Volume III-т зааснаас өөр боловч, гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын техникийн дүгнэлтэд CO ₂ -хийн ялгаруулалтын хэмжээг тодорхойлох тухайн заасан журамтай ижил үр дүнтэй тест, эсхүл дүн шинжилгээний журам (AN 16/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Error	Алдаа	An action or inaction by an operational person that leads to deviations from organizational or the operational person's intentions or expectations. <i>Note.</i> - See Chapter 1 of Annex 19 - Safety Management for a definition of operational personnel.	Байгууллага, эсхүл үйл ажиллагааны ажилтны хүсэл зорилго, эсхүл итгэл үнэмшлээс гажихад хүргэдэг, тухайн ажилтны үйлдэл, эсхүл эс үйлдэл <i>Тэмдэглэл:</i> Annex 19, Chapter 1. SMS үйл ажиллагааны ажилтны тодорхойлолтыг харгах (AN 1)
Error management	Алдааны удирдлага	The process of detecting errors and responding to them with countermeasures that reduce or eliminate the consequences of errors and mitigate the probability of further errors or undesired states.	Алдааг багасгах, эсхүл үр дагаврыг арилгах болон тодорхойгүй төлөв байдал, эсхүл цаашдын алдааны магадлалыг багасгах эсрэг арга хэмжээгээр алдааг илрүүлэх, түүнд хариу үйлдэл хийх үйл явц (AN 1)
Escort	Харгалзагч	An individual authorized by a Contracting State or an aircraft operator to accompany inadmissible persons or deportees being removed from that Contracting State.	Тухайн хэлэлцэн тохиролцогч Улсаас албадан гаргах орох зөвшөөрөлгүй, эсхүл албадан гаргах шаардлагатай этгээдийг харгалзан дагалдахаар Хэлэлцэн тохиролцогч Улс, эсхүл агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрсөн хувь хүн (AN 9)
Essential radio navigation service	Радио навигацийн үндсэн үйлчилгээ	A radio navigation service whose disruption has a significant impact on operations in the affected airspace or aerodrome.	Үйлчилгээний тасалдал нь тухайн агаарын зай, эсхүл аэродромын үйл ажиллагаанд ноцтой нөлөөлдөг радио навигацийн үйлчилгээ (AN 10/I)
Estimated off-block time	Нислэг эхлэх тооцоот цаг	The estimated time at which the aircraft will commence movement associated with departure.	Тухайн нислэгтэй холбоотойгоор агаарын хөлөг хөдөлгөөнөө эхлэх тооцоот цаг (AN 2)
Estimated time of arrival (ETA)	Тооцоот нисэн ирэх цаг (ETA)	For IFR flights, the time at which it is estimated that the aircraft will arrive over that designated point, defined by reference to navigation aids, from which it is intended that an instrument approach procedure will be commenced, or, if no navigation aid is associated with the aerodrome, the time at which the aircraft will arrive over the aerodrome. For VFR flights, the time at which it is estimated that the aircraft will arrive over the aerodrome.	IFR нислэгийн хувьд, навигацийн туслах төхөөрөмжөөр баримжаалан тогтоосон, хэрэглэлийн ойртолтын журмыг эхлүүлэхээр төлөвлөсөн цэг дээр нисэн ирэхэд, эсхүл хэрэв аэродромд навигацийн туслах төхөөрөмж байхгүй бол, тухайн нисэн очих аэродромын дээр нисэн хүрэхэд шаардлагатай тооцоот цаг. VFR нислэгийн хувьд, аэродром дээр нисэн хүрэхэд шаардлагатай тооцоот цаг. (AN 2; PANS-ATM)
Exception	Үл хамаарал	A provision in Annex 18 which excludes a specific item of dangerous goods from the requirements normally applicable to that item.	Аюултай барааны төрөлд хамаарах шаардлагаас аюултай барааны тодорхой төрлийг чөлөөлөх Annex 18-ын заалт (AN 18)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Exemption	Дүрмийн шаардлагаас чөлөөлөх	An authorization, other than an approval, granted by an appropriate national authority providing relief from the provisions of the Technical Instructions.	Техникийн зааварчилгааны шаардлагаас чөлөөлөх холбогдох үндэсний эрх бүхий байгууллагаас гаргасан зөвшөөрлөөс бусад шийдвэр (AN 18)
Exhaust nozzle	Гаралтын яндан	In the exhaust emissions sampling of gas turbine engines where the jet effluxes are not mixed (as in some turbofan engines, for example) the nozzle considered is that for the gas generator (core) flow only. Where, however, the jet efflux is mixed the nozzle considered is the total exit nozzle.	Тийрэлтэд хийн урсгал нь холилддоггүй (ж-нь, турбо-фэн) хөдөлгүүрийн хувьд хийн турбинт хөдөлгүүрийн гаралтын хийн ялгаруулалтын шинжилгээнд цөм хөдөлгүүрийн хийн урсгалыг яндан гэж үзнэ. Гэхдээ, тийрэлтэд хийн урсгал нь холилддог хөдөлгүүрийн хувьд нийт хийн урсгалын гаралтыг яндан гэж үзнэ. (AN 16/II)
Expected approach time	Ойртолтын баримжаат цаг	The time at which ATC expects that an arriving aircraft, following a delay, will leave the holding fix to complete its approach for a landing. <i>Note.- The actual time of leaving the holding fix will depend upon the approach clearance.</i>	Саатсаны дараа, нисэн ирж байгаа агаарын хөлөг буултын ойртолтыг гүйцэтгэхээр хүлээх цэгийг өнгөрнө гэж НХУ-ын тооцоолж байгаа цаг. <i>Тэмдэглэл: Хүлээх цэгийг өнгөрөх бодит цаг нь ойртолтын зөвшөөрлөөс шалтгаална. (AN 2; PANS-ATM)</i>
Extended diversion time operations (EDTO)	Даялах хугацаа сунгасан нислэгийн үйл ажиллагаа (EDTO)	Any operation by an aeroplane with two or more turbine engines where the diversion time to an en-route alternate aerodrome is greater than the threshold time established by the State of the Operator.	Замын дагуух бэлтгэл аэродром хүрэх даялах хугацаа нь Үйл ажиллагаа эрхлэгчийг харьяалах Улсын тогтоосон босго хугацаанаас их байдаг хоёр, эсхүл түүнээс олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцны үйл ажиллагаа (AN 6/I)
Extended flight over water	Усан дээгүүр үргэлжилсэн нислэг	A flight operated over water at a distance of more than 93 km (50 NM), or 30 minutes at normal cruising speed, whichever is the lesser, away from land suitable for making an emergency landing.	Онцгой нөхцөлийн буултыг үйлдэж болох газраас 93 км-ээс (50 NM) алс, эсхүл 30 минут аяллын нислэгийн хэвийн хурдтай нисэх зайн аль бага зайд усан дээгүүр үйлдэх нислэг (AN 6/II)
Extended range operation	Алслалт нэмэгдүүлсэн нислэг	Any flight by an aeroplane with two turbine engines where the flight time at the one engine inoperative cruise speed (in ISA and still air conditions), from a point on the route to an adequate alternate aerodrome, is greater than the threshold time approved by the State of the Operator.	Хоёр турбинт хөдөлгүүртэй нисэх онгоцны (ISA-д, тогтуун агаарт) нэг хөдөлгүүр татгалзсан үеийн аяллын нислэгийн хурдтайгаар нисэж байхад тухайн замын аливаа цэгээс тохирох бэлтгэл аэродром хүртэл нисэх нислэгийн цаг нь агаарын тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын тогтоосон босго хугацаанаас их байх аливаа нислэг (AN 3; AN 6/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
External equipment (helicopter)	Гаднах төхөөрөмж (Нисдэг тэрэг)	Any instrument, mechanism, part, apparatus, appurtenance, or accessory that is attached to or extends from the helicopter exterior but is not used nor is intended to be used for operating or controlling a helicopter in flight and is not part of an airframe or engine.	Нисдэг тэргийг нислэгт удирдахад ашигладаггүй, эсхүл ашиглахад зориулаагүй ба хүчилсэн бүтэц, эсхүл хөдөлгүүрийн хэсэг биш, нисдэг тэрэгний гадна талд бэхэлсэн, эсхүл дүүжилсэн аливаа хэрэглэл, механизм, аппарат, аппаратур эсхүл туслах тоноглол (AN 16/I)
Facility Performance Category I - ILS	CAT I - ILS төхөөрөмжийн үзүүлэлт	An ILS which provides guidance information from the coverage limit of the ILS to the point at which the localizer course line intersects the ILS glide path at a height of 30 m (100 ft) or less above the horizontal plane containing the threshold. <i>Note.- The lower limit is set to 30 m (100 ft) below the minimum Category I decision height (DH).</i>	ILS-ийн бүрхэлтийн хязгаараас босго дээрх хэвтээ хавтгайд 30 м (100 ft), эсхүл түүнээс доош өндөрт локалайзерын чиглэлийн шугам нь ILS глиссадтай огтлолцох цэг хүртэл чиглүүлэлтийн мэдээллээр хангадаг ILS <i>Тэмдэглэл: Доод хязгаарыг минимум CAT I шийдвэр гаргах өндрөөс (DH) доош 30 м-т (100 ft) тохируулсан. (AN 10/I)</i>
Facility Performance Category II - ILS	CAT II - ILS төхөөрөмжийн үзүүлэлт	An ILS which provides guidance information from the coverage limit of the ILS to the point at which the localizer course line intersects the ILS glide path at a height of 15 m (50 ft) or less above the horizontal plane containing the threshold. <i>Note.- The lower limit is set to 15 m (50 ft) below the minimum Category II decision height (DH).</i>	ILS-ийн бүрхэлтийн хязгаараас босго дээрх хэвтээ хавтгайд 15 м (50 ft), эсхүл түүнээс доош өндөрт локалайзерын чиглэлийн шугам нь ILS глиссадтай огтлолцох цэг хүртэл чиглүүлэлтийн мэдээллээр хангадаг ILS <i>Тэмдэглэл: Доод хязгаарыг минимум CAT II шийдвэр гаргах өндрөөс (DH) доош 15 м-т (50 ft) тохируулсан. (AN 10/I)</i>
Facility Performance Category III - ILS	CAT III - ILS төхөөрөмжийн үзүүлэлт	An ILS which, with the aid of ancillary equipment where necessary, provides guidance information from the coverage limit of the facility to, and along, the surface of the runway.	Төхөөрөмжийн бүрхэлтийн хязгаараас эхлэн ХБЗ-ын дагуу, гадаргуу хүртэл туслах төхөөрөмжийн тусламжтайгаар шаардлагатай үед чиглүүлэлтийн мэдээллээр хангадаг ILS (AN 10/I)
Factor of safety	Аюулгүй байдлын хүчин зүйл	A design factor used to provide for the possibility of loads greater than those assumed, and for uncertainties in design and fabrication.	Тооцоолсноос илүү ачааллыг авах чадвар, мөн зохион бүтээлт, үйлдвэрлэлийн тодорхойгүй байдлаас хамгаалахад хэрэглэдэг зохион бүтээлтийн нөөц коэффициент (AN 8)
Fan marker beacon	Дэвүүр маркер дохиологч	A type of radio beacon, the emissions of which radiate in a vertical fan-shaped pattern.	Босоо дэвүүр хэлбэрээр долгион цацдаг радио дохиологчийн төрөл (AN 10/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Farad (F)	Фарад (Ф)	The capacitance of a capacitor between the plates of which there appears a difference of potential of 1 volt when it is charged by a quantity of electricity equal to 1 coulomb.	1 кулонтой тэнцүү цахилгаан цэнэгээр цэнэглэсэн үед ялтас хооронд 1 вольт потенциалын ялгавар гаргадаг конденсаторын багтаамж (AN 5)
Fatigue	Ядаргаа	A physiological state of reduced mental or physical performance capability resulting from sleep loss, extended wakefulness, circadian phase, and/or workload (mental and/or physical activity) that can impair a person's alertness and ability to perform safety-related operational duties.	Аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны ажил үүрэг гүйцэтгэдэг этгээдийн сонор сэрэмж болон чадварыг бууруулдаг нойр алдах, удаан хугацаагаар сэрүүн байх, биоритм алдагдах ба/эсхүл ажлын ачааллаас (оюуны ба/эсхүл биеийн хүчний) шалтгаалан оюуны, эсхүл биеийн хүчний гүйцэтгэлийн чадварыг багасгадаг физиологийн төлөв байдал (AN 6/I; AN 6/III; AN 11)
Fatigue Risk Management System (FRMS)	Ядаргааны эрсдэлийн удирдлагын систем (FRMS)	A data-driven means of continuously monitoring and managing fatigue-related safety risks, based upon scientific principles and knowledge as well as operational experience that aims to ensure relevant personnel are performing at adequate levels of alertness.	Холбогдох ажилтнууд нь ажил үүргээ анхаарал сэрэмжтэй байх шаардлага хангасан түвшинд гүйцэтгэж байгааг бататгах зорилготой, шинжлэх ухааны зарчим, мэдлэг болон үйл ажиллагааны туршлагад суурилсан, ядаргаатай холбоотой аюулгүй байдлын эрсдэлийн байнгын мониторинг хийх болон удирдах өгөгдлийн дүн шинжилгээний (data-driven) арга хэлбэр (AN 6/I)
Feature	Дүрслэл	Abstraction of real world phenomena (ISO 19101*).	Бодит ертөнцийн юмс үзэгдлийн хийсвэр төсөөлөл (ISO 19101*) (AN 4; AN 15)
Feature attribute	Дүрслэлийн шинж тэмдэг	Characteristic of a feature (ISO 19101*).	Дүрслэлийн үзүүлэлт (ISO 19101*) (AN 4; AN 15)
Feature operation	Дүрслэлийн үйл ажиллагаа	Operation that every instance of a feature type may perform (ISO 19110*).	Тухайн төрлийн дүрслэл бүрийн гүйцэтгэж чадах үйл ажиллагаа (ISO 19110*) (AN 15)
Feature relationship	Дүрслэлийн харилцан холбоо	Relationship that links instances of one feature type with instances of the same or a different feature type (ISO 19101*).	Нэг төрлийн дүрслэлийг ижил, эсхүл өөр төрлийн дүрслэлтэй холбодог харилцан холбоо (ISO 19101*) (AN 15)
Feature type	Дүрслэлийн төрөл	Class of real world phenomena with common properties (ISO 19110*).	Нийтлэг шинж чанартай бодит ертөнцийн юмс үзэгдлийн ангилал (ISO 19110*)
		<i>Note.- In a feature catalogue, the basic level of classification is the feature type.</i>	<i>Тэмдэглэл: Дүрслэлийн каталогт ангиллын үндсэн түвшин нь дүрслэлийн төрөл байна. (AN 15)</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Feedstock	Түүхий эд	A type of unprocessed raw material used for the production of aviation fuel.	Нисэхийн түлш үйлдвэрлэхэд ашигладаг боловсруулагдаагүй түүхий эдийн төрөл (AN 16/IV)
Filed flight plan	Хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөө	The flight plan as filed with an ATS unit by the pilot or a designated representative, without any subsequent changes.	Нисгэгч, эсхүл томилогдсон төлөөлөгч НХУ-ний нэгжид хүргүүлсэн, өөрчлөлт ороогүй нислэгийн төлөвлөгөө (AN 2; PANS-ATM)
Final approach	Ойртолтын төгсгөл	That part of an instrument approach procedure which commences at the specified final approach fix or point, or where such a fix or point is not specified, a) at the end of the last procedure turn, base turn or inbound turn of a racetrack procedure, if specified; or b) at the point of interception of the last track specified in the approach procedure; and ends at a point in the vicinity of an aerodrome from which: 1) a landing can be made; or 2) a missed approach procedure is initiated.	Тогтоосон ойртолтын төгсгөлийн сегментийн цэгээс (FAF), эсхүл тийм цэг тогтоогоогүй бол дараах цэгээс эхлүүлдэг хэрэглэлийн ойртолтын журмын хэсэг: a) Хэрэв заасан бол тойрог нислэгийн замын (racetrack) журмын сүүлчийн стандарт-эргэлт, үндсэн-эргэлт, эсхүл зурваст орох эргэлтийн (inbound turn) төгсгөлд; эсхүл b) ойртолтын журамд заасан сүүлчийн замтай огтлолцсон цэгт; болон аэродромын ойролцоох дараах цэгт дуусдаг: 1) буулт үйлдэж болох; эсхүл 2) ойртолтоос 2-т гарах журмыг эхлүүлэх. (AN 4; AN 11)
Final approach and take-off area (FATO)	Ойртолтын төгсгөлийн болон хөөрөлтийн бүс (FATO)	A defined area over which the final phase of the approach manoeuvre to hover or landing is completed and from which the take-off manoeuvre is commenced. Where the FATO is to be used by performance Class 1 helicopters, the defined area includes the rejected take-off area available.	Дээгүүр нь ойртолтын маневрын төгсгөлийн үе шатанд агаарт тогтох нислэг, эсхүл буулт үйлддэг болон түүнээс хөөрөлтийн маневрыг эхлүүлдэг тогтоосон бүс. Ангилал-1 хүчин чадлын үзүүлэлттэй нисдэг тэрэг энэ FATO бүс ашиглах бол тогтоосон бүс нь татгалзсан хөөрөлтийг зогсоох боломжит талбайг багтаадаг. (AN 4; AN 6/III; AN 8; AN 14/II)
Final approach fix or point (FAF or FAP)	Ойртолтын төгсгөлийн сегментийн цэг (FAF or FAP)	That fix or point of an instrument approach procedure where the final approach segment commences.	Ойртолтын төгсгөлийн сегментийг эхлүүлдэг хэрэглэлийн ойртолтын журмын цэг (AN 4)
Final approach segment	Ойртолтын төгсгөлийн сегмент	That segment of an instrument approach procedure in which alignment and descent for landing are accomplished.	Буулт үйлдэхээр тэгшлэлт болон өндөр алдалтыг гүйцэтгэдэг хэрэглэлийн ойртолтын журмын сегмент (AN 4; PANS-OPS/I; PANS-OPS/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Fire resistant	Гал эсэргүүцэх чадвар	The capability to withstand the application of heat by a flame for a period of 5 minutes. <i>Note.- The characteristics of an acceptable flame can be found in ISO 2685.</i>	Галын дөлийн халууны үйлчлэлийг 5 минут тэсвэрлэх чадвар <i>Тэмдэглэл: Хүлээн зөвшөөрөхүйц галын дөлийн үзүүлэлтийг ISO 2685-аас олж болно. (AN 8)</i>
Fireproof	Гал тэсвэрлэх чадвар	The capability to withstand the application of heat by a flame for a period of 15 minutes. <i>Note.- The characteristics of an acceptable flame can be found in ISO 2685.</i>	Галын дөлийн халууны үйлчлэлийг 15 минут тэсвэрлэх чадвар <i>Тэмдэглэл: Хүлээн зөвшөөрөхүйц галын дөлийн үзүүлэлтийг ISO 2685-аас олж болно. (AN 8)</i>
Fireproof material	Галд тэсвэртэй материал	A material capable of withstanding heat as well as or better than steel when the dimensions in both cases are appropriate for the specific purpose.	Хэмжээ нь тусгайлсан зорилгод тохирсон, гантай адил, эсхүл түүнээс илүү халуун тэсвэрлэх чадвартай материал (AN 7)
Fixed light	Тогтмол цацрагтай гэрэл	A light having constant luminous intensity when observed from a fixed point.	Хөдөлгөөнгүй цэгээс ажиглахад тогтмол гэрлийн тодорцтой гэрэл (AN 14/I)
Flight crew member	Нисэх багийн гишүүн	A licensed crew member charged with duties essential to the operation of an aircraft during a flight duty period.	Нислэгийн үүрэгт хугацаанд агаарын хөлөгт гэрчилгээжсэн багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогдсон этгээд (AN 1; AN 2; AN 3; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 9; AN 11; AN 18; PANS-ATM)
Flight data analysis	Нислэгийн өгөгдлийн дүн шинжилгээ	A process of analysing recorded flight data in order to improve the safety of flight operations.	Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор бичигдсэн нислэгийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх үйл явц (AN 6/I)
Flight documentation	Нислэгийн баримт бичгийн бүрдэл	Written or printed documents, including charts or forms, containing meteorological information for a flight.	Нислэгт зориулсан цаг уурын мэдээллийг агуулсан хүснэгт, эсхүл маягтыг багтаасан гараар бичсэн, эсхүл хэвлэмэл баримт бичиг (AN 3)
Flight duty period	Нислэгийн үүрэгт хугацаа	A period which commences when a flight or cabin crew member is required to report for duty that includes a flight or a series of flights and which finishes when the aircraft finally comes to rest and the engines are shut down at the end of the last flight on which he/she is a crew member.	нисэх баг эсхүл бүхээгийн ажилтан нэг эсхүл цуврал нислэг үйлдэхээр нислэгийн үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгаагаар илтгэхээс эхлэн, сүүлчийн нислэгийн төгсгөлд агаарын хөлөг хөдөлгүүрээ унтраан бүрэн зогсох хүртэл үүрэг гүйцэтгэх нийт хугацаа (AN 6/I; AN 6/III)
Flight information centre	Нислэгийн мэдээллийн төв	A unit established to provide flight information service and alerting service.	Нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж (AN 2; AN 3; AN 11; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Flight information region	Нислэгийн мэдээллийн бүс (FIR)	An airspace of defined dimensions within which flight information service and alerting service are provided.	Нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор тогтоосон хэмжээтэй агаарын зай (AN 2; AN 3; AN 4; AN 11; PANS-ATM)
Flight information service	Нислэгийн мэдээллийн үйлчилгээ	A service provided for the purpose of giving advice and information useful for the safe and efficient conduct of flights.	Нислэгийг аюулгүй, үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл болон зөвлөгөө өгөх зорилгоор үзүүлдэг үйлчилгээ (AN 2; AN 10/III; AN 11; PANS-ATM)
Flight level	Нислэгийн түвшин	<p>A surface of constant atmospheric pressure which is related to a specific pressure datum, 1013.2 hectopascals (hPa), and is separated from other such surfaces by specific pressure intervals.</p> <p><i>Note 1.- A pressure type altimeter calibrated i.a.w the Standard Atmosphere:</i></p> <p>a) when set to a QNH altimeter setting, will indicate altitude;</p> <p>b) when set to a QFE altimeter setting, will indicate height above the QFE reference datum;</p> <p>c) when set to a pressure of 1 013.2 hPa, may be used to indicate flight levels.</p> <p><i>Note 2.- The terms “height” and “altitude”, used in Note 1 above, indicate altimetric rather than geometric heights and altitudes.</i></p>	<p>1013.2 hPa-аар тогтоосон даралтын эхлэлийн цэгээс эхэлдэг ба бусад даралтын гадаргуугаас тусгайлан тогтоосон даралтын үечлэлээр зайчлагддаг атмосферийн тогтмол даралтын гадаргуу</p> <p><u>Тэмдэглэл 1:</u> Стандарт Атмосферийн дагуу тохируулга хийгдсэн дараах даралтын төрлийн алтиметр:</p> <p>a) QNH алтиметрийн тохируулгад шилжүүлсэн тохиолдолд, өндрийн-түвшнийг заадаг;</p> <p>b) QFE алтиметрийн тохируулгад шилжүүлсэн тохиолдолд, QFE эхлэлийн цэгээс дээших өндрийг заадаг;</p> <p>c) 1013.2 hPa даралтад шилжүүлсэн тохиолдолд, нислэгийн түвшнийг заахад ашигладаг;</p> <p><u>Тэмдэглэл 2:</u> Тэмдэглэл 1-д хэрэглэсэн “өндөр” болон “өндрийн-түвшин” нь геометрийн бус, алтиметрийн өндөр болон өндрийн-түвшнийг заадаг.</p> <p>(AN 2; AN 3; AN 4; AN 10/II; AN 11; Doc 9388; PANS-ATM; PANS-OPS/II)</p>
Flight manual	Нислэгийн заавар	A manual, associated with the certificate of airworthiness, containing limitations within which the aircraft is to be considered airworthy, and instructions and information necessary to the flight crew members for the safe operation of the aircraft.	НТЧ-ын гэрчилгээтэй холбоотой, тухайн агаарын хөлөг уг хязгаарлалтын хүрээнд нислэгт тэнцэнэ гэж үзэх хязгаарлалт болон агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагааг хангахад нисэх багийн гишүүдэд шаардлагатай зааварчилгаа болон мэдээллийг агуулсан заавар (AN 6/I; AN 6/II; AN 6/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Flight operations officer / flight dispatcher	Нислэгийн диспатчер	A person designated by the operator to engage in the control and supervision of flight operations, whether licensed or not, suitably qualified i.a.w Annex 1, who supports, briefs and/or assists the pilot-in-command in the safe conduct of the flight.	Annex 1-ийн дагуу үнэмлэхтэй, эсхүл үнэмлэхгүй байхаас үл хамааран зохих ёсоор мэргэшсэн, тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэхэд хөлгийн даргыг дэмждэг, зааварчилгаа өгдөг ба/эсхүл тусалдаг нислэгийн үйл ажиллагааны удирдлага, хяналтад оролцуулахаар үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон этгээд (AN 6/I; AN 6/III)
Flight plan	Нислэгийн төлөвлөгөө	Specified information provided to ATS units, relative to an intended flight or portion of a flight of an aircraft.	Агаарын хөлгийн төлөвлөж байгаа нислэг, эсхүл нислэгийн хэсэгтэй холбоотой, НХҮ-ний нэгжид хүргүүлдэг тусгайлан заасан мэдээлэл (AN 1; AN 2; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 11; AN 16/IV; PANS-ATM)
Flight procedures trainer	Нислэгийн журмын дадлагажуур	See Flight simulation training device.	“Дуураймал нислэгийн сургалтын төхөөрөмж”-ийг харах. (AN 1)
Flight recorder	Нислэгийн бичлэгийн төхөөрөмж	Any type of recorder installed in the aircraft for the purpose of complementing accident/incident investigation. <i>Automatic deployable flight recorder (ADFR). A combination flight recorder installed on the aircraft which is capable of automatically deploying from the aircraft.</i>	Осол, эсхүл зөрчилтэй холбоотой шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах зорилгоор агаарын хөлөгт суурилуулсан аливаа бичигч <i>Автоматаар задардаг нислэгийн бичлэгийн төхөөрөмж (ADFR)</i> гэж агаарын хөлгөөс автоматаар салган авч болдог агаарын хөлөгт суурилуулсан нислэгийн бичлэгийн төхөөрөмжийн комбинацыг ойлгоно. (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 13)
Flight safety documents system	Нислэгийн аюулгүй байдлын баримт бичгийн тогтолцоо	A set of interrelated documentation established by the operator, compiling and organizing information necessary for flight and ground operations, and comprising, as a minimum, the operations manual and the operator’s maintenance control manual.	Нислэгийн болон газрын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг нэгтгэн, зохион байгуулж, үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны заавар болон техник үйлчилгээний хяналтын заавар зэргийг багтаасан, үйл ажиллагаа эрхлэгчийн бүрдүүлсэн хоорондын уялдаа холбоотой баримт бичгийн иж бүрдэл (AN 6/I)
Flight simulation training device (FSTD)	Дуураймал нислэгийн сургалтын төхөөрөмж	Any one of the following three types of apparatus in which flight conditions are simulated on the ground: <i>A flight simulator, which provides an accurate representation of the flight deck of a particular aircraft type to the extent that the mechanical,</i>	Газарт нислэгийн нөхцөлийг дуурайлган бүрдүүлдэг дараах 3 төхөөрөмжийн аль нэг: <i>Нислэгийн симулятор:</i> агаарын хөлгийн механик, цахилгаан, электрон гэх мэт системийн удирдлага, нисэх багийн гишүүний үйл ажиллагааны хэвийн орчин болон тухайн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>electrical, electronic, etc. aircraft systems control functions, the normal environment of flight crew members, and the performance and flight characteristics of that type of aircraft are realistically simulated;</p> <p><i>A flight procedures trainer, which provides a realistic flight deck environment, and which simulates instrument responses, simple control functions of mechanical, electrical, electronic, etc. aircraft systems, and the performance and flight characteristics of aircraft of a particular class;</i></p> <p><i>A basic instrument flight trainer, which is equipped with appropriate instruments, and which simulates the flight deck environment of an aircraft in flight in instrument flight conditions.</i></p>	<p>агаарын хөлгийн маягийн үзүүлэлт, нислэгийн өгөгдөхүүнийг бодитоор дуурайлган үзүүлэх зорилгоор тодорхой агаарын хөлгийн маягийн нислэгийн бүхээгийн үнэн зөв, бодит орчныг бүрдүүлдэг төхөөрөмж;</p> <p><i>Нислэгийн журмын дадлагажуур: хэрэглэлийн заалт, агаарын хөлгийн механик, цахилгаан, электрон гэх мэт системийн хялбаршуулсан удирдлага болон тодорхой ангиллын агаарын хөлгийн үзүүлэлт, нислэгийн өгөгдөхүүнийг дуурайлган үзүүлж, нислэгийн бүхээгийн бодит байдалд ойрхон орчныг бүрдүүлдэг төхөөрөмж;</i></p> <p><i>Суурь хэрэглэлийн нислэгийн дадлагажуур: хэрэглэлийн нислэгийн нөхцөлд нисэж байгаа агаарын хөлгийн нислэгийн бүхээгийн орчныг дуурайлган, зохих хэрэглэлээр тоногдсон төхөөрөмж. (AN 1; AN 6/I; AN 6/III)</i></p>
Flight simulator	Нислэгийн симулятор	See Flight simulation training device.	“Дуураймал нислэгийн сургалтын төхөөрөмж”-ийг харах. (AN 1)
Flight time - aeroplanes	Нислэгийн цаг - нисэх онгоц	<p>The total time from the moment an aeroplane first moves for the purpose of taking off until the moment it finally comes to rest at the end of the flight.</p> <p><i>Note.- Flight time as here defined is synonymous with the term “block to block” time or “chock to chock” time in general usage which is measured from the time an aeroplane first moves for the purpose of taking off until it finally stops at the end of the flight.</i></p>	<p>Нисэх онгоц хөөрөлт үйлдэх зорилгоор хөдөлж эхлэх мөчөөс тухайн нислэгийн төгсгөлд бүрэн зогсох хүртэлх нийт хугацаа</p> <p><i>Тэмдэглэл: Нислэгийн цаг нь нисэх онгоц хөөрөлт үйлдэх зорилгоор хөдөлж эхлэхээс тухайн нислэгийн төгсгөлд бүрэн зогсох хүртэл хэмжсэн хугацаагаар тодорхойлогддог “блокоос блокт” хүрэх цаг, эсхүл “эвүүргээс эвүүргэд” хүрэх цаг гэдэг ойлголттой ижил утгатай ерөнхий ойлголт. (AN 1; AN 6/I; AN 6/II)</i></p>
Flight time - helicopters	Нислэгийн цаг - нисдэг тэрэг	The total time from the moment a helicopter’s rotor blades start turning until the moment the helicopter finally comes to rest at the end of the flight, and the rotor blades are stopped.	Нисдэг тэрэгний роторын алга эргэлдэж эхлэх мөчөөс нислэгийн төгсгөлд роторын алганы эргэлт бүрэн зогсох хүртэлх нийт хугацаа (AN 1; AN 6/III)
Flight time - remotely piloted aircraft systems	Нислэгийн цаг - зайнаас удирддаг	The total time from the moment a command and control (C2) link is established between the remote pilot station (RPS) and the remotely piloted aircraft (RPA) for the purpose of taking off or from the	Хөөрөлт үйлдэх зорилгоор зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байр (RPS) болон зайнаас удирддаг агаарын хөлөг (RPA) хоорондын удирдлага болон хяналтын (C2) холболтыг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
	агаарын хөлгийн систем	moment the remote pilot receives control following a handover until the moment the remote pilot completes a handover or the C2 link between the RPS and the RPA is terminated at the end of the flight.	тогтоох, эсхүл зайнаас-удирдах-нисгэгч хяналтыг шилжүүлэн авснаас эхлэн зайнаас-удирдах-нисгэгч хяналтыг шилжүүлэн өгөх, эсхүл нислэгийн төгсгөлд RPS болон RPA хоорондын C2 холболтыг салгах хүртэлх нийт цаг (AN 1)
Flight visibility	Нислэгийн хараа	The visibility forward from the cockpit of an aircraft in flight.	Нислэгийн үед агаарын хөлгийн бүхээгээс урагш харагдах хараа (AN 2; PANS-ATM)
Foot (ft)	Фүүт (ft)	The length equal to 0.304 8 metre exactly.	0.3048 м-тэй тэнцүү уртын нэгж (AN 5)
Forecast	Цаг уурын урьдчилсан мэдээ	A statement of expected meteorological conditions for a specified time or period, and for a specified area or portion of airspace.	Тодорхой цагт, эсхүл цаг хугацааны хооронд, тодорхой бүсийн, эсхүл агаарын зайн хэсгийн урьдчилан таамагласан цаг уурын нөхцөлийн талаарх мэдэгдэл (AN 3; AN 11; PANS-ATM)
Foreign object debris (FOD)	Гадны хаягдал биет (FOD)	An inanimate object within the movement area which has no operational or aeronautical function and which has the potential to be a hazard to aircraft operations.	Үйл ажиллагааны, эсхүл нисэхийн зориулалтгүй бөгөөд агаарын хөлгийн үйл ажиллагаанд бодитоор аюул учруулж болохуйц хөдөлгөөнт талбай дээрх амьгүй биет (AN 14/I)
Forward error correction	Алдааны шууд засалт	The process of adding redundant information to the transmitted signal in a manner which allows correction, at the receiver, of errors incurred in the transmission.	Дамжуулалтын үед хүлээн авагч дээр гарсан алдааг засах боломжтой болгох байдлаар дамжуулсан сигналд нэмэлт мэдээлэл нэмж оруулах үйл явц (AN 10/III)
Frangible object	Хэврэг биет	An object of low mass designed to break, distort or yield on impact so as to present the minimum hazard to aircraft. <i>Note.- Guidance on design for frangibility is contained in the Aerodrome Design Manual (Doc 9157), Part 6.</i>	Агаарын хөлөгт минимум аюул учруулахаар амархан хагардаг, деформацид ордог, эсхүл гулзайдаг байхаар зохион бүтээсэн бага жинтэй биет <u>Тэмдэглэл:</u> Хэврэг байдлыг тооцон зохион бүтээх аргачлал нь Aerodrome Design Manual (Doc 9157), Part 6-д багтсан. (AN 14/I)
Free text message element	Чөлөөт текст мэдээний элемент	Part of a message that does not conform to any standard message element in the PANS-ATM (Doc 4444).	PANS-ATM (Doc 4444)-д заасан аливаа стандарт мэдээний стандарт мэдээний элементтэй үл нийцэх мэдээний хэсэг (AN 10/II)
Free zone	Чөлөөт бүс	A part of the territory of a Contracting State where any goods introduced are generally regarded,	Гаалийн болон импортын татварын хувьд оруулж ирсэн аливаа барааг гаалийн нутаг дэвсгэрийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		insofar as import duties and taxes are concerned, as being outside the customs territory.	гадна байгаа гэж үздэг Хэлэлцэн тохиролцогч Улсын нутаг дэвсгэрийн хэсэг (AN 9)
Frequency channel	Давтамжийн суваг	A continuous portion of the frequency spectrum appropriate for a transmission utilizing a specified class of emission.	Дамжуулалтыг заасан цацралтын ангилал ашиглан хийх, оноосон давтамжийн спектрийн үргэлжилсэн хэсэг (AN 10/II; AN 10/IV)
Front course sector	Курсийн дагуу сектор	The course sector which is situated on the same side of the localizer as the runway.	ХБЗ-ын дагуу локалайзерын ижил тал руу чиглэсэн курсийн сектор (AN 10/I)
Fuel uplift	Түлш нэмж сумлах	Measurement of fuel provided by the fuel supplier, as documented in the fuel delivery notes or invoices for each flight (in litre).	Түлш нийлүүлэгч хангадаг нислэг бүрд сумласан түлшний бүртгэл, эсхүл төлбөрийн баримтаар баталгаажуулсан түлшний хэмжээ (литрээр) (AN 16/IV)
Fully automatic relay installation	Бүрэн автомат дахин дамжуулах төхөөрөмж	A teletypewriter installation where interpretation of the relaying responsibility in respect of an incoming message and the resultant setting-up of the connections required to effect the appropriate retransmissions is carried out automatically, as well as all other normal operations of relay, thus obviating the need for operator intervention, except for supervisory purposes.	Ирсэн мэдээллийг дамжуулахад гүйцэтгэх үүргийг тодорхойлох, дахин дамжуулалтад шаардлагатай сэлгэн залгалтыг гүйцэтгэх болон дамжуулалтад шаардлагатай бусад бүх үйлдлийг автоматаар хийдэг телетайп төхөөрөмж (AN 10/II)
Gain-to-noise temperature ratio	Сигнал-шуугианы температурын харьцаа	The ratio, usually expressed in dB/K, of the antenna gain to the noise at the receiver output of the antenna subsystem. The noise is expressed as the temperature that a 1 ohm resistor must be raised to produce the same noise power density.	Антену дэд системийн хүлээн авагчийн гаралтын дээрх антену сигналыг шуугианд харьцуулсан, dB/K-ээр илэрхийлдэг харьцаа. Шуугианы ижил чадлын нягтралыг гаргахын тулд 1 Ом-оор эсэргүүцлийг нэмэх шаардлагатай температураар илэрхийлдэг шуугиан. (AN 10/III)
GAMET area forecast	GAMET бүсийн урьдчилсан мэдээ	An area forecast in abbreviated plain language for low-level flights for a flight information region or sub-area thereof, prepared by the meteorological office designated by the meteorological authority concerned and exchanged with meteorological offices in adjacent flight information regions, as agreed between the meteorological authorities concerned.	Холбогдох цаг уурын эрх бүхий байгууллагын томилсон цаг уурын төвөөс бэлтгэн гаргадаг ба цаг уурын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоноор зэргэлдээх FIR-ийн цаг уурын төвтэй солилцдог, FIR, эсхүл түүний дэд бүсийн нам түвшний нислэгт зориулан товчилсон ойлгомжтой хэлбэрээр гаргадаг бүсийн урьдчилсан мэдээ (AN 3)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
General aviation operation	Ерөнхий зориулалтын нисэх	An aircraft operation other than a commercial air transport operation or an aerial work operation.	Агаарын тээврийн үйл ажиллагаа болон агаараас гүйцэтгэх ажлаас бусад агаарын хөлгийн үйл ажиллагаа (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 9; AN 17)
Geodesic distance	Геодезийн зай	The shortest distance between any two points on a mathematically defined ellipsoidal surface.	Математик аргаар тодорхойлсон эллипсоид гадаргуу дээрх аливаа хоёр цэгийн хоорондох хамгийн богино зай (AN 4; AN 15)
Geodetic datum	Геодезийн өгөгдөхүүн	A minimum set of parameters required to define location and orientation of the local reference system with respect to the global reference system/frame.	Орон нутгийн тооллын тогтолцоог дэлхийн тооллын тогтолцоотой хамааруулан байршил болон чиглэлийг тогтооход шаардлагатай параметрийн минимум багц (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)
Geoid	Геоид	The equipotential surface in the gravity field of the Earth which coincides with the undisturbed MSL extended continuously through the continents. <i>Note.- The geoid is irregular in shape because of local gravitational disturbances (wind tides, salinity, current, etc.) and the direction of gravity is perpendicular to the geoid at every point.</i>	Эх газрын доогуур үргэлжилсэн тогтуун MSL-тэй давхцах, дэлхийн таталцлын талбайн ижил тэнцүү гадаргуу <i>Тэмдэглэл: Тухайн газар нутгийн таталцлын тогтворгүй байдлаас (салхины урсгал, хөрсний давсархаг чанар, агаарын урсгал) шалтгаалан таталцлын хүч нь газар сайгүй геоидтэй перпендикуляр байдгаас геоид нь жигд бус хэлбэртэй байдаг.</i> (AN 4; AN 14/I; AN 14/II; AN 15; PANS-OPS/II)
Geoid undulation	Геоидын долгион	The distance of the geoid above (positive) or below (negative) the mathematical reference ellipsoid. <i>Note.- In respect to the World Geodetic System - 1984 (WGS-84) defined ellipsoid, the difference between the WGS-84 ellipsoidal height and orthometric height represents WGS-84 geoid undulation.</i>	Математик аргачлалын эллипсоидоос дээр (эерэг), эсхүл доор (сөрөг) орших геоидын зай <i>Тэмдэглэл: WGS-84-р тодорхойлсон эллипсоидын хувьд WGS-84 эллипсоид болон ортометрийн өндрийн хоорондын зөрүү нь WGS-84 геоидын долгионыг илэрхийлнэ.</i> (AN 4; AN 14/I; AN 14/II; AN 15; PANS-OPS/II)
Glide path	Глиссад	A descent profile determined for vertical guidance during a final approach.	Ойртолтын төгсгөлийн сегментийн босоо өндрийн чиглүүлэлтийг тогтоосон өндөр алдалтын хуваарь (AN 4; PANS-ATM)
Glider	Глайдер	A non-power-driven heavier-than-air aircraft, deriving its lift in flight chiefly from aerodynamic reactions on surfaces which remain fixed under given conditions of flight.	Нислэгийн тодорхой нөхцөлд хөдөлгөөнгүй байрласан гадаргуу нь агаартай харилцан үйлчилснээр, нислэгт үндсэн өргөх хүч үүсгэдэг, хөдөлгүүргүй, агаараас хүнд агаарын хөлөг. Үүнд,

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			хөдөлгүүр нь ажиллаж байгаа эсэхээс үл хамааран моторт-глайдер мөн багтана. (AN 1; AN 7)
Glider flight time	Глайдерын нислэгийн цаг	The total time occupied in flight, whether being towed or not, from the moment the glider first moves for the purpose of taking off until the moment it comes to rest at the end of the flight.	Хөөрөлт үйлдэх зорилгоор, чирсэн эсэхээс үл хамааран глайдер анх хөдөлж эхлэхээс тухайн нислэг дуусаж зогсох хүртэлх нислэгт байсан нийт цаг (AN 1)
Gray	Грей (Гй)	The energy imparted by ionizing radiation to a mass of matter corresponding to 1 joule per kilogram.	1 Ж / кг материйн масст хамаарах ионжсон цацрагаар дамжуулсан энерги (AN 5)
Great Circle Distance	Их тойргийн зай	The shortest distance, rounded to the nearest kilometre, between the origin and the destination aerodromes, measured over the earth's surface modelled according to the World Geodetic System 1984 (WGS84). <i>Note.- Latitude and longitude coordinates of aerodromes can be obtained from the ICAO Location Indicators database.</i>	Нисэн гарсан болон нисэх ирэх аэродромын хооронд WGS84-ийн дагуу загварчилсан дэлхийн гадаргуу дээр хэмжиж, ойрын километрт бүхэлдсэн хамгийн богино зай <i>Тэмдэглэл: ICAO Location Indicators database-аас аэродромуудын уртраг болон өргөргийн координатыг авч болно. (AN 16/IV)</i>
Gregorian calendar	Григорийн хуанли / Аргын тооллын хуанли	Calendar in general use; first introduced in 1582 to define a year that more closely approximates the tropical year than the Julian calendar (ISO 19108*). <i>Note.- In the Gregorian calendar, common years have 365 days and leap years 366 days divided into twelve sequential months.</i>	Нийтээр хэрэглэдэг хуанли; Юлианы хуанлиас тропик бүсийн жилийг илүү нарийн тодорхойлдог, 1582 онд анх хэрэглэсэн хуанли. <i>Тэмдэглэл: Григорийн хуанлид 365 хоногтой жил болон 366 хоногтой өндөр жилийг дараалсан 12 сард хуваадаг. (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)</i>
Grid point data in digital form	Солбицлын цэгийн тоон хэлбэртэй өгөгдөл	Computer processed meteorological data for a set of regularly spaced points on a chart, for transmission from a meteorological computer to another computer in a code form suitable for automated use. <i>Note.- In most cases, such data are transmitted on medium- or high-speed telecommunications channels.</i>	Газрын зураг дээр тогтмол зайчилсан цэгийг багцлах зорилгоор автомат ажиллагаанд ашиглахад тохиромжтой хэлбэрээр кодлон цаг уурын компьютероос бусад компьютер руу дамжуулахад зориулан компьютероор боловсруулсан цаг уурын өгөгдөл <i>Тэмдэглэл: Ихэнх тохиолдолд дээрх мэдээллийг дунд, эсхүл өндөр хурдны цахилгаан холбооны сувагаар дамжуулдаг. (AN 3)</i>
Ground earth station (GES)	Хиймэл дагуулын газрын станц	An earth station in the fixed satellite service, or, in some cases, in the aeronautical mobile-satellite service, located at a specified fixed point on land to	Нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээний харилцах шугамыг хангах зорилгоор тогтоосон цэгт, газар дээр хөдөлгөөнгүй

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		provide a feeder link for the aeronautical mobilesatellite service.	суурилуулсан, хиймэл дагуулын суурин холбооны, эсхүл зарим тохиолдолд нисэхийн хиймэл дагуулын-хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашигладаг газрын станц (AN 10/III)
Ground equipment	Газрын үйлчилгээний төхөөрөмж	Articles of a specialized nature for use in the maintenance, repair and servicing of an aircraft on the ground, including testing equipment and cargo- and passenger-handling equipment.	Газарт байгаа агаарын хөлгийн техникийн болон засвар, үйлчилгээ хийхэд ашигладаг, шалгах болон зорчигч, ачаа үйлчилгээний төхөөрөмжийг багтаасан тусгай зориулалттай эд зүйл (AN 9)
Ground handling	Газрын үйлчилгээ	Services necessary for an aircraft's arrival at, and departure from, an airport, other than ATS.	НХҮ-ээс бусад, агаарын хөлөг нисэх буудалд нисэн ирэх, нисэн гарахад шаардлагатай үйлчилгээ (AN 6/I; AN 6/III)
Ground visibility	Газрын хараа	The visibility at an aerodrome as reported by an accredited observer or by automatic systems.	Итгэмжлэгдсэн ажиглагч, эсхүл автомат системээс мэдээлдэг аэродромын ил харааны зай (AN 2; PANS-ATM)
Ground-to-air communication	Газар - агаар холбоо	One-way communication from stations or locations on the surface of the earth to aircraft.	Газарт байрлаж байгаа станц, эсхүл газрын гадаргуу дээрх тухайн байрлалаас агаарын хөлөгтэй холбоо тогтоох нэг талын холбоо (AN 10/II; PANS-ATM)
Gyroplane	Жироплан	A heavier-than-air aircraft supported in flight by the reactions of the air on one or more rotors which rotate freely on substantially vertical axes.	Агаарын урсгалын харилцан үйлчлэлээр, ихэвчлэн босоо тэнхлэгтэй нэг, эсхүл түүнээс олон ротор чөлөөтэй эргэн агаарт хөөрдөг, хөдөлгүүргүй, агаараас хүнд агаарын хөлөг (AN 7)
Half course sector	Курсийн хагас сектор	The sector, in a horizontal plane containing the course line and limited by the loci of points nearest to the course line at which the DDM is 0.0775.	Чиглэлийн шугамыг багтаасан ба DMM нь 0.0775 байдаг чиглэлийн шугамд хамгийн ойрын геометрийн цэгүүдээр хязгаарлагдсан хэвтээ хавтгайн сектор (AN 10/I)
Half ILS glide path sector	Харас ILS глиссадын сектор	The sector in the vertical plane containing the ILS glide path and limited by the loci of points nearest to the glide path at which the DDM is 0.0875.	ILS глиссадыг багтаасан ба DMM нь 0.0875 байдаг глиссадад хамгийн ойрын геометрийн цэгүүдээр хязгаарлагдсан босоо хавтгайн сектор (AN 10/I)
Handover	Шилжүүлэх	The act of passing piloting control from one remote pilot station to another.	Нислэгийн удирдлагыг нэг зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байрнаас нөгөөд шилжүүлэх үйлдэл (AN 1)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Hazard	Аюул	A condition or an object with the potential to cause or contribute to an aircraft incident or accident.	Агаарын хөлгийн осол, эсхүл зөрчилд хүргэх бодит шалтгаан, эсхүл нөлөөлөх нөхцөл, эсхүл биет (AN 19)
Hazard beacon	Аюулын гэрэлт дохио	An aeronautical beacon used to designate a danger to air navigation.	Нислэгт аюултай болохыг дохиолох зорилгоор ашигладаг нисэхийн гэрэлт дохио (AN 14/I)
Heading	Чиглэл	The direction in which the longitudinal axis of an aircraft is pointed, usually expressed in degrees from North (true, magnetic, compass or grid).	Ихэвчлэн хойд зүгээр (жинхэнэ, соронзон, компас, эсхүл солбицол) илэрхийлдэг, агаарын хөлгийн тууш тэнхлэгийг заасан чиглэл (AN 2; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Head-up display (HUD)	Head-up дэлгэц (HUD)	A display system that presents flight information into the pilot's forward external field of view.	Нисгэгчийн урд гадна орчныг харах хэсэгт нислэгийн мэдээллийг харуулдаг дэлгэцийн систем (AN 6/I; AN 6/II)
Health-related documentation	Эрүүл мэндтэй холбоотой баримт бичиг	Documentary evidence required by Contracting States, including those standardized by the World Health Organization (WHO) International Health Regulations (IHR) (2005), to indicate that passengers and crew members have fulfilled the requirements for preventing and mitigating the spread of communicable diseases for the purposes of transiting or entering a Contracting State.	Хэлэлцэн тохиролцогч улс руу нэвтрэн орох эсхүл дамжин өнгөрөх зорилгоор халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах шаардлагыг зорчигч болон багийн гишүүд биелүүлж байгааг илтгэн харуулах Хэлэлцэн тохиролцогч улсуудын шаардаж буй баримт бичгүүд, тухайлбал Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Олон улсын эрүүл мэндийн дүрмүүд (2005)-ээр стандартчилсан журмууд (AN 9)
Heavier-than-air aircraft	Агаараас хүнд агаарын хөлөг	Any aircraft deriving its lift in flight chiefly from aerodynamic forces.	Аэродинамикийн хүчээр нислэгт өөрийн үндсэн өргөх хүчээ үүсгэдэг агаарын хөлөг (AN 7)
Height	Өндөр	The vertical distance of a level, a point or an object considered as a point, measured from a specified datum.	Тусгайлан тогтоосон эхлэлийн цэгээс хэмжсэн бөгөөд тухайн байгууламжийн босоо хэмжээг багтаасан, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зай (AN 2; AN 3; AN 4; AN 6/I; AN 10/I; AN 10/II; AN 11; AN 15; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Helicopter	Нисдэг тэрэг	A heavier-than-air aircraft supported in flight chiefly by the reactions of the air on one or more power-driven rotors on substantially vertical axes.	Ихэвчлэн босоо тэнхлэгтэй, хөдөлгүүр хөтөлдөг нэг, эсхүл түүнээс олон ротор, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр нислэг үйлддэг агаараас

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			хүнд агаарын хөлөг (AN 1; AN 6/III; AN 7; AN 8; AN 16; AN 19)
Helicopter clearway	Нисдэг тэрэгний саадаас чөлөөтэй талбай	A defined area on the ground or water, selected and/or prepared as a suitable area over which a helicopter operated in performance class 1 may accelerate and achieve a specific height.	Холбогдох эрх бүхий байгууллагын хяналтад байгаа, Хүчин чадлын ангилал-1 нисдэг тэрэг дээгүүр нь хурд аван, тодорхой өндрийг авахад тохиромжтой байхаар сонгосон ба/эсхүл бэлтгэсэн газар, эсхүл усан дээр тогтоосон талбай (AN 14/II)
Helicopter stand	Нисдэг тэрэгний зогсоол	A defined area intended to accommodate a helicopter for purposes of: loading or unloading passengers, mail or cargo; fuelling, parking or maintenance; and, where air taxiing operations are contemplated, the TLOF.	Нисдэг тэргийг байрлуулах болон агаараар явгалах боломжийг хангасан, нисдэг тэрэг газардах болон хөөрөх агаарын хөлгийн зогсоол (AN 4; AN 14/II)
Helicopter taxi-route	Нисдэг тэрэг явгалах чиглэлийн зам	A defined path established for the movement of helicopters from one part of a heliport to another. a) <i>Air taxi-route</i> . A marked taxi-route intended for air taxiing. b) <i>Ground taxi-route</i> . A taxi-route centred on a taxiway.	Хэлипортын нэг хэсгээс нөгөө хэсэгт нисдэг тэрэгний шилжих хөдөлгөөнд зориулан тогтоосон зам. (a) <i>Агаараар явгалах зам</i> . Агаараар явгалахад зориулан тэмдэглэсэн агаараар явгалах чиглэлийн зам. (b) <i>Газраар явгалах зам</i> . Явгалах замыг голлосон явгалах чиглэлийн зам. (AN 14/II)
Helicopter taxiway	Нисдэг тэрэг явгалах зам	A defined path on a heliport intended for the ground movement of helicopters and that may be combined with an air taxi-route to permit both ground and air taxiing.	Нисдэг тэрэгний газрын хөдөлгөөнд зориулан хэлипорт дээр тогтоосон зам. Энэ зам нь газраар болон агаараар явгалах аль аль боломжийг хангасан агаараар явгалах замтай хамт байж болно. (AN 14/II)
Helideck	Нисдэг тэрэгний тавцан	A heliport located on a fixed or floating offshore facility such as an exploration and/or production unit used for the exploitation of oil or gas.	Газрын тос, эсхүл байгалийн хийн олборлолтод ашигладаг хайгуул ба/эсхүл үйлдвэрлэлийн нэгж зэрэг суурин, эсхүл далайд хөвдөг байгууламж дээр байрлуулсан хэлипорт (AN 6/III; AN 14/II)
Heliport	Хэлипорт	An aerodrome or a defined area on a structure intended to be used wholly or in part for the arrival, departure and surface movement of helicopters.	Бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн нисдэг тэрэгний нисэн ирэх, нисэн гарах болон гадаргуугийн хөдөлгөөнд ашиглахад зориулсан аэродром, эсхүл байгууламж дээр тогтоосон талбай (AN 4; AN 6/III; AN 14/I; AN 14/II; AN 15)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Heliport elevation	Хэлипортын өндөрлөг	The elevation of the highest point of the FATO.	FATO-гийн хамгийн өндөр цэгийн өндөрлөг (AN 14/II)
Heliport operating minima	Хэлипортын үйл ажиллагааны минимума	The limits of usability of a heliport for: a) take-off, expressed in terms of runway visual range and/or visibility and, if necessary, cloud conditions; b) landing in 2D instrument approach operations, expressed in terms of visibility and/or runway visual range, minimum descent altitude/height (MDA/H) and, if necessary, cloud conditions; and c) landing in 3D instrument approach operations, expressed in terms of visibility and/or runway visual range and decision altitude/height (DA/H) as appropriate to the type and/or category of the operation.	Хэлипортын ашиглалт нь дараах хязгаарлалттай байж болно: a) хөөрөлтийн - ХБЗ-ын ил харааны зай ба/эсхүл хараа, хэрэв шаардлагатай бол үүлний нөхцөлөөр илэрхийлдэг; b) 2D хэрэглэлийн ойртолтоор үйлдэх буултын - хараа ба/эсхүл ХБЗ-ын ил харааны зай, өндөр алдах минимум өндрийн-түвшин/өндөр (MDA/H), хэрэв шаардлагатай бол үүлний нөхцөлөөр илэрхийлдэг; c) 3D хэрэглэлийн ойртолтоор үйлдэх буултын - хараа ба/эсхүл ХБЗ-ын ил харааны зай болон тухайн үйл ажиллагааны төрөл ба/эсхүл категорид хамааралтайгаар шийдвэр гаргах минимум өндрийн-түвшин/өндөрөөр (DA/H) илэрхийлдэг; (AN 4; AN 6/I; AN 6/II) (AN 6/III)
Heliport reference point (HRP)	Хэлипортын хяналтын цэг (HRP)	The designated location of a heliport.	Хэлипортын тогтоосон байрлал (AN 14/II)
Henry (H)	Генри (Гн)	The inductance of a closed circuit in which an electromotive force of 1 volt is produced when the electric current in the circuit varies uniformly at a rate of 1 ampere per second.	Нэг секундэд нэг ампер хурдтай контурт гүйдлийн хүчний жигд өөрчлөлтөд нэг вольтод цахилгаан хөдлөх хүч үүсгэдэг битүү контурын индукц (AN 5)
Hertz (Hz)	Герц (Гц)	The frequency of a periodic phenomenon of which the period is 1 second.	Үргэлжлэх хугацаа нь 1 секунд байх үелсэн үзэгдлийн давтамж (AN 5)
High-risk cargo or mail	Өндөр эрсдэлтэй ачаа, эсхүл шуудан	Cargo or mail which is deemed to pose a threat to civil aviation as a result of specific intelligence; or shows anomalies or signs of tampering which give rise to suspicion.	Тусгай тагнан шалгах ажиллагааны үр дүнд иргэний нисэхэд аюул учруулна гэж үзсэн; эсхүл сэжиг төрүүлэхүйц хэвийн бус байдалтай, эсхүл гэмтэл учруулсан шинж тэмдэгтэй ачаа, эсхүл шуудан (AN 17)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Holding bay	Хүлээх талбай	A defined area where aircraft can be held, or bypassed, to facilitate efficient surface movement of aircraft.	Агаарын хөлгийн гадаргуугийн хөдөлгөөнийг үр дүнтэй зохицуулах зорилгоор агаарын хөлөг түр зогсдог, эсхүл гүйцэж түрүүлдэг тогтоосон талбай (AN 14/I)
Holding procedure	Хүлээх нислэгийн журам	A predetermined manoeuvre which keeps an aircraft within a specified airspace while awaiting further clearance.	Дараагийн зөвшөөрлөө хүлээж байгаа агаарын хөлөг тодорхой заасан агаарын зайд үлдэх боломжийг олгодог урьдчилан тогтоосон маневр (AN 4; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Holdover time	Хамгаалалтын үйлчлэх хугацаа	The estimated time the anti-icing fluid (treatment) will prevent the formation of ice and frost and the accumulation of snow on the protected (treated) surfaces of an aeroplane.	Мөстөлт эсэргүүцэх шингэн цацуулсан нисэх онгоцны гадаргуу дээр мөс, цан үүсэх ба цас тогтохоос хамгаалах тооцоот хугацаа (AN 14/I)
Homing	Чиглэх	The procedure of using the direction-finding equipment of one radio station with the emission of another radio station, where at least one of the stations is mobile, and whereby the mobile station proceeds continuously towards the other station.	Нэг станц нь хөдөлгөөнт станц байх ба хөдөлгөөнт станц нь нөгөө станцыг тасралтгүй чиглэн нисэхдээ тухайн радио станцын цацсан дохиогоор чиглэл-ологч төхөөрөмжөө ашиглах журам (AN 10/II)
Hostile environment	Аюултай орчин	An environment in which: a) a safe forced landing cannot be accomplished because the surface and surrounding environment are inadequate; or b) the helicopter occupants cannot be adequately protected from the elements; or c) SAR response/capability is not provided consistent with anticipated exposure; or d) there is an unacceptable risk of endangering persons or property on the ground.	Дараах аль нэг нөхцөл бүрдсэн орчин: a) газрын гадаргуу болон хүрээлэн буй орчны байдлаас шалтгаалан аюулгүй аргагүйдсэн буулт үйлдэх боломжгүй; b) нисдэг тэргэнд байгаа хүмүүсийг тодорхой хүчин зүйлээс зохих ёсоор хамгаалах боломжгүй; c) учирч болзошгүй аюултай дүйцэх ЭХАТ арга хэмжээ авах нөхцөл хангагдаагүй; d) газарт байгаа хүн, эсхүл эд хөрөнгөд аюул учруулах эрсдэл ихтэй. (AN 6/III)
Hot spot	Сэрэмжлэх цэг	A location on an aerodrome movement area with a history or potential risk of collision or runway incursion, and where heightened attention by pilots/drivers is necessary.	ХБЗ-ыг хөндлөн нэвтрэх, эсхүл мөргөлдөх тохиолдол гарч байсан түүхтэй, эсхүл гарах бодит эрсдэлтэй ба нисгэгч / жолооч нарын өндөржүүлсэн анхаарал шаардлагатай аэродромын хөдөлгөөний талбай дахь байрлал (AN 4; AN 14)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Human Factors principles	Хүний хүчин зүйлийн зарчим	Principles which apply to aeronautical design, certification, training, operations and maintenance and which seek safe interface between the human and other system components by proper consideration to human performance.	Хүний чадавхыг зөв тодорхойлсноор хүн болон бусад системийн бүрдэл хэсгийн хоорондын аюулгүй харилцааг бий болгодог, нисэхийн бүтээгдэхүүний зохион бүтээлт, гэрчилгээжүүлэлт, сургалт, үйл ажиллагаа болон техник үйлчилгээнд тавьдаг зарчим (AN 3; AN 4; AN 6/I; AN 6/III; AN 8; AN 11; AN 14/I; AN 15; AN 17; PANS-ATM)
Human performance	Хүний чадавх	(A) Human capabilities and limitations which have an impact on the safety, security and efficiency of aeronautical operations. (B) Human capabilities and limitations which have an impact on the safety, security and efficiency of aeronautical operations.	(A) Нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдал болон үр дүнд нөлөөлдөг хүний чадвар болон хязгаарлалт (AN 1; AN 5; AN 6/I; AN 6/III; AN 8; AN 10/I; AN 11; AN 14/I; AN 16/I) (B) Нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт болон үр дүнд нөлөөлдөг хүний чадвар болон хязгаарлалт (AN 17)
Hypsometric tints	Өндрийн өнгөний шатлал	A succession of shades or colour gradations used to depict ranges of elevation.	Өндөрлөгийн хүрээг дүрслэхэд ашигладаг үндсэн болон туслах өнгө аажим хувирах шатлал (AN 4)
ICAO competency framework	ICAO-гийн ур чадварын тодорхойлолт	A competency framework, developed by ICAO, is a selected group of competencies for a given aviation discipline. Each competency has an associated description and observable behaviours.	ICAO-гийн боловсруулсан ур чадварын тодорхойлолт гэж нисэхийн тодорхой ажил мэргэжилд зориулан сонгосон ур чадварын бүлэг. Ур чадвар бүр нь тохирох тодорхойлолт болон таньж тогтоогохуйц зан төлөвийн шаардлагатай байна. (AN 1)
ICAO meteorological information exchange model (IWXXM)	ICAO цаг уурын мэдээлэл солилцох загвар (IWXXM)	A data model for representing aeronautical meteorological information.	Нисэхийн цаг уурын мэдээг тайлбарласан өгөгдлийн загвар (AN 3)
ICAO Public Key Directory (ICAO PKD)	ICAO олон нийтийн үндсэн лавлах (ICAO PKD)	The central database serving as the repository of Document Signer Certificates (CDS) (containing Document Signer Public Keys), CSCA Master List (MLCSCA), Country Signing CA Link Certificates (ICCSA) and Certificate Revocation Lists issued by Participants, together with a system for their distribution worldwide, maintained by ICAO on behalf of Participants in order to facilitate the validation of data in eMRTDs.	eMRTD-ийн өгөгдлийн баталгаажуулалтыг хийх зорилгоор оролцогчийн өмнөөс ICAO-гоос хангадаг, Баримт бичигт гарын үсэг зурагчийн гэрчилгээний сан (CDS), CSCA ерөнхий жагсаалт (ML _{CSCA}), IC _{CSCA} болон Оролцогчийн олгосон гэрчилгээг хүчингүй болгох жагсаалт, тэдгээрийг дэлхий даяар түгээх системийн хамт үйлчилдэг төв өгөгдлийн сан (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Identification beacon	Ялгах гэрэлт дохио	An aeronautical beacon emitting a coded signal by means of which a particular point of reference can be identified.	Кодолсон гэрлэн дохиог цацах хэлбэрээр тодорхой хяналтын цэгийг таньж тогтооход тусалдаг нисэхийн гэрэлт дохио (AN 14/I)
IFR flight	IFR нислэг	A flight conducted i.a.w the instrument flight rules.	Хэрэглэлийн нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэг (AN 2; AN 11; PANS-ATM)
ILS continuity of service	ILS үйлчилгээний найдвартай байдал	That quality which relates to the rarity of radiated signal interruptions. The level of continuity of service of the localizer or the glide path is expressed in terms of the probability of not losing the radiated guidance signals.	Цацаж байгаа дохионы тасалдлын магадлалтай холбоотой чанар. Локалайзер, эсхүл глиссадын үйлчилгээний найдвартай түвшнийг цацаж байгаа чиглүүлэх дохиог алдахгүй байх магадлалын нөхцөлөөр илэрхийлдэг. (AN 10/I)
ILS glide path	ILS глиссад	That locus of points in the vertical plane containing the runway centre line at which the DDM is zero, which, of all such loci, is the closest to the horizontal plane.	Бүх геометрийн цэгийн хэвтээ хавтгайд хамгийн ойр, DMM нь тэг байдаг ХБЗ-ын гол шугамыг багтаасан босоо хавтгайн геометрийн цэг (AN 10/I)
ILS glide path angle	ILS глиссадын өнцөг	The angle between a straight line which represents the mean of the ILS glide path and the horizontal.	ILS глиссадын дундаж утгыг илэрхийлдэг шулуун шугам болон хэвтээ тэнхлэгийн хоорондох өнцөг (AN 10/I)
ILS glide path sector	ILS глиссадын сектор	The sector in the vertical plane containing the ILS glide path and limited by the loci of points nearest to the glide path at which the DDM is 0.175. <i>Note.- The ILS glide path sector is located in the vertical plane containing the runway centre line, and is divided by the radiated glide path in two parts called upper sector and lower sector, referring respectively to the sectors above and below the glide path.</i>	ILS глиссадыг багтаасан ба DMM нь 0.175 байдаг глиссатад хамгийн ойрын геометрийн цэгүүдээр хязгаарлагдсан босоо хавтгайн сектор <i>Тэмдэглэл: ILS глиссадын сектор нь ХБЗ-ын гол шугамыг багтаасан босоо хавтгайд байрлах ба глиссадын дээд болон доод секторыг тодорхойлсон, цацаж байгаа глиссадын дээд сектор болон доод сектор гэж дууддаг хоёр хэсэгт хуваагддаг. (AN 10/I)</i>
ILS integrity	ILS бүрэн байдал	That quality which relates to the trust which can be placed in the correctness of the information supplied by the facility. The level of integrity of the localizer or the glide path is expressed in terms of the probability of not radiating false guidance signals.	Тухайн төхөөрөмжийн хангаж байгаа мэдээллийн үнэн зөв байдалд итгэлтэй байхтай холбоотой чанар. Локалайзер, эсхүл глиссадын бүрэн байдлын түвшнийг буруу чиглүүлэх дохиог цацахгүй байх магадлалаар тодорхойлдог. (AN 10/I)
ILS Point "A"	ILS "A" цэг	A point on the ILS glide path measured along the extended runway centre line in the approach	Босгоноос 7.5 км-ийн (4 NM) зайд ойртолтын чиглэлд ХБЗ-ын үргэлжилсэн гол шугамын дагуу хэмжсэн ILS глиссад дээрх цэг (AN 10/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		direction a distance of 7.5 km (4 NM) from the threshold.	
ILS Point "B"	ILS "B" цэг	A point on the ILS glide path measured along the extended runway centre line in the approach direction a distance of 1 050 m (3 500 ft) from the threshold.	Босгоноос 1050 м-ийн (3500 ft) зайд ойртолтын чиглэлд ХБЗ-ын үргэлжилсэн гол шугамын дагуу хэмжсэн ILS глиссад дээрх цэг (AN 10/I)
ILS Point "C"	ILS "C" цэг	A point through which the downward extended straight portion of the nominal ILS glide path passes at a height of 30 m (100 ft) above the horizontal plane containing the threshold.	Босгыг багтаасан хэвтээ хавтгайн дээгүүр 30 м-ийн (100 ft) өндөрт нэвтрэх хэвийн ILS глиссадын доош үргэлжилсэн шулуун хэсэг огтлон гарсан цэг (AN 10/I)
ILS Point "D"	ILS "D" цэг	A point 4 m (12 ft) above the runway centre line and 900 m (3 000 ft) from the threshold in the direction of the localizer.	ХБЗ-ын гол шугамаас дээш 4 м-т (12 ft) болон локалайзерын чиглэлд босгоноос 900 м-т (3000 ft) байгаа цэг (AN 10/I)
ILS Point "E"	ILS "E" цэг	A point 4 m (12 ft) above the runway centre line and 600 m (2 000 ft) from the stop end of the runway in the direction of the threshold. <i>Note.- See Attachment C, Figure C-1.</i>	ХБЗ-ын гол шугамаас дээш 4 м-т (12 ft) болон локалайзерын чиглэлд босгоноос 600 м-т (2000 ft) байгаа цэг <i>Тэмдэглэл: "Annex 10 Vol. I, Attachment C, Figure C-1"-ийг хар. (AN 10/I)</i>
ILS reference datum (Point "T")	ILS хяналтын цэг ("T" цэг)	A point at a specified height located above the intersection of the runway centre line and the threshold and through which the downward extended straight portion of the ILS glide path passes.	ХБЗ-ын гол шугам болон босгын уулзвараас дээш тогтоосон өндөрт байрласан ба ILS глиссадын доош үргэлжилсэн шулуун хэсгийг огтолдог цэг (AN 10/I)
Immigration control	Хилийн хяналт	Measures adopted by States to control the entry into, transit through and departure from their territories of persons travelling by air.	Агаараар зорчиж байгаа этгээд тухайн Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, дамжин өнгөрөх болон нисэн гарахад хяналт тавих зорилгоор тухайн Улсын тогтоосон арга хэмжээ (AN 9)
Import duties and taxes	Импортын барааны татвар, хураамж	Customs duties and all other duties, taxes or charges, which are collected on or in connection with the importation of goods. Not included are any charges which are limited in amount to the approximate cost of services rendered or collected by the customs on behalf of another national authority.	Барааг импортлох, үүнтэй холбоотой ногдуулах гаалийн татвар болон бусад татвар, хураамж, төлбөрийн нийлбэр. Бусад үндэсний эрх бүхий байгууллагын өмнөөс гаалийн байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээний нийт хураамж болон түүнтэй холбоотой бусад төлбөр, хураамжийн дүн үүнд хамаарахгүй. (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Imposter	Бусдын баримт бичиг ашиглагч	A person who impersonates the rightful holder of a genuine travel document.	Жинхэнэ аяллын баримт бичгийн хууль ёсны эзэмшигч гэж хуурамчаар мэдүүлсэн этгээд (AN 9)
Improperly documented person	Баримт бичгийн зөрчилтэй этгээд	A person who travels, or attempts to travel: (a) with an expired travel document or an invalid visa; (b) with a counterfeit, forged or altered travel document or visa; (c) with someone else's travel document or visa; (d) without a travel document; or (e) without a visa, if required.	Аялж байгаа, эсхүл аялахыг завдсан дараах этгээд: (a) хугацаа нь дууссан аяллын баримт бичигтэй, эсхүл хүчингүй визтэй; (b) хуурамч, дуураймал, засвартай баримт бичиг, эсхүл визтэй; (c) бусдын баримт бичиг, эсхүл визтэй, эсхүл; (d) аяллын баримт бичиггүй, эсхүл; (e) шаардлагатай визгүй. (AN 9)
Inadmissible person	Орох зөвшөөрөлгүй этгээд	A person who is or will be refused admission to a State by its authorities.	Тухайн Улсад нэвтрэхийг түүний эрх бүхий байгууллага зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрөл олгохгүй этгээд (AN 9)
INCERFA	INCERFA	The code word used to designate an uncertainty phase.	Тодорхой бус үеийг илэрхийлэхэд зориулан ашигладаг түлхүүр үг (AN 11)
Incident	Зөрчил	An occurrence, other than an accident, associated with the operation of an aircraft which affects or could affect the safety of operation. <i>Note.- The types of incidents which are of main interest to the International Civil Aviation Organization for accident prevention studies are listed in Annex 13, Attachment C.</i>	Агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад хэрэг явдал <u>Тэмдэглэл:</u> Ослоос урьдчилан сэргийлэх судалгааны ИКАО-гийн үндсэн зорилго болох зөрчлийн төрлүүд нь "Annex 13, Attachment C"-д өгөгдсөн. (AN 11; AN 13; AN 19; PANS-ATM)
Independent parallel approaches	Үл хамаарах зэрэгцээ ХБЗ-нд ойртолт үлдэх	Simultaneous approaches to parallel or near-parallel instrument runways where radar separation minima between aircraft on adjacent extended runway centre lines are not prescribed.	Зэрэгцээ ХБЗ-ын гол шугамын дагуу агаарын хөлөг хооронд радарын зайчлалын минимал-гогтоогоогүй зэрэгцээ, эсхүл бараг зэрэгцээ хэрэглэлийн ХБЗ-нд нэгэн зэрэг үйлдэх ойртолт (AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Independent parallel departures	Үл хамаарах зэрэгцээ ХБЗ-аас нисэн гарах	Simultaneous departures from parallel or near-parallel instrument runways.	Зэрэгцээ, эсхүл бараг зэрэгцээ хэрэглэлийн ХБЗ-аас нэгэн зэрэг үйлдэх хөөрөлт (AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Industry codes of practice	Салбарын практик аргачлалын код	Guidance material developed by an industry body, for a particular sector of the aviation industry to comply with the requirements of the International Civil Aviation Organization's Standards and Recommended Practices, other aviation safety requirements and the best practices deemed appropriate. <i>Note.- Some States accept and reference industry codes of practice in the development of regulations to meet the requirements of Annex 19, and make available, for the industry codes of practice, their sources and how they may be obtained.</i>	ICAO-гийн стандарт, зөвлөмж болон шаардлагатай гэж үзсэн нисэхийн аюулгүй байдлын бусад шаардлагыг дагаж мөрдөх зорилгоор агаарын тээврийн тодорхой нэг салбараас боловсруулсан зааварчилгаа <i>Тэмдэглэл: Зарим Улсууд Аннекс 19-ийн шаардлагыг хангах зорилгоор дүрмээ боловсруулахдаа салбарын практик аргачлалын кодыг хүлээн зөвшөөрч, түүнийг иш татдаг бөгөөд салбарын практик аргачлалын код, тэдгээрийн эх сурвалж болон хэрхэн олж авах аргыг нээлттэй болгодог. (AN 6/II; AN 19)</i>
In-flight security officer / Air-marshal	Эйр-маршал	A person who is authorized by the government of the State of the Operator and the government of the State of Registration to be deployed on an aircraft with the purpose of protecting that aircraft and its occupants against acts of unlawful interference. This excludes persons employed to provide exclusive personal protection for one or more specific people travelling on the aircraft, such as personal bodyguards.	Тухайн үйл ажиллагаа эрхлэгчийг харьяалах Улсын засгийн газар болон Бүртгэгч Улсын засгийн газраас агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийг хууль бус нөлөөллийн үйлдлээс хамгаалах зорилгоор агаарын хөлөгт үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөл олгосон этгээд. Тухайн агаарын хөлөгт аялж байгаа нэг, эсхүл хэд хэдэн тусгай хүмүүсийг хувийн тусгай хамгаалалтаар хангахаар томилогдсон хувийн бие хамгаалагч зэрэг этгээд үүнд хамаарахгүй. (AN 17)
Initial approach segment	Ойртолтын эхлэлийн сегмент	That segment of an instrument approach procedure between the initial approach fix and the intermediate approach fix or, where applicable, the final approach fix or point.	Ойртолтын эхлэлийн цэг (IAF) болон ойртолтын дундын цэг (IF) хоорондох, эсхүл хамааралтай тохиолдолд ойртолтын эхлэлийн цэг (IAF) болон ойртолтын төгсгөлийн сегментийн цэг (FAF) хоорондох, хэрэглэлийн ойртолтын журмын сегмент (AN 4; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Instrument approach operations	Хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаа	An approach and landing using instruments for navigation guidance based on an instrument approach procedure. There are two methods for executing instrument approach operations: a) a two-dimensional (2D) instrument approach operation, using lateral navigation guidance only; and	Хэрэглэлийн ойртолтын журамд суурилсан нислэгийн чиглүүлэгч хэрэглэл ашиглан үйлддэг ойртолт болон буулт. Дараах хоёр аргаар хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>b) a three-dimensional (3D) instrument approach operation, using both lateral and vertical navigation guidance.</p> <p><i>Note.- Lateral and vertical navigation guidance refers to the guidance provided either by:</i></p> <p>a) a ground-based radio navigation aid; or</p> <p>b) computer-generated navigation data from ground-based, space-based, self-contained navigation aids or a combination of these.</p>	<p>а) зөвхөн хэвтээ тэнхлэгийн нислэгийн чиглүүлэгч ашигладаг хоёр хэмжээст (2D) хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаа;</p> <p>б) босоо болон хэвтээ 2 тэнхлэгийн нислэгийн чиглүүлэгч ашигладаг гурван хэмжээст (3D) хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаа</p> <p><u>Тэмдэглэл:</u> Хэвтээ болон босоо нислэгийн чиглүүлэгч гэж дараах төхөөрөмжөөс өгсөн чиглүүлэгчийг ойлгоно:</p> <p>а) газарт суурилсан радио навигаацийн туслах төхөөрөмж; эсхүл</p> <p>б) газарт суурилсан, сансарт суурилсан, өөртөө агуулсан навигаацийн туслах хэрэгсэл, эсхүл эдгээрийн комбинацаас компьютероор гаргаж авдаг навигаацийн өгөгдөл. (AN 2)</p>
Instrument approach procedure	Хэрэглэлийн ойртолтын журам	<p>A series of predetermined manoeuvres by reference to flight instruments with specified protection from obstacles from the initial approach fix, or where applicable, from the beginning of a defined arrival route to a point from which a landing can be completed and thereafter, if a landing is not completed, to a position at which holding or en-route obstacle clearance criteria apply.</p> <p>Instrument approach procedures are classified as follows:</p> <p><i>Non-precision approach (NPA) procedure.</i> An instrument approach procedure designed for 2D instrument approach operations Type A.</p> <p><i>Note.- Non-precision approach procedures may be flown using a continuous descent final approach (CDFA) technique. CDFA with advisory VNAV guidance calculated by on-board equipment are considered 3D instrument approach operations. CDFA with manual calculation of the required rate of descent are considered 2D instrument approach operations. For more information on CDFA, refer to PANS-OPS (Doc 8168) Volume I, Part II, Section 5.</i></p>	<p>Саадаас, ойртолтын эхлэлийн цэгээс (IAF), эсхүл хамааралтай бол, тогтоосон нисэн ирэх замын эхлэлээс буулт үйлдэж чадах цэг хүртэл болон түүний дараа, хэрэв буулт үйлдэж чадаагүй бол хүлээх, эсхүл нислэгийн замын дагуу саадыг давах зайн шалгуурыг хангах байршил хүртэл тогтоосон хамгаалалттай нислэгийн хэрэглэлээр баримжаалан гүйцэтгэх урьдчилан тогтоосон бүлэг маневр.</p> <p>Хэрэглэлийн ойртолтын журмыг дараах байдлаар ангилдаг:</p> <p><i>Нарийвчлалтай бус ойртолтын (NPA) журам:</i> хэвтээ чиглүүлэгчийг ашигладаг, гэхдээ босоо чиглүүлэгчийг ашигладаггүй хэрэглэлийн ойртолтын журам;</p> <p><u>Тэмдэглэл:</u> Үргэлжлэн өндөр алдах ойртолтын төгсгөлийн (CDFA) арга техникийг ашиглан нарийвчлалтай бус ойртолт үйлдэх журмаар нислэг үйлдэж болно. Бүхээгийн төхөөрөмжөөр тооцоолсон анхааруулах VNAV чиглүүлэгчтэй CDFA-г 3D хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаа гэж тооцно. Шаардлагатай өндөр алдах хурдыг гар</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p><i>Approach procedure with vertical guidance (APV).</i> A performance-based navigation (PBN) instrument approach procedure designed for 3D instrument approach operations Type A.</p> <p><i>Precision approach (PA) procedure.</i> An instrument approach procedure based on navigation systems (ILS, MLS, GLS and SBAS Cat I) designed for 3D instrument approach operations Type A or B.</p> <p><i>Note.- Refer to Annex 6 for instrument approach operation types.</i></p>	<p>аргаар тооцолсон CDFa-г 2D хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагаа гэж тооцно.</p> <p><i>Босоо чиглүүлэгчтэй ойртолтын журам (APV):</i> Хэвтээ болон босоо чиглүүлэгчийг ашигладаг, гэхдээ нарийвчлалтай ойртолт болон буултын үйл ажиллагааны тогтоосон шаардлагыг хангадаггүй хэрэглэлийн журам;</p> <p><i>Нарийвчлалтай ойртолтын (PA) журам:</i> Үйл ажиллагааны категориор нь тогтоосон миниматай, нарийвчлалтай хэвтээ болон босоо чиглүүлэгчийг ашигладаг хэрэглэлийн ойртолтын журам.</p> <p><i>Тэмдэглэл:</i> Хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагааны төрөл Аннекс 6-д байгаа. (AN 2; AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; PANS-OPS/I; PANS-OPS/II)</p>
Instrument flight procedure design service	Хэрэглэлийн нислэгийн журам зохиох үйлчилгээ	A service established for the design, documentation, validation, maintenance and periodic review of instrument flight procedures necessary for the safety, regularity and efficiency of air navigation.	Нислэгийн үйл ажиллагааг аюулгүй, тогтмол, үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай хэрэглэлийн нислэгийн журмыг зохиох, баримтжуулах, баталгаажуулах, засвар өөрчлөлт болон хуваарьт үнэлгээ хийхэд зориулан үзүүлдэг үйлчилгээ (AN 11)
Instrument flight time	Хэрэглэлийн нислэгийн цаг	Time during which a pilot is piloting an aircraft, or a remote pilot is piloting a remotely piloted aircraft, solely by reference to instruments and without external reference points.	Гадны хяналтын цэгийг ашиглалгүй, зөвхөн хэрэглэл ашиглан нисгэгч агаарын хөлгөөр, эсхүл зайнаас-удирдах-нисгэгч зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйлдсэн нислэгийн хугацаа (AN 1)
Instrument ground time	Хэрэглэлийн газрын дадлагын цаг	Time during which a pilot is practising, on the ground, simulated instrument flight in a flight simulation training device approved by the Licensing Authority.	Гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн дуураймал нислэгийн сургалтын төхөөрөмжөөр нисгэгч газарт дуураймал хэрэглэлийн нислэгийн дадлага хийх цаг (AN 1)
Instrument meteorological conditions (IMC)	Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл (IMC)	<p>Meteorological conditions expressed in terms of visibility, distance from cloud, and ceiling, less than the minima specified for VMC.</p> <p><i>Note.- The specified minima for VMC are contained in Annex 2, Chapter 4.</i></p>	<p>VMC-д заасан минимумагаас бага, хараагаар, үүлнээс барих зайгаар болон үүлний суурийн өндрөөр илэрхийлдэг цаг уурын нөхцөл</p> <p><i>Тэмдэглэл:</i> VMC-ийн заасан минимума нь Annex 2, Chapter 4-т багтсан. (AN 2; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 11; PANS-ATM)</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Instrument runway	Хэрэглэлийн ХБЗ	<p>One of the following types of runways intended for the operation of aircraft using instrument approach procedures:</p> <p>a) <i>Non-precision approach runway.</i> A runway served by visual aids and non-visual aid(s) intended for landing operations following an instrument approach operation type A and a visibility not less than 1 000 m.</p> <p>b) <i>Precision approach runway, category I.</i> A runway served by visual aids and non-visual aid(s) intended for landing operations following an instrument approach operation type B with a decision height (DH) not lower than 60 m (200 ft) and either a visibility not less than 800 m or a runway visual range not less than 550 m.</p> <p>c) <i>Precision approach runway, category II.</i> A runway served by visual aids and non-visual aid(s) intended for landing operations following an instrument approach operation type B with a decision height (DH) lower than 60 m (200 ft) but not lower than 30 m (100 ft) and a runway visual range not less than 300 m.</p> <p>d) <i>Precision approach runway, category III.</i> A runway served by visual aids and non-visual aid(s) intended for landing operations following an instrument approach operation type B with a decision height (DH) lower than 30 m (100 ft), or no decision height and a runway visual range less than 300 m, or no runway visual range limitations.</p> <p><i>Note 1.- Visual aids need not necessarily be matched to the scale of non-visual aids provided. The criterion for the selection of visual aids is the conditions in which operations are intended to be conducted.</i></p> <p><i>Note 2.- Refer to “Annex 6 - Operation of Aircraft” for instrument approach operation types.</i></p>	<p>Хэрэглэлийн ойртолтын журмыг ашиглаж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулсан дараах аль нэг төрлийн ХБЗ:</p> <p>a) <i>Нарийвчлалтай бус ойртолтын ХБЗ:</i> хараа 1000 м-ээс багагүй байхад хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагааны төрөл-А-гийн дараа буулт үйлдэхэд зориулсан, ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоноглогсон ХБЗ;</p> <p>b) <i>CAT I Нарийвчлалтай ойртолтын ХБЗ:</i> хараа 800 м-ээс багагүй, эсхүл ХБЗ-ын ил харааны зай 550 м-ээс багагүй ба шийдвэр гаргах өндөр (DH) нь 60 м-ээс (200 ft) багагүй байхад <i>хэрэглэлийн</i> ойртолтын үйл ажиллагааны төрөл-В-гийн дараа буулт үйлдэхэд зориулсан, ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоноглогсон ХБЗ;</p> <p>c) <i>CAT II Нарийвчлалтай ойртолтын ХБЗ:</i> ХБЗ-ын ил харааны зай 300 м-ээс багагүй ба шийдвэр гаргах өндөр (DH) нь 60 м-ээс (200 ft) бага, гэхдээ 30 м-ээс (100 ft) багагүй байхад хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагааны төрөл-В-гийн дараа буулт үйлдэхэд зориулсан, ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоноглогсон ХБЗ;</p> <p>d) <i>CAT III нарийвчлалтай ойртолтын ХБЗ:</i> шийдвэр гаргах өндөр (DH) нь 30 м-ээс (100 ft) доош, эсхүл шийдвэр гаргах өндөр (DH) заагаагүй ба ХБЗ-ны ил харааны зай 300 м-ээс багагүй байх, эсхүл ХБЗ-ны ил харааны зайн хязгаарлалт <i>заагаагүй</i> байхад хэрэглэлээр ойртолт үйлдэх үйл ажиллагааны төрөл-В-гийн дараа буултын үйл ажиллагаанд зориулан ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр тоноглогсон ХБЗ:</p> <p><i>Тэмдэглэл 1: Ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ нь ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээний</i></p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			<p>түвшинд байх шаардлагагүй. Ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний сонголтын шалгуур нь тухайн гүйцэтгэх үйл ажиллагааны нөхцөлөөс шалтгаална.</p> <p><u>Тэмдэглэл 2:</u> Хэрэглэлийн ойртолтын үйл ажиллагааны төрлийг "Аппех 6 - Operation of Aircraft"-д заасан. (AN 14/I)</p>
Instrument time	Хэрэглэлийн цаг	Instrument flight time or instrument ground time.	Хэрэглэлийн нислэгийн цаг, эсхүл хэрэглэлийн газрын дадлагын цаг (AN 1)
Integrated survival suit	Аврах хувцас	A survival suit which meets the combined requirements of the survival suit and life jacket.	Аврах хувцас болон аврах хантааз нэгдсэн шаардлагыг хангасан аврах хувцас (AN 6/III)
Integrity classification (aeronautical data)	Бүрэн байдлын ангилал (нисэхийн өгөгдөл)	<p>Classification based upon the potential risk resulting from the use of corrupted data. Aeronautical data is classified as:</p> <p>a) routine data: there is a very low probability when using corrupted routine data that the continued safe flight and landing of an aircraft would be severely at risk with the potential for catastrophe;</p> <p>b) essential data: there is a low probability when using corrupted essential data that the continued safe flight and landing of an aircraft would be severely at risk with the potential for catastrophe; and</p> <p>c) critical data: there is a high probability when using corrupted critical data that the continued safe flight and landing of an aircraft would be severely at risk with the potential for catastrophe.</p>	<p>Ангилал нь алдаатай өгөгдөл ашигласнаас үүсэх бодит эрсдэлд суурилдаг. Нисэхийн өгөгдөл нь дараах ангилалтай:</p> <p>a) <i>энгийн өгөгдөл:</i> алдаатай энгийн өгөгдлийг ашигласан тохиолдолд агаарын хөлөг нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх болон буулт үйлдэхэд аюултай ослын бодит эрсдэлийн магадлал маш бага;</p> <p>b) <i>зайлшгүй шаардлагатай өгөгдөл:</i> алдаатай зайлшгүй шаардлагатай өгөгдлийг ашигласан тохиолдолд агаарын хөлөг нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх болон буулт үйлдэхэд аюултай ослын бодит эрсдэлийн магадлал бага;</p> <p>c) <i>эрсдэлтэй өгөгдөл:</i> алдаатай эрсдэлтэй өгөгдлийг ашигласан тохиолдолд агаарын хөлөг нислэгийг аюулгүй үргэлжлүүлэх болон буулт үйлдэхэд аюултай ослын бодит эрсдэлийн магадлал их. (AN 4; AN 11; AN 14/I; AN 15)</p>
Interactive API (iAPI) system	Интерактив зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем (iAPI)	An electronic system that transmits, during check-in, API data elements collected by the aircraft operator to public authorities who, within existing business processing times for passenger check-in, return to the operator a response message for each passenger and/or crew member.	Бүртгэлийн үед агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн цуглуулсан, зорчигчийн урьдчилсан мэдээллийн (API) өгөгдлийн элементийг, зорчигч бүртгэлийн хэвийн бизнес үйл ажиллагааны хугацаанд зорчигч ба/эсхүл багийн гишүүн бүрийн хариу мэдээллийг үйл ажиллагаа эрхлэгчид

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			буцааж өгдөг төрийн эрх бүхий байгууллагад дамжуулдаг цахим систем (AN 9)
Intermediate approach segment	Ойртолтын дундын сегмент	That segment of an instrument approach procedure between either the intermediate approach fix and the final approach fix or point, or between the end of a reversal, racetrack or dead reckoning track procedure and the final approach fix or point, as appropriate.	Ойртолтын дундын цэг (IF) болон ойртолтын төгсгөлийн сегментийн цэг (FAF) хооронд, эсхүл буцааж хэрэглэх, тойрог нислэгийн замын (racetrack), эсхүл байгаа өгөгдлөөр тооцоолсон (dead reckoning) замын журмын төгсгөл болон ойртолтын төгсгөлийн сегментийн цэг (FAF) хооронд хэрэглэлийн ойртолтын журмын сегмент (AN 4; PANS-OPS/I; PANS-OPS/II; PANS-ATM)
Intermediate holding position	Завсрын хүлээх байршил	A designated position intended for traffic control at which taxiing aircraft and vehicles shall stop and hold until further cleared to proceed, when so instructed by the aerodrome control tower.	Аэродромын удирдлагын цамхгийн зааварчилгаагаар, явгалж байгаа агаарын хөлөг болон тээврийн хэрэгсэл тухайн байршилд зогсож, хөдөлгөөнөө үргэлжлүүлэх зөвшөөрөл өгөх хүртэл хүлээдэг, хөдөлгөөн удирдахад зориулан тогтоосон байршил (AN 4; AN 14/I)
International airport	Олон улсын нисэх буудал	Any airport designated by the Contracting State in whose territory it is situated as an airport of entry and departure for international air traffic, where the formalities incident to customs, immigration, public health, animal and plant quarantine and similar procedures are carried out.	Гааль, иргэн харьяат, эрүүл ахуй, амьтан, ургамлын хорио цээрийн хяналт болон бусад ижил төстэй асуудалтай холбоотой зөрчлийг албан ёсоор зохицуулдаг, Хэлэлцэн тохиролцогч Улсаас өөрийн газар нутаг дээр олон улсын нислэг хүлээн авах болон нислэгт гаргахаар томилогдсон нисэх буудал (AN 9; AN 15)
International airways volcano watch (IAVW)	Олон улсын агаарын замын галт уулын ажиглалт (IAVW)	International arrangements for monitoring and providing warnings to aircraft of volcanic ash in the atmosphere. <i>Note.- The IAVW is based on the cooperation of aviation and non-aviation operational units using information derived from observing sources and networks that are provided by States. The watch is coordinated by ICAO with the cooperation of other concerned international organizations.</i>	Атмосферт дэгдсэн галт уулын үнсний мониторинг хийж, агаарын хөлөгт анхааруулга өгдөг олон улсын зохицуулалт <i>Тэмдэглэл: Олон улсын агаарын замын галт уулнаас сэрэмжлүүлэх үйл ажиллагаа нь гишүүн Улсаас тодорхойлсон ажиглалтын эх сурвалж болон сүлжээнээс дамжуулж байгаа мэдээллийг ашигладаг нисэхийн болон нисэхийн бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурладаг. Энэ хяналт нь ICAO болон бусад олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаагаар зохицуулагддаг. (AN 3)</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
International NOTAM office	Олон улсын NOTAM-ын төв	An office designated by a State for the exchange of NOTAM internationally.	Олон улсын хэмжээнд NOTAM солилцохоор тухайн Улсын томилсон нэгж (AN 11; AN 15)
International operating agency	Олон улсын үйл ажиллагааны байгууллага	An agency of the kind contemplated in Article 77 of the Convention.	Конвенцын Зүйл 77-д төрлийг нь тодорхойлсон байгууллага (AN 7)
International telecommunication service	Олон улсын цахилгаан холбооны үйлчилгээ	A telecommunication service between offices or stations of different States, or between mobile stations which are not in the same State, or are subject to different States.	Бусад улсын байгууллага, эсхүл станц хоорондын, эсхүл нэг улсад харьяалагдаагүй, эсхүл бусад улсын хөдөлгөөнт станц хоорондын цахилгаан холбооны үйлчилгээ (AN 10/II)
Interpilot air-to-air communication	Нисгэгч хоорондын "агаар-агаар" холбоо	Two-way communication on the designated air-to-air channel to enable aircraft engaged in flights over remote and oceanic areas out of range of VHF ground stations to exchange necessary operational information and to facilitate the resolution of operational problems.	VHF газрын станцын бүрхэлтгүй бөглүү болон далайн бүс дээгүүр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд шаардлагатай үйл ажиллагааны мэдээллээ солилцох болон хүндрэлтэй асуудлаа зохицуулахад ашигладаг, тогтоосон "агаар-агаар" суваг ашигладаг хоёр талын холбоо (AN 10/II)
Investigation	Шинжлэн шалгах	A process conducted for the purpose of accident prevention which includes the gathering and analysis of information, the drawing of conclusions, including the determination of causes and/or contributing factors and, when appropriate, the making of safety recommendations.	Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шалтгаан ба/эсхүл нөлөөлөх хүчин зүйлийн тодорхойлолт багтсан дүгнэлт бэлтгэх болон шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажлыг багтаасан ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлдэг үйл явц (AN 13)
Investigator-in-charge	Шинжлэн шалгах багийн ахлагч	A person charged, on the basis of his or her qualifications, with the responsibility for the organization, conduct and control of an investigation. <i>Note.- Nothing in the above definition is intended to preclude the functions of an investigator-in-charge being assigned to a commission or other body.</i>	Мэргэшил, дадлага туршлагыг нь үндэслэн, шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх ба удирдах үүрэгтэй томилогдсон этгээд <i>Тэмдэглэл: Дээрх тодорхойлолт нь шинжлэн шалгах багийн ахлагчид оноосон үүргийг комисс, эсхүл бусад этгээдэд шилжүүлнэ гэсэн утга агуулаагүй.</i> (AN 13)
Isogonal	Изогон	A line on a map or chart on which all points have the same magnetic variation for a specified epoch.	Тодорхой мөчлөгт ижил соронзон хазайлттай бүх цэгийг холбосон зураг, эсхүл газрын зураг дээрх шугам (AN 4)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Isogriv	Изогрив	A line on a map or chart which joins points of equal angular difference between the North of the navigation grid and Magnetic North.	Навигацийн торны Хойд болон Соронзон Хойд зүгийн хоорондох өнцгийн зөрүү нь ижил байх бүх цэгийг холбосон зураг, эсхүл газрын зураг дээрх шугам (AN 4)
Isolated aerodrome	Тусгаарлагдсан аэродром (Isolated)	A destination aerodrome for which there is no destination alternate aerodrome suitable for a given aeroplane type.	Тухайн нисэх онгоцны маягийн хувьд тохиромжтой бэлтгэл аэродромгүй нисэн очих аэродром (AN 6/I, 6/II)
Joint rescue coordination centre (JRCC)	Нэгдсэн авран туслах зохицуулалтын төв	A rescue coordination centre responsible for both aeronautical and maritime SAR operations.	Нисэхийн болон далайн ЭХАТ үйл ажиллагаа хариуцсан авран туслах зохицуулалтын төв (AN 12)
Joule	Жоуль (Ж)	The work done when the point of application of a force of 1 newton is displaced a distance of 1 metre in the direction of the force.	Биетэд 1 N хүчээр үйлчилж, 1 м зайд шилжүүлэхэд зарцуулдаг энерги (AN 5)
Kelvin	Кельвин	A unit of thermodynamic temperature which is the fraction 1/273.16 of the thermodynamic temperature of the triple point of water.	Усны гуравласан цэгийн термодинамик температурын 1/273.16-тай тэнцэх термодинамик температурын нэгж (AN 5)
Kilogram (kg)	Килограмм (кг)	The unit of mass equal to the mass of the international prototype of the kilogram.	Олон улсын жишиг (prototype) 1 кг масстай тэнцэх массын нэгж (AN 5)
Knot (kt)	Зангилаа (нот)	The speed equal to 1 nautical mile per hour.	1 цагт туулах далайн миль зай, хурдны нэгж (AN 5)
Known consignor	Бүртгэлтэй илгээгч	A consignor who originates cargo or mail for its own account and whose procedures meet common security rules and standards sufficient to allow the carriage of cargo or mail on any aircraft.	Өөрийн хариуцлагын доор, аливаа агаарын хөлгөөр ачаа, эсхүл шууданг тээвэрлэх зөвшөөрөл олгоход хангалттай, аюулгүйн хамгаалалтын нийтлэг дүрэм, стандартад нийцсэн журамтай, ачаа, эсхүл шуудан явуулдаг илгээгч (AN 17)
Lading	Ачих	The placing of cargo, mail, baggage or stores on board an aircraft to be carried on a flight.	Нислэгт тээвэрлэхээр агаарын хөлөгт ачаа, шуудан, тээш, эсхүл бүхээгийн нөөцийг байрлуулах (AN 9)
Landing area	Буултын талбай	That part of a movement area intended for the landing or take-off of aircraft.	Агаарын хөлгийн буулт, эсхүл хөөрөлт үйлдэхэд зориулсан хөдөлгөөнт талбайн хэсэг (AN 2; AN 4; AN 13; AN 14/I; PANS-ATM)
Landing decision point (LDP)	Буултын шийдвэр гаргах цэг	The point used in determining landing performance from which, an engine failure occurring at this point,	Хөдөлгүүр татгалзсан тухайн цэгээс буултыг аюулгүй үргэлжлүүлж болох, эсхүл цуцлагдсан

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		the landing may be safely continued or a balked landing initiated. <i>Note.- LDP applies only to helicopters operating in performance Class 1.</i>	буулт хийхэд (2-т гарах) шаардлагатай буултын үзүүлэлтийг тодорхойлоход ашигладаг цэг <i>Тэмдэглэл: LDP нь зөвхөн Хүчин чадлын Ангилал-1 нисдэг тэрээний үйл ажиллагаанд хамаарна. (AN 6/III)</i>
Landing direction indicator	Буултын чиглэл заагч	A device to indicate visually the direction currently designated for landing and for take-off.	Буулт болон хөөрөлт үйлдэх оноосон чиглэлийг ил хараагаар заах хэрэгсэл (AN 4; AN 14/I)
Landing distance available (LDA)	Буултын боломжит зай (LDA)	The length of runway which is declared available and suitable for the ground run of an aeroplane landing.	Нисэх онгоц буулт үйлдэн, газрын гүйлтэд ашиглахад бэлэн ба тохиромжтой гэж зарласан ХБЗ-ын урт (AN 6/I; AN 14/I)
Landing surface	Буултын гадаргуу	That part of the surface of an aerodrome which the aerodrome authority has declared available for the normal ground or water run of aircraft landing in a particular direction.	Тодорхой чиглэлд агаарын хөлөг газар, эсхүл усан дээр хэвийн буултын гүйлт үйлдэх боломжтой гэж зарласан гадаргуугийн хэсэг (AN 6/I; AN 8)
Large aeroplane	Нисэх онгоц - Том	An aeroplane having a passenger seating configuration of more than 30 seats, or a payload capacity of more than 3410 kg.	30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг-аас их нисэх онгоц (AN 6/I; AN 6/II)
Laser-beam critical flight zone (LCFZ)	Лазерын гэрэл эрсдэлтэй нислэгийн зоон (LCFZ)	Airspace in the proximity of an aerodrome but beyond the LFFZ where the irradiance is restricted to a level unlikely to cause glare effects.	Нүд гялбах нөлөөгүй байх түвшинд гэрлийн цацрагийг хязгаарласан LFFZ-ийн гаднах, аэродромын зэргэлдээх агаарын зай (AN 14/I)
Laser-beam free flight zone (LFFZ)	Лазерын гэрлээс чөлөөтэй нислэгийн зоон (LFFZ)	Airspace in the immediate proximity of the aerodrome where the irradiance is restricted to a level unlikely to cause any visual disruption.	Хараанд нөлөөлөхгүй байх түвшинд гэрлийн цацрагийг хязгаарласан аэродромын зэргэлдээх агаарын зай (AN 14/I)
Laser-beam sensitive flight zone	Лазерын гэрлийн нөлөөлөлд мэдрэмтгий нислэгийн зоон (LSDZ)	Airspace outside, and not necessarily contiguous with, the LFFZ and LCFZ where the irradiance is restricted to a level unlikely to cause flash-blindness or after-image effects.	Нүд сохлом хурц гэрэл, эсхүл хурц гэрэлд цохиулсны дараах нөлөөгүй байх түвшинд гэрлийн цацрагийг хязгаарласан, LFFZ болон LCFZ-ийн гаднах, заавал зэрэгцээ бус агаарын зай (AN 14/I)
Level	Түвшин	A generic term relating to the vertical position of an aircraft in flight and meaning variously, height, altitude or flight level.	Нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой өндөр, өндрийн-түвшин, эсхүл нислэгийн түвшнийг илэрхийлдэг ерөнхий нэр томьёо (AN 2; AN 3; AN 4; AN 11; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Licensing Authority	Үнэмлэх олгох эрх бүхий байгууллага	<p>The Authority designated by a Contracting State as responsible for the licensing of personnel.</p> <p><i>Note.- In the provisions of Annex 1, the Licensing Authority is deemed to have been given the following responsibilities by the Contracting State:</i></p> <p>a) <i>assessment of an applicant's qualifications to hold a licence or rating;</i></p> <p>b) <i>issue and endorsement of licences and ratings;</i></p> <p>c) <i>designation and authorization of approved persons;</i></p> <p>d) <i>approval of training courses;</i></p> <p>e) <i>approval of the use of flight simulation training devices and authorization for their use in gaining the experience or in demonstrating the skill required for the issue of a licence or rating; and</i></p> <p>f) <i>validation of licences issued by other Contracting States.</i></p>	<p>Хэлэлцэн тохиролцогч Улсын томилсон, ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт хариуцсан эрх бүхий байгууллага</p> <p><i>Тэмдэглэл: Annex-1-ийн хувьд, Үнэмлэх олгох эрх бүхий байгууллага нь тухайн Хэлэлцэн тохиролцогч улсын олгосон дараах эрхтэй байна:</i></p> <p>a) <i>үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргаагчийн мэргэшилд үнэлгээ хийх;</i></p> <p>b) <i>үнэмлэх болон зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийх;</i></p> <p>c) <i>зөвшөөрөгдсөн этгээдийг томилох болон эрх олгох;</i></p> <p>d) <i>сургалтын курсийн зөвшөөрөл олгох;</i></p> <p>e) <i>Дуураймал нислэгийн сургалтын төхөөрөмж ашиглах зөвшөөрөл олгох болон үнэмлэх, зэрэглэл олгоход шаардлагатай туршлага хуримтлуулах, эсхүл мэргэшлээ шалгуулах зорилгоор тэдгээрийг ашиглах эрх олгох;</i></p> <p>f) <i>бусад Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх. (AN 1)</i></p>
Lighter-than-air aircraft	Агаараас хөнгөн агаарын хөлөг	Any aircraft supported chiefly by its buoyancy in the air.	Өөрийн хөвөх чадвараар давамгайлсан агаарт хөвөн тогтдог агаарын хөлөг (AN 7)
Lighting system reliability	Гэрэлтүүлгийн системийн найдвартай ажиллагаа	The probability that the complete installation operates within the specified tolerances and that the system is operationally usable.	Төхөөрөмж цогц байдлаараа тодорхой зөвшөөрөгдсөн хязгаарт ажиллах болон системийн ажиллагаатай байх магадлал (AN 14/I)
Likely	Магадлалтай	In the context of the medical provisions in Chapter 6, likely means with a probability of occurring that is unacceptable to the medical assessor.	Annex 1, Chapter 6-ийн хувьд, Эрүүл мэндийн шалгагч хүлээн зөвшөөрөхгүй байх нөхцөл үүсэх магадлал (AN 1)
Limit loads	Ачааллын хязгаар	The maximum loads assumed to occur in the anticipated operating conditions.	Төлөвлөсөн үйл ажиллагааны нөхцөлд байж болох максимум ачаалал (AN 8)
Litre (L)	Литр (л)	A unit of volume restricted to the measurement of liquids and gases which is equal to 1 cubic decimetre.	1 дм ³ -тэй тэнцүү шингэн болон хийн хэмжээгээр хязгаарлагдсан эзлэхүүний нэгж (AN 5)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Load factor	Хэт ачааллын хүчин зүйл	The ratio of a specified load to the weight of the aircraft, the former being expressed in terms of aerodynamic forces, inertia forces, or ground reactions.	Аэродинамикийн хүч, инерцийн хүч, эсхүл газрын эсрэг үйлчлэлээр илэрхийлдэг заасан ачааллыг тухайн агаарын хөлгийн жинд харьцуулсан харьцаа (AN 8)
Location indicator	Байршил заагч	A four-letter code group formulated i.a.w rules prescribed by ICAO and assigned to the location of an aeronautical fixed station.	Нисэхийн суурин холбооны станцын байршилд оноосон, ICAO-гийн журмын дагуу томьёолсон 4 үсгэн код (AN 10/II; PANS-ATM)
Logon address	Нэвтрэх хаяг	A specified code used for data link logon to an ATS unit.	НХҮ-ний нэгжид data-link-ээр нэвтрэхэд хэрэглэдэг тусгай код (AN 4; AN 10/II; AN 15)
Low-visibility operations (LVO)	Хараа бага үеийн үйл ажиллагаа (LVO)	Approach operations in RVRs less than 550 m and/or with a DH less than 60 m (200 ft) or take-off operations in RVRs less than 400 m.	RVR 550 м-ээс бага ба/эсхүл DH 60 м-ээс (200 ft) бага үед ойртолт үйлдэх үйл ажиллагаа, эсхүл RVR 400 м-ээс бага үед хөөрөлт үйлдэх үйл ажиллагаа (AN 6/I; AN 6/II)
Lumen (Lm)	Люмин (Lm)	The luminous flux emitted in a solid angle of 1 steradian by a point source having a uniform intensity of 1 candela.	1 стерадиан биет өнцгөөр 1 кандел жигд гэрлийн хүчтэй цэгэн эх үүсвэрээс цацагддаг гэрлийн урсгал (AN 5)
Lux (Lx)	Люкс (Lx)	The illuminance produced by a luminous flux of 1 lumen uniformly distributed over a surface of 1 square metre.	1 м ² гадаргуу дээгүүр 1 люмин жигд тархсан гэрлийн урсгалаар үүсдэг гэрэлтүүлэг (AN 5)
Magnetic variation	Соронзон хазайлт	The angular difference between True North and Magnetic North. <i>Note.- The value given indicates whether the angular difference is East or West of True North.</i>	Жинхэнэ хойд зүг ба Соронзон хойд зүг хоорондын өнцгийн зөрүү <i>Тэмдэглэл: Өгөгдсөн утга нь Жинхэнэ Хойд зүг болон Зүүн, эсхүл Баруун чиглэлийн өнцгийн зөрүүг илэрхийлдэг. (AN 4)</i>
Mail	Шуудан	Dispatches of correspondence and other items tendered by and intended for delivery to postal services i.a.w the rules of the Universal Postal Union (UPU).	Дэлхийн шуудангийн холбооны (UPU) дүрмийн дагуу шуудангийн үйлчилгээнд хүлээн авч, хүргүүлэхээр илгээх захидал болон бусад эд зүйлс (AN 9)
Maintenance	Техник үйлчилгээ	The performance of tasks required to ensure the continuing airworthiness of an aircraft, including any one or combination of overhaul, inspection, replacement, defect rectification, and the embodiment of a modification or repair.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангийн НТЧ-ын хадгалалтыг бататгахад шаардлагатай, их засвар, эд анги үзлэг шалгалт, солилт, дутагдал арилгах болон модификаци, эсхүл засвар, эсхүл тэдгээрийн комбинацыг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			багтаасан агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангид хийж гүйцэтгэх ажил (AN 1; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 8)
Maintenance organization's procedures manual	Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар	A document endorsed by the head of the maintenance organization which details the maintenance organization's structure and management responsibilities, scope of work, description of facilities, maintenance procedures and quality assurance or inspection systems.	Техник үйлчилгээний байгууллагын бүтэц, удирдлагын үүрэг хариуцлага, гүйцэтгэх ажлын хамрах хүрээ, байгууламжийн тодорхойлолт, техник үйлчилгээ гүйцэтгэх журам болон чанар баталгаажуулалтын, эсхүл хяналт, шалгалтын тогтолцоог дэлгэрэнгүй заасан, тухайн техник үйлчилгээний байгууллагын удирдах ажилтан баталсан баримт бичиг (AN 6/I; AN 6/III; AN 8)
Maintenance program	Техник үйлчилгээний хөтөлбөр	A document which describes the specific scheduled maintenance tasks and their frequency of completion and related procedures, such as a reliability program, necessary for the safe operation of those aircraft to which it applies.	Агаарын хөлгийн үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай тусгай хуваарьт техник үйлчилгээний ажил, тэдгээрийг гүйцэтгэх давтамж болон найдвартай ажиллагааны хөтөлбөр зэрэг холбогдох журмыг тодорхойлсон баримт бичиг (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Maintenance records	Техник үйлчилгээний бүртгэл	Records that set out the details of the maintenance carried out on an aircraft, engine, propeller or associated part.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл холбогдох эд ангид хийсэн техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан бүртгэл (AN 8)
Maintenance release	Ашиглалтад шилжүүлэх	A document which contains a certification confirming that the maintenance work to which it relates has been completed in a satisfactory manner i.a.w appropriate airworthiness requirements.	Тухайн техник үйлчилгээний ажлыг холбогдох НТЧ-ын шаардлагын дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн болохыг бататгах гэрчилгээжүүлэлтийн баримт бичиг (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 8)
Manoeuvring area	Маневрын талбай	That part of an aerodrome to be used for the take-off, landing and taxiing of aircraft, excluding aprons.	Агаарын хөлгийн хөөрөлт болон буулт үйлдэх болон хөөрөлт, буулттай холбоотой агаарын хөлгийн гадаргуу дээрх хөдөлгөөнд ашигладаг, апроноос бусад аэродромын хэсэг (AN 2; AN 4; AN 11; AN 14/I; AN 15; PANS-ATM)
Marker	Тэмдэгт / Маркер	An object displayed AGL in order to indicate an obstacle or delineate a boundary.	Аливаа саад, эсхүл хил хязгаарыг харуулах зорилгоор газрын түвшнээс дээш байрлуулсан байгууламж (AN 14/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Marking	Тэмдэглэгээ	A symbol or group of symbols displayed on the surface of the movement area in order to convey aeronautical information.	Хөдөлгөөнт талбайн гадаргуу дээр байрлуулсан нисэхийн мэдээллийг илэрхийлдэг тэмдэг, эсхүл бүлэг тэмдэг (AN 4; AN 14/I)
Master minimum equipment list (MMEL)	Мастер минимум төхөөрөмжийн жагсаалт (MMEL)	A list established for a particular aircraft type by the organization responsible for the type design with the approval of the State of Design containing items, one or more of which is permitted to be unserviceable at the commencement of a flight. The MMEL may be associated with special operating conditions, limitations or procedures.	Нислэг эхлэх үед ажиллагаагүй байж болохыг нь зөвшөөрсөн нэг, эсхүл хэд хэдэн эд ангийг багтаасан, Зохион бүтээгч Улсын зөвшөөрөлтэй тухайн маягийн загварыг хариуцсан байгууллага тухайн агаарын хөлгийн хөлгийн маягт зориулан, боловсруулж гаргасан жагсаалт. MMEL нь үйл ажиллагааны тусгай нөхцөл, хязгаарлалт, эсхүл журамтай холбоотой байж болно. (AN 6/I; AN 6/III)
Maximum diversion time	Даялах максимум хугацаа	Maximum allowable range, expressed in time, from a point on a route to an en-route alternate aerodrome.	Нислэгийн замын цэгээс замын дагуух бэлтгэл аэродром хүртэлх, цагаар илэрхийлэгддэг зөвшөөрөгдөх максимум зай (AN 6/I)
Maximum mass	Максимум масс	Maximum certificated take-off mass.	Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн масс (AN 6/I; AN 6/III; AN 13)
Maximum passenger seating capacity	Максимум зорчигчийн суудлын багтаамж	The maximum certificated number of passengers for the aeroplane type design.	Тухайн нисэх онгоцны маягийн хувьд гэрчилгээжсэн максимум зорчигчийн тоо (AN 16/III)
Maximum take-off mass	Максимум хөөрөлтийн масс	The highest of all take-off masses for the type design.	Тухайн маягийн загварын хувьд хамгийн их нийт хөөрөлтийн масс (AN 16/III)
Mean power (of a radio transmitter)	Дундаж чадал (радио дамжуулагч)	The average power supplied to the antenna transmission line by a transmitter during an interval of time sufficiently long compared with the lowest frequency encountered in the modulation taken under normal operating conditions.	Энгийн ажлын горимын үеийн модуляцаар үүсэх нам давтамжийн хувьд хангалттай урт хугацаанд радио дамжуулагчаас антены шугамд очиж байгаа дундаж чадал (AN 10/I)
Medical Assessment	Эрүүл мэндийн үнэлгээ	The evidence issued by a Contracting State that the licence holder meets specific requirements of medical fitness.	Тухайн үнэмлэх эзэмшигч нь эрүүл мэндийн тодорхой шаардлагыг хангасан болохыг гэрчлэн Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон нотлох баримт (AN 1)
Medical assessor	Эрүүл мэндийн шалгагч	A physician, appointed by the Licensing Authority, qualified and experienced in the practice of aviation medicine and competent in evaluating and	Үнэмлэх олгох эрх бүхий байгууллагын эрүүл мэндийн шалгагчийн гаргасан тайланд үнэлгээ хийдэг, нисэхийн анагаах ухааны чиглэлээр мэргэшсэн ба туршлага хуримтлуулсан эмч

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>assessing medical conditions of flight safety significance.</p> <p><i>Note 1.- Medical assessors evaluate medical reports submitted to the Licensing Authority by medical examiners. (Medical assessor / medical examiner (Part 67))</i></p> <p><i>Note 2.- Medical assessors are expected to maintain the currency of their professional knowledge.</i></p>	<p><u>Тэмдэглэл 1:</u> Эрүүл мэндийн шалгагч нь Үнэмлэх олгох эрх бүхий байгууллагад эксперт-эмчийн хүргүүлсэн эрүүл мэндийн тайланд дүгнэлт хийнэ. (Medical assessor / medical examiner (Part 67))</p> <p><u>Тэмдэглэл 2:</u> Эрүүл мэндийн шалгагч нь өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа байнга хадгалдаг байна. (AN 1)</p>
Medical examiner	Эксперт-эмч	<p>A physician with training in aviation medicine and practical knowledge and experience of the aviation environment, who is designated by the Licensing Authority to conduct medical examinations of fitness of applicants for licences or ratings for which medical requirements are prescribed.</p> <p><i>Note.- (Medical examiner / medical expert (Part 67))</i></p>	<p>Эрүүл мэндийн шаардлагыг нь заасан үнэмлэх, эсхүл зэрэглэл авах хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн байдалд шалгалт хийхээр Үнэмлэх олгох эрх бүхий байгууллагын томилсон, нисэхийн анагаах ухааны сургалтад хамрагдсан ба нисэхийн салбарт ажилласан практик дадлага туршлага, мэдлэгтэй эмч (AN 1)</p> <p><u>Тэмдэглэл:</u> (Medical examiner / medical expert (Part 67))</p>
Medium aeroplane	Нисэх онгоц - Дунд	<p>An aeroplane with a passenger seating configuration of 10 to 30 seats, or a payload capacity of 3410 kg or less and a MCTOW of greater than 5700 kg.</p>	<p>10 - 30 зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг, эсхүл түүнээс бага, MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй нисэх онгоц (AN 6/I; AN 6/II)</p>
Message field	Мэдээний талбай	<p>An assigned area of a message containing specified elements of data.</p>	<p>Мэдээллийн тодорхой өгөгдлийг агуулсан мэдээний заагдсан хэсэг (AN 10/II)</p>
Metadata	Мета-өгөгдөл	<p>Data about data (ISO 19115*).</p> <p><i>Note.- Data that describes and documents data.</i></p>	<p>Өгөгдлийн талаарх өгөгдөл</p> <p><u>Тэмдэглэл:</u> Өгөгдлийг зааж, баримтжуулсан өгөгдөл. (AN 4; AN 15)</p>
Meteorological authority	Цаг уурын эрх бүхий байгууллага	<p>The authority providing or arranging for the provision of meteorological service for international air navigation on behalf of a Contracting State.</p>	<p>Хэлэлцэн тохиролцогч Улсын нэрийн өмнөөс олон улсын агаарын навигацид цаг уурын үйлчилгээ үзүүлдэг, эсхүл түүнийг зохицуулдаг эрх бүхий байгууллага (AN 3)</p>
Meteorological bulletin	Цаг уурын бюллетен	<p>A text comprising meteorological information preceded by an appropriate heading.</p>	<p>Гарчгийг нь урьдчилан хэвлэсэн цаг уурын мэдээлэл агуулсан бичвэр (AN 3)</p>
Meteorological information	Цаг уурын мэдээлэл	<p>Meteorological report, analysis, forecast, and any other statement relating to existing or expected meteorological conditions.</p>	<p>Цаг уурын бодит болон урьдчилан таамагласан нөхцөлтэй холбоотой цаг уурын мэдээлэл, дүн</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			шинжилгээ, урьдчилсан мэдээ болон бусад мэдэгдэл (AN 3; AN 6/II; PANS-ATM)
Meteorological office	Цаг уурын алба	An office designated to provide meteorological service for international air navigation.	Олон улсын агаарын навигацид цаг уурын үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон нэгж (AN 3; AN 11; PANS-ATM)
Meteorological operational channel	Цаг уурын үйл ажиллагааны суваг	A channel of the aeronautical fixed service (AFS), for the exchange of aeronautical meteorological information.	Нисэхийн цаг уурын мэдээлэл солилцох зорилготой нисэхийн суурин холбооны үйлчилгээний (AFS) суваг (AN 10/II)
Meteorological operational telecommunication network	Цаг уурын үйл ажиллагааны цахилгаан холбооны сүлжээ	An integrated system of meteorological operational channels, as part of the aeronautical fixed service (AFS), for the exchange of aeronautical meteorological information between the aeronautical fixed stations within the network.	Сүлжээний хүрээнд нисэхийн суурин холбооны станцуудын хооронд цаг уурын мэдээлэл солилцоход зориулсан AFS-ийн хэсэг болох цаг уурын үйл ажиллагааны сувгийн нэгдсэн систем (AN 10/II)
Meteorological report	Цаг уурын мэдээ	A statement of observed meteorological conditions related to a specified time and location.	Тогтоосон хугацаа болон байрлалтай холбоотой ажиглагдсан цаг уурын нөхцөлийн мэдэгдэл (AN 3; PANS-ATM)
Meteorological satellite	Цаг уурын хиймэл дагуул	An artificial Earth satellite making meteorological observations and transmitting these observations to Earth.	Цаг уурын ажиглалт хийж, тэдгээр мэдээллийг дэлхий рүү дамжуулдаг хиймэл дагуул (AN 3)
Meteorological watch office (MWO)	Цаг уурын ажиглалтын алба (MWO)	An office designated to provide information concerning the occurrence or expected occurrence of specified en-route weather and other phenomena in the atmosphere that may affect the safety of aircraft operations within its specified area of responsibility.	Заасан хариуцлагын бүсэд агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болох тухайн замын дагуух цаг агаарын үзэгдэл, эсхүл урьдчилан таамаглаж болох үзэгдэл болон атмосферийн бусад аюултай үзэгдлийн талаар мэдээ хангах зорилгоор байгуулсан алба (AN 3)
Metre	Метр (м)	The distance travelled by light in a vacuum during 1/299 792 458 of a second.	Вакумд 1/299792458 секундийн хугацаанд гэрлийн туулах замын урт (AN 5)
Minimum descent altitude (MDA) or minimum descent height (MDH)	Өндөр алдах минимум өндрийн-түвшин (MDA), эсхүл өндөр алдах минимум өндөр (MDH)	A specified altitude or height in a 2D instrument approach operation or circling approach operation below which descent must not be made without the required visual reference. <i>Note.- Minimum descent altitude (MDA) is referenced to MSL and minimum descent height (MDH) is referenced to the aerodrome elevation or to the threshold elevation</i>	2D хэрэглэлийн ойртолт, эсхүл тойргоор ойртолт үйлдэх үйл ажиллагаанд шаардлагатай ил харааны баримжаагүйгээр өндөр алдалтыг гүйцэтгэж болохгүй, тогтоосон өндрийн-түвшин, эсхүл өндөр <i>Тэмдэглэл: MDA-г MSL-ээр илэрхийлдэг ба MDH-г аэродромын өндөрлөгөөр, эсхүл хэрэв босгын өндөр нь</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<i>if that is more than 2 m (7 ft) below the aerodrome elevation. A minimum descent height for a circling approach is referenced to the aerodrome elevation.</i>	<i>аэродромын өндөрлөгөөс доош 2 м-ээс (7 ft) илүү нам бол босгын өндөрлөгөөр илэрхийлдэг. Тойргоор ойртолт үйлдэх MDH-г аэродромын өндөрлөгөөр илэрхийлдэг. (AN 6/I; AN 6/II; AN 6/III; PANS-OPS/I; PANS-OPS/II)</i>
Minimum en-route altitude (MEA)	Нислэгийн замын минимум өндрийн-түвшин (MEA)	The altitude for an en-route segment that provides adequate reception of relevant navigation facilities and ATS communications, complies with the airspace structure and provides the required obstacle clearance.	Холбогдох навигацийн байгууламж болон НХҮ-ний холбооны төхөөрөмжийн сигналын хүлээн авалтын шаардлагыг хангасан, агаарын зайн зохион байгуулалтад нийцсэн бөгөөд шаардлагатай саадаас чөлөөтэй байх нөхцөлийг хангасан нислэгийн тодорхой үе шатанд хамаарах өндрийн-түвшин (AN 4; AN 15)
Minimum equipment list (MEL)	Минимум төхөөрөмжийн жагсаалт (MEL)	A list which provides for the operation of aircraft, subject to specified conditions, with particular equipment inoperative, prepared by an operator in conformity with, or more restrictive than, the MMEL established for the aircraft type.	Заасан нөхцөлөөс шалтгаалан тодорхой төхөөрөмж нь ажиллагаагүй болсон агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан, тухайн агаарын хөлгийн маягийн MMEL-д нийцүүлэн, эсхүл түүнээс илүү хязгаарлалттай байхаар үйл ажиллагаа эрхлэгчийн боловсруулан гаргасан жагсаалт (AN 6/I; AN 6/III)
Minimum obstacle clearance altitude (MOCA)	Саадыг давах минимум өндрийн-түвшин (MOCA)	The minimum altitude for a defined segment of flight that provides the required obstacle clearance.	Заасан нислэгийн үе шат шаардлагатай саадаас чөлөөтэй байх нөхцөлийг хангадаг минимум өндрийн-түвшин (AN 4; AN 15)
Minimum sector altitude	Секторын минимум өндрийн-түвшин	The lowest altitude which may be used which will provide a minimum clearance of 300 m (1 000 ft) above all objects located in an area contained within a sector of a circle of 46 km (25 NM) radius centred on a significant point, the aerodrome reference point (ARP) or the heliport reference point (HRP).	Тодорхой цэг, аэродромын хяналтын цэг (ARP), эсхүл хелипортын хяналтын цэгт (HRP) төвтэй 46 км (25 NM) радиустай тойргийн сектор дотор тухайн талбайд байгаа бүх байгууламжийн дээгүүр минимум 300 м-ийн (1000 ft) чөлөөтэй байх зайг хангахад ашиглаж болох хамгийн бага өндрийн-түвшин (AN 3; AN 4; PANS-OPS/I)
Minor	Насанд хүрээгүй этгээд	A person who has not attained the age of majority as determined under the law applicable to the person.	Тухайн хүнд хамаарах хуулийн дагуу насанд хүрсэн гэж тогтоогдоогүй этгээд (AN 9)
Mishandled baggage	Төөрсөн тээш	Baggage involuntarily, or inadvertently, separated from passengers or crew.	Санаандгүй, эсхүл анхаарал болгоомжгүйгээр нисэх баг, эсхүл зорчигчоос төөрсөн тээш (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Missed approach point	Ойртолтоос 2-т гарах цэг	That point in an instrument approach procedure at or before which the prescribed missed approach procedure must be initiated in order to ensure that the minimum obstacle clearance is not infringed.	Саадыг давах минимум зайг зөрчихгүй байхын тулд энэ цэгт, эсхүл түүнээс өмнө заасан ойртолтоос 2-т гарах журмыг эхлүүлсэн байх ёстой хэрэглэлийн ойртолтын журмын цэг (AN 4)
Missed approach procedure	Ойртолтоос 2-т гарах журам	The procedure to be followed if the approach cannot be continued.	Ойртолтыг үргэлжлүүлэх боломжгүй нөхцөлд дагаж мөрдөх журам (AN 4; PANS-OPS/I; PANS-OPS/II; PANS-ATM)
Mobile surface station	Гадаргуугийн хөдөлгөөнт холбооны станц	A station in the aeronautical telecommunication service, other than an aircraft station, intended to be used while in motion or during halts at unspecified points.	Агаарын хөлгийн станцаас бусад, хөдөлгөөний үед, эсхүл заагдаагүй цэгт зогсож байхад ашиглах зориулалттай нисэхийн холбооны үйлчилгээний станц (AN 10/II)
Mode S subnetwork	Mode S дэд сүлжээ	A means of performing an interchange of digital data through the use of secondary surveillance radar (SSR) Mode S interrogators and transponders i.a.w defined protocols.	Тогтоосон протоколын дагуу SSR Mode S интегратор болон транспондер ашиглан тоон өгөгдлийн харилцан солилцоог хийдэг хэрэгсэл (AN 10/III)
Modification	Модификаци	A change to the type design of an aircraft, engine or propeller. <i>Note.- A modification may also include the embodiment of the modification which is a maintenance task subject to a maintenance release. Further guidance on aircraft maintenance (modification and repair) is contained in the Airworthiness Manual (Doc 9760).</i>	Агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийн загварын өөрчлөлт <i>Тэмдэглэл: Модификацид ашиглалтад шилжүүлэх шаардлагатай техник үйлчилгээний ажлын хүрээнд хийдэг модификацийн хэрэгжүүлэлт мөн багтдаг. Агаарын хөлгийн техник үйлчилгээ (модификаци болон засвар)-ний гарын авлага нь Airworthiness Manual (Doc 9760)-д багтсан. (AN 6/I; AN 6/II; AN 8)</i>
Mole	Моль (моль)	The amount of substance of a system which contains as many elementary entities as there are atoms in 0.012 kilogram of carbon-12. <i>Note.- When the mole is used, the elementary entities must be specified and may be atoms, molecules, ions, electrons, other particles or specified groups of such particles.</i>	12 гр масстай атомтой тэнцүү нүүрстөрөгч-12 эгэл бөөмсийг агуулсан системийн бодисын хэмжээ <i>Тэмдэглэл: Моль нэгжийг хэрэглэх үед эгэл бөөмсийг тусгайлан тогтоосон байх хэрэгтэй бөгөөд тэдгээр нь атом, молекул, ион, электрон болон бусад хэсгүүд байж болох, эсхүл ангилсан эгэл хэсгүүд байж болно. (AN 5)</i>
Monitoring	Мониторинг	A cognitive process to compare an actual to an expected state. <i>Note.- Monitoring is embedded in the competencies for a given role within an aviation discipline, which serve as countermeasures in the threat and error management</i>	Бодит байдлыг төсөөлсөн төлөв байдалтай харьцуулах танин мэдэхүйн үйл явц <i>Тэмдэглэл: Мониторинг нь нисэхийн тухайн ажил мэргэжилд хамаарах чиг үүргийн (албан тушаал) хувьд, заналхийлэл болон алдааны удирдлагын загварын</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<i>model. It requires knowledge, skills and attitudes to create a mental model and to take appropriate action when deviations are recognized.</i>	<i>дагуу хариу арга хэмжээ авах үр чадварын шаардлагыг багтаадаг. Энэ нь алдааг таньж тогтоон, үр дагаврыг ухамсарлан, холбогдох арга хэмжээ авахад хэрэгтэй мэдлэг, чадвар болон хандлагыг шаарддаг. (AN 1)</i>
Movement area	Хөдөлгөөнт бүс	That part of an aerodrome to be used for the take-off, landing and taxiing of aircraft, consisting of the manoeuvring area and the apron(s).	Агаарын хөлгийн хөөрөлт болон буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулагдсан, маневрын талбай, техник үйлчилгээний талбай болон апроныг багтаасан аэродромын тодорхой хэсэг (AN 2; AN 4; AN 11; AN 14/I; AN 15; PANS-ATM)
Narcotics control	Мансууруулах бодисын хяналт	Measures to control the illicit movement of narcotics and psychotropic substances by air.	Мансууруулах болон сэтгэгцэд нөлөөлөх бодисыг агаараар хууль бусаар тээвэрлэхэд тавих хяналтын арга хэмжээ (AN 9)
National accreditation body	Үндэсний итгэмжлэгдсэн этгээд	A body authorized by a State which attests that a verification body is competent to provide specific verification services.	Баталгаажуулах этгээд нь тухайн баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх чадвартай болохыг аттестатчилсан Улс зөвшөөрөл олгосон этгээд (AN 16/IV)
Nautical mile (NM)	Далайн миль (NM)	The length equal to 1 852 metres exactly.	1852 м-тэй тэнцүү уртын нэгж (AN 5)
Navigation specification	Навигацийн тодорхойлолт	A set of aircraft and flight crew requirements needed to support performance-based navigation operations within a defined airspace. There are two kinds of navigation specifications: <i>Required navigation performance (RNP) specification.</i> A navigation specification based on area navigation that includes the requirement for performance monitoring and alerting, designated by the prefix RNP, e.g. RNP 4, RNP APCH. <i>Area navigation (RNAV) specification.</i> A navigation specification based on area navigation that does not include the requirement for performance monitoring and alerting, designated by the prefix RNAV, e.g. RNAV 5, RNAV 1.	Тогтоосон агаарын зайд PBN (үзүүлэлтэд суурилсан навигаци) үйл ажиллагааг дэмжихэд шаарддаг, агаарын хөлөг болон нисэх багийн шаардлагын багц. Дараах хоёр төрлийн навигацийн тодорхойлолт байдаг: <i>Навигацийн шаардлагатай үзүүлэлтийн (RNP) тодорхойлолт:</i> RNP 4, RNP APCH зэрэг RNP-ээр илэрхийлдэг, үзүүлэлтийн мониторинг болон анхааруулах шаардлагыг багтаасан бүсийн навигацид суурилсан навигацийн тодорхойлолт; <i>Бүсийн навигацийн (RNAV) тодорхойлолт:</i> RNAV 5, RNAV 1 зэрэг RNP-ээр илэрхийлдэг, үзүүлэлтийн мониторинг болон анхааруулах шаардлагыг багтаагаагүй бүсийн навигацид суурилсан навигацийн тодорхойлолт.

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<i>Note.- The Performance-based Navigation (PBN) Manual (Doc 9613), Volume II, contains detailed guidance on navigation specifications.</i>	<i>Тэмдэглэл: навигацййн тодорхойлолтын дэлгэрэнгүйг ICAO Doc 9613 The Performance-based Navigation (PBN) Manual, Volume II-м заасан.</i> (AN 3; AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 10/I; AN 11; AN 15)
Near-parallel runways	Бараг зэрэгцээ ХБЗ	Non-intersecting runways whose extended centre lines have an angle of convergence/divergence of 15 degrees or less.	Гол шугамуудыг үргэлжлүүлэхэд хоорондоо 15 ба түүнээс бага өнцгөөр уулздаг, огтлолцоогүй ХБЗ (AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Necessary precautions	Шаардлагатай урьдчилан сэргийлэх үзлэг	Verifications carried out by adequately trained staff members of the aircraft operator or the company operating on behalf of the aircraft operator, at the point of embarkation, in order to ensure that every person holds a valid travel document and, where applicable, the visa or residence permit required to enter the State of transit and/or receiving State. These verifications are designed to ensure that irregularities (e.g. obvious document alteration) are detected.	Этгээд бүр нь хүчинтэй аяллын баримт бичигтэй бөгөөд транзит ба/эсхүл хүлээн авах Улс нь шаарддаг бол орох виз, эсхүл оршин суугчийн зөвшөөрөлтэй болохыг бататгах зорилгоор агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа компанийн зохих сургалтад хамрагдсан ажилтан хөлөгт орохоос өмнө хийдэг баталгаажуулалт. Энэ баталгаажуулалтын үзлэгийг баримт бичгийн засвар өөрчлөлттэй холбоотой зөрчлийг илрүүлдэг байхыг бататгахаар зохион байгуулдаг. (AN 9)
Network station	Сүлжээний станц	An aeronautical station forming part of a radiotelephony network.	Радио-холбооны сүлжээний хэсгийг бүрдүүлдэг нисэхийн холбооны станц (AN 10/II)
New entrant	Шинэ оролцогч	Any aeroplane operator that commences an aviation activity falling within the scope of this Volume on or after its entry into force and whose activity is not in whole or in part a continuation of an aviation activity previously performed by another aeroplane operator.	Бусад нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчийн эрхэлж байсан нисэхийн үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн үргэлжлүүлээгүй бөгөөд хүчинтэй Annex 16, Volume IV-д хамаарах нисэхийн үйл ажиллагааг шинээр эхлүүлж байгаа нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч (AN 16/IV)
Newton (N)	Ньютон (Н)	The force which when applied to a body having a mass of 1 kilogram gives it an acceleration of 1 metre per second squared.	1 кг масстай биетэд 1 м / сек ² хурдатгал өгөх хүч (AN 5)
Next data authority	Дараагийн өгөгдлийн эрх бүхий нэгж	The ground system so designated by the current data authority through which an onward transfer of communications and control can take place.	Түүнийг ашиглан цаашдын холбоо болон удирдлагыг шилжүүлэн гүйцэтгэж чадах, хүчинтэй

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			өгөгдлийн эрх бүхий нэгжээр томилогдсон газрын систем (AN 10/II; PANS-ATM)
Next intended user	Дараагийн хэрэглэгч	The entity that receives the aeronautical data or information from the AIS.	НМҮ-нээс нисэхийн өгөгдөл, эсхүл мэдээллийг хүлээн авдаг байгууллага (AN 15)
Night	Шөнө	The hours between- - the end of evening civil twilight, which is when the centre of the setting sun's disc is 6 degrees below the horizon which ends approximately 30 minutes after sunset; and - the beginning of morning civil twilight, which is when the centre of the rising sun's disc is 6 degrees below the horizon which starts approximately 30 minutes before sunrise;	Үдшийн бүрий дуусахаас үүрийн гэгээ эхлэх хүртэлх хугацаа: - үдшийн бүрий нь жаргаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар жаргаснаас хойш 30 минутын дараа дуусна. - үүрийн гэгээ нь ургаж байгаа нарны голч тэнгэрийн хаяанаас 6° доор буюу нар мандахаас 30 минутын өмнө эхэлнэ. (AN 1; AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Non-congested hostile environment	Шигүү суурьшлын бус аюултай орчин	A hostile environment outside a congested area.	Шигүү суурьшлын бүсийн гаднах аюултай орчин (AN 6/III)
Non-duty period	Үүргээс чөлөөтэй байх хугацаа	A continuous and defined period of time, subsequent to and/or prior to duty periods, during which the air traffic controller is free of all duties.	Үүрэгт хугацааны дараа ба/эсхүл үүрэгт хугацаа хүртэлх нислэгийн хөдөлгөөний удирдагч бүх ажил үүргээс чөлөөтэй байдаг, үргэлжилсэн ба тогтоосон цаг хугацаа (AN 11)
Non-hostile environment	Аюулгүй орчин	An environment in which: a) a safe forced landing can be accomplished because the surface and surrounding environment are adequate; b) the helicopter occupants can be adequately protected from the elements; c) SAR response/capability is provided consistent with anticipated exposure; and d) the assessed risk of endangering persons or property on the ground is acceptable. <i>Note.- Those parts of a congested area satisfying the above requirements are considered non-hostile.</i>	Дараах нөхцөл бүрдсэн орчин: a) газрын гадаргуу болон хүрээлэн буй орчны байдлаас шалтгаалан аюулгүй аргагүйдсэн буулт үйлдэх боломжтой; b) нисдэг тэргэнд байгаа хүмүүсийг тодорхой хүчин зүйлээс зохих ёсоор хамгаалах боломжтой; c) учирч болзошгүй аюултай дүйцэх ЭХАТ арга хэмжээ авах нөхцөл хангагдсан; d) газарт байгаа хүн, эсхүл эд хөрөнгөд учруулах аюулын тооцсон эрсдэл нь хүлээн зөвшөөрөгдөхүйц бага.

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			<i>Тэмдэглэл:</i> Дээрх шаардлагыг хангасан шигүү суурьшлын бүсийн хэсгийг аюулгүй орчин гэж үзнэ. (AN 6/III)
Non-instrument runway	Хэрэглэлийн бус ХБЗ	A runway intended for the operation of aircraft using visual approach procedures or an instrument approach procedure to a point beyond which the approach may continue in VMC. <i>Note.- VMC are described in Chapter 3 of Annex 2 - Rules of the Air.</i>	Ил хараагаар ойртолтын журам, эсхүл хэрэглэлийн ойртолтын журмыг тухайн цэгийг өнгөрснөөс хойш ойртолтыг ил харааны цаг уурын нөхцөлд үргэлжлүүлэн ашигладаг агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулсан ХБЗ <i>Тэмдэглэл:</i> VMC-ийг Chapter 3 of Annex 2 - Rules of the Air-т заасан. (AN 14/I)
Non-network communications	Сүлжээний бус холбоо	Radiotelephony communications conducted by a station of the aeronautical mobile service, other than those conducted as part of a radiotelephony network.	Радио-холбооны сүлжээний хэсгээр хийгдэж байгаагаас бусад, нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний станцаар тогтоодог радио-холбоо (AN 10/II)
Non-volatile particulate matter (nvPM)	Шатдаггүй хатуу биетийн хэсгүүд	Emitted particles that exist at a gas turbine engine exhaust nozzle exit plane that do not volatilize when heated to a temperature of 350°C.	Хийн турбинт хөдөлгүүрийн яндангийн гаралтаас 350°C хүртэл халаахад шатдаггүй гардаг хатуу бодис (AN 16/II)
Normal flight zone (NFZ)	Хэвийн нислэгийн зоон (NFZ)	Airspace not defined as LFFZ, LCFZ or LSFZ but which must be protected from laser radiation capable of causing biological damage to the eye.	LFFZ, LCFZ, эсхүл LSFZ гэж тогтоогоогүй, гэхдээ нүдэнд биологийн гэмтэл учруулж чадах лазерын тусгалаас хамгаалагдсан байх шаардлагатай агаарын зай (AN 14/I)
NOTAM (Notice to airmen)	NOTAM	A notice distributed by means of telecommunication containing information concerning the establishment, condition or change in any aeronautical facility, service, procedure or hazard, the timely knowledge of which is essential to personnel concerned with flight operations.	Аливаа нисэхийн байгууламж, үйлчилгээ, журам, эсхүл аюулын нөхцөл, өөрчлөлт, эсхүл тогтолцооны талаар нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд цаг алдалгүй мэдэх зайлшгүй шаардлагатай мэдээллийг агуулсан, цахилгаан холбооны хэрэгслээр тараадаг мэдээ (AN 10/II; AN 11; AN 15; PANS-ATM)
Notifying State	Мэдэгдэл гаргасан Улс	The State that has submitted to ICAO the request for the registration of or change in the three-letter designator of an aeroplane operator over which it has jurisdiction.	Тухайн нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцсан Улсаас оноосон дөрвөн тоог (гурван үсэг) бүртгүүлэх, эсхүл өөрчлөх тухай хүсэлтийг ICAO-д гаргасан Улс (AN 16/IV)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Observable behaviour (OB)	Таньж тогтоогдохуйц зан төлөв	A single role-related behaviour that can be observed and may or may not be measurable.	Таньж тогтоож болдог ба хэмжигдэхүйц, эсхүл хэмжигдэхүйц бус байж болох нэг ажил үүрэгтэй холбоотой зан төлөв (AN 1)
Observation (meteorological)	Ажиглалт (цаг уурын)	The evaluation of one or more meteorological elements.	Цаг уурын нэг, эсхүл хэд хэдэн элементийг ажиглах үйл ажиллагаа (AN 3)
Obstacle	Саад	<p>All fixed (whether temporary or permanent) and mobile objects, or parts thereof, that:</p> <p>a) are located on an area intended for the surface movement of aircraft; or</p> <p>b) extend above a defined surface intended to protect aircraft in flight; or</p> <p>c) stand outside those defined surfaces and that have been assessed as being a hazard to air navigation.</p> <p><i>Note.- The term obstacle is used in Annex 4 solely for the purpose of specifying the charting of objects that are considered a potential hazard to the safe passage of aircraft in the type of operation for which the individual chart series is designed.</i></p>	<p>Дараах бүх суурин (түр, эсхүл байнгын) болон хөдөлгөөнт байгууламж, эсхүл тэдгээрийн хэсэг:</p> <p>a) агаарын хөлгийн гадаргуугийн хөдөлгөөн зориулсан талбайд байрласан; эсхүл</p> <p>b) нислэгт байгаа агаарын хөлгийг хамгаалах зорилгоор тогтоосон гадаргуугаас дээш өргөгдсөн; эсхүл</p> <p>c) нислэгийн үйл ажиллагаанд аюултай гэж тогтоосон тухайн тодорхойлсон гадаргуугаас гадна байрласан.</p> <p><i>Тэмдэглэл:</i> Аннех 4-т “саад” гэдэг тодорхойлолтыг зөвхөн тухайн зургийн сөрийг зориулан боловсруулсан үйл ажиллагааны төрөлд агаарын хөлөг аюулгүй давахад бодит аюултай гэж тооцогдох биетийн зураглалыг тодорхойлоход ашигладаг. (AN 4; AN 11; AN 14/I; AN 14/II; AN 15)</p>
Obstacle clearance altitude (OCA) or obstacle clearance height (OCH)	Саадыг давах өндрийн-түвшин (OCA), эсхүл саадыг давах өндөр (OCH)	<p>The lowest altitude or the lowest height above the elevation of the relevant runway threshold or the aerodrome elevation as applicable, used in establishing compliance with appropriate obstacle clearance criteria.</p> <p><i>Note 1.- Obstacle clearance altitude is referenced to MSL and obstacle clearance height is referenced to the threshold elevation or in the case of non-precision approaches to the aerodrome elevation or the threshold elevation if that is more than 2 m (7 ft) below the aerodrome elevation. An obstacle clearance height for a circling approach is referenced to the aerodrome elevation.</i></p>	<p>Саадаас чөлөөтэй байх холбогдох шалгуурыг хангахад ашигладаг тухайн ХБЗ-ын босгын өндөр, эсхүл тухайн аэродромын өндөрлөгийн аль хамааралтайгаас дээших хамгийн бага өндрийн-түвшин, эсхүл хамгийн бага өндөр.</p> <p><i>Тэмдэглэл 1:</i> Саадыг давах өндрийн-түвшнийг MSL-ээр ба саадыг давах өндрийг босгын өндөрлөгөөр, эсхүл нарийвчлалтай бус ойртолтын хувьд аэродромын өндөрлөгөөр, эсхүл хэрэв босгын өндөр нь аэродромын өндөрлөгөөс доош 2 м-ээс (7 ft) илүү нам бол босгын өндөрлөгөөр өгдөг. Тойргоор үйлдэх ойртолтын хувьд саадыг давах өндрийг аэродромын өндөрлөгөөр өгдөг.</p> <p><i>Тэмдэглэл 2:</i> Хоёр нэр томьёог хамт ашиглах бол хялбарчлах зорилгоор “саадыг давах өндрийн-түвшин/өндөр” буюу “OCA/H” гэж товчилж болно.</p>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>Note 2.- For convenience when both expressions are used they may be written in the form “obstacle clearance altitude/height” and abbreviated “OCA/H”.</p> <p>Note 3.- See Procedures for Air Navigation Services - Aircraft Operations (Doc 8168), Volume I, Part I, Section 4, Chapter 1, 1.5, and Volume II, Part I, Section 4, Chapter 5, 5.4”-ийг үз. (AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)</p>	<p><u>Тэмдэглэл 3:</u> Энэ тодорхойлолтыг хэрэглэхдээ “Procedures for Air Navigation Services - Aircraft Operations (Doc 8168), Volume I, Part I, Section 4, Chapter 1, 1.5, and Volume II, Part I, Section 4, Chapter 5, 5.4”-ийг үз. (AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)</p>
Obstacle free zone	Саадаас чөлөөтэй зоон	The airspace above the inner approach surface, inner transitional surfaces, and balked landing surface and that portion of the strip bounded by these surfaces, which is not penetrated by any fixed obstacle other than a low-mass and frangibly mounted one required for air navigation purposes.	Нислэгийн үйл ажиллагаанд зориулан суурилуулсан хөнгөн, хагарамхай саадаас бусад суурин саадаар огтлогдоогүй ойртолтын дотоод гадаргуу, шилжилтийн дотоод гадаргуу болон цуцлагдсан буултын гадаргуу болон эдгээр гадаргуугаар хүрээлэгдсэн талбайн хэсгээс дээших агаарын зай (AN 4; AN 14/I; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Obstacle limitation surfaces	Саадыг хязгаарлах гадаргуу	Airspace defined around an aerodrome that enables operations at the aerodrome to be conducted safely and that prevents the aerodrome from becoming unusable by the growth of obstacles around the aerodrome.	Аэродромын үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх, аэродромын эргэн тойрны саадын өсөлтийн улмаас тухайн аэродромыг ашиглах боломжгүй болохоос сэргийлэх зорилгоор аэродромын эргэн тойронд тусгайлан тогтоосон агаарын зай (AN 10/I; AN 14/I; AN 14/II; AN 15)
Obstacle/terrain data collection surface	Саад / газрын бартааны өгөгдөл цуглуулах гадаргуу	A defined surface intended for the purpose of collecting obstacle/terrain data.	Саад / газрын бартааны өгөгдөл цуглуулах зорилгоор тогтоосон гадаргуу (AN 15)
Offset frequency simplex	Шилжих давтамжтай симплекс	A variation of single channel simplex wherein telecommunication between two stations is effected by using in each direction frequencies that are intentionally slightly different but contained within a portion of the spectrum allotted for the operation.	Хоёр станцын хооронд чиглэл тус бүрд зориуд бага зэрэг ялгаатай, гэхдээ үйл ажиллагаанд нь зориулсан спекторын хэсгийн хүрээнд багтдаг давтамж ашигладаг цахилгаан холбооны ганц сувагтай симплексийн нэг хэлбэр (AN 10/II; AN 10/V)
Offshore operations	Офшор үйл ажиллагаа	Operations which routinely have a substantial proportion of the flight conducted over sea areas to or from offshore locations. Such operations include, but are not limited to, support of offshore oil, gas and mineral exploitation and sea-pilot transfer.	Нислэгийн үйл ажиллагааны дийлэнх хэсгийг офшор луу, эсхүл офшороос далай дээгүүр гүйцэтгэх үйл ажиллагаа. Эдгээр үйл ажиллагаанд далайгаас газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох болон далайн нисгэгч (sea-pilot)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			шилжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа хамаарна.
Ohm	Ом	The electric resistance between two points of a conductor when a constant difference of potential of 1 volt, applied between these two points, produces in this conductor a current of 1 ampere, this conductor not being the source of any electromotive force.	Цахилгаан хөдөлгөгч хүчний эх үүсвэр болоогүй дамжуулагчийн хоёр цэгийн хооронд 1 вольтын тогтмол потенциалын ялгавартай хүчдэл өгөхөд тухайн дамжуулагч 1 ампер гүйдэл үүсгэдэг дамжуулагчийн хоёр цэгийн хоорондох цахилгаан эсэргүүцэл (AN 5)
Operating base	Үйл ажиллагааны төв	The location from which operational control is exercised. <i>Note.- An operating base is normally the location where personnel involved in the operation of the aeroplane work and the records associated with the operation are located. An operating base has a degree of permanency beyond that of a regular point of call.</i>	Агаарын тээвэрлэгч үйл ажиллагаагаа удирдаж байгаа байрлал <i>Тэмдэглэл: Үйл ажиллагааны төв гэж тухайн нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарах ажилтан болон тухайн үйл ажиллагаанд хамаарах бүртгэл байрлаж байгаа байрлал. Үйл ажиллагааны төв нь хэвийн дуудлага хүлээн авах цэгээс илүү тогтвортой байдлын зэрэгтэй байдаг. (AN 6/II)</i>
Operation	Үйл ажиллагаа	An activity or group of activities which are subject to the same or similar hazards and which require a set of equipment to be specified, or the achievement and maintenance of a set of pilot competencies, to eliminate or mitigate the risk of such hazards. <i>Note.- Such activities could include, but would not be limited to, offshore operations, heli-hoist operations or emergency medical service.</i>	Тухайн аюулын эрсдэлийг арилгах, эсхүл бууруулахын тулд тусгайлсан багц төхөөрөмж, эсхүл нисгэгчийн өндөр ур чадварын гүйцэтгэл болон хадгалалтыг шаарддаг, ижил, эсхүл төстэй аюулд хамаарах ажиллагаа, эсхүл бүлэг ажиллагаа <i>Тэмдэглэл: Тухайн ажиллагаа нь офшор үйл ажиллагаа, нисдэг тэрэгний дүүжин үйл ажиллагаа, эмнэлгийн яаралтай тусламж (гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй) зэрэг үйл ажиллагааг хамаарч болно. (AN 6/III)</i>
Operational control	Нислэгийн үйл ажиллагааны удирдлага	The exercise of authority over the initiation, continuation, diversion or termination of a flight in the interest of the safety of the aircraft and the regularity and efficiency of the flight.	Агаарын хөлгийн аюулгүй байдал болон нислэгийг тогтмол, үр ашигтай гүйцэтгэх ашиг сонирхлын үүднээс нислэг эхлүүлэх, үргэлжлүүлэх, чиглэл өөрчлөх, эсхүл цуцлах эрх үүргийг хэрэгжүүлэх (AN 3; AN 6/I; AN 6/III; PANS-ATM)
Operational control communications	Үйл ажиллагааны удирдлагын холбоо	Communications required for the exercise of authority over the initiation, continuation, diversion or termination of a flight in the interest of the safety	Аюулгүй, тогтмол болон үр ашигтай байх зорилгоор нислэгийг эхлүүлэх, үргэлжлүүлэх,

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		of the aircraft and the regularity and efficiency of a flight.	даялах, эсхүл цуцлах эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай холбоо (AN 10/IV)
Operational credit	Үйл ажиллагааны кредит	A credit authorized for operations with an advanced aircraft enabling lower aerodrome operating minima than would normally be authorized for a basic aircraft, based upon the performance of advanced aircraft systems utilizing the available external infrastructure.	Гадна дэд бүтцийг ашигладаг сайжруулсан агаарын хөлгийн системийн үзүүлэлтэд суурилсан, ихэвчлэн үндсэн агаарын хөлөгт зөвшөөрдгөөс доогуур аэродромын үйл ажиллагааны минимал-олгодог сайжруулсан агаарын хөлгийн үйл ажиллагаанд зөвшөөрдөг кредит (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Operational flight plan	Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө	The operator's plan for the safe conduct of the flight based on considerations of aeroplane performance, other operating limitations and relevant expected conditions on the route to be followed and at the aerodromes concerned.	Тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэх зорилгоор нислэгийн замд болон аэродромд дагаж мөрдөх шаардлагатай, тухайн нисэх онгоцны үзүүлэлт, бусад үйл ажиллагааны хязгаарлалт болон таамаглаж байгаа бодит нөхцөлийн төсөөлөлд суурилан гаргасан, гэрчилгээ эзэмшигчийн төлөвлөгөө (AN 3; AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Operational personnel	Үйл ажиллагааны ажилтан	Personnel involved in aviation activities who are in a position to report safety information. <i>Note.- Such personnel include, but are not limited to: flight crews; air traffic controllers; aeronautical station operators; maintenance technicians; personnel of aircraft design and manufacturing organizations; cabin crews; flight dispatchers, apron personnel and ground handling personnel.</i>	Аюулгүй байдлын мэдээллийг илтгэх үүрэгтэй нисэхийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан. <i>Тэмдэглэл: Дараах этгээд багтах ба тэдгээрээр хязгаарлагдахгүй: нисэх баг; нислэгийн хөдөлгөөний удирдагч; нислэгийн мэдээллийн ажилтан; техник үйлчилгээний ажилтан; агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх байгууллагын ажилтан; бүхээгийн ажилтан; нислэгийн диспатчер; аэрон болон газрын үйлчилгээний ажилтан. (AN 19)</i>
Operational planning	Үйл ажиллагааны төлөвлөлт	The planning of flight operations by an operator.	Агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагааны төлөвлөлт (AN 3)
Operations in performance Class 1	Хүчин чадал Ангилал-1-ийн үйл ажиллагаа	Operations with performance such that, in the event of a critical engine failure, performance is available to enable the helicopter to safely continue the flight to an appropriate landing area, unless the failure occurs prior to reaching the take-off decision point (TDP) or after passing the landing decision point (LDP), in which cases the helicopter must be	Хөөрөлтийн шийдвэр гаргах цэг (TDP) хүрэхээс өмнө, эсхүл буултын шийдвэр гаргах цэг (LDP) өнгөрсний дараа гарсан татгалзал нь тухайн нисдэг тэрэг татгалзсан хөөрөлтийн, эсхүл буултын талбайд буух чадвартай байхаас бусад тохиолдолд, эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан үед нислэгийг тохиромжтой буултын талбай хүртэл

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		able to land within the rejected take-off or landing area.	аюулгүй үргэлжлүүлж чадах хүчин чадалтай нисдэг тэрэгний үйл ажиллагаа. (AN 6/III)
Operations in performance Class 2	Хүчин чадал Ангилал-2-ын үйл ажиллагаа	Operations with performance such that, in the event of critical engine failure, performance is available to enable the helicopter to safely continue the flight to an appropriate landing area, except when the failure occurs early during the take-off manoeuvre or late in the landing manoeuvre, in which cases a forced landing may be required.	Хөөрөлтийн маневрын үед, эсхүл буултын маневрын төгсгөлд гарсан татгалзал нь аргагүйдсэн буулт үйлдэхийг шаарддаг байхаас бусад тохиолдолд, эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан үед нислэгийг тохиромжтой буултын талбай хүртэл аюулгүй үргэлжлүүлж чадах хүчин чадалтай нисдэг тэрэгний үйл ажиллагаа. (AN 6/III)
Operations in performance Class 3	Хүчин чадал Ангилал-3-ын үйл ажиллагаа	Operations with performance such that, in the event of an engine failure at any time during the flight, a forced landing will be required.	Нислэгийн аль ч үед хөдөлгүүр татгалзсан үед аргагүйдсэн буулт үйлдэхийг шаарддаг хүчин чадалтай нисдэг тэрэгний үйл ажиллагаа. (AN 6/III)
Operations manual	Үйл ажиллагааны заавар	A manual containing procedures, instructions and guidance for use by operational personnel in the execution of their duties.	Үйл ажиллагааны ажилтан ажил үүрэг гүйцэтгэхдээ ашиглахад зориулсан журам, зааварчилгаа болон гарын авлагыг агуулсан заавар (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Operations personnel	Нислэгийн үйл ажиллагааны ажилтан	crew member, maintenance personnel and other flight operations officer	Нисэх багийн гишүүд, инженер техникийн ажилтан болон нислэгийн диспатчер (AN 1; AN 6)
Operations specifications	Үйл ажиллагааны тодорхойлолт	The authorizations including specific approvals, conditions and limitations associated with the air operator certificate and subject to the conditions in the operations manual.	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээтэй холбоотой, үйл ажиллагааны зааврын нөхцөлд заасны дагуу тогтоосон эрх, нөхцөл болон хязгаарлалт (AN 6/I; AN 6/III)
Operator	Үйл ажиллагаа эрхлэгч	A person, organization or enterprise engaged in or offering to engage in an aircraft operation. <i>Note.- In the context of remotely piloted aircraft, an aircraft operation includes the remotely piloted aircraft system.</i>	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл эрхлэхийг зорьж байгаа хувь хүн, эсхүл байгууллага <u>Тэмдэглэл:</u> Зайнаас удирддаг агаарын хөлгийн хувьд агаарын хөлгийн үйл ажиллагаа нь зайнаас удирддаг агаарын хөлгийн системийг багтаана. (AN 2)
Operator's maintenance control manual	Үйл ажиллагаа эрхлэгчийн техник үйлчилгээний хяналтын заавар	A document which describes the operator's procedures necessary to ensure that all scheduled and unscheduled maintenance is performed on the operator's aircraft on time and in a controlled and satisfactory manner.	Үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлөг дээр хийгдэх хуваарьт болон хуваарьт бус техник үйлчилгээг цаг хугацаанд нь, хяналттай бөгөөд шаардлага хангасан байдлаар гүйцэтгэдэг болохыг бататгахад шаардлагатай үйл ажиллагаа

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			эрхлэгчийн журмыг заасан баримт бичиг (AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Optimum conditions	Тохиромжтой нөхцөл	The combinations of altitude and airspeed within the approved operating envelope defined in the aeroplane flight manual that provides the highest specific air range value at each reference aeroplane mass.	Тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт тодорхойлсон зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны хүрээнд нисэх онгоцны нэгж масст харьцуулсан хамгийн их харьцуулсан алслалтыг өгдөг өндрийн-түвшин болон агаарын хурдны комбинац (AN 16/III)
Organization responsible for the type design	Маягийн загварыг хариуцах байгууллага	The organization that holds the type certificate, or equivalent document, for an aircraft, engine or propeller type, issued by a Contracting State.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийн хувьд, Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичиг эзэмшдэг байгууллага (AN 8)
Origination (aeronautical data or aeronautical information)	Эх үүсвэр (нисэхийн өгөгдөл, эсхүл мэдээлэл)	The creation of the value associated with new data or information or the modification of the value of existing data or information.	Шинэ өгөгдөл, эсхүл мэдээлэлтэй холбоотой бүтээгдэхүүн бий болгох, эсхүл байгаа өгөгдөл, эсхүл мэдээллийн үнэ цэнд сайжруулалт хийх (AN 15)
Originator (aeronautical data or aeronautical information)	Анхдагч байгууллага (нисэхийн өгөгдөл, эсхүл мэдээлэл)	An entity that is accountable for data or information origination and/or from which the AIS organization receives aeronautical data and aeronautical information.	Өгөгдөл, эсхүл мэдээллийн эх үүсвэрийг хариуцдаг ба/эсхүл НМУ-ний байгууллага нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээллийг хүлээн авдаг байгууллага (AN 15)
Ornithopter	Орнитоптер	A heavier-than-air aircraft supported in flight chiefly by the reactions of the air on planes to which a flapping motion is imparted.	Дэвэх хөдөлгөөний тусламжтайгаар агаар онгоцтой харилцан үйлчилснээр ихэнх өргөх хүчээ үүсгэн нислэгт тогтдог агаараас хүнд агаарын хөлөг (AN 7)
Orphan aircraft type	Өнчирсэн агаарын хөлгийн маяг	An aircraft which has its Type Certificate revoked by the State of Design, and no longer has a designated State of Design i.a.w Annex 8. These aircraft do not meet the Standards of Annex 8.	Зохион бүтээгч улс нь Маягийн гэрчилгээг хүчингүй болгосон болон Annex 8-ын дагуу хариуцсан Зохион бүтээгч Улс байхгүй болсон агаарын хөлөг. Эдгээр агаарын хөлөг нь Annex 8-ын стандартыг хангадаггүй. (AN 8)
Orthometric height	Ортометрийн өндөр	Height of a point related to the geoid, generally presented as an MSL elevation.	Ихэвчлэн MSL-ийн өндөрлөгөөр илэрхийлдэг, геоидтой холбоотой цэгийн өндөр (AN 4; AN 14/I; AN 15)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Outer main gear wheel span (OMGWS)	Гадна үндсэн дугуй хоорондын зай (OMGWS)	The distance between the outside edges of the main gear wheels.	Үндсэн дугуйн гадна талын ирмэг хоорондын зай (AN 14/I)
Overpack	Гадуур боодол	An enclosure used by a single shipper to contain one or more packages and to form one handling unit for convenience of handling and stowage. <i>Note.- A unit load device is not included in this definition.</i>	Хадгалах болон тээвэрлэхэд тохиромжтой, тээвэрлэлтийн нэг нэгж болгон нэг, эсхүл түүнээс олон баглаа боодлыг багтаадаг ганц илгээгчийн ашигладаг баглаа <i>Тэмдэглэл:</i> Ачилтын нэгж төхөөрөмж нь энэ тодорхойлолтод ороогүй. (AN 18)
Oxides of nitrogen	Азотын исэл	The sum of the amounts of the nitric oxide and nitrogen dioxide contained in a gas sample calculated as if the nitric oxide were in the form of nitrogen dioxide.	Хийн дээжид агуулагдсан азотын хүчлийн ислийг (NO) азотын диоксидын (NO ₂) хэлбэрт байгаа гэж тооцоолсон NO ба NO ₂ -ын хэмжээний нийлбэр (AN 16/II)
Package	Баглаа боодол	The complete product of the packing operation consisting of the packaging and its contents prepared for transport.	Тээвэрлэлтэд зориулж бэлдсэн баглаа боодлын иж бүрдэл болон түүний агууламжаас бүрдсэн, савлах үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн (AN 18)
Packaging	Баглаа боодлын иж бүрдэл	Receptacles and any other components or materials necessary for the receptacle to perform its containment function. <i>Note.- For radioactive material, see Part 2, paragraph 7.2 of the Technical Instructions.</i>	Агуулагдсан эд зүйлс болон бодисыг найдвартай, аюулгүй хадгалах зориулалт бүхий аливаа хэрэгсэл болон бусад эд зүйл, эсхүл материал <i>Тэмдэглэл:</i> Радио идэвхт материалын хувьд Техникийн зааварчилгааны "Part 2, paragraph 7.2"-е хар. (AN 18)
Pascal	Паскаль (Па)	The pressure or stress of 1 newton per square metre.	Ньютоныг 1 м ² талбайд хуваасантай тэнцүү даралт, эсхүл механик хүчдэл (AN 5)
Passenger aircraft	Зорчигч тээврийн агаарын хөлөг	An aircraft that carries any person other than a crew member, an operator's employee in an official capacity, an authorized representative of an appropriate national authority or a person accompanying a consignment or other cargo.	Нисэх багийн гишүүд, албан үүргээ гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийн ажилтан, холбогдох үндэсний эрх бүхий байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл илгээх бараа, эсхүл бусад ачаа дагалдагч этгээдээс бусад аливаа этгээдийг тээвэрлэж байгаа агаарын хөлөг (AN 18)
Passenger amenities	Зорчигчийн тав тух	Facilities provided for passengers which are not essential for passenger processing.	Зорчигчийн зайлшгүй үйлчилгээнээс бусад зорчигчийн тав тухыг хангах байгууламж (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Passenger Data Single Window	Зорчигчийн өгөгдлийн нэг цонх	A facility that allows parties involved in passenger transport by air to lodge standardized passenger information (i.e. API, iAPI and/or PNR) through a single data entry point to fulfil all regulatory requirements relating to the entry and/or exit of passengers that may be imposed by various agencies of the Contracting State.	Зорчигчийн орох ба/эсхүл гарахтай холбоотой, Хэлэлцэн тохиролцогч Улсын зарим байгууллага тогтоож болох зохицуулалтын бүх шаардлагыг хангах зорилгоор өгөгдөл оруулах нэг цэгээр дамжуулан, агаараар зорчигч тээвэрлэдэг талуудад стандартчилсан зорчигчийн мэдээллийг (API, iAPI ба/эсхүл зорчигчийн нэрийн бүртгэл (Passenger Name Record) гэх мэт) оруулах боломжийг олгодог төхөөрөмж (AN 9)
Pathway	Үйлдвэрлэх явц	A specific combination of feedstock and conversion process used for the production of aviation fuel.	Нисэхийн түлшний үйлдвэрлэлд ашигладаг түүхий эд болон нэрэлтийн үйл явцын тусгай комбинац (AN 16/IV)
Pavement classification rating (PCR)	Хучилтын ангиллын зэрэглэл (PCR)	A number expressing the bearing strength of a pavement.	Хучилтын даацын чадварыг илэрхийлдэг тоо (AN 14/I)
Performance Class 1 helicopter	Хүчин чадлын Ангилал-1 нисдэг тэрэг	A helicopter with performance such that, in case of engine failure, it is able to land on the rejected take-off area or safely continue the flight to an appropriate landing area.	Хөдөлгүүр татгалзсан тохиолдолд татгалзсан хөөрөлтийн талбайд буух, эсхүл нислэгийг тохиромжтой буултын талбай хүртэл аюулгүй үргэлжлүүлж чадах хүчин чадалтай нисдэг тэрэг (AN 8)
Performance Class 2 helicopter	Хүчин чадлын Ангилал-2 нисдэг тэрэг	A helicopter with performance such that, in case of engine failure, it is able to safely continue the flight, except when the failure occurs prior to a defined point after take-off or after a defined point before landing, in which cases a forced landing may be required.	Хөөрөлтийн дараах тогтоосон цэг хүрэхээс өмнө, эсхүл буултын өмнөх тогтоосон цэгийг өнгөрсний дараа гарсан татгалзал нь аргагүйдсэн буулт үйлдэхийг шаарддаг байхаас бусад тохиолдолд, хөдөлгүүр татгалзсан үед нислэгийг аюулгүй үргэлжлүүлж чадах хүчин чадалтай нисдэг тэрэг (AN 8)
Performance Class 3 helicopter	Хүчин чадлын Ангилал-3 нисдэг тэрэг	A helicopter with performance such that, in case of engine failure at any point in the flight profile, a forced landing must be performed.	Нислэгийн аль ч үе шатанд хөдөлгүүр татгалзсан тохиолдолд, аргагүйдсэн буулт заавал үйлдэх шаардлагатай хүчин чадалтай нисдэг тэрэг (AN 8)
Performance criteria	Чадавхын шалгуур	Statements used to assess whether the required levels of performance have been achieved for a competency. A performance criterion consists of	Ур чадварын хувьд, тухайн хүний чадавх шаардлагатай түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийхэд ашигладаг тодорхойлолт. Гүйцэтгэлийн

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		an observable behaviour, condition(s) and a competency standard.	шалгуур нь таньж тогтоогдохуйц зан төлөв, нөхцөл болон ур чадварын стандартаас бүрдэнэ. (AN 1)
Performance model	Үзүүлэлт тооцоолох загвар	An analytical tool or method validated from corrected flight test data that can be used to determine the specific air range values for calculating the CO ₂ emissions evaluation metric value at the reference conditions.	Тогтоосон нөхцөлд CO ₂ -хийн ялгаруулалтын хэмжээг тооцох дүн шинжилгээний арга, эсхүл харьцуулсан алслалтын хэмжээг тодорхойлоход ашигладаг шалгах нислэгийн зарлуулсан өгөгдлөөр баталгаажуулсан арга (AN 16/III)
Performance-based aerodrome operating minima (PBAOM)	Үзүүлэлтэд суурилсан аэродромын үйл ажиллагааны минима (PBAOM)	A lower aerodrome operating minima, for a given take-off, approach or landing operation, than is available when using a basic aircraft.	Үндсэн агаарын хөлөг ашиглахад зориулсан минима-гаас доогуур тухайн хөөрөлт, ойртолт, эсхүл буултын аэродромын үйл ажиллагааны минима (AN 6/I, AN 6/II, AN 6/III)
Performance-based communication (PBC)	Үзүүлэлтэд суурилсан холбоо	Communication based on performance specifications applied to the provision of ATS.	НХҮ-ний хангалтад ашигладаг үзүүлэлтийн шаардлагад суурилсан холбоо (AN 6/I; AN 11)
Performance-based navigation (PBN)	Үзүүлэлтэд суурилсан навигаци (PBN)	Area navigation based on performance requirements for aircraft operating along an ATS route, on an instrument approach procedure or in a designated airspace. <i>Note.- Performance requirements are expressed in navigation specifications (RNAV specification, RNP specification) in terms of accuracy, integrity, continuity, availability and functionality needed for the proposed operation in the context of a particular airspace concept.</i>	Хэрэглэлийн ойртолтын журамд, эсхүл тогтоосон агаарын зайд, НХҮ-тэй нислэгийн замд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт зориулсан, үзүүлэлтийн шаардлагад суурилсан бүсийн навигаци <i>Тэмдэглэл: Навигацийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийн шаардлага (RNAV тодорхойлолт, RNP тодорхойлолт) нь тодорхой агаарын зайн зарчмын хүрэн дэх үйл ажиллагаанд хэрэгтэй нарийвчлал, бүрэн бүтэн байдал, тасралтгүй байдал, бэлэн байдал болон ажиллагааны чадварын нөхцөлөөр илэрхийлэгдэнэ. (AN 3; AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 10; AN 11; AN 15)</i>
Performance-based surveillance (PBS)	Үзүүлэлтэд суурилсан ажиглалт	Surveillance based on performance specifications applied to the provision of ATS.	НХҮ-ний хангалтад ашигладаг үзүүлэлтийн шаардлагад суурилсан ажиглалт (AN 6/I, AN 6/II, AN 6/III, AN 11, AN 15)
Person with disabilities	Хөгжлийн бэрхшээлтэй этгээд	Any person whose mobility is reduced due to a physical incapacity (sensory or locomotor), an intellectual deficiency, age, illness or any other cause of disability when using transport and whose	Тээврийн үйл ажиллагааны үед биеийн чадваргүй (мэдрэхүй болон хөдөлгөөний), оюуны хомсдолтой, нас, өвчин, эсхүл бусад шалтгаанаар чадвараа алдсаны улмаас явах чадвар нь

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		situation needs special attention and the adaptation to the person's needs of the services made available to all passengers.	хязгаарлагдсан болон тухайн этгээдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, ердийн зорчигчдод үзүүлдэг үйлчилгээнээс илүү тусгайлсан анхаарал халамж шаарддаг аливаа этгээд (AN 9)
Pilot (to)	Нисэх/жолоодох	To manipulate the flight controls of an aircraft during flight time.	Нислэгийн үед агаарын хөлгийн нислэгийн удирдлагыг жолоодож, удирдах (AN 1)
Pilot flying (PF)	Идэвхтэй нисгэгч	The pilot whose primary task is to control and manage the flight path. The secondary tasks of the PF are to perform non-flight path related actions (radio communications, aircraft systems, other operational activities, etc.) and to monitor other crew members.	Тухайн үе шатанд нислэгийг удирдах, зохицуулах үндсэн үүрэгтэй нисгэгчийг; Мөн идэвхтэй нисгэгч нь радио холбоо барих, агаарын хөлгийн системийг хянах, бусад үйл ажиллагааг гүйцэтгэх багийн бусад гишүүдэд хяналт тавих үүрэгтэй. (AN 1)
Pilot monitoring (PM)	Ажиглагч нисгэгч	The pilot whose primary task is to monitor the flight path and its management by the PF. The secondary tasks of the PM are to perform non-flight path related actions (radio communications, aircraft systems, other operational activities, etc.) and to monitor other crew members.	Тухайн нислэгийн үйл явцад хяналт тавих ба НХУ-тай радио холбоо барих, агаарын хөлгийн системийг хянах, бусад үйл ажиллагааг гүйцэтгэх багийн бусад гишүүдэд хяналт тавих үүрэгтэй нисгэгч; Мөн ажиглагч нисгэгч нь нислэгийн төлөвлөгөөг мөрдөх, түлшинд хяналт тавих, шалгах-хуудсыг унших болон газардах анги, далавчны флапс удирдах үүрэгтэй. (AN 1)
Pilot-in-command	Хөлгийн дарга	(A)The pilot designated by the operator, or in the case of general aviation, the owner, as being in command and charged with the safe conduct of a flight. (B)The pilot responsible for the operation and safety of the aircraft during flight time.	(A)Нислэгийг удирдан, аюулгүй гүйцэтгэх үүрэг хүлээсэн, агаарын тээвэрлэгчийн, эсхүл ерөнхий зориулалтын нисэхийн хувьд агаарын хөлөг эзэмшигчийн томилсон нисгэгч (AN 1, AN 2, AN 3, AN 6/I, AN 6/II, AN 6/III, AN 11, AN 18, PANS-ATM) (B)Нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлыг хариуцсан нисгэгч (AN 9)
Pilot-in-command under supervision	Шалгуулж байгаа хөлгийн дарга	Co-pilot performing, under the supervision of the pilot-in-command, the duties and functions of a pilot-in-command, i.a.w a method of supervision acceptable to the Licensing Authority.	Агаарын хөлгийн даргын хяналтад үнэмлэх олгох эрх бүхий байгууллагын хүлээн зөвшөөрөхүйц хяналтын аргачлалын дагуу хөлгийн даргын ажил, үүргийг гүйцэтгэж байгаа хамтран нисгэгч (AN 1)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Point light	Цэгэн гэрэл	A luminous signal appearing without perceptible length.	Богино урттай гэрлийн дохио (AN 4)
Point of no return	Буцах боломжгүй болох цэг	The last possible geographic point at which an aircraft can proceed to the destination aerodrome as well as to an available en-route alternate aerodrome for a given flight.	тухайн цэгээс нисэх онгоц нисэн очих аэродром руу, мөн тухайн нислэгт өгөгдсөн нислэгийн замын дагуух бэлтгэл аэродром руу нисэн хүрч чадах газар зүйн сүүлчийн боломжит цэг (AN 6/I; AN 6/II)
Point-in-space (PinS) approach	Сансрын цэгээр (PinS) үйлдэх ойртолт	The point-in-space approach is based on GNSS and is an approach procedure designed for helicopter only. It is aligned with a reference point located to permit subsequent flight manoeuvring or approach and landing using visual manoeuvring in adequate visual conditions to see and avoid obstacles.	PinS-ээр үйлдэх ойртолт нь GNSS-д суурилдаг ба энэ ойртолтын журмыг зөвхөн нисдэг тэргэнд ашигладаг. Энэ нь саадыг харах болон түүнээс зайлсхийхэд хангалттай ил харааны нөхцөлд ил харааны маневр ашиглан дараагийн нислэгийн маневр, эсхүл ойртолт болон буултыг гүйцэтгэх боломж олгохоор байрлуулсан хяналтын цэгтэй холбогддог. (AN 14/II)
Point-in-space (PinS) visual segment	Сансрын цэгийн (PinS) ил харааны сегмент	This is the segment of a helicopter PinS approach procedure from the MAPt to the landing location for a PinS “proceed visually” procedure. This visual segment connects the PinS to the landing location. <i>Note.- The procedure design criteria for a PinS approach and the detailed design requirements for a visual segment are established in the Procedures for Air Navigation Services - Aircraft Operations (PANS-OPS, Doc 8168).</i>	Энэ нь PinS “ил хараагаар үргэлжлүүлэх” журмын хувьд MAPT-аас буултын байрлал хүртэл нисдэг тэргээр PinS ашиглан үйлдэх ойртолтын журмын сегмент <u>Тэмдэглэл:</u> PinS-ойртолтын журам зохиолтын шалгуур болон ил харааны сегмент зохиох дэлгэрэнгүй шаардлагыг “Procedures for Air Navigation Services - Aircraft Operations (PANS-OPS, Doc 8168)”-д заасан. (AN 14/II)
Point-to-point	Цэгээс цэгт	Pertaining or relating to the interconnection of two devices, particularly end-user instruments. A communication path of service intended to connect two discrete end-users; as distinguished from broadcast or multipoint service.	Хоёр төхөөрөмжийн холболттой холбоотой, эсхүл хамааралтай тухайн төгсгөлийн хэрэглэгчийн хэрэгсэл. Хоёр тусдаа төгсгөлийн хэрэглэгчийг холбох зориулалттай, радио нэвтрүүлгийн, эсхүл олон хэрэглэгчтэй үйлчилгээнээс ялгаатай үйлчилгээний холбох зам (AN 10/III)
Portrayal	Дүрслэл	Presentation of information to humans (ISO 19117*).	Хүмүүст хүргэж байгаа мэдээллийн танилцуулга (ISO 19117*) (AN 4; AN 15)
Position (geographical)	Байршил (газар зүйн)	Set of coordinates (latitude and longitude) referenced to the mathematical reference ellipsoid	Газрын гадаргуу дээрх цэгийн байршлыг тодорхойлох математик аргачлалын эллипсоидод

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		which define the position of a point on the surface of the Earth.	үндэслэн уртраг ба өргөргөөр тодорхойлох солбицол (AN 4; 15)
Post spacing	Өндөрлөг хоорондын зай	Angular or linear distance between two adjacent elevation points.	Зэргэлдээ хоёр өндөрлөгийн хоорондын өнцгийн, эсхүл шугаман зай (AN 15)
Powered-lift	Эгц дээш хөөрч, буудаг нисэх онгоц	A heavier-than-air aircraft capable of vertical take-off, vertical landing, and low-speed flight, which depends principally on engine-driven lift devices or engine thrust for the lift during these flight regimes and on non-rotating aerofoil(s) for lift during horizontal flight.	Эгц дээш хөөрөх, буух болон бага хурдтай нислэг үйлдэх чадвартай ба эдгээр нислэгийн горимд хөдөлгүүрээр хөтөлдөг өргөх хүчний төхөөрөмж, эсхүл хөдөлгүүрийн татах хүчээр өргөх хүч үүсгэх ба хэвтээ нислэгт хөдөлгөөнгүй гадаргуугаар өргөх хүч үүсгэх зарчмаар агаарт нисдэг агаараас хүнд агаарын хөлөг (AN 1)
Powerplant	Хүчний төхөөрөмж	The system consisting of all the engines, drive system components (if applicable), and propellers (if installed), their accessories, ancillary parts, and fuel and oil systems installed on an aircraft but excluding the rotors for a helicopter.	Агаарын хөлөгт суурилуулсан бүх хөдөлгүүр, хөтлөх системийн бүрдэл хэсэг (хэрэв хамааралтай бол), сэнс (хэрэв суурилуулсан бол), тэдгээрийн туслах тоноглол, туслах эд анги, түлш болон тосны систем. Гэхдээ үүнд нисдэг тэрэгний үндсэн ротор багтахгүй (AN 8)
Precision	Нарийвчлал	The smallest difference that can be reliably distinguished by a measurement process. <i>Note.- In reference to geodetic surveys, precision is a degree of refinement in performance of an operation or a degree of perfection in the instruments and methods used when taking measurements.</i>	Хэмжилтийн явцад найдвартай тодорхойлж чадах хамгийн бага ялгаа <i>Тэмдэглэл: Геодезийн судалгааны хувьд, нарийвчлал нь үйл ажиллагааны гүйцэтгэлийн бүрэн төгс байдал, эсхүл хэмжилт хийхэд ашигладаг багаж хэрэгсэл болон аргачлалын оновчтой байдал. (AN 15)</i>
Precision approach procedure	Нарийвчлалтай ойртолтын журам	An instrument approach procedure utilizing azimuth and glide path information provided by ILS or PAR.	ILS, эсхүл PAR-ийн азимут болон глиссадын мэдээллийг ашиглан гүйцэтгэдэг хэрэглэлийн ойртолтын журам (AN 4)
Precision approach runway	Нарийвчлалтай ойртолтын ХБЗ	see <i>Instrument runway</i> .	Хэрэглэлийн ХБЗ-г үз (AN 14/I)
Pre-flight information bulletin (PIB)	Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол (PIB)	A presentation of current NOTAM information of operational significance, prepared prior to flight.	Нислэгийн өмнө бэлтгэсэн, нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой, хүчинтэй NOTAM мэдээллийн танилцуулга (AN 15)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Preliminary report	Урьдчилсан тайлан	The communication used for the prompt dissemination of data obtained during the early stages of the investigation.	Шинжлэн шалгах ажиллагааны эхний үе шатанд олдсон мэдээллийг яаралтай дамжуулахад ашигладаг тайлан (AN 13)
Pressure-altitude	Өндрийн-түвшний даралт	An atmospheric pressure expressed in terms of altitude which corresponds to that pressure in the Standard Atmosphere.	Тухайн стандарт атмосферийн даралтад тохирсон, өндрийн-түвшний утгаар илэрхийлдэг атмосферийн даралт (AN 2; AN 6/I; AN 8; PANS-ATM)
Prevailing visibility	Давамгайлах хараа	The greatest visibility value, observed i.a.w the definition of "visibility", which is reached within at least half the horizon circle or within at least half of the surface of the aerodrome. These areas could comprise contiguous or non-contiguous sectors. <i>Note.- This value may be assessed by human observation and/or instrumented systems. When instruments are installed, they are used to obtain the best estimate of the prevailing visibility.</i>	Тэнгэрийн хаяаны тойргийн хагасаас багагүй хүрээнд, эсхүл аэродромын гадаргуугийн хагасаас багагүй хүрээнд, "хараа"-ны тодорхойлолтын дагуу тогтоосон хамгийн сайн харааны хэмжээ. Эдгээр хүрээ нь үргэлжилсэн, эсхүл хэсэгчилсэн байж болно. <i>Тэмдэглэл: Энэ нь хүний ажиглалтаар ба/эсхүл хэрэгслээр тодорхойлсон утга байж болно. Хэрэгсэл ашигласан тохиолдолд давамгайлах харааг илүү оновчтой тодорхойлно гэж үзнэ.</i> (AN 3)
Primary frequency	Үндсэн давтамж	The radiotelephony frequency assigned to an aircraft as a first choice for air-ground communication in a radiotelephony network.	Радио-холбооны сүлжээнд агаар-газар холбооны нэгдүгээр сонголт болгон агаарын хөлөгт оноосон радио-холбооны давтамж (AN 10/II)
Primary means of communication	Холбооны үндсэн хэрэгсэл	The means of communication to be adopted normally by aircraft and ground stations as a first choice where alternative means of communication exist.	Холбооны нөөц хэрэгсэл байгаа үед эхний сонголтоор агаарын хөлөг болон газрын станцын хооронд холбоо барихад ихэвчлэн ашигладаг холбооны хэрэгсэл (AN 10/II; AN 10/V)
Primary runway(s)	Үндсэн ХБЗ	Runway(s) used in preference to others whenever conditions permit.	Таатай нөхцөлд бусад ХБЗ-аас ашиглахад илүү тохиромжтой ХБЗ (AN 14/I)
Printed communications	Хэвлэгдмэл холбоо	Communications which automatically provide a permanent printed record at each terminal of a circuit of all messages which pass over such circuit.	Тухайн хэлхээгээр дайран өнгөрч байгаа бүх мэдээний хэлхээний терминал бүрд бодитоор хэвлэгдсэн бүртгэлийг автоматаар гаргадаг холбоо (AN 11)
Problematic use of substances	Бодисыг хэтрүүлэн хэрэглэх	The use of one or more psychoactive substances by aviation personnel in a way that:	Нисэхийн ажилтан нэг, эсхүл түүнээс олон сэтгэцэд нөлөөлөх бодисыг дараах байдлаар хэрэглэх:

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>a) constitutes a direct hazard to the user or endangers the lives, health or welfare of others; and/or</p> <p>b) causes or worsens an occupational, social, mental or physical problem or disorder.</p>	<p>a) хэрэглэгчдэд шууд аюул учруулах, эсхүл бусдын амь нас, эрүүл мэнд, эсхүл амар амгаланд аюултай байх; ба/эсхүл</p> <p>b) мэргэжлийн, нийгмийн, сэтгэцийн, эсхүл бие махбодын хүндрэл, эсхүл эмгэг үүсгэх, эсхүл муутгах. (AN 1, AN 2)</p>
Procedure altitude / height	Өндрийн-түвшний / өндрийн журам	A published altitude/height used in defining the vertical profile of a flight procedure, at or above the minimum obstacle clearance altitude/height where established.	Хэрэв минимум саадыг давах өндрийн-түвшин / өндрийг тогтоосон бол, уг өндрийн-түвшин / өндөрт, эсхүл түүнээс дээш нислэгийн журмын босоо профайлыг тогтооход ашигладаг, зарлагдсан өндрийн-түвшин / өндөр (AN 4; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Procedure turn	Стандарт-эргэлт	<p>A manoeuvre in which a turn is made away from a designated track followed by a turn in the opposite direction to permit the aircraft to intercept and proceed along the reciprocal of the designated track.</p> <p><i>Note 1.- Procedure turns are designated “left” or “right” according to the direction of the initial turn.</i></p> <p><i>Note 2.- Procedure turns may be designated as being made either in level flight or while descending, according to the circumstances of each individual procedure.</i></p>	<p>Агаарын хөлөг тогтоосон замын хайрцагт орж түүний дагуу нисэх зорилгоор ниссэн гарах замаас гарч эсрэг чиглэлд эргэлт хийх маневр.</p> <p><i>Тэмдэглэл 1: Үндсэн-эргэлтийн чиглэлээс шалтгаалан “зүүн”, эсхүл “баруун” гэж стандарт-эргэлтийг тогтоодог.</i></p> <p><i>Тэмдэглэл 2: Стандарт-эргэлтийг тухайн журмын нөхцөл байдалд нийцүүлэн түвшинээ хадгалах, эсхүл өндөр алдах нислэгийн аль ч үед гүйцэтгэж болохоор боловсруулна. (AN 4; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)</i></p>
Prognostic chart	Прогноз зураг	A forecast of a specified meteorological element(s) for a specified time or period and a specified surface or portion of airspace, depicted graphically on a chart.	Өгөгдсөн цаг, эсхүл хугацаанд болон өгөгдсөн гадаргуу, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан газрын зураг дээр зураглал хэлбэрээр дүрслэн үзүүлсэн цаг уурын элементийн урьдчилсан мэдээ (AN 3)
Prohibited area	Хориотой бүс	An airspace of defined dimensions, above the land areas or territorial waters of a State, within which the flight of aircraft is prohibited.	Агаарын хөлгийн нислэгийг хориглодог, тухайн Улсын газар, эсхүл усан хилийн дээгүүр тодорхой хэмжээтэй тогтоосон агаарын зай (AN 2; AN 4; AN 11; AN 15)
Protected flight zones	Хамгаалагдсан нислэгийн зоон	Airspace specifically designated to mitigate the hazardous effects of laser radiation.	Лазерын гэрлийн аюултай нөлөөг багасгах зорилгоор тусгайлан тогтоосон агаарын зай (AN 14/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Protected service volume	Хамгаалагдсан үйлчилгээний хэмжээ	A part of the facility coverage where the facility provides a particular service i.a.w relevant SARPs and within which the facility is afforded frequency protection.	Холбогдох стандарт, зөвлөмжийн дагуу тодорхой үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тухайн байгууламж нь уг хамгаалалтын хүрээнд давтамжийн хамгаалалттай байх ёстой байгууламжийн хамгаалалтын хэсэг (AN 10/I)
Protection area	Хамгаалалтын талбай	A defined area surrounding a stand intended to reduce the risk of damage from helicopters accidentally diverging from the stand.	Нисдэг тэрэг санамсаргүй байдлаар зогсоолоос хазайн гарах хохирлын эрсдлийг багасгах зорилгоор зогсоолын хүрээлсэн тогтоосон талбай (AN 14/II)
Psychoactive substances	Сэтгэцэд нөлөөлөх бодис	Alcohol, opioids, cannabinoids, sedatives and hypnotics, cocaine, other psychostimulants, hallucinogens, and volatile solvents, whereas coffee and tobacco are excluded.	Согтууруулах ундаа, опиоид, каннионид, тайвшруулах, нойрсуулах, кокаин, бусад сэтгэцийн идэвхжүүлэгч, галлюциноген болон дэгдэмхий уусмал, гэхдээ тамхи болон кофе эдгээрт хамаарахгүй (AN 1; AN 2; AN 6/I; AN 6/II; AN 6/III)
Public authorities	Төрийн эрх бүхий байгууллага	The agencies or officials of a Contracting State responsible for the application and enforcement of the particular laws and regulations of that State which relate to any aspect of these Standards and Recommended Practices.	Стандарт, зөвлөмжтэй холбоотой аливаа асуудлаар тухайн Улсын хууль, тогтоомжийн хэрэглээ болон албадан хэрэгжүүлэлтийг хариуцсан Хэлэлцэн тохиролцогч Улсын байгууллага, эсхүл албан тушаалтан (AN 9)
Public health emergency of international concern	Олон улсын анхаарал татах нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл	An extraordinary event which is determined, as provided in the <i>International Health Regulations (2005)</i> of the World Health Organization: (i) to constitute a public health risk to other States through the international spread of disease and (ii) to potentially require a coordinated international response.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Олон улсын эрүүл мэндийн дүрэмд (2005 оны) заасны дагуу тогтоосон дараах онцгой үйл явдал: (i) олон улсын хэмжээнд өвчин тархсанаар бусад Улсын нийтийн эрүүл мэндэд эрсдэл учруулах; (ii) олон улсын хэмжээнд зохион байгуулалттай сөрөг арга хэмжээ авахыг бодиттойгоор шаардах. (AN 9)
Public health risk	Нийтийн эрүүл мэндийн эрсдэл	A likelihood of an event that may affect adversely the health of human populations, with an emphasis on one which may spread internationally or may present a serious and direct danger.	Хүн амын эрүүл мэндэд аюултайгаар нөлөөлөхүйц, үе шаттайгаар олон улсад түгэн тархаж, эсхүл шууд ноцтой аюултай байж болзошгүй үйл явдал (AN 9)
Quality	Чанар	Degree to which a set of inherent characteristics fulfils requirements (ISO 9000*).	Үндсэн үзүүлэлтийн багц нь шаардлага (ISO 9000*) хангасан байдлыг илэрхийлдэг түвшин

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>Note 1.- The term "quality" can be used with adjectives such as poor, good or excellent.</p> <p>Note 2.- "Inherent", as opposed to "assigned", means existing in something, especially as a permanent characteristic.</p>	<p><u>Тэмдэглэл 1:</u> "Чанар" гэсэн нэр томъёог муу, сайн, эсхүл маш сайн гэсэн тэмдэг нэртэй хэрэглэдэг.</p> <p><u>Тэмдэглэл 2:</u> "Үндсэн" гэдэг ойлголт нь "олдмол" гэдэг ойлголтын эсрэг утгыг агуулдаг, аливаа зүйл дотор байдаг ба ялангуяа байнгын үзүүлэлтийг агуулдаг ойлголт. (AN 15)</p>
Quality assurance	Чанар баталгаажуулалт	Part of quality management focused on providing confidence that quality requirements will be fulfilled (ISO 9000*).	Чанарын шаардлагыг бүрэн хангана гэсэн итгэл бий болгоход чиглэсэн чанарын удирдлагын хэсэг (ISO 9000*) (AN 3; AN 15)
Quality control	Чанарын хяналт	Part of quality management focused on fulfilling quality requirements (ISO 9000*).	Чанарын шаардлагыг бүрэн хангахад чиглэсэн, чанарын удирдлагын хэсэг (ISO 9000*) (AN 3; AN 15)
Quality management	Чанарын удирдлага	Coordinated activities to direct and control an organization with regard to quality (ISO 9000*).	Чанарыг зорилго болгон байгууллагыг чиглүүлэх болон удирдах зохицуулалттай үйл ажиллагаа (ISO 9000*) (AN 3; AN 15)
Quality system	Чанарын тогтолцоо	<p>(A) Documented organizational procedures and policies; internal audit of those policies and procedures; management review and recommendation for quality improvement.</p> <p>(B) procedures and instructions to the extent necessary to assure the quality of the test and/or calibration results.</p>	<p>(A) Баримтжуулсан байгууллагын журам болон бодлого; эдгээр журам болон бодлогын дотоод аудит; чанарыг сайжруулах зорилготой удирдлагын дүгнэлт болон зөвлөмж (AN 1)</p> <p>(B) Тестийн чанар ба/эсхүл тохируулгын үр дүнг бататгахад шаардлагыг хангах зорилгоор өөрийн бодлого, тогтолцоо, хөтөлбөр, журам болон зааварчилгааг баримтжуулсан эрх бүхий лабораторийн удирдлагын тогтолцоо (AN 16/II)</p>
Quarantine	Хорио цээр	The restriction of activities and/or separation from others of suspect persons who are not ill or of suspect baggage, containers, conveyances or goods in such a manner as to prevent the possible spread of infection or contamination.	Халдвар, эсхүл бохирдлын болзошгүй тархалтаас сэргийлэх зорилгоор өвдөөгүй боловч сэжиг бүхий этгээдүүд, эсхүл сэжиг бүхий тээш, контейнер, илгээмж, эсхүл бараанд хорио хязгаарлалт тогтоох ба/эсхүл бусдаас тусгаарлах ажиллагаа (AN 9)
Radian	Радиан	The plane angle between two radii of a circle which cut off on the circumference an arc equal in length to the radius.	Радиусын урттай тэнцүү нумыг огтолдог тойргийн хоёр радиус хоорондын хавтгай өнцөг (AN 5)
Radio bearing	Радио чиглэл	The angle between the apparent direction of a definite source of emission of electro-magnetic	Цахилгаан соронзон долгион цацруулагч эх үүсвэрийн харагдах чиглэл болон радио чиглэл-

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		waves and a reference direction, as determined at a radio direction-finding station. A <i>true</i> radio bearing is one for which the reference direction is that of True North. A <i>magnetic</i> radio bearing is one for which the reference direction is that of Magnetic North.	ологч станцаар тодорхойлсон хяналтын чиглэл хоорондын өнцөг. Жинхэнэ радио чиглэл гэж Жинхэнэ Хойд зүгээр тодорхойлдог хяналтын чиглэлийг ойлгоно. Соронзон радио чиглэл гэж Соронзон Хойд зүгээр тодорхойлдог хяналтын чиглэлийг ойлгоно. (AN 10/II)
Radio direction-finding (RR S1.12)	Радио чиглэл-ологч	Radiodetermination using the reception of radio waves for the purpose of determining the direction of a station or object.	Станц, эсхүл байгууламжийн чиглэлийг тодорхойлох зорилгоор радио долгион хүлээн авагч ашиглан радио нэвтрүүлэг ологч (AN 10/II)
Radio direction-finding station (RR S1.91)	Радио чиглэл-ологч станц	A radiodetermination station using radio direction finding. <i>Note.- The aeronautical application of radio direction finding is in the aeronautical radio navigation service.</i>	Радио чиглэл-ологч ашиглан радио нэвтрүүлэг ологч-станц <i>Тэмдэглэл: Нисэхийн радио навигацгийн үйлчилгээнд Радио чиглэл-ологчийг ашигладаг.</i> (AN 10/II)
Radio navigation service	Радио навигацгийн үйлчилгээ	A service providing guidance information or position data for the efficient and safe operation of aircraft supported by one or more radio navigation aids.	Агаарын хөлгийн үйл ажиллагааг аюулгүй, үр ашигтай байхад зориулан нэг, эсхүл хэд хэдэн радио навигацгийн туслах төхөөрөмжийн тусламжтайгаар чиглүүлэх мэдээлэл, эсхүл байрлалын өгөгдлөөр хангадаг үйлчилгээ (AN 10/I; AN 11; AN 15)
Radiotelephony	Радио-холбоо	A form of radiocommunication primarily intended for the exchange of information in the form of speech.	Мэдээллийг ярианы хэлбэрээр солилцох үндсэн зорилготой радио-холбооны хэлбэр (AN 2; AN 11)
Radiotelephony network	Радио-холбооны сүлжээ	A group of radiotelephony aeronautical stations which operate on and guard frequencies from the same family and which support each other in a defined manner to ensure maximum dependability of air-ground communications and dissemination of air-ground traffic.	Ажилладаг давтамжаа бусад ижил төрлийн давтамжаас хамгаалдаг ба агаар-газар холбоо болон агаар-газар нислэгийн хөдөлгөөний нэвтрүүлгийн максимум найдвартай байдлыг бататгах зорилгоор бие биеэ тодорхой хэлбэрээр дэмждэг нисэхийн радио-холбооны бүлэг станц (AN 10/II)
Rated air traffic controller	Зэрэглэлтэй нислэгийн хөдөлгөөний удирдагч	An air traffic controller holding a licence and valid ratings appropriate to the privileges to be exercised.	Тодорхой ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой үнэмлэх болон хүчинтэй зэрэглэл эзэмшдэг нислэгийн хөдөлгөөний удирдагч (AN 1)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Rated thrust	Тооцоот татах хүч	For engine emissions purposes, the maximum take-off thrust approved by the certificating authority for use under normal operating conditions at ISA sea level static conditions, and without the use of water injection. Thrust is expressed in kilonewtons.	Хөдөлгүүрийн хийн ялгаруулалтыг тодорхойлоход, ISA-д, далайн түвшний статик нөхцөлд, хэвийн үйл ажиллагааны үед, усан хөргөлт ашиглахгүйгээр гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн максимум хөөрөлтийн татах хүч. Татах хүчийг кило-тонноор илэрхийлдэг. (AN 16/II)
Rating	Зэрэглэл	An authorization entered on or associated with a licence and forming part thereof, stating special conditions, privileges or limitations pertaining to such licence.	Тухайн үнэмлэх, эсхүл гэрчилгээтэй холбоотой тусгай нөхцөл, эрх, эсхүл хязгаарлалтыг заасан үнэмлэх, гэрчилгээний тэмдэглэгээ (AN 1)
Readback	Хариу давтах	A procedure whereby the receiving station repeats a received message or an appropriate part thereof back to the transmitting station so as to obtain confirmation of correct reception.	Мэдээлэл хүлээн авсан нэгж нь мэдээллээ үнэн зөв хүлээн авснаа бататгах зорилгоор авсан мэдээлэл, эсхүл түүний холбогдох хэсгийг дамжуулсан нэгжид эргэн хариу мэдэгдэж давтах журам (AN 10/II)
Recertification	Дахин гэрчилгээжүүлэлт	Certification of an aircraft with or without a revision to its certification noise levels, to a Standard different to that to which it was originally certificated.	Агаарын хөлгийн дуу чимээний түвшний гэрчилгээжүүлэлтийг дахин хийсэн эсэхээс үл хамааран, анхны гэрчилгээ олгосон стандартаас өөр стандартаар гэрчилгээжүүлэх (AN 16/I)
Reference geometric factor	Жишиг геометрийн хүчин зүйл	An adjustment factor based on a measurement of aeroplane fuselage size derived from a two-dimensional projection of the fuselage.	Их биеийн 2 хэмжээст проекцоос авсан нисэх онгоцны их биеийн хэмжээний хэмжилтэд суурилсан тохируулгын хүчин зүйл (AN 16/III)
Reference pressure ratio	Жишиг даралтын харьцаа	The ratio of the mean total pressure at the last compressor discharge plane of the compressor to the mean total pressure at the compressor entry plane when the engine is developing take-off thrust rating in ISA sea level static conditions. <i>Note.- Methods of measuring reference pressure ratio are given in Appendix 1.</i>	ISA-д, далайн түвшний статик нөхцөлд хөдөлгүүр хөөрөлтийн горимд ажиллаж байх үеийн компрессорын арын талбайн нийт даралтыг компрессорын оролтын талбайн нийт даралтад харьцуулсан харьцаа <i>Тэмдэглэл: Жишиг даралтын харьцааг хэмжих аргыг Annex 16/II, Appendix 1-д заасан. (AN 16/II)</i>
Regional air navigation agreement	Бүсийн агаарын навигацийн гэрээ	Agreement approved by the Council of ICAO normally on the advice of a regional air navigation meeting.	Бүсийн агаарын навигацийн уулзалтын зөвлөмжийг үндэслэн ICAO консулын баталсан гэрээ (AN 3)
Regular station	Үндсэн станц	A station selected from those forming an en-route air-ground radiotelephony network to communicate	Хэвийн нөхцөлд агаарын хөлөгтэй холбоо тогтоох, эсхүл холбоог барьж авах (intercept) зорилгоор

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		with or to intercept communications from aircraft in normal conditions.	нислэгийн замын дагуу агаар-газар радио-холбооны сүлжээг бүрдүүлж байгаа станцуудаас сонгосон станц (AN 10/II)
Regulated agent	Зохицуулалттай агент	An agent, freight forwarder or any other entity who conducts business with an operator and provides security controls that are accepted or required by the appropriate authority in respect of cargo or mail.	Ачаа, эсхүл шуудангийн хувьд үйл ажиллагаа эрхлэгчтэй хамтран бизнес эрхэлдэг бөгөөд зохих эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн, эсхүл шаарддаг аюулгүйн хамгаалалтын хяналтыг гүйцэтгэдэг агент, ачаа илгээгч, эсхүл бусад байгууллага (AN 17)
Rejected take-off area	Татгалзсан хөөрөлтийн талбай	A defined area on a heliport suitable for helicopters operating in performance class 1 to complete a rejected take-off.	Хүчин чадлын Ангилал-1-ийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хувьд татгалзсан хөөрөлт үйлдэхэд тохиромжтой хэлипорт дээр тогтоосон талбай (AN 14/II)
Release of goods	Барааг чөлөөлөх	The action by the customs authorities to permit goods undergoing clearance to be placed at the disposal of the persons concerned.	Гаалийн бүрдүүлэлт хийсний дараа гаалийн байгууллагаас хүлээн авагчид барааг чөлөөт эргэлтэд оруулах зөвшөөрөл олгох үйл ажиллагаа (AN 9)
Relief	Рельеф / өндрийн огтлол	The inequalities in elevation of the surface of the Earth represented on aeronautical charts by contours, hypsometric tints, shading or spot elevations.	Хаялбар, гипсометрийн өнгө, сүүдэр, эсхүл өндөрлөгийн хэмжээсээр нислэгийн зурагт дүрсэлсэн газрын гадаргуугийн өндөрлөгийн хотгор гүдгэр (AN 4; AN 15)
Relief flights	Тусламжийн нислэг	Flights operated for humanitarian purposes which carry relief personnel and relief supplies such as food, clothing, shelter, medical and other items during or after an emergency and/or disaster and/or are used to evacuate persons from a place where their life or health is threatened by such emergency and/or disaster to a safe haven in the same State or another State willing to receive such persons.	Онцгой нөхцөл ба/эсхүл гамшгийн үед, эсхүл түүний дараа тусламжийн ажилтан болон хүнс, хувцас, сууц, эм бэлдмэл, хоргодох оромж болон бусад эд зүйл зэрэг тусламжийн барааг тээвэрлэдэг ба/эсхүл тухайн онцгой нөхцөл ба/эсхүл гамшгаас шалтгаалан тэдний амь нас, эрүүл мэндэд аюултай газраас тухайн Улсын аюулгүй газар, эсхүл эдгээр хүмүүсийг хүлээн авахыг зөвшөөрсөн өөр Улс руу хүлээн нүүлгэн шилжүүлэхэд ашигладаг хүмүүнлэгийн зорилгоор үйлддэг нислэг (AN 9)
Remote co-pilot	Зайнаас-удирдах-хамтран нисгэгч	A licensed remote pilot serving in any piloting capacity other than as remote pilot-in-command but excluding a remote pilot who is in the remote	Зайнаас-удирдах-хөлгийн даргаас бусад нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа гэрчилгээжсэн зайнаас-удирдах-нисгэгч. Гэхдээ зайнаас-удирдах-

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		pilot station for the sole purpose of receiving flight instruction.	нисгэгчийн ажлын байранд нислэгийн зааварчилгаа авч байгаа зайнаас-удирдах-нисгэгч үүнд багтахгүй. (AN 1)
Remote flight crew member	Зайнаас-удирдах-нисэх багийн гишүүн	A licensed flight crew member charged with duties essential to the operation of a remotely piloted aircraft system during a flight duty period.	Нислэгийн үүрэгт хугацаанд зайнаас удирддаг агаарын хөлгийн системийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үүрэг гүйцэтгэхээр томилогдсон гэрчилгээжсэн нисэх багийн гишүүн (AN 1)
Remote pilot	Зайнаас-удирдах-нисгэгч	A person charged by the operator with duties essential to the operation of a remotely piloted aircraft and who manipulates the flight controls, as appropriate, during flight time.	Нислэгийн цагийн хугацаанд зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үүрэг гүйцэтгүүлэхээр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон, нислэгийн жолоодлогыг зохих ёсоор гүйцэтгэдэг этгээд (AN 1, AN 2)
Remote pilot station (RPS)	Зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байр	The component of the remotely piloted aircraft system containing the equipment used to pilot the remotely piloted aircraft.	Зайнаас удирддаг агаарын хөлгийн нисгэгчийн ашигладаг төхөөрөмжийг агуулсан зайнаас удирддаг агаарын хөлгийн системийн бүрдэл хэсэг (AN 1, AN 2)
Remote pilot-in-command	Зайнаас-удирдах-хөлгийн дарга	The remote pilot designated by the operator as being in command and charged with the safe conduct of a flight.	Нислэгийг удирдан, аюулгүй гүйцэтгэх зорилгоор үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон зайнаас-удирдах-нисгэгч (AN 1)
Remotely piloted aircraft (RPA)	Зайнаас удирддаг агаарын хөлөг	An unmanned aircraft which is piloted from a remote pilot station.	Зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байрнаас удирдаж нисгэдэг хүнгүй агаарын хөлөг (AN 1, AN 2)
Remotely piloted aircraft system (RPAS)	Зайнаас удирддаг агаарын хөлгийн систем	A remotely piloted aircraft, its associated remote pilot station(s), the required command and control links and any other components as specified in the type design.	Зайнаас удирддаг агаарын хөлөг, түүнтэй холбоотой зайнаас-удирдах-нисгэгчийн ажлын байр, шаардлагатай дохио болон удирдлагын холболт болон маягийн загварт заасан бусад бүрдэл хэсэг (AN 1, AN 2)
Removal of a person	Буцаан гаргах	Action by the public authorities of a State, i.a.w its laws, to direct a person to leave that State.	Аливаа этгээдийг хуулийн дагуу тухайн Улсаас гаргах төрийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа (AN 9)
Removal order	Буцаан гаргах шийдвэр	A written order served by a State on the operator on whose flight an inadmissible person travelled	Агаарын тээвэрлэгчийн нислэгээр зорчин ирсэн, тухайн Улсад нэвтрэх эрхгүй этгээдийг нутаг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		into that State, directing the operator to remove that person from its territory.	дэвсгэрээсээ буцаан гаргасан тухай эрх бүхий байгууллагаас агаарын тээвэрлэгчид бичгээр хүргүүлсэн шийдвэр (AN 9)
Rendering (a Certificate of Airworthiness) valid	НТЧ-ын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх	The action taken by a Contracting State, as an alternative to issuing its own Certificate of Airworthiness, in accepting a Certificate of Airworthiness issued by any other Contracting State as the equivalent of its own Certificate of Airworthiness.	Хэлэлцэн тохиролцогч Улс нь өөрийн НТЧ-ын гэрчилгээ олгохын оронд бусад Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон НТЧ-ын гэрчилгээг өөрийн НТЧ-ын гэрчилгээтэй дүйцнэ гэж хүлээн зөвшөөрөх арга хэмжээ (AN 8)
Rendering (a licence) valid	Үнэмлэх хүлээн зөвшөөрөх	The action taken by a Contracting State, as an alternative to issuing its own licence, in accepting a licence issued by any other Contracting State as the equivalent of its own licence.	Хэлэлцэн тохиролцогч Улс нь өөрийн үнэмлэх олгохын оронд бусад Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон үнэмлэхийг өөрийн үнэмлэхтэй дүйцнэ гэж хүлээн зөвшөөрөх үйлдэл (AN 1)
Repair	Засвар	The restoration of an aircraft, engine, propeller or associated part to an airworthy condition i.a.w the appropriate airworthiness requirements after it has been damaged or subjected to wear.	Гэмтсэн, эсхүл элэгдсэн агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, эсхүл тэдгээрийн эд ангийг холбогдох НТЧ-ын шаардлагын дагуу нислэгт тэнцэх нөхцөлд сэргээн оруулах үйл явц (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 8)
Repatriation flights	Нутаг буцаах нислэг	Special flights organized, facilitated or supported by a State for the exclusive purpose of transporting that State's nationals, and other eligible persons, from foreign countries to that State, or a safe third country, through operations by State aircraft, humanitarian flights or chartered/non-scheduled commercial flights.	Улсын агаарын хөлгийн, хүмүүнлэгийн, эсхүл чартер/хуваарьт бус арилжааны нислэгээр гадаад орноос тухайн Улс, эсхүл аюулгүй гуравдагч орон руу өөрийн улсын харьяат болон бусад эрх бүхий этгээдийг тээвэрлэх онцгой зорилгоор тухайн Улсын зохион байгуулдаг, тусламж, эсхүл дэмжлэг үзүүлдэг тусгай нислэг (AN 9)
Repetitive flight plan (RPL)	Давтагдах нислэгийн төлөвлөгөө (RPL)	A flight plan related to a series of frequently recurring, regularly operated individual flights with identical basic features, submitted by an operator for retention and repetitive use by ATS units.	Үйл ажиллагаа эрхлэгч нь НХҮ-ний нэгжид давтан ашиглах болон хадгалуулах зорилгоор хүргүүлсэн, байнга давтагддаг, тогтмол гүйцэтгэдэг, ижил төрлийн, тусдаа нислэгт хамаарах нислэгийн төлөвлөгөө (AN 2; PANS-ATM)
Reporting period	Тайлангийн хугацаа	A period which commences on 1 January and finishes on 31 December in a given year for which an aeroplane operator or State reports required information. The flight departure time (UTC)	Нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл Улс нь шаардлагатай мэдээллийг тайлагнадаг, тухайн жилийн 1 сарын 1-нд эхэлж, 12 сарын 31-нд дуусдаг хугацаа.

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		determines which reporting period a flight belongs to.	Нислэгийн нисэн гарах (UTC) цаг нь тухайн нислэг хамаарах тайлангийн хугацааг тодорхойлно. (AN 16/IV)
Reporting point	Илтгэх цэг	A specified (named) geographical location in relation to which the position of an aircraft can be reported.	Агаарын хөлөг байрлалаа харьцуулан илтгэж болох онцгойлон заасан газар зүйн байршил (AN 2; AN 3; AN 4; AN 11; PANS-ATM)
Required communication performance (RCP) specification	Холбооны шаардлагатай үзүүлэлтийн (RCP) тодорхойлолт	A set of requirements for ATS provision and associated ground equipment, aircraft capability, and operations needed to support performance-based communication.	НХҮ-ний хангалт, холбогдох газрын төхөөрөмж, агаарын хөлгийн хүчин чадал болон үзүүлэлтэд суурилсан холбоонд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй үйл ажиллагааны шаардлагын иж бүрдэл (AN 6/I; AN 6/II)
Required surveillance performance (RSP) specification	Ажиглалтын шаардлагатай үзүүлэлтийн (RSP) тодорхойлолт	A set of requirements for ATS provision and associated ground equipment, aircraft capability, and operations needed to support performance-based surveillance.	НХҮ-ний хангалт, холбогдох газрын төхөөрөмж, агаарын хөлгийн хүчин чадал болон үзүүлэлтэд суурилсан ажиглалтад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй үйл ажиллагааны шаардлагын иж бүрдэл (AN 6/I)
Requirement	Шаардлага	Need or expectation that is stated, generally implied or obligatory (ISO 9000*).	Тогтоосон, ихэвчлэн хэрэгжүүлдэг, эсхүл хэрэгжүүлэхийг үүрэг болгосон хэрэгцээ, эсхүл хүлээлт
Rescue	Авран туслах	An operation to retrieve persons in distress, provide for their initial medical or other needs, and deliver them to a place of safety.	Аюулд өртсөн этгээдийг аврах, анхан шатны эмнэлгийн тусламж, эсхүл бусад хэрэгцээг хангах болон тэднийг аюулгүй газарт хүргэх үйл ажиллагаа (AN 12)
Rescue co-ordination centre	Авран туслах зохицуулалтын төв	A unit responsible for promoting efficient organization of SAR services and for coordinating the conduct of SAR operations within a SAR region.	ЭХАТ бүсийн хүрээнд ЭХАТ үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, тухайн үйл ажиллагааны гүйцэтгэлийн зохицуулах үүрэгтэй нэгж (AN 3; AN 11; AN 12; PANS-ATM)
Rescue subcentre	Авран туслах дэд төв	A unit subordinate to a rescue coordination centre, established to complement the latter according to particular provisions of the responsible authorities.	Авран туслах үйл ажиллагааг зохицуулагч төвийн үйл ажиллагааг тодорхой нутаг дэвсгэр, хүрээнд нөхөж ажиллахаар, түүний доор байгуулагдсан нэгж (AN 12)
Rest period	Амралтын хугацаа	A continuous and defined period of time, subsequent to and/or prior to duty, during which flight or cabin crew members are free of all duties.	Үүрэг гүйцэтгэж эхлэхийн өмнө ба/эсхүл дараа нисэх баг, эсхүл бүхээгийн ажилтан бүх үүрэгт

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			ажлаас чөлөөтэй байх тасралтгүй үргэлжилсэн, тусгайлан тогтоосон цаг хугацаа (AN 6/I; AN 6/III)
Restricted area	Хязгаарлалттай бүс	An airspace of defined dimensions, above the land areas or territorial waters of a State, within which the flight of aircraft is restricted i.a.w certain specified conditions.	Агаарын хөлгийн нислэгийг заасан нөхцөлийн дагуу хязгаарладаг, тухайн Улсын газар, эсхүл усан хилийн дээгүүр тодорхой хэмжээтэй тогтоосон агаарын зай (AN 2; AN 4; AN 11; AN 15)
Reversal procedure	Буцааж хэрэглэх журам	A procedure designed to enable aircraft to reverse direction during the initial approach segment of an instrument approach procedure. The sequence may include procedure turns or base turns.	Хэрэглэлийн ойртолтын журмын ойртолтын эхлэлийн сегментэд агаарын хөлөг эсрэг чиглэлд ашиглах боломжтой байхаар зохиосон журам. Энэ дараалал нь стандарт-эргэлт, эсхүл үндсэн-эргэлтийг багтааж болно. (AN 4; PANS-OPS/II)
Risk assessment	Эрсдэлийн үнэлгээ	The process of hazard identification, risk analysis and risk evaluation.	Аюулыг таньж тогтоох, эрсдлийн дүн шинжилгээ болон эрсдэлийн дүгнэлт гаргах үйл явц. (AN 9)
Risk management	Эрсдэлийн удирдлага	The systematic application of management procedures and practices which provide border inspection agencies with the necessary information to address movements or consignments which represent a risk.	Хилийн хяналтын байгууллагыг эрсдэлийг агуулсан хөдөлгөөн, эсхүл илгээх барааг тодорхойлоход шаардлагатай мэдээллээр хангадаг удирдлагын журам болон практик туршлагын системчилсэн хэрэглээ (AN 9)
Road	Зам	An established surface route on the movement area meant for the exclusive use of vehicles.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулан тогтоосон зам (AN 14/I)
Road-holding position	Замын хүлээх байршил	A designated position at which vehicles may be required to hold.	Тээврийн хэрэгслийн хүлээх шаардлагатай тогтоосон байршил (AN 14/I)
Rotorcraft	Роторт-хөлөг	A power-driven heavier-than-air aircraft supported in flight by the reactions of the air on one or more rotors.	Нэг, эсхүл түүнээс олон ротор, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр нислэг үйлддэг хөдөлгүүртэй агаараас хүнд агаарын хөлөг (AN 1; AN 7)
Route segment	Замын хэсэг	A route or portion of route usually flown without an intermediate stop.	Ихэвчлэн завсрын буултгүй нисдэг зам, эсхүл замын хэсэг (AN 10/II)
Route stage	Замын үе шат	A route or portion of a route flown without an intermediate landing.	Завсрын буултгүй нисдэг зам, эсхүл замын хэсэг (AN 15)
Routing Directory	Замын лавлах	A list in a communication centre indicating for each addressee the outgoing circuit to be used.	Хаяг бүрийн ашигладаг сувгийг харуулсан холбооны төвийн жагсаалт (AN 10/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
RPA observer	Зайнаас удирддаг агаарын хөлгийн ажиглагч	A trained and competent person designated by the operator who, by visual observation of the remotely piloted aircraft, assists the remote pilot in the safe conduct of the flight.	Зайнаас удирддаг агаарын хөлгийн ил харааны ажиглалт хийж, тухай нислэгийг аюулгүй гүйцэтгэхэд зайнаас-удирдах-нисгэгчид тусалдаг, үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон, сургалтад хамрагдсан ба мэргэшсэн этгээд (AN 2)
Runway	Хөөрч, буух зурвас (ХБЗ)	A defined rectangular area on a land aerodrome prepared for the landing and take-off of aircraft.	Агаарын хөлгийн буулт, хөөрөлтөд зориулан бэлдсэн, газрын аэродром дээр тогтоосон тэгш өнцөгт талбай (AN 2; AN 3; AN 4; AN 11; AN 14/I; PANS-ATM)
Runway condition assessment matrix (RCAM)	ХБЗ-ын нөхцөлийн үнэлгээний матрикс (RCAM)	A matrix allowing the assessment of the runway condition code, using associated procedures, from a set of observed runway surface condition(s) and pilot report of braking action.	ХБЗ-ын гадаргуугийн тогтоосон нөхцөлийн бүрдэл болон нисгэгчийн тоормослох үйлдлийн талаарх тайланд үндэслэн, холбогдох журмыг ашиглан ХБЗ-ын нөхцөлийн кодоод үнэлгээ өгдөг матрикс (AN 14/I)
Runway condition code (RWYCC)	ХБЗ-ын нөхцөлийн код	A number describing the runway surface condition to be used in the runway condition report.	ХБЗ-ын нөхцөлийн мэдээнд хэрэглэх зорилгоор ХБЗ-ын гадаргуугийн нөхцөлийг тайлбарладаг тоо (AN 14/I)
Runway condition report (RCR)	ХБЗ-ын нөхцөлийн мэдээ	A comprehensive standardized report relating to runway surface condition(s) and its effect on the aeroplane landing and take-off performance.	ХБЗ-ын гадаргуугийн нөхцөл, түүний нисэх онгоцны буулт болон хөөрөлтийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөтэй холбоотой цогц стандартчилсан мэдээ (AN 14/I)
Runway end safety area (RESA)	ХБЗ-ын төгсгөлийн аюулгүйн талбай (RESA)	An area symmetrical about the extended runway centre line and adjacent to the end of the strip primarily intended to reduce the risk of damage to an aeroplane undershooting or overrunning the runway.	ХБЗ-ын үргэлжилсэн төвийн шугамтай тэгш хэмтэй ба нисэх онгоц ХБЗ-д дутуу суух, эсхүл даван гүйж гарах үед учрах гэмтлийн эрсдэлийг багасгахад зориулсан ХБЗ-ын талбайн төгсгөлтэй зэрэгцээ байрлах талбай (AN 14/I)
Runway guard lights	ХБЗ-ын хамгаалалтын гэрэл	A light system intended to caution pilots or vehicle drivers that they are about to enter an active runway.	Нисгэгч, эсхүл тээврийн хэрэгслийн жолоочид ашиглаж байгаа ХБЗ-д нэвтэрч байгааг анхааруулах зорилготой гэрлэн дохионы систем (AN 14/I)
Runway strip	ХБЗ-ын талбай	A defined area including the runway and stopway, if provided, intended:	ХБЗ болон зогсоох зурвасыг (хэрэв зогсоох зурвас/stopway байгаа бол) багтаасан, дараах зорилгоор тогтоосон талбай:

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		a) to reduce the risk of damage to aircraft running off a runway; and b) to protect aircraft flying over it during take-off or landing operations.	a) ХБЗ-аас агаарын хөлөг гарах үед үүсэх гэмтлийн эрсдэлийг багасгах; b) хөөрөлт, эсхүл буулт үйлдэх үйл ажиллагааны үед тухайн ХБЗ-ын талбайн дээгүүр нисэж байгаа агаарын хөлгийг саадаас хамгаалах гадаргууг хангах. (AN 4; AN 14/I)
Runway surface condition(s)	ХБЗ-ын гадаргуугийн нөхцөл	A description of the condition(s) of the runway surface used in the runway condition report which establishes the basis for the determination of the runway condition code for aeroplane performance purposes.	Нисэх онгоцны үзүүлэлтийн зорилгоор ХБЗ-ын нөхцөлийн кодыг тодорхойлох суурийг бүрдүүлдэг ХБЗ-ын нөхцөлийн мэдээнд хэрэглэдэг ХБЗ-ын гадаргуугийн нөхцөлийн тодорхойлолт (AN 14/I)
Runway turn pad	ХБЗ-ын эргэлтийн талбай	A defined area on a land aerodrome adjacent to a runway for the purpose of completing a 180-degree turn on a runway.	ХБЗ дээр 180 градус эргэх зорилгоор газрын аэродромд ХБЗ-ын дэргэд тогтоосон талбай (AN 14/I)
Runway visual range (RVR)	ХБЗ-ын ил харааны зай (RVR)	The range over which the pilot of an aircraft on the centre line of a runway can see the runway surface markings or the lights delineating the runway or identifying its centre line.	ХБЗ-ын гадаргуугийн тэмдэглэгээ, эсхүл ХБЗ-г тэмдэглэсэн, эсхүл түүний гол шугамыг харуулсан гэрлийг ХБЗ-ын төвийн шугам дээр байгаа агаарын хөлгийн нисгэгчийн харж чадах зай (AN 3; AN 4; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 10/I; AN 11; AN 14/I; PANS-ATM)
Runway-holding position	ХБЗ-ын хүлээх байршил	A designated position intended to protect a runway, an obstacle limitation surface, or an ILS/MLS critical/sensitive area at which taxiing aircraft and vehicles shall stop and hold, unless otherwise authorized by the aerodrome control tower. <i>Note.- In radiotelephony phraseologies, the expression "holding point" is used to designate the runway-holding position.</i>	Аэродромын удирдлагын цамхаас зөвшөөрснөөс бусад тохиолдолд ХБЗ, саадыг хязгаарлах гадаргуу, эсхүл ILS/MLS-ын эрсдэлтэй/мэдрэг талбайг хамгаалах зорилгоор явгалж байгаа агаарын хөлөг болон тээврийн хэрэгсэл зогсож хүлээхэд зориулан тогтоосон байршил <i>Тэмдэглэл:</i> Радио холбооны стандарт хэллэгт "хүлээлтийн цэг" гэсэн ойлголтыг ХБЗ-ын хүлээх байршилыг тогтооход хэрэглэдэг. (AN 2; AN 4; AN 14/I; PANS-ATM)
Runway-type FATO	ХБЗ-ын төрөл FATO	A FATO having characteristics similar in shape to a runway.	ХБЗ-ын хэлбэртэй ижил төстэй үзүүлэлттэй FATO (AN 14/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Safe forced landing	Аюулгүй аргагүйдсэн буулт	Unavoidable landing or ditching with a reasonable expectancy of no injuries to persons in the aircraft or on the surface.	Агаарын хөлөгт, эсхүл гадаргуу дээр байгаа хүмүүст гэмтэл учруулахгүй байх боломжтой гэж үзсэн газар, эсхүл усан дээр гарцаагүй байдалд үйлдэх буулт (AN 6/I)
Safety	Аюулгүй байдал	The state in which risks associated with aviation activities, related to, or in direct support of the operation of aircraft, are reduced and controlled to an acceptable level.	Агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл түүнд шууд дэмжлэг үзүүлэх нисэхийн үйл ажиллагаанд хамаарах эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшин хүртэл бууруулах ба хянах төлөв байдал (AN 19)
Safety area	Аюулгүйн талбай	A defined area on a heliport surrounding the FATO which is free of obstacles, other than those required for air navigation purposes, and intended to reduce the risk of damage to helicopters accidentally diverging from the FATO.	Нислэгийн үйл ажиллагааны зорилгоор шаардсанаас бусад, санамсаргүй байдлаар FATO-гоос гадуур орсон нисдэг тэрэгний гэмтлийн эрсдэлийг багасгах зорилготой, саадаас чөлөөтэй FATO-гоор хүрээлэгдсэн хелипорт дээр тогтоосон талбай (AN 14/II)
Safety data	Аюулгүй байдлын өгөгдөл	A defined set of facts or set of safety values collected from various aviation-related sources, which is used to maintain or improve safety. <i>Note.- Such safety data is collected from proactive or reactive safety-related activities, including but not limited to:</i> a) accident or incident investigations; b) safety reporting; c) continuing airworthiness reporting; d) operational performance monitoring; e) inspections, audits, surveys; or f) safety studies and reviews.	Аюулгүй байдлыг хадгалах, эсхүл сайжруулах зорилгоор ашигладаг, нисэхтэй холбоотой олон төрлийн эх сурвалжаас цуглуулсан, тогтоосон баримтын багц, эсхүл аюулгүй байдлын үнэлгээний багц <u>Тэмдэглэл:</u> Эдгээр аюулгүй байдлын өгөгдлийг дараах идэвхтэй, эсхүл хариу үйлдэл дээр тогтсон аюулгүй байдалтай холбоотой ажиллагааны үр дүнд цуглуулдаг: a) осол, эсхүл зөрчлийг шинжлэх шалгах; b) аюулгүй байдлын тайлан мэдээлэл; c) НТЧ-ын байнгын хэрэгжүүлэлтийн мэдээлэл; d) үйл ажиллагааны гүйцэтгэлийн мониторинг; e) үзлэг, аудит болон үнэлгээ; эсхүл f) аюулгүй байдлын судалгаа болон дүгнэлт. (AN 19)
Safety information	Аюулгүй байдлын мэдээлэл	Safety data processed, organized or analysed in a given context so as to make it useful for safety management purposes.	Аюулгүй байдлын удирдлагын зорилгоор хэрэглэхэд тохиромжтой байхаар өгөгдсөн нөхцөлийн дагуу боловсруулсан, зохион

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			байгуулсан, эсхүл дүн шинжилгээ хийгдсэн аюулгүй байдлын өгөгдөл (AN 19)
Safety management system	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	A systematic approach to managing safety, including the necessary organizational structures, accountability, responsibilities, policies and procedures.	Аюулгүй байдлыг удирдахад шаардлагатай байгууллагын бүтэц зохион байгуулалт, хариуцлага, үүрэг, бодлого болон журмыг багтаасан системчилсэн хандлага (AN 6/I; AN 6/III; AN 11; AN 14/I; AN 19)
Safety oversight	Аюулгүй байдлын хяналт	A function performed by a State to ensure that individuals and organizations performing an aviation activity comply with safety-related national laws and regulations.	Нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн болон байгууллага аюулгүй байдалтай холбоотой үндэсний хууль, дүрмийг дагаж мөрдөж байгааг бататгах зорилгоор төрөөс хэрэгжүүлдэг ажиллагаа (AN 19)
Safety performance	Аюулгүй байдлын гүйцэтгэл	A State or a service provider's safety achievement as defined by its safety performance targets and safety performance indicators.	Өөрийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилт болон аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтээр тодорхойлдог тухайн Улс, эсхүл үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын хангалтын үр дүн (AN 19)
Safety performance indicator	Аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт	A data-based parameter used for monitoring and assessing safety performance.	Аюулгүй байдлын гүйцэтгэлийн мониторинг болон үнэлгээнд ашигладаг өгөгдөлд суурилсан параметр (AN 19)
Safety performance target	Аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилт	The State or service provider's planned or intended target for a safety performance indicator over a given period that aligns with the safety objectives.	Тогтоосонд хугацаанд аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг аюулгүй байдлын зорилгод хүргэхээр тухайн Улс, эсхүл үйлчилгээний байгууллагын төлөвлөсөн, эсхүл зорьж байгаа үр дүн (AN 19)
Safety recommendation	Аюулгүй байдлын зөвлөмж	A proposal of an accident investigation authority based on information derived from an investigation, made with the intention of preventing accidents or incidents and which in no case has the purpose of creating a presumption of blame or liability for an accident or incident. In addition to safety recommendations arising from accident and incident investigations, safety recommendations may result from diverse sources, including safety studies.	Шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон бусад эх үүсвэрийг үндэслэн, бусдыг буруутгах, эсхүл хариуцлага хүлээлгэх зорилго агуулаагүй бөгөөд агаарын хөлгийг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг (AN 13)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Safety recommendation of global concern (SRGC)	Нийтийг хамарсан асуудалтай холбоотой аюулгүй байдлын зөвлөмж (SRGC)	A safety recommendation regarding a systemic deficiency having a probability of recurrence, with significant consequences at a global level, and requiring timely action to improve safety. <i>Note.- The Manual of Aircraft Accident and Incident Investigation (Doc 9756), Part IV - Reporting contains the criteria for a recommendation to be classified as an SRGC.</i>	Дэлхий нийтийн түвшинд ноцтой үр дагавартай ба аюулгүй байдлыг сайжруулахын тулд цаг алдалгүй арга хэмжээ авахыг шаарддаг, давтагдах магадлал өндөртэй тогтолцооны алдаатай холбоотой аюулгүй байдлын зөвлөмж <i>Тэмдэглэл:</i> “Manual of Aircraft Accident and Incident Investigation (Doc 9756), Part IV - Reporting”-д зөвлөмжийг SRGC гэж ангилж шалгуурыг агуулсан. (AN 13)
Safety risk	Аюулгүй байдлын эрсдэл	The predicted probability and severity of the consequences or outcomes of a hazard.	Аюулын үр дүн, эсхүл үр дагаврыг урьдчилан харсан магадлал ба хүндрэл (AN 19)
Safety-sensitive personnel	Нислэгийн аюулгүй байдалд шууд хамааралтай ажилтан	Persons who might endanger aviation safety if they perform their duties and functions improperly including, but not limited to, crew members, aircraft maintenance personnel and air traffic controllers.	Ажил, үүргээ хангалтгүй гүйцэтгэх нь нисэхийн аюулгүй байдалд аюултай байж болох багийн гишүүд, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан, нислэгийн хөдөлгөөний удирдагч зэрэг этгээд (AN 2)
SAR aircraft	ЭХАТ агаарын хөлөг	An aircraft provided with specialized equipment suitable for the efficient conduct of SAR missions.	ЭХАТ үйл ажиллагааг үр дүнтэй хийхэд тохиромжтой тусгай хэрэгслээр тоногдсон агаарын хөлөг (AN 12)
SAR facility	ЭХАТ алба	Any mobile resource, including designated SAR units, used to conduct SAR operations.	ЭХАТ үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг, томилогдсон ЭХАТ нэгжийг багтаасан хөдөлгөөнт алба (AN 12)
SAR region	ЭХАТ бүс	An area of defined dimensions, associated with a rescue coordination centre, within which SAR services are provided.	Авран туслах зохицуулалтын төвтэй холбоотой, тухайн бүсийн хүрээнд ЭХАТ үйлчилгээгээр хангадаг, тодорхой хэмжээтэй бүс (AN 12)
SAR service	ЭХАТ үйлчилгээ	The performance of distress monitoring, communication, coordination and SAR functions, initial medical assistance or medical evacuation, through the use of public and private resources, including cooperating aircraft, vessels and other craft and installations.	Агаарын хөлөг, хөлөг онгоц болон бусад хөлөг болон төхөөрөмжийг багтаасан нийтийн болон хувийн эх үүсвэрийг ашиглан, аюулын мониторинг, холбоо, зохицуулалт, ЭХАТ ажиллагаа болон анхан шатны эмнэлгийн тусламж, эсхүл эмнэлгийн нүүлгэн шилжүүлэлт гүйцэтгэх үйлчилгээ (AN 12)
SAR services unit	ЭХАТ үйлчилгээний нэгж	A generic term meaning, as the case may be, rescue coordination centre, rescue subcentre or alerting post.	Тухайн нөхцөлөөс хамааран авран туслах зохицуулалтын төв, авран туслах дэд төв, эсхүл түгшүүрийн мэдээллийн нэгж гэх мэт утгатай ерөнхий нэр томьёо (AN 3)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
SAR unit	ЭХАТ нэгж	A mobile resource composed of trained personnel and provided with equipment suitable for the expeditious conduct of SAR operations.	ЭХАТ үйл ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэх зорилгоор сургагдсан ажилтнуудаас бүрдсэн ба шаардлагатай төхөөрөмжөөр хангагдсан хөдөлгөөнт алба (AN 12)
Satisfactory evidence	Хангалттай нотлох баримт	A set of documents or activities that a Contracting State accepts as sufficient to show compliance with an airworthiness requirement.	НТЧ-ын шаардлагын нийцлийг хангалттай харуулсан гэж Хэлэлцэн тохиролцогч Улс хүлээн зөвшөөрсөн баримт бичиг, эсхүл ажиллагааны бүрдэл (AN 8)
Screening	Аюулгүйн үзлэг	The application of technical or other means which are intended to identify and/or detect weapons, explosives or other dangerous devices, articles or substances which may be used to commit an act of unlawful interference.	Хууль бус нөлөөллийн үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг илрүүлэх ба/эсхүл танихад чиглэсэн техникийн, эсхүл бусад арга хэлбэрийг ашиглан хийх ажиллагаа (AN 17)
Search	Эрэн хайх	An operation normally coordinated by a rescue coordination centre or rescue subcentre using available personnel and facilities to locate persons in distress.	Аюулд өртсөн этгээдийг хайж олох зорилгоор боломжтой байгаа ажилтан болон төхөөрөмж ашиглан авран туслах зохицуулалтын төв, эсхүл авран туслах дэд төвөөс ихэвчлэн зохицуулдаг үйл ажиллагаа (AN 12)
Second	Секунд	The duration of 9 192 631 770 periods of the radiation corresponding to the transition between the two hyperfine levels of the ground state of the caesium-133 atom.	Цезий-133 атомын үндсэн төлөвийн хэт нимгэн хоёр түвшний хоорондох шилжилттэй тэнцүү цацрагийн 9 192 631 770 мөчлөгийн үргэлжлэх хугацаа (AN 5)
Secondary frequency	Хоёрдогч давтамж	The radiotelephony frequency assigned to an aircraft as a second choice for air-ground communication in a radiotelephony network.	Радио-холбооны сүлжээнд агаар-газар холбооны хоёрдогч сонголт болгон агаарын хөлөгт оноосон радио-холбооны давтамж (AN 10/II)
Secondary surveillance radar	Ажиглалтын хоёрдогч радар (SSR)	A surveillance radar system which uses transmitters/receivers (interrogators) and transponders. <i>Note.- The requirements for interrogators and transponders are specified in Chapter 3.</i>	Дамжуулагч / хүлээн авагч (интегратор) болон транспондер ашигладаг ажиглалтын радарын систем <i>Тэмдэглэл:</i> “Annex 10/IV, Chapter 3”-м интегратор болон транспондерын шаардлагыг заасан. (AN 10/IV; PANS-ATM)
Security audit	Аюулгүйн хамгаалалтын аудит	An in-depth compliance examination of all aspects of the implementation of the national civil aviation security program.	Аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн бүх чиглэлээр хийх гүнзгий үзлэг шалгалт (AN 17)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Security control	Аюулгүйн хамгаалалтын хяналт	A means by which the introduction of weapons, explosives or other dangerous devices, articles or substances which may be used to commit an act of unlawful interference can be prevented.	Хууль бус нөлөөллийн үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлж чадах арга хэмжээ (AN 17)
Security culture	Аюулгүйн хамгаалалтын соёл	A set of security-related norms, values, attitudes and assumptions that are inherent in the daily operation of an organization and are reflected by the actions and behaviours of all entities and personnel within the organization.	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг болох, тухайн байгууллагын бүх нэгж болон ажилтнуудын үйлдэл, зан төлөвт тусгалаа олсон аюулгүйн хамгаалалттай холбоотой хэм хэмжээ, үнэт зүйлс, хандлага болон төсөөллийн бүрдэл (AN 17)
Security equipment	Аюулгүйн хамгаалалтын төхөөрөмж	Devices of a specialized nature for use, individually or as part of a system, in the prevention or detection of acts of unlawful interference with civil aviation and its facilities.	Иргэний нисэхийн үйл ажиллагаа болон түүний байгууламжид учирч болох хууль бус нөлөөллийн үйлдлийг илрүүлэх, эсхүл урьдчилан сэргийлэхэд хувь хүн, эсхүл нэгдсэн системд ашиглах тусгай зориулалтын төхөөрөмж (AN 9)
Security inspection	Аюулгүйн хамгаалалтын үзлэг шалгалт	An announced or unannounced examination of the effectiveness of the implementation of specific security measures.	Өвөрмөц аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжүүлэлтийн үр дүнтэй байдалд хийх зарласан, эсхүл зарлаагүй үзлэг шалгалт (AN 17)
Security restricted area (Sterile area)	Аюулгүйн хамгаалалтын хяналттай бүс (Үзлэгийн дараах бүс)	Those areas of the airside of an airport which are identified as priority risk areas where in addition to access control, other security controls are applied.	Тухайн бүсэд нэвтрэх хяналт дээр нэмж аюулгүйн хамгаалалтын бусад хяналтыг хийдэг өндөр эрсдэлтэй бүс гэж тогтоосон нисэх буудлын хамгаалалттай бүсийн талбай (AN 17)
Security test	Аюулгүйн үзлэгийн сорилт	A covert or overt trial of an aviation security measure which simulates an attempt to commit an unlawful act.	Хууль бус үйлдлийн оролдлогыг зохиомлоор бүрдүүлэн хийдэг нисэхийн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний ил, эсхүл далд шалгалт (AN 17)
Segregated parallel operations	Тусгаарлагдсан зэрэгцээ ХБЗ-ын үйл ажиллагаа	Simultaneous operations on parallel or near-parallel instrument runways in which one runway is used exclusively for approaches and the other runway is used exclusively for departures.	Нэгийг нь зөвхөн ойртолтод, нөгөөг нь зөвхөн нисэн гарахад ашигладаг зэрэгцээ, эсхүл бараг зэрэгцээ хэрэглэлийн ХБЗ-нд нэгэн зэрэг гүйцэтгэх үйл ажиллагаа (AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Self-sustaining powered sailplane	Мото-глайдер	A powered aeroplane with available engine power which allows it to maintain level flight but not to take off under its own power.	Хөдөлгүүрийн чадал нь нислэгийн түвшнээ хадгалан нисэх боломж олгодог, хөдөлгүүртэй нисэх онгоц, гэхдээ өөрийн хүчээр хөөрөлт үйлдэх чадваргүй (AN 16)
Semi-automatic relay installation	Хагас автомат дахин дамжуулах төхөөрөмж	A teletypewriter installation where interpretation of the relaying responsibility in respect of an incoming message and the resultant setting-up of the connections required to effect the appropriate retransmissions require the intervention of an operator but where all other normal operations of relay are carried out automatically.	Ирж байгаа мэдээг дамжуулахтай холбоотой тодорхойлолт ба дахин дамжуулалтад шаардлагатай сэлгэн залгалтыг гүйцэтгэхэд холбоочны оролцоо шаардлагатай, гэхдээ дамжуулалтад шаардлагатай бусад бүх үйлдлийг автоматаар хийдэг телетайп төхөөрөмж (AN 10/II)
Series of flights	Цуврал нислэг	Series of flights are consecutive flights that: a) begin and end within a period of 24 hours; and b) are all conducted by the same pilot-in-command.	Дараах дараалсан нислэг: a) эхэлснээс хойш 24 цагийн дотор дуусдаг, b) нэг хөлгийн дарга үйлддэг (AN 6/III)
Serious incident	Ноцтой зөрчил	An incident involving circumstances indicating that there was a high probability of an accident and associated with the operation of an aircraft which, in the case of a manned aircraft, takes place between the time any person boards the aircraft with the intention of flight until such time as all such persons have disembarked, or in the case of an unmanned aircraft, takes place between the time the aircraft is ready to move with the purpose of flight until such time as it comes to rest at the end of the flight and the primary propulsion system is shut down. <i>Note 1.- The difference between an accident and a serious incident lies only in the result.</i> <i>Note 2.- Examples of serious incidents can be found in Attachment C.</i>	Агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, хүнтэй агаарын хөлгийн хувьд, нислэгийн зорилгоор аливаа этгээд агаарын хөлөгт орсон цагаас эхлээд тухайн этгээд буух цаг хугацааны хооронд болсон, эсхүл хүнгүй агаарын хөлгийн хувьд, тухайн нислэгийн зорилгоор агаарын хөлөг хөдлөхөд бэлэн болсон цагаас эхлээд нислэгийн төгсгөлд зогсож, үндсэн хөдөлгүүрээ унтраах хүртэлх хугацааны хооронд болсон, осол болох өндөр магадлалтай нөхцөлд гарсан зөрчил <i>Тэмдэглэл 1: Осол болон ноцтой зөрчлийн ялгааг зөвхөн түүний үр дагавраар тодорхойлдог.</i> <i>Тэмдэглэл 2: Ноцтой зөрчлийн жишээнүүдийг “Annex 13, Attachment C”-с олж болно. (AN 13)</i>
Serious injury	Хүнд гэмтэл	An injury which is sustained by a person in an accident and which:	Ослын улмаас хүнд учирсан дараах гэмтэл: a) гэмтэл авснаас хойш 7 хоногийн дотор, 48 цагаас дээш хугацаагаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай; эсхүл

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<p>a) requires hospitalization for more than 48 hours, commencing within seven days from the date the injury was received; or</p> <p>b) results in a fracture of any bone (except simple fractures of fingers, toes or nose); or</p> <p>c) involves lacerations which cause severe haemorrhage, nerve, muscle or tendon damage; or</p> <p>d) involves injury to any internal organ; or</p> <p>e) involves second or third degree burns, or any burns affecting more than 5 per cent of the body surface; or</p> <p>f) involves verified exposure to infectious substances or injurious radiation.</p>	<p>b) хөл, гарын хуруу, эсхүл хамрын ясны жижиг хугарлаас бусад ясны хугаралд хүргэсэн; эсхүл</p> <p>c) биеийн гэмтлээс шалтгаалан цус ихээр алдах, мэдрэлийн судас, булчин, эсхүл шөрмөс хүндээр гэмтэх; эсхүл</p> <p>d) дотоод эрхтний гэмтэл; эсхүл</p> <p>e) II, эсхүл III зэргийн түлэгдэлт, эсхүл их биеийн гадаргуугийн 5%-иас дээш түлэгдэлт; эсхүл</p> <p>f) халдварт бодисын хордлого, эсхүл гэмтэл учруулахуйц төөнөлт; (AN 13; AN 18; AN 19)</p>
Shipboard heliport	Хөлөг онгоцны хэлипорт	A heliport located on a ship that may be purpose or non-purpose-built. A purpose-built shipboard heliport is one designed specifically for helicopter operations. A non-purpose-built shipboard heliport is one that utilizes an area of the ship that is capable of supporting a helicopter but not designed specifically for that task.	Зориулалтын, эсхүл зориулалтын бусаар хөлөг онгоцон дээр байрлуулсан хэлипорт. Зориулалтын дагуу байгуулсан хөлөг онгоцны хэлипорт нь нисдэг тэрэгний үйл ажиллагаанд тусгайлан зориулагдсан. Зориулалтын бусаар байгуулсан хөлөг онгоцны хэлипорт нь тухайн зорилгоор бүтээгээгүй боловч нисдэг тэрэгний ачааллыг даах чадвартай хөлөг онгоцны талбайг ашигладаг. (AN 14/II)
Shoulder	Хөвөө	An area adjacent to the edge of a pavement so prepared as to provide a transition between the pavement and the adjacent surface.	Хучилт болон зэргэлдээх гадаргуу хоорондын шилжилтийг хангах зорилгоор бэлтгэсэн хучилтын ирмэгтэй залгаа талбай (AN 4; AN 14/I)
Siemens (S)	Сименс (См)	The electric conductance of a conductor in which a current of 1 ampere is produced by an electric potential difference of 1 volt.	1 вольт цахилгаан потенциалын ялгавраар 1 ампер цахилгаан гүйдэл үүсгэдэг дамжуулагчийн цахилгаан дамжуулах чадвар (AN 5)
Sievert (Sv)	Сиверт (Зв)	The unit of radiation dose equivalent corresponding to 1 joule per kilogram.	1 Ж / кг-тай тэнцүү цацрагийн тунгийн эквивалент нэгж (AN 5)
SIGMET information	SIGMET мэдээлэл	Information issued by a meteorological watch office concerning the occurrence or expected occurrence of specified en-route weather and other	Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, тухайн нислэгийн замын дагуу ажиглагдсан, эсхүл үүсэж болно гэж

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		phenomena in the atmosphere that may affect the safety of aircraft operations.	таамагласан цаг агаарын аюултай үзэгдлийн талаар цаг уурын албанаас гаргадаг мэдээлэл (AN 3; AN 11; PANS-ATM)
Sign	Тэмдэг	a) <i>Fixed message sign</i> . A sign presenting only one message. b) <i>Variable message sign</i> . A sign capable of presenting several predetermined messages or no message, as applicable.	a) <i>Тогтмол мэдээллийн тэмдэг</i> . Зөвхөн нэг мэдээг илэрхийлдэг тэмдэглэгээ; b) <i>Хувьсах мэдээллийн тэмдэг</i> . Урьдчилан тогтоосон хэд хэдэн мэдээг илэрхийлдэг тэмдэглэгээ (AN 14/I)
Sign a maintenance release (to)	Ашиглалтад шилжүүлэхээр гарын үсэг зурах	To certify that maintenance work has been completed satisfactorily i.a.w appropriate airworthiness requirements, by issuing the maintenance release referred to in Annex 6 (in the case of a release not issued by an approved maintenance organization) or Annex 8 (in the case of a release issued by an approved maintenance organization).	Аппех 6-д (хэрэв зөвшөөрөгдсөн ТҮБ ашиглалтад шилжүүлээгүй бол), эсхүл Аппех 8-д (хэрэв зөвшөөрөгдсөн ТҮБ ашиглалтад шилжүүлсэн бол) заасан ашиглалтад шилжүүлэхээр холбогдох НТЧ-ын шаардлагын дагуу тухайн техник үйлчилгээний ажлыг амжилттай гүйцэтгэсэн болохыг гэрчилгээжүүлэх (AN 1)
Signal area	Дохионы талбай	An area on an aerodrome used for the display of ground signals.	Газрын дохиог байрлуулах зорилгоор ашигладаг аэродромын талбай (AN 2; AN 14/I; PANS-ATM)
Significant	Онцгой	In the context of the medical provisions in Chapter 6, <i>significant</i> means to a degree or of a nature that is likely to jeopardize flight safety.	Аппех 1, Chapter 6-д заасан эрүүл мэндийн шаардлагатай холбоотойгоор, чухал гэж нислэгийн аюулгүй байдалд аюул учруулж болох түвшин, эсхүл хэлбэрийг ойлгоно. (AN 1)
Significant point	Тодорхой цэг	A specified geographical location used in defining an ATS route or the flight path of an aircraft and for other navigation and ATS purposes.	НХҮ-тэй нислэгийн зам, эсхүл агаарын хөлгийн нислэгийн зам тодорхойлоход ашигладаг ба нислэг чиглүүлэх болон НХҮ-ний бусад зорилгоор тогтоосон газар зүйн байрлал (AN 4; AN 11; PANS-ATM)
Simplex	Симплекс	A method in which telecommunication between two stations takes place in one direction at a time. <i>Note.- In application to the aeronautical mobile service this method may be subdivided as follows:</i> a) <i>single channel simplex</i> ; b) <i>double channel simplex</i> ; c) <i>offset frequency simplex</i> .	Хоёр станцын хоорондын радио-холбоог тухайн агшинд нэг чиглэлтэй болгох арга <u>Тэмдэглэл:</u> Энэ аргыг нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд дараах байдлаар ашиглана: a) <i>ганц сувагтай симплекс</i> ; b) <i>хоёр сувагтай симплекс</i> ; c) <i>давтамж дарах симплекс</i> . (AN 10/II; AN 10/V)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Single channel simplex	Ганц сувагтай симплекс	Simplex using the same frequency channel in each direction.	Чиглэл бүрд ижил давтамжийн суваг ашигладаг симплекс (AN 10/II; AN 10/V)
Single Window	Нэг цонх	A facility that allows parties involved in trade and transport to lodge standardized information and documents with a single entry point to fulfil all import, export, and transit-related regulatory requirements. If information is electronic then individual data elements should only be submitted once.	Худалдаа болон тээвэрт оролцогч талуудад бүх импорт, экспорт болон транзиттай холбоотой зохицуулалтын шаардлагыг хангах зорилгоор нэг нэвтрэх цэгээр стандартчилсан мэдээлэл болон баримт бичгийг оруулах боломж олгодог төхөөрөмж. Хэрэв мэдээлэл нь цахим бол хувийн өгөгдлийн элементийг ганц удаа дамжуулна. (AN 9)
Slotted aloha	Хуваарьт холбоо	A random access strategy whereby multiple users access the same communications channel independently, but each communication must be confined to a fixed time slot. The same timing slot structure is known to all users, but there is no other coordination between the users.	Хоорондоо хамааралгүйгээр олон хэрэглэгч нэг ижил холбооны суваг ашигладаг санамсаргүй хандалтын зарчим. Гэхдээ холбоо бүр нь тогтсон цагийн хуваариар хязгаарлагдсан байх ёстой. Тухайн цагийн хуваарийн бүтэц нь бүх хэрэглэгчид мэдээлэгдсэн байдаг боловч үүнд хэрэглэгч хоорондын зохицуулалт байдаггүй. (AN 10/III)
Small aeroplane	Нисэх онгоц - Жижиг	An aeroplane having a passenger seating configuration of 9 seats or less, and a MCTOW of 5700 kg or less.	9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, MCTOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц (AN 6/I)
Smoke	Утаа	The carbonaceous materials in exhaust emissions which obscure the transmission of light.	Гэрлийн урсгал саатуулдаг, яндангийн хийн ялгаруулалтад байдаг нүүрстөрөгч материал (AN 16/II)
Smoke Number	Утааны тоо	The dimensionless term quantifying smoke emissions (see 3 of Appendix 2).	Утааны ялгаруулалтыг тооцоолдог хэмжээсгүй нөхцөл (Annex 16/II, Appendix 2.3-ыг хар) (AN 16/II)
SNOWTAM	SNOWTAM	A special series NOTAM given in a standard format providing a surface condition report notifying the presence or cessation of hazardous conditions due to snow, ice, slush, frost, standing water or water associated with snow, slush, ice or frost on the movement area.	Хөдөлгөөнт бүс дээрх цас, шалбааг, мөс, эсхүл цан хяруутай холбоотой цас, мөс, шалбааг, цан хяруу, тогтоол усны улмаас аюултай нөхцөл бий болсон, эсхүл түүнийг арилгасан талаарх гадаргуугийн нөхцөлийн мэдээллийг стандарт форматаар хангадаг, тусгай серийн NOTAM (AN 10/II; AN 15)
Solo flight time	Бие даасан нислэгийн цаг	Flight time during which a student pilot is the sole occupant of an aircraft.	Сурагч-нисгэгч агаарын хөлгийн бүхээгт ганцаараа үйлдсэн нислэгийн цаг (AN 1)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Solo flight time - remotely piloted aircraft systems	Зайнаас удирддаг агаарын хөлгийн системийн бие даасан нислэгийн цаг	Flight time during which a student remote pilot is controlling the remotely piloted aircraft system, acting solo.	Зайнаас-удирдах-сурагч нисгэгч зайнаас удирддаг агаарын хөлгийн системийг бие даан удирдан ниссэн нислэгийн цаг (AN 1)
Space weather centre (SWXC)	Сансрын цаг агаарын төв (SWXC)	A centre designated to monitor and provide advisory information on space weather phenomena expected to affect high-frequency radio communications, communications via satellite, GNSS-based navigation and surveillance systems and/or pose a radiation risk to aircraft occupants. <i>Note.- A space weather centre is designated as global and/or regional.</i>	Өндөр давтамжийн радио-холбоо, хиймэл дагуулын холбоо, GNSS-д суурилсан навигаци болон ажиглалтын системд нөлөөлж болох ба/эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүст радиацийн төөнөлтийн эрсдэл учруулж болох сансрын цаг агаарын аюултай үзэгдэлд мониторинг хийж, зөвлөмжийн мэдээгээр хангах зорилгоор байгуулсан төв <i>Тэмдэглэл: Сансрын цаг агаарын төвийг дэлхийн ба/эсхүл бүсийн хэмжээнд томилдог. (AN 3)</i>
Spare parts	Сэлбэг	Articles, including engines and propellers, of a repair or replacement nature for incorporation in an aircraft.	Агаарын хөлөгт засвар үйлчилгээ хийх, эсхүл солих зорилгоор ашигладаг хөдөлгүүр, сэнсийг багтаасан эд зүйл (AN 9)
Special VFR flight	Тусгай VFR нислэг	A VFR flight cleared by ATC to operate within a control zone in meteorological conditions below VMC.	НХУ-ын нэгжээс VMC-ээс бага цаг уурын нөхцөлд, удирдлагын зоонд үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрсөн VFR нислэг (AN 2; AN 11; PANS-ATM)
Specific air range	Харьцуулсан алслалт	The distance an aeroplane travels in the cruise flight phase per unit of fuel consumed.	Аяллын нислэгийн үе шатанд нэг нэгж түлш зарцуулахад тухайн нисэх онгоцны туулах зай (AN 16/III)
Specific approval	Тусгай зөвшөөрөл	An approval which is documented in the operations specifications for commercial air transport operations or in the list of specific approvals for general aviation operations. <i>Note.- The terms authorization, specific approval, approval and acceptance are further described in Annex 6, Part I, Attachment B / Annex 6, Part II, Attachment 3.D / Annex 6, Part III, Attachment D.</i>	агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд үйл ажиллагааны тодорхойлолтод, эсхүл ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааны хувьд тусгай зөвшөөрлийн хуудсанд баримтжуулсан зөвшөөрөл <i>Тэмдэглэл: Эрх, тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл ойлголтыг “Annex 6, Part I, Attachment B / Annex 6, Part II, Attachment 3.D / Annex 6, Part III, Attachment D”-д дэлгэрэнгүй тайлбарласан. (AN 6/I; AN 6/II; AN 6/III)</i>

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Standard atmosphere	Стандарт атмосфер	The atmospheric standard as described in ICAO Document 7488 - Manual of the ICAO Standard Atmosphere	ICAO Doc 7488 Manual of the ICAO Standard Atmosphere-т заасан атмосферийн стандарт (AN 8)
Standard isobaric surface	Стандарт изобар гадаргуу	An isobaric surface used on a worldwide basis for representing and analysing the conditions in the atmosphere.	Атмосферийн нөхцөлийг илэрхийлэх, дүн шинжилгээ хийхэд дэлхий нийтээр ашигладаг изобар гадаргуу (AN 3)
Standard message element	Стандарт мэдээний элемент	Part of a message defined in the PANS-ATM (Doc 4444) in terms of display format, intended use and attributes.	Дэлгэцийн формат, ашиглах зориулалт болон шинж чанарын хувьд PANS-ATM (Doc 4444)-д тодорхойлсон мэдээний хэсэг (AN 10/II)
Standardized health documents	Стандартчилсан эрүүл мэндийн баримт бичиг	Documents standardized by the World Health Organization (WHO) under the International Health Regulations (IHR) (2005).	Олон улсын эрүүл мэндийн дүрмийн (2005) дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын стандартчилсан баримт бичиг
State of Design	Зохион бүтээгч Улс	The State having jurisdiction over the organization responsible for the type design.	Тухайн маягийн загварын эрх эзэмшдэг байгууллагыг хуулийн дагуу хариуцдаг Улс (AN 8; AN 13; AN 16/I; AN 19)
State of Design of Modification	Модификацийг боловсруулсан Улс	The State having jurisdiction over the individual or organization responsible for the design of the modification or repair of an aircraft, engine or propeller.	Агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний тухайн модификаци, эсхүл засварын боловсруулалтыг хариуцсан хувь хүн, эсхүл байгууллагыг хуулийн дагуу хариуцдаг Улс (AN 8)
State of Destination	Хүлээн авагч Улс	The State in the territory of which the consignment is finally to be unloaded from an aircraft.	Газар нутаг дээр нь тухайн илгээх барааг агаарын хөлгөөс хамгийн сүүлд буулгасан Улс (AN 18)
State of Manufacture	Үйлдвэрлэгч Улс	The State having jurisdiction over the organization responsible for the final assembly of the aircraft, engine or propeller.	Агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсний угсралтыг бүрэн хийж дуусгасан байгууллагыг хуулийн дагуу хариуцдаг Улс (AN 8; AN 9; AN 13; AN 19)
State of Occurrence	Хэрэг явдал болсон Улс	The State in the territory of which an accident or incident occurs.	Газар нутаг дээр нь агаарын хөлгийн осол, эсхүл зөрчил гарсан Улс (AN 13)
State of Origin	Илгээгч Улс	The State in the territory of which the consignment is first to be loaded on an aircraft.	Газар нутаг дээр нь агаарын хөлөгт илгээх барааг анх ачсан Улс (AN 18)
State of Registry	Бүртгэгч Улс	The State on whose register the aircraft is entered.	Агаарын хөлгийг өөрийн бүртгэлд авсан Улс (AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 7; AN 8; AN 9; AN 12; AN 13)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
State of the Aerodrome	Аэродромыг харьяалах Улс	The State in whose territory the aerodrome is located.	Тухайн аэродром байрлаж байгаа газар нутгийг харьяалах Улс (AN 6/I; AN 6/II)
State of the Operator	Агаарын тээвэрлэгчийг харьяалах Улс	The State in which the operator's principal place of business is located or, if there is no such place of business, the operator's permanent residence.	Тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн албан ёсны бизнесийн байр байрладаг, эсхүл ийм байр байхгүй бол түүний байнгын оршин суудаг Улс (AN 6/I; AN 6/III; AN 13; AN 18; AN 19)
State of the principal location of a general aviation operator	Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан ёсоор байрладаг Улс	The State in which the operator of a general aviation aircraft has its principal place of business or, if there is no such place of business, its permanent residence. <i>Note.- Guidance concerning the options for the principal location of a general aviation operator is contained in the Manual on the Implementation of Article 83 bis of the Convention on International Civil Aviation (Doc 10059).</i>	Ерөнхий зориулалтын нисэхийн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч өөрийн албан ёсны бизнес эрхэлдэг, эсхүл хэрэв тийм бизнес эрхэлдэг газар байхгүй бол түүний байнгын оршин суудаг Улс <i>Тэмдэглэл: Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан ёсны байрлалын сонголтын талаарх гарын авлага Manual on the Implementation of Article 83 bis of the Convention on International Civil Aviation (Doc 10059)-д багтсан. (AN 6/II)</i>
State pair	Улсын хос	A group of two States composed of a departing State or its territories and an arrival State or its territories.	Нисэн гарах Улс, эсхүл түүний газар нутаг болон нисэн хүрэх Улс, эсхүл түүний газар нутгаас бүрдсэн хоёр бүлэг Улс (AN 16/IV)
State Safety program (SSP)	Аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр	An integrated set of regulations and activities aimed at improving safety.	Аюулгүй байдлыг сайжруулах зорилготой эрх зүйн зохицуулалт болон үйл ажиллагааны нэгдмэл цогц арга хэмжээ (AN 1; AN 13; AN 19)
State volcano observatory	Гал уулын ажиглалтын төв	A volcano observatory, designated by regional air navigation agreement, to monitor active or potentially active volcanoes within a State and to provide information on volcanic activity to its associated area control centre/flight information centre, meteorological watch office and volcanic ash advisory centre.	Тухайн Улсын идэвхтэй, эсхүл идэвхжиж болох галт уулд мониторинг хийж, холбогдох бүсийн удирдлагын төв/нислэгийн мэдээллийн төв, цаг уурын ажиглалтын алба болон галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төвийг галт уулын идэвхжилтэй холбоотой мэдээгээр хангах зорилгоор бүсийн агаарын навигацийн гэрээгээр байгуулсан галт уулын ажиглалтын төв (AN 3)
Static load-bearing surface	Статик ачаалал даах гадаргуу	A surface capable of supporting the mass of a helicopter situated upon it.	Өөр дээрх нисдэг тэрэгний массыг даах чадвартай гадаргуу (AN 14/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Station declination	Станцын хазайлт	An alignment variation between the zero degree radial of a VOR and True North, determined at the time the VOR station is calibrated.	VOR станцад тохируулга хийх үед тодорхойлдог, VOR станцын тэг градусын радиал өнцөг болон Жинхэнэ Хойд зүг хоорондын чиглэлийн зөрүү (AN 11; AN 14/I; AN 15)
Steradian	Стерадан (Ср)	The solid angle which, having its vertex in the centre of a sphere, cuts off an area of the surface of the sphere equal to that of a square with sides of length equal to the radius of the sphere.	Бөмбөрцгийн гадаргууд радиусын квадраттай (r^2) тэнцүү талбайг огтолдог, бөмбөрцгийн төвд оройтой биет өнцөг (AN 5)
Stopway	Зогсоох зурвас	A defined rectangular area on the ground at the end of take-off run available prepared as a suitable area in which an aircraft can be stopped in the case of an abandoned take-off.	хөөрөлтийг үргэлжлүүлэхээс татгалзсан тохиолдолд, агаарын хөлгийг зогсоох зорилгоор хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) төгсгөлд бэлдсэн, газар дээр тогтоосон, тохиромжтой тэгш өнцөгт талбай (AN 4; AN 14/I; PANS-ATM)
Stores (Supplies)	Бүхээгийн нөөц (хангалт)	a) Stores (supplies) for consumption; and b) Stores (supplies) to be taken away.	a) Бүхээгийн хэрэглээний нөөц (хангалт); b) Бүхээгийн буцаж ирсэн нөөц (хангалт). (AN 9)
Stores (Supplies) for consumption	Бүхээгийн хэрэглээний нөөц (хангалт)	Goods, whether or not sold, intended for consumption by the passengers and the crew on board aircraft, and goods necessary for the operation and maintenance of aircraft, including fuel and lubricants.	Агаарын хөлгийн зорчигч, нисэх багийн гишүүдийн үйлчилгээнд зориулан хэрэглэх, эсхүл борлуулах бараа болон агаарын хөлгийн техник үйлчилгээнд шаардлагатай бараа, түүнчлэн шатахуун, тослох материал (AN 9)
Stores (Supplies) to be taken away	Бүхээгийн буцаж ирсэн нөөц (хангалт)	Goods for sale to the passengers and the crew of aircraft with a view to being landed.	Зорчигч, нисэх багийн гишүүдийн хэрэглээнээс агаарын хөлөг газардахад буцаж ирсэн бараа (AN 9)
Subsonic aeroplane	Дуунаас бага хурдтай нисэх онгоц	An aeroplane incapable of sustaining level flight at speeds exceeding flight Mach number of 1.	Нислэгийн Mach-тоо 1-ээс хэтэрсэн үед нислэгийн түвшнээ хадгалж чаддаггүй нисэх онгоц (AN 16/I)
Surface level heliport	Гадаргуугийн түвшний хэлипорт	A heliport located on the ground or on a structure on the surface of the water .	Газар дээр, эсхүл усан дээр байрласан хэлипорт (AN 14/II)
Surveillance	Хяналт	The State activities through which the State proactively verifies through inspections and audits that aviation licence, certificate, authorization or approval holders continue to meet the established	Тухайн Улс нь нисэхийн үнэмлэх, гэрчилгээ, эрх, эсхүл зөвшөөрөл эзэмшигчдийг тогтоосон шаардлага болон ажиллагааг шаардлагатай ур чадвар болон аюулгүй байдлын түвшинд үргэлжлүүлэн хангаж байгааг үзлэг, аудитаар

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		requirements and function at the level of competency and safety required by the State.	урьдчилан шалгах хэлбэрээр тухайн Улсын гүйцэтгэх ажиллагаа (AN 19)
Surveillance radar	Ажиглалтын радар	Radar equipment used to determine the position of an aircraft in range and azimuth.	Агаарын хөлгийн байршлыг алслалтын зай болон азимутаар тодорхойлоход ашигладаг радарын төхөөрөмж (AN 10/IV; PANS-ATM)
Switch.-over time (light)	Шилжүүлэн залгах хугацаа (гэрэл)	The time required for the actual intensity of a light measured in a given direction to fall from 50 per cent and recover to 50 per cent during a power supply changeover, when the light is being operated at intensities of 25 per cent or above.	Гэрэл 25%, эсхүл түүнээс дээш хувийн тодорцтой асаж байгаа үед цахилгаан тэжээл сэлгэн залгахад, тодорхой чиглэлд хэмжсэн бодит гэрлийн тодорц 50%-иас буураад, эргэж 50% хүртэл сэргээгдэхэд шаардлагатай хугацаа (AN 14/I)
Synthetic vision system (SVS)	Синтетик дүрслэлийн систем (SVS)	A system to display data-derived synthetic images of the external scene from the perspective of the flight deck.	Нислэгийн бүхээгийн бодит өгөгдлөөс-гарган авсан гадаад орчны синтетик дүрсийг харуулдаг систем (AN 6/I; AN 6/II)
Take-off and initial climb phase	Хөөрөлтийн болон өндөр авалтын эхний үе шат	That part of the flight from the start of take-off to 300 m (1 000 ft) above the elevation of the FATO, if the flight is planned to exceed this height, or to the end of the climb in the other cases.	Хөөрөлтийн цэгээс FATO-гийн өндөрлөгөөс дээш 300 м хүртэлх (хэрэв тухайн нислэгийг энэ өндрөөс дээш гүйцэтгэхээр төлөвлөсөн бол), бусад тохиолдолд өндөр авалтын төгсгөл хүртэлх нислэгийн хэсэг (AN 6/III)
Take-off decision point	Хөөрөлтийн шийдвэр гаргах цэг	The point used in determining take-off performance from which, an engine failure occurring at this point, either a rejected take-off may be made or a take-off safely continued. <i>Note.- TDP applies only to helicopters operating in performance Class 1.</i>	Хөдөлгүүр татгалзсан тухайн цэгээс татгалзсан хөөрөлт хийж болох, эсхүл хөөрөлтийг аюулгүй үргэлжлүүлэхэд шаардлагатай хөөрөлтийн үзүүлэлтийг тодорхойлоход ашигладаг цэг <u>Тэмдэглэл:</u> TDP нь зөвхөн хүчин чадлын Ангилал-1-ээр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэргэнд хамаарна. (AN 6/III)
Take-off phase	Хөөрөлтийн үе шат	The operating phase defined by the time during which the engine is operated at the rated thrust.	Хөдөлгүүр хөөрөлтийн горимоор ажилласан хугацаагаар тодорхойлдог нислэгийн үе шат (AN 16)
Take-off run available (TORA)	Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай	The length of runway declared available and suitable for the ground run of an aeroplane taking off.	Нисэх онгоцны хөөрөлтийн газрын гүйлтэд ашиглахад тохиромжтой ба боломжтой гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн мэдүүлсэн ХБЗ-ын урт (AN 6/I; AN 14/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Take-off runway	Хөөрөлтийн зурвас	A runway intended for take-off only.	Зөвхөн хөөрөлтөд зориулсан зурвас (AN 14/I)
Take-off surface	Хөөрөлтийн гадаргуу	That part of the surface of an aerodrome which the aerodrome authority has declared available for the normal ground or water run of aircraft taking off in a particular direction.	Тодорхой чиглэлд агаарын хөлөг хөөрөлт үйлдэхээр газар, эсхүл усан дээгүүр хэвийн гүйлт үйлдэх боломжтой гэж аэродромын эрх бүхий байгууллагаас зарласан аэродромын гадаргуугийн хэсэг (AN 6/I; AN 8)
Target level of safety (TLS)	Аюулгүй байдлын зорилтот түвшин	A generic term representing the level of risk which is considered acceptable in particular circumstances.	Тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж үзсэн, эрсдэлийн түвшнийг илэрхийлдэг ерөнхий нэр томьёо (AN 6/I; AN 6/II)
Taxi / ground idle	Явгалалт / газрын бага горим	The operating phases involving taxi and idle between the initial starting of the propulsion engine(s) and the initiation of the take-off roll and between the time of runway turn-off and final shutdown of all propulsion engine(s).	Үндсэн хөдөлгүүр асаах мөчөөс эхлэн хөөрөлтийн гүйлтийг эхлэх хүртэл болон ХБЗ-аас гарахаас эхлэн үндсэн хөдөлгүүрийг унтраах хүртэлх хугацаанд явгалах болон бага чадлын горимыг багтаасан үйл ажиллагааны үе шат (AN 16/II)
Taxiing	Явгалалт	Movement of an aircraft on the surface of an aerodrome under its own power, excluding take-off and landing.	Хөөрөлт, буултаас бусад, агаарын хөлөг өөрийн хүчээр аэродромын гадаргуу дээр хийдэг агаарын хөлгийн хөдөлгөөн (AN 2; AN 4; AN 11; PANS-ATM)
Taxi-route	Явгалах чиглэлийн зам	A defined path established for the movement of helicopters from one part of a heliport to another. A taxi-route includes a helicopter air or ground taxiway which is centred on the taxi-route.	Хэлипортын нэг хэсгээс нөгөө хэсэгт нисдэг тэрэгний шилжих хөдөлгөөнд зориулан тогтоосон зам. Явгалах чиглэлийн зам нь түүнийг голлосон нисдэг тэрэгний агаарын, эсхүл газрын явгалах замыг багтаана. (AN 4)
Taxiway	Явгалах зам	A defined path on a land aerodrome established for the taxiing of aircraft and intended to provide a link between one part of the aerodrome and another, including: a) <i>Aircraft stand taxiway</i> . A portion of an apron designated as a taxiway and intended to provide access to aircraft stands only. b) <i>Apron taxiway</i> . A portion of a taxiway system located on an apron and intended to provide a through taxi route across the apron. c) <i>Rapid exit taxiway</i> . A taxiway connected to a runway at an acute angle and designed to allow	Агаарын хөлгийн явгалалт зориулсан ба аэродромын нэг хэсгийг нөгөө хэсэгтэй холбох зорилгоор газрын аэродром дээр тогтоосон дараах зам: a) <i>Агаарын хөлгийн зогсоолын явгалах шугам (Aircraft stand taxiway)</i> - явгалах замаар тогтоосон ба зөвхөн агаарын хөлгийн зогсоолд хүрэхэд зориулсан апроны хэсэг b) <i>Апроны явгалах зам (Apron taxiway)</i> - Апрон дээр байрласан ба апроныг хөндлөн нэвтрэн явгалахад зориулсан явгалах замын системийн хэсэг

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		landing aeroplanes to turn off at higher speeds than are achieved on other exit taxiways thereby minimizing runway occupancy times.	с) <i>Хурдтай гарах явгалах зам (Rapid exit taxiway)</i> - бусад явгалах замаас илүү хурдтайгаар, ХБЗ-ыг эзлэх хугацааг багасгах зорилгоор буулт үйлдэж байгаа нисэх онгоц өндөр хурдтайгаар эргэн гарах боломжтойгоор зохион бүтээсэн, ХБЗ-тай хурц өнцгөөр холбогдсон явгалах зам. (AN 2; AN 4; AN 14/I; PANS-ATM)
Taxiway intersection	Явгалах замын огтлолцол	A junction of two or more taxiways.	2, эсхүл түүнээс олон явгалах замын огтлолцол (AN 14/I)
Taxiway strip	Явгалах талбай	An area including a taxiway intended to protect an aircraft operating on the taxiway and to reduce the risk of damage to an aircraft accidentally running off the taxiway.	Явгалах зам дээр үйл ажиллагаа байгаа агаарын хөлгийг хамгаалах болон явгалах замаас санамсаргүйгээр гарсан агаарын хөлгийн гэмтлийн эрсдэлийг бууруулах зорилготой явгалах замыг багтаасан талбай (AN 14/I)
Technical Instructions	Техникийн зааварчилгаа	The <i>Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air</i> (Doc 9284), approved and issued periodically i.a.w the procedure established by the ICAO Council.	ICAO-гийн Зөвлөлийн тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд батлан, гаргадаг ICAO Doc 9284 " <i>Technical Instructions for the Safe Transport of Dangerous Goods by Air</i> " (AN 18)
Telecommunication (RR S1.3)	Цахилгаан холбоо (RR S1.3)	Any transmission, emission, or reception of signs, signals, writing, images and sounds or intelligence of any nature by wire, radio, optical or other electromagnetic systems.	Аливаа хэлбэрийн тэмдэгт, дохио, бичиг, дүрс болон дуу, эсхүл мэдээг утсаар, радиогоор, дүрсээр, эсхүл бусад цахилгаан соронзон системээр дамжуулах, цацах, эсхүл хүлээн авах (AN 10/II)
Teletypewriter tape	Телетайп төхөөрөмжийн тууз	A tape on which signals are recorded in the 5-unit Start-Stop code by completely severed perforations (Chad Type) or by partially severed perforations (Chadless Type) for transmission over teletypewriter circuits.	Телетайп төхөөрөмжийн хэлхээгээр дамжуулах зорилгоор бүтэн нүхлэлттэй (Chad Type), эсхүл хэсэгчилсэн нүхлэлттэй (Chadless Type) тууз ашиглан 5 нэгж Start-Stop кодоор сигнал бичдэг тууз (AN 10/II)
Temporary admission	Гаалийн түр зөвшөөрөл	The customs procedure under which certain goods can be brought into a customs territory conditionally relieved totally or partially from payment of import duties and taxes; such goods must be imported for a specific purpose and must be intended for re-exportation within a specified period and without having undergone any change	Зарим барааг импортын татвар, хураамжаас тодорхой нөхцөлтэйгөөр бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлж болох гаалийн журам; Ийм барааг тодорхой зорилгоор импортлох ба заасан хугацаанд хэрэглээнээс шалтгаалсан

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		except normal depreciation due to the use made of them.	элэгдэл хорогдлоос бусад аливаа өөрчлөлтгүйгээр рэ-экспорт хийдэг байх ёстой. (AN 9)
Terminal arrival altitude	Аэродромд нисэн ирэх өндрийн-түвшин (ТАА)	The lowest altitude that will provide a minimum clearance of 300 m (1 000 ft) above all objects located in an arc of a circle defined by a 46 km (25 NM) radius centred on the initial approach fix (IAF), or where there is no IAF on the intermediate approach fix (IF), delimited by straight lines joining the extremity of the arc to the IF. The combined TAAs associated with an approach procedure shall account for an area of 360 degrees around the IF.	Ойртолтын эхлэлийн цэгт (IAF) төвтэй, 46 км-ийн (25 NM) радиуст тогтоосон, эсхүл дундын цэгт (IF) IAF байхгүй тохиолдолд, нумын төгсгөлүүдээс IF хүртэл татсан шулуун шугамаар холбосон тойргийн нуман дээр байрлах бүх байгууламжаас дээш саадыг давах минимум 300 м-ийн (1000 ft) өндрийг хангадаг хамгийн бага өндрийн-түвшин. Ойртолтын журамд хамаарах ерөнхий ТАА нь IF-ийн ойролцоох 360° талбайг хамарна. (AN 4; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Terminal control area	Ойртолтын удирдлагын бүс	A control area normally established at the confluence of ATS routes in the vicinity of one or more major aerodromes.	Нэг, эсхүл хэд хэдэн томоохон аэродромын ойролцоо, ихэвчлэн НХҮ-тэй нислэгийн замтай давхцуулан тогтоодог удирдлагын бүс (AN 2; AN 11; PANS-ATM)
Terrain	Газрын бартаа	The surface of the Earth containing naturally occurring features such as mountains, hills, ridges, valleys, bodies of water, permanent ice and snow, and excluding obstacles.	Уул, толгод, эрэг, хөндий, усан гадаргуу, мөнх цас ба мөс зэрэг байгалийн гаралтай газар зүйн хэв шинжийг агуулсан дэлхийн гадаргуу. Үүнд саад багтахгүй. (AN 4; AN 15)
Tesla	Тесла (Т)	The magnetic flux density given by a magnetic flux of 1 weber per square metre.	1 м ² талбайд 1 вебр соронзон урсгалаар үүсдэг соронзон урсгалын нягтрал (AN 5)
Threat	Аюул заналхийлэл	Events or errors that occur beyond the influence of an operational person, increase operational complexity and must be managed to maintain the margin of safety. <i>Note.- See Chapter 1 of Annex 19 - Safety Management for a definition of operational personnel.</i>	Ажилтнаас хамааралгүй гардаг, үйл ажиллагааны төвөгшлийг нэмэгдүүлдэг бөгөөд аюулгүйн хамгаалалтын түвшнийг хадгалахын тулд заавал удирдаж, хянадаг байх шаардлагатай тохиолдол, эсхүл алдаа <i>Тэмдэглэл:</i> "Chapter 1 of Annex 19 - Safety Management"-ийн үйл ажиллагааны ажилтны тодорхойлолтыг хар. (AN 1)
Threat management	Аюул заналхийллйн удирдлага	The process of detecting threats and responding to them with countermeasures that reduce or eliminate the consequences of threats and mitigate the probability of errors or undesired states.	Хүсээгүй төлөв байдал, эсхүл алдаа гарах магадлалыг багасгах болон заналхийллйн үр дагаврыг бууруулах, эсхүл арилгах сөрөг арга

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
			хэмжээ бүхий заналхийллийг илрүүлэх, хариу үйлдэл хийх үйл явц (AN 1)
Threshold	Босро	The beginning of that portion of the runway usable for landing.	Буулт үйлдэхэд ашигладаг ХБЗ-ын хэсгийн эхлэл (AN 3; AN 4; AN 14/I; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Threshold time	Босро хугацаа	The range, expressed in time, established by the State of the Operator, to an en-route alternate aerodrome, whereby any time beyond requires a specific approval for EDTO from the State of the Operator.	Замын дагуух бэлтгэл аэродром хүртэл тухайн Үйл ажиллагаа эрхлэгчийг харьяалах Улсын тогтоосон, хугацаагаар илэрхийлдэг зай. Энэ хугацаанаас цааших аливаа хугацаа нь Үйл ажиллагаа эрхлэгчийг харьяалах Улсаас EDTO нислэгийн тусгай зөвшөөрөл шаарддаг. (AN 6/I)
Through-flight	Шууд нислэг	A particular operation of aircraft, identified by the operator by the use throughout of the same symbol, from point of origin via any intermediate points to point of destination.	Эхлэлийн цэгээс завсрын цэгээр дамжин, нисэн хүрэх цэг хүртэл ижил аяллын дугаар ашигладаг, үйл ажиллагаа эрхлэгчийн тодорхойлсон агаарын хөлгийн тодорхой үйл ажиллагаа (AN 9)
Tilt-rotor	Тилт-ротор	A powered-lift capable of vertical take-off, vertical landing, and sustained low-speed flight, which depends principally on engine-driven rotors mounted on tilttable nacelles for the lift during these flight regimes and on nonrotating aerofoil(s) for lift during high-speed flight.	Эгц дээш хөөрөх, буух болон бага хурдтай тогтвортой нислэгийг хүчний төхөөрөмжийн өргөх хүчээр хийх чадвартай, эдгээр нислэгийн горимд өргөх хүч нь бөхийж эргэдэг хөдөлгүүрийн рам (nacelle) дээр бэхлэгдсэн хөдөлгүүрээр хөтлөгддөг ротороор үүсдэг ба өндөр хурдтай нислэгт эргэдэггүй хавтгай дээр үүссэн өргөх хүчний зарчмаас шалтгаалан нисдэг төхөөрөмж (AN 16/I)
Time division multiple access (TDMA)	Хугацаагаар хуваах олон оролтын арга (TDMA)	A multiple access scheme based on time-shared use of an RF channel employing: (1) discrete contiguous time slots as the fundamental shared resource; and (2) a set of operating protocols that allows users to interact with a master control station to mediate access to the channel.	Дараах радио давтамжийн сувгийн цагийг хувааж ашиглахад суурилсан олон оролттой схем: (1) хувааж ашигладаг үндсэн эх үүсвэр шиг салангид зэрэгцээ цагийн интервал; (2) сувагт нэвтрэхийн тулд хэрэглэгчийг үндсэн хяналтын станцтай харилцан ажиллах боломжоор хангадаг ажлын багц протокол. (AN 10/III)
Time division multiplex (TDM)	Хугацаагаар хуваах мультиплекс (TDM)	A channel sharing strategy in which packets of information from the same source but with different	Ижил эх үүсвэртэй боловч хугацаагаар эрэмбэлсэн өөр өөр хүлээн авагчтай мэдээллийн багцыг ижил сувгаар суваг хувааж ашиглах арга (AN 10/III)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		destinations are sequenced in time on the same channel.	
Time-in-position	Үүрэгт ажлын хугацаа	The period of time when an air traffic controller is exercising the privileges of the air traffic controller's licence at an operational position.	Нислэгийн хөдөлгөөний удирдагч өөрийн хариуцсан үйл ажиллагааны байранд нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхээ хэрэгжүүлсэн цаг хугацаа (AN 11)
Tonne (t)	Тонн	The mass equal to 1 000 kilograms.	1000 кг-тай тэнцүү жин (AN 5)
Torn-tape relay installation	Torn-tape дахин дамжуулах төхөөрөмж	A teletypewriter installation where messages are received and relayed in teletypewriter tape form and where all operations of relay are performed as the result of operator intervention.	Мэдээ хүлээн авах, дамжуулах үйл ажиллагааг телетайп төхөөрөмжийн туузан дээр хийдэг, гэхдээ мэдээг дахин дамжуулах үйл ажиллагааг холбоочны оролцоотойгоор хийдэг телетайп төхөөрөмж (AN 10/II)
Total estimated elapsed time (Total EET)	Нийт тооцоот өнгөрөлтийн цаг (нийт EET)	For IFR flights, the estimated time required from take-off to arrive over that designated point, defined by reference to navigation aids, from which it is intended that an instrument approach procedure will be commenced, or, if no navigation aid is associated with the destination aerodrome, to arrive over the destination aerodrome. For VFR flights, the estimated time required from take-off to arrive over the destination aerodrome.	IFR нислэгийн хувьд, хөөрөлтийн дараа навигацийн туслах төхөөрөмжөөр баримжаалан тогтоосон, хэрэглэлийн ойртолтын журмыг эхлүүлэхээр төлөвлөсөн цэг дээр нисэн ирэхэд, эсхүл хэрэв нисэн очих аэродромд навигацийн туслах төхөөрөмж байхгүй бол, тухайн нисэн очих аэродромын дээр нисэн хүрэхэд шаардлагатай тооцоот цаг. VFR нислэгийн хувьд, хөөрөлтийн дараа нисэн очих аэродром дээр нисэн хүрэхэд шаардлагатай тооцоот цаг. (AN 2; PANS-ATM)
Total vertical error	Босоо түвшний нийт зөрүү	The vertical geometric difference between the actual pressure altitude flown by an aircraft and its assigned pressure altitude (flight level).	Агаарын хөлөг нисэж байгаа бодит өндрийн-түвшний даралтын болон оноосон өндрийн-түвшний даралт (нислэгийн түвшин) хоорондын геометрийн босоо зөрүү (AN 6/I; AN 6/II)
Touchdown	Газардах цэг	The point where the nominal glide path intercepts the runway. <i>Note.- "Touchdown" as defined above is only a datum and is not necessarily the actual point at which the aircraft will touch the runway.</i>	Глиссадын чиглэл тухайн ХБЗ-ыг огтлох цэг <u>Тэмдэглэл:</u> Дээр тодорхойлсон "газардах цэг" нь зөвхөн хийсвэр цэг бөгөөд агаарын хөлөг ХБЗ-т газардах бодит цэг биш. (AN 10/I; PANS-ATM)
Touchdown and lift-off area (TLOF)	Газардах болон хөөрөх талбай	A load bearing area on which a helicopter may touch down or lift off.	Нисдэг тэрэг газардах, эсхүл хөөрөх ачааллыг авч байгаа талбай (AN 4; AN 6/III; AN 14/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Touchdown zone	Газардах зоон	The portion of a runway, beyond the threshold, where it is intended landing aeroplanes first contact the runway.	Буултын үед нисэх онгоц ХБЗ-нд анх шүргэхэд зориулсан, босгын дараах ХБЗ-ын хэсэг (AN 3; AN 4; AN 14/I)
Touchdown/positioning circle	Газардах/байрлах тойрог	A touchdown positioning marking (TDPM) in the form of a circle used for omnidirectional positioning in a TLOF.	TLOF-д аль ч чиглэлд байрлахад ашигладаг тойрог хэлбэртэй газардах/байрлах талбайн тэмдэглэгээ (TDPM) (AN 14/II)
Touchdown/positioning marking (TDPM)	Газардах/байрлах талбайн тэмдэглэгээ	A marking or set of markings providing visual cues for the positioning of helicopters.	Нисдэг тэрэг байрлахад ил харааны тэмдгээр хангах тэмдэглэгээ, эсхүл бүлэг тэмдэглэгээ (AN 14/II)
Traceability	Мөшгөх боломж	Ability to trace the history, application or location of that which is under consideration (ISO 9000*). <i>Note.- When considering product, traceability can relate to:</i> - the origin of materials and parts; - the processing history; and - the distribution and location of the product after delivery.	Тухайн авч үзэж байгаа зүйлтэй холбоотой түүх, хэрэглээ, эсхүл байрлалыг эргэн мөшгөж тогтоох боломж <u>Тэмдэглэл:</u> Бүтээгдэхүүний хувьд, мөшгөх боломжид дараах мэдээлэл хамаарна: - материал болон эд ангийн гарал үүсэл; - боловсруулалтын түүх; - хүргэлтээс хойших тухайн бүтээгдэхүүний түгээлт болон байрлал. (AN 15)
Track	Замын мөр	The projection on the earth's surface of the path of an aircraft, the direction of which path at any point is usually expressed in degrees from North (true, magnetic or grid).	Замын аль ч цэгийн чиглэл нь ихэвчлэн хойд зүгээс (жинхэнэ, соронзон, эсхүл тор) градусаар илэрхийлдэг агаарын хөлгийн замын газрын гадаргуу дээрх тусгал (AN 2; AN 4; AN 11; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Traffic avoidance advice	Нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмж	Advice provided by an ATS unit specifying manoeuvres to assist a pilot to avoid a collision.	Мөргөлдөхөөс зайлсхийхэд нисгэгчид туслах зорилгоор маневрыг зааж НХҮ-ний нэгжээс өгдөг зөвлөмж (AN 2; AN 11; PANS-ATM)
Traffic information	Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл	Information issued by an ATS unit to alert a pilot to other known or observed air traffic which may be in proximity to the position or intended route of flight and to help the pilot avoid a collision.	Тухайн байршил, эсхүл төлөвлөсөн нислэгийн замын ойр байж болох, мэдэгдэж байгаа, эсхүл ажиглагдсан нислэгийн хөдөлгөөнийг нисгэгчид анхааруулж, мөргөлдөхөөс зайлсхийхэд нисгэгчид туслах зорилгоор НХҮ-ний нэгжээс өгдөг мэдээлэл (AN 2; AN 11; PANS-ATM)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Traffic information service - broadcast (TIS-B) IN	Хөдөлгөөний мэдээллийн үйлчилгээ - радио нэвтрүүлэг (TIS-B) IN	A surveillance function that receives and processes surveillance data from TIS-B OUT data sources.	TIS-B OUT өгөгдлийн эх үүсвэрээс ажиглалтын өгөгдлийг хүлээн авч, боловсруулдаг ажиглалтын ажиллагаа (AN 10/IV)
Traffic information service - broadcast (TIS-B) OUT	Хөдөлгөөний мэдээллийн үйлчилгээ - радио нэвтрүүлэг (TIS-B) OUT	A function on the ground that periodically broadcasts the surveillance information made available by ground sensors in a format suitable for TIS-B IN capable receivers.	Газрын мэдрэгчээс авсан ажиглалтын мэдээллийг TIS-B IN чадвартай хүлээн авагчид тохиромжтой форматаар тодорхой давтамжтайгаар мэдээлдэг газрын ажиллагаа (AN 10/IV)
Transfer cargo and mail	Дамжих ачаа болон шуудан	Cargo and mail departing on an aircraft other than that on which it arrived.	Нисэн ирснээсээ өөр агаарын хөлгөөр нисэн гарч байгаа ачаа болон шуудан (AN 17)
Transfer of control point	Удирдлага шилжүүлэх цэг	A defined point located along the flight path of an aircraft, at which the responsibility for providing ATC service to the aircraft is transferred from one control unit or control position to the next.	Агаарын хөлгийг НХУ-ын үйлчилгээгээр хангах үүргээ нэг удирдлагын нэгж, эсхүл удирдлагын байрнаас дараагийн нэгж, эсхүл байранд шилжүүлдэг, агаарын хөлгийн нислэгийн зам дээр байрладаг тогтоосон цэг (AN 11; PANS-ATM)
Transferring unit	Дамжуулах нэгж	ATC unit in the process of transferring the responsibility for providing ATC service to an aircraft to the next ATC unit along the route of flight.	Агаарын хөлгийг НХУ-ээр хангах үүргээ тухайн нислэгийн замын дагуух дараагийн НХУ-ын нэгжид шилжүүлж байгаа НХУ-ын нэгж (AN 11)
Transit delay	Дамжуулалтын хоцролт	In packet data systems, the elapsed time between a request to transmit an assembled data packet and an indication at the receiving end that the corresponding packet has been received and is ready to be used or forwarded.	Багц өгөгдлийн системийн хувьд бэлтгэсэн өгөгдлийн багцыг дамжуулах хүсэлт гаргахаас эхлэн тухайн багцыг эцсийн цэгт хүлээн авч ашиглах, эсхүл дамжуулахад бэлэн болох хүртэл болж өнгөрсөн хугацаа (AN 10/III)
Transition altitude	Шилжих өндрийн-түвшин (TA)	The altitude at or below which the vertical position of an aircraft is controlled by reference to altitudes.	Тухайн цэг, эсхүл түүнээс доогуур нисэж байгаа агаарын хөлгийн босоо байршлыг өндрийн-түвшнээр илэрхийлэн удирддаг өндрийн-түвшин (<i>алтиметрийн тохируулга QNH</i>) (AN 2; AN 4; PANS-ATM)
Transition layer	Шилжих давхарга	the airspace between the transition altitude (TA) and the transition level (TL):	Шилжих өндрийн-түвшин (TA) болон шилжих түвшний (TRL) хоорондох агаарын зай (PANS-ATM; PANS-OPS/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Transition level	Шилжих түвшин (TRL)	the lowest flight level (FL) available for use above the transition altitude (TA) (altimeter setting 1013 hPa):	Шилжих өндрийн-түвшнээс (ТА) дээш, ашиглах боломжтой хамгийн доод нислэгийн түвшин (FL) (алтиметр 1013 hPa) (PANS-ATM; PANS-OPS/I)
Transponder occupancy	Транспондер завгүй байх	A state of unavailability of the transponder from the time it detects an incoming signal that appears to cause some action or from the time of a self-initiated transmission, to the time that it is capable of replying to another interrogation.	Ямар нэг үйлдэл хийхийг шаардсан ирж байгаа дохиог таньж тогтоосон цагаас, эсхүл өөрийн санаачилгаар дамжуулалт хийсэн цагаас эхлэн өөр асуултад хариулах чадвартай болох цаг хүртэлх транспондерын хариулахгүй завгүй байх нөхцөл (AN 10/IV)
Travel document	Аяллын баримт бичиг	A passport or other official document of identity issued by a State or organization, which may be used by the rightful holder for international travel.	Эрх бүхий эзэмшигч нь олон улсын аялалд ашигладаг, тухайн Улс, эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон паспорт, эсхүл бусад албан баримт бичиг (AN 9)
Tributary station	Салаа станц	An aeronautical fixed station that may receive or transmit messages and/or digital data but which does not relay except for the purpose of serving similar stations connected through it to a communication centre.	Түүгээр дамжуулан холбооны төвтэй холбоо тогтоосон ижил төрлийн станцад үйлчлэх зорилготойгоос бусад мэдээ ба/эсхүл өгөгдөл хүлээн авах, эсхүл дамжуулах боломжтой нисэхийн суурин холбооны станц (AN 10/II)
Tropical cyclone	Тропик циклон	Generic term for a non-frontal synoptic-scale cyclone originating over tropical or sub-tropical waters with organized convection and definite cyclonic surface wind circulation.	Конвекц болон тодорхой циклоны гадаргуугийн салхины эргүүлгээр тропик, эсхүл субтропик далай дээр үүсдэг фронтын бус синоптик масштабтай циклоны ерөнхий нэр томьёо (AN 3)
Tropical cyclone advisory centre	Тропик циклоноос сэрэмжлүүлэх төв	A meteorological centre designated by regional air navigation agreement to provide advisory information to meteorological watch offices, world area forecast centres and international OPMET databanks regarding the position, forecast direction and speed of movement, central pressure and maximum surface wind of tropical cyclones.	Цаг уурын ажиглалтын алба, Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв болон олон улсын ОРМЕТ өгөгдлийн санг тропик циклоны байрлал, чиглэлийн урьдчилсан мэдээ болон хөдөлгөөний хурд, төвийн даралт болон максимум гадаргуугийн салхины талаар сэрэмжлүүлэх мэдээллээр хангах зорилгоор бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон цаг уурын төв (AN 3)
Two-frequency glide path system	Хоёр давтамжтай глиссид систем	An ILS glide path in which coverage is achieved by the use of two independent radiation field patterns spaced on separate carrier frequencies within the particular glide path channel.	Тодорхой глиссадын сувгийн хүрээнд тусдаа дамжуулагчийн давтамжаар зайчлагдсан бүрхэлт нь хоёр үл хамаарах долгион тархалтын талбайн дүрсээр хангагддаг ILS глиссид (AN 10/I)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Two-frequency localizer system	Хоёр давтамжтай локалайзер систем	A localizer system in which coverage is achieved by the use of two independent radiation field patterns spaced on separate carrier frequencies within the particular localizer VHF channel.	Тодорхой локалайзерын VHF сувгийн хүрээнд тусдаа дамжуулагчийн давтамжаар зайчлагдсан бүрхэлт нь хоёр үл хамаарах долгион тархалтын талбайн дүрсээр хангагддаг локалайзер систем (AN 10/I)
Type Certificate	Маягийн гэрчилгээ	A document issued by a Contracting State to define the design of an aircraft, engine or propeller type and to certify that this design meets the appropriate airworthiness requirements of that State. <i>Note.- In some Contracting States a document equivalent to a Type Certificate may be issued for an engine or propeller type.</i>	Агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийн загварыг тодорхойлон, тухайн Улсын НТЧ-ын холбогдох шаардлагад нийцэж байгааг гэрчилгээжүүлэхээр Хэлэлцэн тохиролцогч Улсын олгосон баримт бичиг <u>Тэмдэглэл:</u> Зарим Хэлэлцэн тохиролцогч Улсад хөдөлгүүр, эсхүл сэнсний маягт Маягийн Гэрчилгээтэй дүйцэх баримт бичгийг олгож болно. (AN 8; AN 16)
Type design	Маягийн загвар	The set of data and information necessary to define an aircraft, engine or propeller type for the purpose of airworthiness determination.	НТЧ-ыг тогтоох зорилгоор агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийг тодорхойлоход хэрэгтэй өгөгдөл болон мэдээллийн бүрдэл (AN 8)
Ultimate load	Дээд ачаалал	The limit load multiplied by the appropriate factor of safety.	Ачааллын хязгаарыг тохирох аюулгүй байдлын хүчин зүйлийн коэффициентээр үржүүлсэн ачаалал (AN 8)
UN number	UN дугаар	The four-digit number assigned by the United Nations Committee of Experts on the Transport of Dangerous Goods and on the Globally Harmonized System of Classification and Labelling of Chemicals to identify an article or substance or a particular group of articles or substances.	Бодис, эсхүл тодорхой бүлгийн бодисыг таньж тогтоох зорилгоор НҮБ-ын Аюултай бараа Тээвэрлэлтийн Экспертийн хорооноос болон Химийн бүтээгдэхүүнийг ангилал болон шошгын Дэлхийн Нэгдсэн Системд оноосон 4 оронтой тоо (AN 18)
Unaccompanied baggage	Эзэн нь дагалдаагүй тээш	Baggage that is transported as cargo and may or may not be carried on the same aircraft with the person to whom it belongs.	Эзэмшигч нь зорчиж байгаа ижил агаарын хөлөгт авч явсан, эсхүл авч яваагүй ачаатай адил тээвэрлэдэг тээш (AN 9)
Unaccompanied minor	Дагалдагчгүй насанд хүрээгүй этгээд	A minor travelling alone or travelling only in the company of another minor.	Ганцаараа аялж байгаа, эсхүл өөр насанд хүрээгүй этгээдтэй хамт аялж байгаа насанд хүрээгүй этгээд (AN 9)
Unburned hydrocarbons	Шатаагүй нүүрсустөрөгч	The total of hydrocarbon compounds of all classes and molecular weights contained in a gas sample, calculated as if they were in the form of methane.	Хийн дээжид агуулагдсан, бүгд метан хэлбэрт байгаа гэж тооцсон бүх ангилал болон молекулын жинтэй нийт нүүрсустөрөгчийн бүрдэл (AN 16/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
Uncertainty phase (INSERFA)	Тодорхой бус үе (INSERFA)	A situation wherein uncertainty exists as to the safety of an aircraft and its occupants.	Агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдал тодорхой бус болсон нөхцөл (AN 11; AN 12; PANS-ATM)
Unclaimed baggage	Нэхэмжлээгүй тээш	Baggage that arrives at an airport and is not picked up or claimed by a passenger.	Нисэх буудалд ирсэн боловч зорчигч аваагүй, эсхүл нэхэмжлээгүй тээш (AN 9)
Unidentified baggage	Танигдаагүй тээш	Baggage at an airport, with or without a baggage tag, which is not picked up by or identified with a passenger.	Нисэх буудалд зорчигч аваагүй, эсхүл таниагүй ба тээшний шошготой, эсхүл шошгогүй тээш (AN 9; AN 17)
Unit load device	Ачилтын нэгж төхөөрөмж	Any type of freight container, aircraft container, aircraft pallet with a net, or aircraft pallet with a net over an igloo. <i>Note.- An overpack is not included in this definition.</i>	Багц ачааны болон агаарын хөлгийн чингэлэг, агаарын хөлгийн тортой ачааны тавцан, эсхүл агаарын хөлгийн хэлбэржүүлсэн тортой ачааны тавцан. <i>Тэмдэглэл: Гадуур боодол, цацраг идэвхт материалын багц ачааны чингэлэг орохгүй. (AN 18)</i>
Unlading	Буулгах	The removal of cargo, mail, baggage or stores from an aircraft after a landing.	Буулт үйлдсэний дараа агаарын хөлгөөс ачаа, шуудан, тээш, эсхүл бүхээгийн нөөцийг авах (AN 9)
Unmanned free balloon	Хүнгүй чөлөөт бөмбөлөг	A non-power-driven, unmanned, lighter-than-air aircraft in free flight. <i>Note.- Unmanned free balloons are classified as heavy, medium or light i.a.w specifications contained in Appendix 5.</i>	Хөдөлгүүргүй, хүнгүй, чөлөөт нислэг үйлддэг агаараас хөнгөн агаарын хөлөг <i>Тэмдэглэл: Annex 2, Appendix 5-д заасан үзүүлэлтийн дагуу хүнгүй чөлөөт бөмбөлгийг хүнд, дунд, эсхүл хөнгөн гэж ангилдаг. (AN 2; PANS-ATM)</i>
Unpredictability	Гэнэтийн үзлэг	The implementation of security measures in order to increase their deterrent effect and their efficiency, by applying them at irregular frequencies, different locations and/or with varying means, i.a.w a defined framework.	Тэдгээрийн илрүүлэлтийн нөлөө болон үр дүнг сайжруулах зорилгоор тогтмол бус давтамжтайгаар, өөр өөр байрлалд ба/эсхүл өөр өөр хэлбэрээр тогтоосон ажлын хүрээнд гүйцэтгэдэг аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжүүлэлт (AN 17)
Upper-air chart	Өндрийн зураг	A meteorological chart relating to a specified upper-air surface or layer of the atmosphere.	Дээд агаарын зай, эсхүл атмосферийн давхаргыг тодорхойлсон цаг уурын зураг (AN 3)
Usability factor	Ашиглалтын коэффициент	The percentage of time during which the use of a runway or system of runways is not restricted because of the crosswind component.	Хөндлөнгийн салхины бүрдэл хэсгээс шалтгаалан, ХБЗ-ын ашиглалтыг хязгаарлаагүй байх цагийг хувиар илэрхийлдэг харьцаа

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		<i>Note.- Crosswind component means the surface wind component at right angles to the runway centre line.</i>	<i>Тэмдэглэл: Хөндлөнгийн салхины бүрдэл хэсэг гэж ХБЗ-ын гол шугамд тэгш өнцгөөр чиглэсэн гадаргуугийн салхины бүрдэл хэсэг (AN 14/I)</i>
Validation	Баталгаажуулах	Confirmation, through the provision of objective evidence, that the requirements for a specific intended use or application have been fulfilled (ISO 9000*).	Зориулалтын тусгай хэрэглээ, эсхүл хэрэглээний шаардлагыг хангасан болохыг бодит нотлох баримт ашиглан бататгах (ISO 9000) (AN 15)
Vectoring	Чиглүүлэх	Provision of navigational guidance to aircraft in the form of specific headings, based on the use of an ATS surveillance system.	НХУ-ний ажиглалтын системд суурилсан, тусгайлсан чиглэл ашиглан агаарын хөлгийг чиглүүлэх навигацийн арга (AN 4)
Verification	Баталгаажуулалт	Confirmation, through the provision of objective evidence, that specified requirements have been fulfilled (ISO 9000*).	Тухайн тогтоосон шаардлагыг бүрэн хангасан болохыг бодит нотлох баримт ашиглан гаргасан баталгаа (ISO 9000*)
		<i>Note.- The term “verified” is used to designate the corresponding status.</i>	<i>Тэмдэглэл: “Баталгаажуулсан” гэсэн хэллэгийг холбогдох нөхцөлийг тогтооход хэрэглэдэг. (AN 15)</i>
Verification body	Баталгаажуулах этгээд	A legal entity that performs the verification of an Emissions Report and, when required, an Emissions Unit Cancellation Report, as an accredited independent third party.	Хийн ялгаруулалтын тайлангийн баталгаажуулалт болон шаардлагатай бол итгэмжлэгдсэн бие даасан гуравдагч талын өмнөөс Хийн ялгаруулалтын нэгжийн цуцалсан тайланг гаргадаг хуулийн этгээд (AN 16/IV)
Verification of report	Тайлангийн баталгаажуулалт	An independent, systematic and sufficiently documented evaluation process of an emissions report and, when required, a cancellation of eligible emissions units report.	Хийн ялгаруулалтын тайлангийн бие даасан, системчилсэн ба хангалттай баримтжуулсан үнэлгээний үйл явц. Шаардлагатай тохиолдолд хийн ялгаруулалтын нэгжийн тохирох тайланг цуцалдаг. (AN 16/IV)
Verification report	Баталгаажуулалтын тайлан	A document, drafted by the verification body, containing the verification statement and required supporting information.	Баталгаажуулах этгээд боловсруулсан, баталгаажуулалтын мэдэгдэл болон шаардлагатай дагалдах мэдээллийг багтаасан баримт бичиг (AN 16/IV)
Verification team	Баталгаажуулалтын баг	A group of verifiers, or a single verifier that also qualifies as a team leader, belonging to a verification body conducting the verification of an Emissions Report and, when required, an	Хийн ялгаруулалтын тайлан баталгаажуулдаг болон шаардлагатай бол Хийн ялгаруулалтын нэгжийн тайланг цуцалдаг баталгаажуулах этгээдэд хамаарах багийн ахлагчийн эрх бүхий бүлэг баталгаажуулагч, эсхүл ганц

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		Emissions Unit Cancellation Report. The team can be supported by technical experts.	баталгаажуулагч. Тухайн багт техникийн шинжээч байж болно. (AN 16/IV)
VFR flight	VFR нислэг	A flight conducted i.a.w the visual flight rules.	Ил харааны нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэг (AN 2; AN 11; PANS-ATM)
VHF digital link (VDL)	VHF digital link (VDL)	A constituent mobile subnetwork of the aeronautical telecommunication network (ATN), operating in the aeronautical mobile VHF frequency band. In addition, the VDL may provide non-ATN functions such as, for instance, digitized voice.	Нисэхийн хөдөлгөөнт VHF давтамжийн хэсэгт ажилладаг ATN-ний хөдөлгөөнт дэд сүлжээг бүрдүүлэгч. Мөн энэ нь яриаг тоон үйлдэлд шилжүүлэх зэрэг ATN-бус үйлдлийг хийнэ. (AN 10/III; AN 10/V)
Visibility	Хараа	<p>Visibility for aeronautical purposes is the greater of:</p> <p>a) the greatest distance at which a black object of suitable dimensions, situated near the ground, can be seen and recognized when observed against a bright background;</p> <p>b) the greatest distance at which lights in the vicinity of 1 000 candelas can be seen and identified against an unlit background.</p> <p><i>Note 1.- The two distances have different values in air of a given extinction coefficient, and the latter b) varies with the background illumination. The former a) is represented by the meteorological optical range (MOR).</i></p> <p><i>Note 2.- The definition applies to the observations of visibility in local routine and special reports, to the observations of prevailing and minimum visibility reported in METAR and SPECI and to the observations of ground visibility.</i></p>	<p>Нисэхийн үйл ажиллагааны зорилгоор ашигладаг дараах зайны аль ихийг:</p> <p>a) газар дээр байрлуулсан тохиромжтой хэмжээтэй хар биетийг тод гэгээтэй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай;</p> <p>b) 1000 кандел гэрлийн ойролцоо байгаа гэрлийг харанхуй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай.</p> <p><i>Тэмдэглэл 1:</i> Дээрх 2 зай нь агаарын тунгалагшлын коэффициент (extinction coefficient) болон сүүлийн b) нь дэвсгэрийн гэрэлтүүлгийн өөрчлөлтөөс хамаарч өөр утгатай байдаг. Эхний a) нь цаг уурын оптик зайгаар (MOR) илэрхийлэгддэг.</p> <p><i>Тэмдэглэл 2:</i> Энэ тодорхойлолтыг орон нутгийн бодит болон тусгай мэдээний харааны ажиглалт, METAR болон SPECI-д өгсөн дамавагйлах болон минимум харааны ажиглалт болон газрын харааны ажиглалтад хэрэглэдэг. (AN 2; AN 3; PANS-ATM)</p>
Visitor	Түр ирэгч	Any person who disembarks and enters the territory of a Contracting State other than that in which that person normally resides; remains there lawfully as prescribed by that Contracting State for legitimate non-immigrant purposes, such as touring, recreation, sports, health, family reasons, religious pilgrimages, or business; and does not	Хэлэлцэн тохиролцогч Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суудаггүй, тухайн Улсад цагаачлах зорилгогүйгээр хууль тогтоомжийн дагуу зорчиж, тухайн Улсын нутаг дэвсгэр дээр ашиг олох үйл ажиллагаа эрхлэхгүйгээр аялал, амралт, спорт, эрүүл мэнд, гэр бүл, шашны болон албан зорилгоор зорчиж байгаа аливаа этгээд (AN 9)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		take up any gainful occupation while staying in the territory visited.	
Visual approach procedure	Ил хараагаар ойртолтын журам	A series of predetermined manoeuvres by visual reference, from the initial approach fix, or where applicable, from the beginning of a defined arrival route to a point from which a landing can be completed and thereafter, if a landing is not completed, a go-around procedure can be carried out.	Ойртолтын эхлэлийн цэгээс (IAF), эсхүл хамааралтай бол тогтоосон нисэн ирэх замын эхлэлээс, буулт үйлдэж болох цэг хүртэл болон түүнээс цааш хэрэв буулт үйлдээгүй бол 2-т гарах журмыг гүйцэтгэх, ил харааны баримжаагаар урьдчилан тодорхойлсон цуврал маневр (AN 4)
Visual line-of-sight (VLOS) operation	Шууд харж удирдах (VLOS) үйл ажиллагаа	An operation in which the remote pilot or RPA observer maintains direct unaided visual contact with the remotely piloted aircraft.	Зайнаас-удирдах-нисгэгч, эсхүл зайнаас удирддаг агаарын хөлгийн ажиглагч зайнаас удирддаг агаарын хөлөгтэй дуран ашиглахгүй, шууд ил хараа хадгалан гүйцэтгэдэг үйл ажиллагаа (AN 2)
Visual meteorological conditions (VMC)	Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл (VMC)	Meteorological conditions expressed in terms of visibility, distance from cloud, and ceiling, equal to or better than specified minima. <i>Note.- The specified minima are contained in Annex 2, Chapter 4.</i>	Заасан минима-тай тэнцүү, эсхүл түүнээс дээш, хараагаар, үүлнээс барих зайгаар болон үүлний суурийн өндрөөр илэрхийлдэг цаг уурын нөхцөл <i>Тэмдэглэл: Заасан минима нь Annex 2, Chapter 4-т багтсан.</i> (AN 2; AN 6/I; AN 6/II; AN 6/III; AN 11; PANS-ATM)
Volcanic ash advisory centre	Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв	A meteorological centre designated by regional air navigation agreement to provide advisory information to meteorological watch offices, area control centres, flight information centres, world area forecast centres and international OPMET databanks regarding the lateral and vertical extent and forecast movement of volcanic ash in the atmosphere.	Цаг уурын хяналтын алба, бүсийн удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төв, Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв болон олон улсын OPMET өгөгдлийн санг галт уулын дэлбэрэлтээс шалтгаалж агаарт тархсан галт уулын үнсний босоо, хэвтээ чиглэлийн шилжилт хөдөлгөөний бодит болон сэрэмжлүүлэх мэдээллээр хангах үүрэгтэй, бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон цаг уурын төв (AN 3)
VOLMET	VOLMET	Meteorological information for aircraft in flight.	Нислэгт байгаа агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээлэл (AN 3; AN 15)
Volt (V)	Вольт (В)	The unit of electric potential difference and electromotive force which is the difference of electric potential between two points of a conductor carrying a constant current of 1 ampere, when the	Цэгүүдийн хоорондох энергийн цацралт нь нэг ватттай тэнцэх үед нэг ампер тогтмол гүйдэл өнгөрдөг дамжуулагчийн хоёр цэгийн хоорондох цахилгаан потенциалын ялгавартай тэнцэх

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
		power dissipated between these points is equal to 1 watt.	цахилгаан хөдөлгөгч хүч болон цахилгааны потенциалын ялгаврын нэгж (AN 5)
V _{toss}	V _{toss}	The minimum speed at which climb shall be achieved with the critical engine inoperative, the remaining engines operating within approved operating limits.	Эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан үед үлдсэн хөдөлгүүр нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны хязгаар дотор ажиллаж байхад өндөр авалт хийх минимум хурд (AN 6/III)
Watt	Ватт (чадал)	The power which gives rise to the production of energy at the rate of 1 joule per second.	1 Ж / сек-тэй тэнцүү энерги үүсгэхэд зарцуулдаг чадал (AN 5)
Waypoint	Замын цэг	A specified geographical location used to define an area navigation route or the flight path of an aircraft employing area navigation. Waypoints are identified as either: <i>Fly-by waypoint.</i> A waypoint which requires turn anticipation to allow tangential interception of the next segment of a route or procedure; or <i>Flyover waypoint.</i> A waypoint at which a turn is initiated in order to join the next segment of a route or procedure.	Бүсийн навигаци ашиглан нисэж байгаа агаарын хөлгийн тухайн бүсийн навигацийн зам, эсхүл нислэгийн замыг тодорхойлох зорилгоор ашигладаг тусгайлан тогтоосон газар зүйн байрлал. Замын цэгийг нь дараах аль нэг байдлаар тэмдэглэнэ: “Флай-бай замын цэг” (fly-by waypoint): Замын, эсхүл журмын дараагийн хэсэгт шүргэн шилжих зорилгоор урьдчилан эргэлт хийхийг шаарддаг замын цэг; эсхүл “Флайовер замын цэг” (flyover waypoint): замын, эсхүл журмын дараагийн хэсэгт нэгдэх зорилгоор эргэлт хийж эхлэх замын цэг. (AN 4; AN 11; PANS-ATM; PANS-OPS/I; PANS-OPS/II)
Weber (Wb)	Вебер (Вб)	The magnetic flux which, linking a circuit of one turn, produces in it an electromotive force of 1 volt as it is reduced to zero at a uniform rate in 1 second.	Нэг секундэд битүү контур доторх нэг ороомог хэлбэр дэх нэг вольтыг тэг хүртэлх жигд бууралтад цахилгаан хөдөлгөх хүчийг үүсгэдэг соронзон урсгал (AN 5)
Wet runway	Нойтон ХБЗ	The runway surface is covered by any visible dampness or water up to and including 3 mm deep within the intended area of use.	Ашиглахаар төлөвлөсөн талбай дээрх харагдахуйц чийг тунадастай, эсхүл 3 мм хүртэл усаар бүрхэгдсэн ХБЗ-ын гадаргуу (AN 6/I)
Winching area	Өргөгч-төхөөрөмж ашиглах талбай	An area provided for the transfer by helicopter of personnel or stores to or from a ship.	Нисдэг тэргээр хөлөг онгоцонд, эсхүл хөлөг онгоцноос хүн, эсхүл нөөцийг татлагаар дамжуулах талбай (AN 14/II)

НЭР ТОМЬЁО		ТОДОРХОЙЛОЛТ	
АНГЛИ	МОНГОЛ	АНГЛИ	МОНГОЛ
World area forecast centre (W AFC)	Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв (W AFC)	A meteorological centre designated to prepare and issue significant weather forecasts and upper-air forecasts in digital form on a global basis direct to States using the aeronautical fixed service Internet based services.	Дэлхийн хэмжээнд цаг агаарын онцгой үзэгдлийн урьдчилсан мэдээ болон дээд агаар мандлын урьдчилсан мэдээг тоон хэлбэрээр бэлтгэн, гаргаж интернэтэд суурилсан нисэхийн тогтсон үйлчилгээ авдаг Улсуудад шууд дамжуулах зориулалттай цаг уурын төв (AN 3)
World area forecast system (WAFS)	Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний систем	A worldwide system by which world area forecast centres provide aeronautical meteorological en-route forecasts in uniform standardized formats.	Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төвөөс нислэгийн замын нисэхийн цаг уурын урьдчилсан мэдээг нэгдсэн стандартчилсан форматаар хангадаг дэлхийг хамарсан систем (AN 3)
Z marker beacon	Конус маркер дохиологч	A type of radio beacon, the emissions of which radiate in a vertical cone-shaped pattern.	Босоо конус хэлбэрээр долгионоо цацдаг радио дохиологчийн төрөл (AN 10/I)

ТӨГСӨВ.